

ГАРЧИГ

Өмнөтгөл	11
----------------	----

Нэг. БУРИАД ХЭЛ-АЯЛГУУНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД

Гантогтох Г.,	Монгол улс дахь буриад хэл-аялгууны хэрэглээ, хандлага.....	13
Батцэрэн Г.,	Радио телевизээр нэвтрүүлж буй буриад ястны соёл урлагийн талаархи санал бодол, судалгаа.....	21
Базарова Ц.Б.,	Хари гүрэнэй эрхэтэдтэ буриад хэлэ заалгаха тухай.....	23
Бальжинимаева Н.Н.		
Белоусова М.Ю.	Буриад хэлые хойто үедөө үлдээхэд интернэтийн үүрэг чухал болох нь.....	27
Дондокова Ж.Ц.,	Язык периодических изданий Усть-Ордынского бурятского округа на бурятском языке.....	34
Жамьян Санжанов	ОХУ-ын буриад аялгууны үгийн сангийн хөгжил.....	37
Одмандах М.,	Буриад хэл-аялгуугаарх нэвтрүүлгийг боловсронгуй болгоход нэмэрлэх хэдэн санал.....	45
Оюунцэцэг Л.,	Монгол улас дахи “MN-2” телевизэй “Буриад хэлэнэй нэбтэрүүлгэ”-ые нийхэм соёлой антропологой зүгтээ шэнжэлэхэнь	48
Патаева В.Д.,	Мүнөө үедэ буриад баримжаа хэлэнэй байдал.....	55
Халхарова Л.Ц.,	Буриад хэлэн дээрэ олониетэдэ мэдээсэл дамжуулдаг хэрэгсэлнүүд тухай.....	59
Цэрэндондог Б.,	Буриад хэлэмнай орхигдохо ёһогүй.....	62
Цэрэннадмид Б.,	Даяаршиж буй үеийн монголын буриадуудын хэл аялгууны байдал.....	65
Эрдэнэцогт Ж.,	Үндэсний цөөнхөд зориулсан нэвтрүүлэг бэлтгэж байгаа байдал, чиг хандлага.....	68
Эрдынеева А.Д.,	Урданай гэр байрануудай онсо шэнжэнүүд тухай	74

Хоёр. БУРИАД СУДЛАЛЫН ӨГҮҮЛЛҮҮД

Афанасьева Е.Ф.,	Россиин эвенкүүд.....	80
Аюшеевна Н.В.,	Ц.Дон тухай мүнөө үсын зураглал.....	83
Будаин Б.Б.,	Захаамин нютаг хэлэнэй нэрэ хэлэлгын хубинуудай онсо шэнжэ.....	89

Куриганова И.А.,	Буряад арадай эртэ урда сагнаа хахижа ябаһан элүүр байх ёһо заншал.....	95
Мядагмаа Б.,	Буриад зоны үр хүүхдээ сурган хүмүүжүүлж ирсэн ардын өв уламжлалын тухайд.....	102
Оюунтунгалаг А.,	Багшийн сургуулийн түүхэнд буриадын сэхээтнүүдийн оруулсан хувь нэмэр.....	106
Самбуу А.,	Монгол хүний хөгжил угийн бичгээр хөтлөгдөж байжээ.....	116
Чинзориг Б.,	XX зууны эхэн үеийн Монголын боловсролд буриад сэхээтнүүдийн оруулсан хувь нэмрийг судлах тухайд.....	123
Цэдэнжав Д.,		
Патаева В.Д.,	Буриад бөөгийн зан үйл, үг хэллэг.....	126
Эрдынеева А.Д.,	Этимология и семантика ойконимов бурятского языка.....	138

Гурав. АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

Одмандах М.,	Бичигт цагаан чулууны эрэлд	149
--------------	-----------------------------------	-----

Дөрөв. ОРЧУУЛГА

Мунко-Бато Нимаев	Шилийн голын буриад генерал.....	165
-------------------	----------------------------------	-----

Тав. ХӨРӨГ, ТЭМДЭГЛЭЛ

Г.Гантогтох	Баруун долоон буриадын утгалаач Л.Галбаабадраа оточ ламбугай.....	170
Д.Бадамням	Их эмч Буджавын Санжмятав буюу Санжмятав Будажапович Цыбиктаров (1877-1921)	180

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Буриад хэлний өдөрт зориулсан дугуй ширээний ярилцлага.....	188
Буриад хэлэнэй үсгэлдэр, мөнөөдөр, үглөөдөр.....	194
Буриад хэл-аялгууны хэрэглээний асуудалд.....	196
Буриад хэлэнэй ерээдүй.....	199

ОГЛАВЛЕНИЕ

Предисловие.....	11
------------------	----

1. К ВОПРОСАМ ФУНКЦИОНИРОВАНИЯ БУРЯТСКОГО ЯЗЫКА И ЕГО ДИАЛЕКТОВ

Гантогтох Г.	Проблемы развития бурятского языка и его диалектов в Монголии.....	13
Батцэрэн Г.	Комментарии о теле-радиопередачах, посвященных культуре и искусству бурят.....	21
Базарова Ц.Б.	О преподавании бурятского языка как иностранного.....	23
Бальжинимаева Н.Н., Белоусова М.Ю.	Роль Интернета в сохранении и развитии бурятского языка.....	27
Дондокова Ж. Ц.	О периодических изданиях Усть-Ордынского бурятского округа на бурятском языке.....	34
Санжанов Ж.	Развитие лексики бурятских диалектов в РФ.....	37
Одмандах М.	К совершенствованию теле-радиопередач на бурятском языке.....	45
Оюунцэцэг Л.	Анализ передач на бурятском языке телеканала “MN-2” в аспекте социально-культурологической антропологии.....	48
Патаева В.Д.	О современном состоянии бурятского литературного языка.....	55
Халхарова Л.Ц.	Средства массовой информации на бурятском языке.....	59
Цэрэндондог Б.	Не допустим к вымеранию бурятского языка.....	62
Цэрэннадмид Б.	Бурят-монгольский язык в условиях глобализации.....	65
Эрдэнэцогт Ж.	О методике подготовки программ телепередач, посвященных национальным меньшинствам.....	68
Эрдынеева А.Д.	Особенности традиционного бурятского жилища.....	74

2. СТАТЬИ ПО БУРЯТОВЕДЕНИЮ

Афанасьева Е.Ф.	Российские эвенки.....	80
Аюшеевна Н.В., Будаин Б.Б.	Современные зарисовки о Ц.Дон Ономастические особенности закаменского диалекта.....	83 89

Куриганова И.А.	Обычаи и традиции бурят по сохранению здоровья с древних времён.....	95
Мядагма Б.	Роль бурятских народных традиций в воспитании подрастающего поколения.....	102
Оюунтунгалаг А.	Вклад бурятской интеллигенции в историю педагогического образования Монголии.....	106
Самбуу А.	Роль родословных в эволюции монгольского этноса....	116
Чинзориг Б.,	К вопросам изучения о вкладе бурятских интелегенций в развитии образования Монголии в начале XX века.	123
Цэдэнжав Д.,		
Патаева В.Д.	Лексика шаманских обрядов бурят.....	126
Эрдынеева А.Д.	Этимология и семантика ойконимов бурятского языка.....	138

3. ПУТЕВЫЕ ЗАМЕТКИ

Одмандах М.	В поисках камня “Бичигт цагаан чулуу”.....	149
-------------	--	-----

4. ПЕРЕВОД

Мунко-Бато Нимаев.	Бурят-генерал Шилин-гола.....	165
--------------------	-------------------------------	-----

5. ПОРТРЕТЫ И ЗАРИСОВКИ

Гантогтох.Г.	Лама-врачеватель Л. Галбаабадраа – знаток семи западно-бурятских общин.....	170
Бадамням Д.	Врач Санжмятав Будажапович Цыбиктаров (1877-1921).....	180

6. НОВОСТИ

Круглый стол, посвященный Дню бурятского языка.....	188
Бурятский язык: вчера, сегодня, завтра.....	194
К вопросу функционирования бурятских диалектов.....	196
О будущем бурятского языка.....	199

TABLE OF CONTENTS

Foreword.....	11
---------------	----

I. ISSUES OF USING THE BURYAT LANGUAGE

Gantogtokh G.,	Problems in using the Buryat Mongolian language and its trend.....	13
Battseren G.,	Studies of radio and television programs on ethnic Buryat Culture and Art.....	21
Bazarova Ts.B.,	About learning Buryat language to foreigners.....	23
Baljinyamaeva N.N.,		
Belousova M.Yu.,	The importance of the Internet in the developing of the Buryat language and in inheritance to young generation.....	27
Dondokova J. Ts.,	About periodicals on Buryat language in Ust-Orda Buryat District	34
Jamyan Sanjanov	To development of the lexico as a wealth of the Buryat language.....	37
Odmandakh M.,	On the improvement of television programs on Buryat language.....	45
Oyuntsetseg L.,	About MN-2 Program casting program on the Buryat language and its evaluation from the point of socio-cultural anthropology.....	48
Pataeva V.D.,	Situation of modern Buryat literature language.....	55
Khalkharova L.Ts.,	About TV program studios in the Buryat language.....	59
Tserendondog B.,	Not to say endangering Buryat language.....	62
Tserennadmid B.,	Situation for Buryat-Mongolian language in process of globalization.....	65
Erdenetsogt J.,	Methodical principles of preparing telecast program for national minorities.....	68
Erdeneeva A.D.,	On the ancient types of residential constructions.....	74

II. ARTICLES IN BURYAT STUDIES

Afanasieva E.F.,	Russian Evenkies.....	80
Аюшеевна Н.В.,	Contemporary news about Ts.Don.....	83
Budain B.B.,	Specialty of Zakamen buryat language dialect.....	89

Kuriganova I.A.,	Buryat traditional custom and habits to preserve the health since ancient times.....	95
Myadagmaa B.,	About Buryat traditions in the education of their children.....	102
Oyuntungalag A.,	Contribution of Buryat intellectuals in historical development of Education in Mongolia.....	106
Sambuu A.,	As genealogical record can affect human development.....	116
Tsedenjav D.,		
Pataeva B.D.,	Rituals and statements of Buryat shaman.....	126
Erdyneeva A.D.,	Etymology and semantics oikonyms of Buryat language.....	138

III. TRAVEL NOTES

Odmandakh M.,	In search of a stone “Bichigt Tsagaan chuluu”.....	149
---------------	--	-----

IV. TRANSLATIONS

Munkh-bat Nyamaev	Buryat-General of the river “Shiliin gol”.....	165
-------------------	--	-----

V. PORTRAIT AND NOTES

Gantogtokh G.,	Otoch lambugay L.Galbaabadraa of Western seven Buryats...	170
Badamnyam D.,	About the doctor Budzhavyn Sanzhmyatav or Sanzhmyatav Budazhapovich Tsybiktarov (1877-1921).....	180

VI. NEWS AND INFORMATION

Diary of a round table dedicated to the Day of the Buryat language	188
Yesterday, today and tomorrow of Buryat language.....	194
Issues of using the Buryat language.....	196
About Future of Buryat language.....	199

ӨМНӨТГӨЛ

Буриад судлалын академийн үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд тогтмолжиж, олон нийтийг хамарсан болон тусгай эрдэм шинжилгээний туурвилыг дор бүрнээ хийж ирлээ. Өнгөрсөн хугацаанд бид бүхэн цөөнгүй эрдэм шинжилгээний бага хурал, хэлэлцүүлэг, зөвлөлгөөнийг амжилттай зохион байгуулж, олон тооны илтгэл, өгүүллийг манай эрдэмтэд бичсэн байна.

2010 онд олон улсын “Алтаргана-2010” наадамд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг “Нүүдлийн соёл иргэншил ба буриад монголчууд” сэдвээр хийж, тусгай эмхтгэлийг хэвлүүлэн гаргаж олны хүртээл болгосноос гадна ОХУ-ын Буриад улсад тэмдэглэдэг “Буриад хэлний олон улсын өдөр”-ийг монгол улсад тогтмол зохион байгуулж, жил бүрийн 10-р сарын сүүлээр дугуй ширээний ярилцлага, хурал зөвлөлгөөнийг зохион байгуулж ирлээ. Энэ үеэр буриад хэл-аялгууны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг ярилцаж, хадгалан үлдэх, хөгжүүлэн дэлгэрүүлэхэд олон нийтийн оролцоо, буриад зон олны идэвх санаачлагын тухай ярилцаж, тодорхой санал санаачилгууд гарч, түүнийг хэрэгжүүлэх, ажил хэрэг болгохын төлөө багагүй чармайн ажиллаж байна.

Монгол оронд аж төрж буй буриад монголчуудынхаа өв соёлыг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах, шинжлэн судлахаар Хэнтий, Дорнод, Төв, Хөвсгөл аймгийн буриад сумдаар аялж, багагүй судалгааны эх хэрэглэгдэхүүнийг цуглуулж, судалгааны өгүүлэл, ном товхимлыг олны хүртээл болгов.

Буриад зон олны өв уламжлал, соёлыг хадгалан авч үлдэх, өвлүүлэн үлдээхэд ихээхэн хувь нэмэр болж байгаа нэг зүйл нь НҮБ-ын ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр МҮОНТ-ийн 2-р суваг нээгдэж, үндэсний цөөнх Казак, Тува, монголын эртний томоохон овог аймгийн нэг буриадын хэл соёлыг сурталчилан дэлгэрүүлэх зорилгоор нэвтрүүлэг бэлтгэн цацах болсон явдал юм. Хэдийгээр хүмүүст хүрч, олон нийтийн зүгээс сайшаалыг хүртэж байгаа ч зарим шүүмжлэлийг дагуулж, хэл аялгууны талаарх олон нийтийн бухимдлыг төрүүлж амжив. Энэ байдлыг засаж сайжруулахад манай академи тодорхой алхам хийж чадалгүй өдийг хүрсэн билээ.

Харин 2013 оны 11-р сарын 22-ны өдөр “Буриад хэл-аялгууны хэрэглээний асуулдалд” сэдэвт эрдэм шинжилгээ, онол-практикийн бага хурлыг зохион байгуулж, Монголын үндэсний олон нийтийн телевизийн MN2 сувгаар нэвтрүүлж буй буриад хэл-аялгуугаарх мэдээ мэдээллийн үнэ, цэнэ, түүнийг цаашид боловсронгуй болгоход голлон анхаарч, олон сайхан санал, санаачлага гарсныг бид хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж байна. Энэ нь тус телевизийн хамт олны ажлыг дэмжих, хамтран ажиллах, буриад хэл-аялгуугаарх нэвтрүүлгийн чанарыг сайжруулахад өөрсдийн хувь нэмрийг оруулахад чиглэгдсэн томоохон ажлын нэг байлаа.

Цаашид зөвхөн хэлний асуудлыг хөндөх биш нэвтрүүлгийн бодлогод чанарын шинэчлэл хийж, буриад зон түмний уламжлалт өв соёл, түүх дурсгал, зан заншлын тухай цуврал нэвтрүүлгийг бэлтгэх, өнөөгийн буриад түмний аж төрөл, удам судраа хадгалан үлдэж явааг тод томруун харуулсан бүтээлийг олон нийтийн хүртээл болгоход бид дэмжлэг болохыг хичээж байна.

Буриад судлалын эрдэм шинжилгээний сэтгүүлээ сүүлийн жилүүдэд хэвлүүлж амжаагүй боловч энэ удаагийн дугаарыг сүүлд зохион байгуулсан хурлын илтгэлүүдээс болон зарим судлаачдын буриад судлалын өгүүллүүдийг эмхтгэн та бүхний гарт хүргэж байна.

Удахгүй “Алтаргана-2014” наадам Хэнтий аймгийн Дадал суманд зохион байгуулагдахтай холбогдуулан “Буриад түмний Алтаргана наадам, түүний түүх, үр нөлөө” сэдэвт олон улсын хурлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Тус хурлаар Алтаргана наадмын түүхийг үнэн зөвөөр нь тодруулж, монголчуудын ухамсарт сэтгэлгээнд хэрхэн нөлөөлсөн, өнөөдрийн түвшинд олон улсын наадам болтлоо өргөжин тэлсэн бахархалт түүхийг бүтээлцсэн ахмад үе, орон нутгийн удирдлагуудын тухай тодруулан гаргах цаг нь нэгэнт болжээ. Ийм ажлыг хийхээр бид төлөвлөж байгаагийн хувьд өнгөрсөн хугацаанд хийсэн судалгааны бүтээлүүдээс дээжлэн та бүхэндээ толилуулж байна.

“Буриад хэл-аялгууны хэрэглээний асуудалд” сэдэвт хурлаар монголд буриад хэл-аялгуугаар нэвтрүүлж буй нэвтрүүлгийн хэл найруулга, чанар, чансааны тухай тусгайлан хэлэлцэж, олон сайхан саналууд гарсныг MN2 суваг телевизийн удирдлагууд нааштайгаар хүлээн авч, мэргэжлийн зүгээс болон бусад хамтын ажиллагаа өргөжиж эхэлснээр нэвтрүүлгийн тоо, чанар сайжирч, хүмүүсийн, үзэгч олны сэтгэлд ч нийцэж эхэлж байгаа нь бидний хамтын ажлын бодит үр дүн гарч эхэлж байгааг харуулж байна.

Гэвч цаашдаа хийх, сайжруулах ажил их байгааг мартах учиргүй. Өмнөх хэдэн жилд уг сэтгүүл маань завсарлаж, удсан тул нийтлэгдэж амжаагүй цөөнгүй өгүүллийг энэ удаа эмхлэн олны хүртээл болгож байна. Цаашид таслалгүй улам сайжруулах зорилго тавин ажиллана.

Эрдмийн цагаан хаяа биднийг үүрд түших болтугай.

Буриад судлалын академийн ерөнхийлөгч,
доктор **М.Одмандах**

*Хөх морин жилийн хаврын тэргүүн сарын шинийн
9-ны билэгт сайн өдөр.*

Нэг. БУРИАД ХЭЛ-АЯЛГУУНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД

Гончигийн Гантогтох,


Доктор Sc.D Проф.

МУИС, Монгол Хэл Соёлын Сургууль

МОНГОЛ УЛС ДАХЬ БУРИАД ХЭЛ-АЯЛГУУНЫ ХЭРЭГЛЭЭ, ХАНДЛАГА


Монгол улсын нутаг дэвсгэр дээр монгол, түрэг хэл үндсэн харилцааны хэрэглүүр болдог. Түрэг хэл нь казах, тува хэл, алтайн хэлний нийтлэг зүй тогтлоороо монгол түмэнтэйгээ олон зууны туршид аж төрж, харилцаж хэвшжээ.

Монгол хэл нь эргэн тойрон монгол үндэстнийхээ дунд орших хүй хэлхээ, холбоотой бөгөөд монгол улсад монгол төрлийн хэлний төлөөлөл бүрэн бий. Буриад аялгуу нь буриад хэлний төлөөлөл болж монгол улсад өргөн хэрэглэгдэж байна.



БУРИАД АЯЛГУУ

Монгол улсын Дорнод, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгийн нутагт буриад аялгуугаар ярилцагчид оршин суудаг. Дорнод аймгийн буриад зон Агын аман аялгуугаар ярилцах ба Хэнтий аймгийн буриад зон Хорийн аялгуугаар, Төв,



Тайлбар. 1977-2001 оны хооронд Монгол улсын ШУА-ийн ХЗХ-ийн судлаач Ж.Цолоо, Г.Гантогтох нарын Монгол улсын буриад аялгуу, аман зохиол судалсан хээрийн шинжилгээний ангийн замын сүлжээ

Санагын
аман
аялгуу

Сонгоол
аман
аялгуу

Түнхэний
аман аялгуу

**ХОРИЙН
АМАН
АЯЛГУУ**


Ага аман
аялгуу

Барга аман
аялгуу

Хамниган
аман
аялгуу

БУРИАД АЯЛГУУНЫ ХҮЙ ХЭЛХЭЭ

Монгол улсын буриад зон Оросын холбооны улсын буриад монголчуудтай болон БНХАУ-ын Хөлөнбуйр аймгийн барга буриадтайгаа хэл аялгуу, сэтгэлгээ, хэв заншил, шашин мөргөл, ахуй амьдрал, аж төрөл, үүх түүхээрээ хүйн хэлхээ холбоотой.



ТОЛЬ БИЧГИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

“Буриад аялгууны толь бичиг”-ийг 1977 оноос 2011 он хүртэл хугацаанд судлан сурвалжилж, эмхлэн боловсруулж амьд аман аялгууны хэрэглээг түшиглэн зохиож, найруулсан билээ. Хэрэглэгдэхүүнийг дурдвал:

- ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн шинжилгээний ангийн хэрэглэгдэхүүн
- ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн шинжилгээний албан томилолтын хэрэглэгдэхүүн
- Бөө мөргөлийн хэрэглэгдэхүүн
- Аман зохиолын төрөл зүйлийн хэрэглэгдэхүүн
- Угсаатны зүйн хэрэглэгдэхүүн

- Орон нутгийг судлах музейн хэрэглэгдэхүүн
- Эд өлгийн хэрэглэгдэхүүн
- Ахуй амьдрал, аж төрлийн хэрэглэгдэхүүн
- Мал маллагааны арга ажиллагаа

БНМАУ-ын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс удаа дараалан томилсон шинжилгээний ангийн хэрэглэгдэхүүн, албан томилолтын тайлан зэрэгт түшиглэн БНМАУ-ын нутгийн аялгууны толь бичиг (Буриад аялгуу) III боть, Улаанбаатар, 1988 он, 1629-2503 (редактор Н.Шарав-Иш, техник редактор хийж хэвлэлийн эх бэлтгэсэн М.Алтанцэцэг, Ч.Куланда нар, зохиогч Г.Гантогтох, Сөүл хотод фото зургийн аргаар 100 хувь хэвлүүлсэн билээ, 5550 толгой үгтэй нутгийн аялгууны толь бичиг)-ийг хэвлэгдэхээс нь өмнө ЗХУ-ын (хуучин нэрээр) ШУА-ийн Хэлшинжлэлийн Хүрээлэнгийн Түрэг монгол хэлний сектор, Дорно дахины судлах хүрээлэнгийн Түрэг монгол хэлний секторын салбарын буриадын филиалын хүндэт эрдэмтэн доктор А.А.Дарбеева, Г.Ц.Пюрбеев, М.Н.Орловская, З.В.Шевернина, ЗХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын буриадын филиалын хүндэт эрдэмтэн доктор В.И.Рассадин, Л.Д.Шагдаров, Ц.Б.Будаев, Д.Г.Дамдинов, БНУАУ-ын нэрт монголч эрдэмтэн доктор Дорж Кара багш нар уншиж, харамгүй зөвлөмж, санал бичиж өгч байсан юм.

Толь бичгийн арга зүй

- Буриад нутгийн аялгуу, угсаа сэтгэц хэл шинжлэлийн толь бичиг
- Толгой үг (20000) – кирилл, латин галиг үсгээр
- Буриад аялгууны өвөрмөц дуудлага, хэлбэр, үгийн сангийн онцлог бүхий толгой үгийг сонгон авсан
- Аман аялгуу тус бүрийн нийтлэг хийгээд өвөрмөц толгой үгийг сонгон оруулж, аль аялгуу болохыг нь заасан
- Монгол утга зохиолын хэлээр хөрвүүлсэн
- Толгой үгийн шилжмэл утга бүхэнд орос хэлээр хадмал орчуулга хийсэн

Жишээ нь:

haapi/ hāfi (Khorī., Aga., Tunk., San., Bar.), sāfi (Tson., Kham.) 1. саарь: цыпки; hārmāē degeltē hāfi γarṭāē сармай дээлтэй саарин гармай (ШАХ); 2. сайр сайн, хамгийн сайн: самый, лучший, первосортный; hāriṅ γutul сайран гутал; hāfi torṅon сайр торго; toxom gūlime хойуṅin torṅonōē hāfi belēl тохом гөлөм хоёр минь торгоны сайр билээ. (БАД); 3. тачигнасан хүйтэн: пора самых холодных хусов; ūgelē toṅ yēxe žābarṭāē xahāēyē hāfi žābar gelsexe өвлийн тун их жавартай үеийг тачигнасан хүйтэн гэлцдэг; hāfi xūitende malā šūyūi sō orūlžā, buryāha otolžō ūgdeg тачигнасан хүйтэнд малаа шугуй дунд оруулж, бургас цавчиж өгдөг; // Mo. sayari

- Аман аялгуунд авиа зүй, үг бүтэх ёс, үгийн сангийн талаар төлөөлөх холбоо үг хоршоо үг нийлэмж үг заншилт үг хэллэгийг сонгон оруулсан
- Буриад амьд ярианы хэлц хэллэгийг оруулж, галиг үсгээр тэмдэглэж нийцэт утгаар нь хөрвүүлсэн

Жишээ нь:

- Ямар эх хэрэглэгдэхүүнээс ишлэж авснаа товчилсон үсгээр заасан
- Нутгийн аялгууны мэдээлэгчдийг хавсралт болгон оруулсан

Ном зүй

- Буриад аялгууны толь бичгүүд
- Буриад хэл аялгууны судлалын сурвалжууд
- Буриад аялгууны үгийн сангийн хэрэглэгдэхүүн зэргийн 100 гаруй бүтээлийг ашигласан ном зүй хавсаргасан

ТОЛЬ БИЧГИЙН ШИНЭЛЭГ ТАЛ

1. Буриад нутгийн аялгууны өргөн хүрээтэй толь бичиг
2. Угсаа сэтгэц хэл шинжлэлийн зориулалттай толь бичиг
3. Буриад аялгууны үгийн нийцэт утгыг хөрвүүлэхдээ, утгын хэрэглээний өнгө аясыг холбоо үгээр тодруулж илэрхийлсэн.
4. Буриад зоны өвөрмөц сэтгэлгээ бүхий бууза мушхаха (бууз чимхэх), шарха уяха (шарх боох), хүхэ далайтар гозуули амар (сүх далайтал үхэр амар) гэх мэт үг хэллэгийг зэргэцүүлж үзүүлсэн

5. Буриад зоны аж төрөх зан үйлийн үг хэллэг, өвөрмөц хэлц, төрт ёсны зан үйлийн үг хэллэг, мөргөл

залбирал шашны ёсны зан үйлийн үг хэллэг, хэлцийг хэлэх тохиолдол, болох нөхцөл, аль нутагт яаж хэлдгийг аман зохиолын хийгээд аман

дабталаа/ *daḅtālā* (Khorī., Aga., Tson., Tunk., San.) *давтмал ир, давтлаа: острие косы после отбития;* *xažūrāē ēfīyē* *xažūhāni alxār hāēsa daḅtāzā nimgelhēni* *daḅtālā gexe, daḅtālā γaryaxadā alxārā ende* *tende sōxingūi, xažūrāē āgtāē talahān* *žēgdexen nanšāhār, ūzūr xūrterin ūldēzē* *ōēro ōēroxon žēnyēnehen dūyīn tahalyārā-* *gūigēr daḅtadag yūme* *өвсний хадуурын ирийг хажуугаас нь алхаар сайн давтаж нимгэлснийг давтмал ир гэнэ, давтлаа гаргахдаа алхаараа энд тэнд цохилгүй, хадуурын аагтай талаас нь жигдхэн балбасаар үзүүр хүртэл нь хөөж ойр ойрхон жингэнэсэн дууг нь таслалгүйгээр давтдаг юм. (БДЗ)*

шэрээдэһэ(н)/ *šērēdehe(ᠨ)* (Aga., Khorī.) *ширээдэс: металлические искры (при ковке);* *šērēdehetēlē ulān γalāē᠋ᠭāla ḅnīn* *dēren busalyahan, šērem tūmūr toγōnōē᠋ᠭō* *᠋ᠣxin dēren busalyahan ādar sayā᠋ᠨ uγālā yūhe* *domno᠋ᠭ hamarnab* *ширээдэстэй л улаан галынхаа л дөлөн дээр нь буцалгасан, хүрэл төмөр тогооныхоо охин дээр буцалгасан аадар цагаан угаалаа ес домнон самарнам. (БМД); // Mo. sirigedesū*

аялгууны амьд баримтаас авч оруулсныг дээрх жишээнээс үлгэрлэж үзнэ үү.

ТОЛЬ БИЧГИЙН ХЭРЭГЛЭЭ

1. Буриадын зоны хэл, соёл, зан заншил, өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэхэд
2. Буриад хэл зааж сургахад
3. Буриад хэлний хэрэглээг өргөтгөхөд
4. Монгол төрлийн хэлний хөрвүүлгэнд
5. Монгол хэлний нутгийн аялгууны судлалд
6. Угсаа сэтгэц хэл шинжлэлийн судлалд
7. Угсаатны зүйн судлалд
8. Хүн судлалд
9. Аман зохиол судлалд
10. Монгол судлалд
11. Монгол хэлний сурвалж бичгийн судлалд
12. Дундад эртний хийгээд эртний монгол хэлний судлалд
13. Дэлхийн эрсдэж буй хэлийг хамгаалахад
14. Буриад хэлтэй ард түмний харилцаанд

MN-2 ТВ СУВГИЙН БУРИАД НЭВТРҮҮЛЭГ

MN2 тв сувгийн буриад хэлээр явуулж байгаа нэвтрүүлэг нь буриад зоны хэл аялгууны хэв загварыг олон түмэнд таниулж, түрэг төрлийн хэлээр нэвтрүүлж байгаа мэдээг монгол хэлний буриад аялгуугаар хөрвүүлж олон түмний сонорт хүргэж байгаа нь буянтай, буриад хэл аялгууг түгээх нэгэн сэжим болж дэлхийн сонорт хүргэж өгдөг буриад хэл аялгууны гүүр болж байна. Энэ нь сайшаалтай хэрэг. Гэвч авианы түвшинд, аялгын түвшинд буриад хэл аялгууг дамжуулж байгаа нь учир дутагдалтай боловч цаашид гүнзгийрүүлэн боловсруулж, буриад хэл аялгууны хэлзүй, утгазүй, хэв заншил, заншилт хэллэг, буриад үгийн сангийн үгээр мөн тэрчлэн хэвшмэл тогтсон үг хэллэгийг дэлгэрүүлэх шаардлага байгаа юм.

- ✓ Түрэг төрлийн хэл аялгууг Монгол хэлээр Буриад аялгуугаар хөрвүүлэн нэвтрүүлж байгаа нь нэвтрүүлгийн агуулгыг таниулах хүртээмжтэй.
- ✓ Халх Монгол аялгууг авианы зүй тогтлын дагуу Буриад аялгуугаар хөрвүүлж байгаа нь зохистой боловч Буриад үгийн сан, заншилт хэллэгийн талаар дутагдалтай.
- ✓ MN-2 ТВ сувгаар мэдээнээс гадна тусгай нэвтрүүлгийг жинхэнэ Буриад хэл аялгуутай зоноор яриулж, хөөрөлдөөн зохион байгуулбал үр өгөөжтэй болно.

ТАХИЛ ТАЙЛГЫН ЗАН ҮЙЛ

Тэнгэрийн сүлдэр хэмээх буриад бөөгийн холбоо буриад хэл аялгууг дэлгэрүүлэх талаар олон бөө нарын хүчийг зохион байгуулж, жил бүхэн тахилга, тайллага үйлддэг сайхан заншилтай. Үүнээс үлгэр авч буриад түмний зан үйлийг

үйлдэж, соёлын өвийг дамжуулан хөгжүүлэх, хойч үед хүргэхэд үлгэр жишээ болохуйц үйлдэл мөн учир нутаг нутагт дэлгэрүүлэхийг уриалж байна. Тухайлбал,

- ✓ Шувууны даллагын зан үйл
- ✓ Гал тахилгын зан үйл
- ✓ Буриад бөөгийн чанар хийх зан үйл
- ✓ Туульс хайлах зан үйл
- ✓ Чандруу нэрэх зан үйл

зэргийг ном горим, уламжлалын дагуу үйлдэж, олон түмэнд хүргэх нь чухал байна. Тэгэхдээ бие биенээ дууриалгүй нутаг нутгийнхаа хэв заншлыг хадгалах учиртай. Жишээ нь, буриад дээл хувцас гэхэд заавал хори, агын буриадын өмсдөг дээл хувцасыг бүх буриад түмэнд түгээнэ гэвэл уламжлал биш дууриамал болж, нутаг нутгийн өвөрмөц нандин соёлын өв мартагдаж хоцрох тул ялангуяа, баруун буриад зон минж, булга, суусар, гөрөөсний арьсан дах хэмээх өмсгөлөө сэргээж, бутын чинээн залаатай булган хийсгүүр малгайгаа гөрөөсний арьсан годоһон гутлаа өмсвөл зүйд нийцтэй болох мэт.

Цаашид буриад хэл аялгууг хөгжүүлж, түгээн дэлгэрүүлэх арга хэлбэрүүд:

1. Буриад нутгийн аялгууны толийг юун түрүүнд улс улсдаа нутаг нутгийн аман аялгуугаар цэгцэлж гаргах. Энэ нь ОХУ-ын Эрхүү буюу баруун буриад аман аялгууны толь, Буриад улс буюу хори буриадын салбар аман аялгууны толь бичиг, БНХАУ-ын Хөлөнбуйр аймгийн Шинэхээний буриад, барга буриад аман аялгууны толь бичиг гэх зэргээр тусгайлан гаргаад дараа нь буриадын аман аялгууны иж бүрэн толь бичиг хэвлүүлэх нь чухал байна,
2. Олон нийтэд зориулан буриад хэл аялгуугаар нэвтрүүлэг бэлтгэж явуулахдаа унаган буриад хэлтэй, буриад хэв заншилаа хадгалсан, буриад ахуйгаа таниулах амьд яриаг сурталчилан таниулахад чиглэгдсэн сурвалжлага авч нийтэд түгээх,
3. Цахим сүлжээг сайтар ашиглаж, мартагдаж байгаа соёлын биет бус өвийг хадгалж, түгээн дэлгэрүүлэхэд анхаарах. Тухайлбал, аман зохиолын эх хэрэглэгдэхүүн, аж төрлийн, бүр тодорхой хэлбэл, арьс, нэхий элдэх, утах, эд хэрэглэгдэхүүн хийх технологийг зааж, нийтэд түгээх. Аман зохиолын хэрэглэгдэхүүнээс хэрэглээний хэв заншил, зан үйлийн хэрэглэгдэхүүнийг үзүүлэх, жишээлбэл, хүүхдийн даахь үргээх, тоонто тайх, өлгий мялаах, бэр эрэх гэх мэт.
4. Буриад хэл аялгууны сургалтын хөтөлбөрийг боловсруулж, орчин үеийн цахим сургалтын сүлжээнд оруулж, нийтлэж байгаа туршлагыг гүнзгийрүүлэн улам боловсронгуй болгож, хэрэглээ, харилцаа талаас нь бодитой үзүүлбэр болгож үзүүлэх. Жишээ нь, сагаалганы зан үйл, тэнгэр, индэрт мөргөх, золгох, мэндлэх хүндлэх ёс, суудал горим, зоог шүүс барих, битүүлэх, шинэлэх, малын хишиг буяныг хурайлж бэлчээр залах,

насан хутгийн өлзий оршоох зан үйл, хаврын баярын уур амьсгалыг таниулах зан үйл, хэлц хэллэг, хайр энэрэлийн харьцааг илэрхийлэх өгүүлэмж, зан үйл, тоглоом наадгай, наадмын зан үйлийн олон хувилбаруудыг бодит байдлаар хичээл болгож үзүүлэх.

5. Буриад хэл аялгууг эзэмшсэн түвшин тогтоох тест, сорил боловсруулах. Энэ нь төрөл бүрийн түвшинг тодорхойлоход чиглэгдсэн байна. Жишээ нь, анхан шатны түвшинд авианы сэлгээ, тохироог бүрдүүлэх, дунд шатны түвшинд хэлзүйн хэлбэржилийг үндэс болгож буриад монгол хэлний бүтцийг эзэмшсэн байх, ахисан түвшинд буриад нутгийн аялгууны буюу буриад хэлний өвөрмөц хийгээд заншилт үг хэллэгийг эзэмшсэн байдлыг тодорхойлох сорилууд болно.
6. Улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, тодорхой сэдвээр дугуй ширээний ярилцлага, эрдэм шинжилгээний хурал, семинарыг тогтмол явуулж харилцан мэдээлж байх.
7. Буриад зоны Алтаргана наадам, Ёохор наадам тэргүүтэн олон улсын чанартай болсон наадмыг зохион байгуулахын өмнө оролцогч талууд урьдчилсан бэлтгэлээ сайн хангаж, урьд урьд жилийнхээ үзүүлбэрийг аль болохоор давтахгүй байхыг хичээх хэрэгтэй байна.
8. Өсвөр насны хүүхдийг аль болохоор оролцуулж идэвхтэй сургах үйл ажиллагааг хөгжүүлж, хөхүүлэн дэмжих. Ялангуяа, наадмын гол шалгаруулалтанд тогтмол ордог, хүүхдийн үзүүлбэрийг үндсэн шалгуур болгож үзүүлдэг байхад анхаарах.
9. Буриад хэлээр хэвлүүлэх ном зохиолыг олшруулж, зөвхөн номоор зогсохгүй янз бүрийн бичлэг, CD, DVD, богино хэмжээний кино, ялангуяа баримтат кино, клип, дуу хөгжмийн бичвэрүүдийг асар олноор дэлгэрүүлэх. Ялангуяа, буриад сумдад буюу Буриад улсад явж байгаа тээврийн хэрэгсэлд байрлуулж, сонсгож байх.
10. Монгол бичгээ ерөнхий боловсролын сургуулиудад чанартай зааж, буриад сумдын сургуулиудад буриад аялгуугаар дуудуулж уншуулах, буриад хэл аялгууны харилцааны хэрэглүүр болгон хэрэглэхийг бодлогоор дэмжих зэрэг олон ажлыг хийж амжуулах буриад хэл аялгууны хэрэглээг дэлгэрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болно.

Г.Батцэрэн

СУИС-ийн багш, доктор, дэд профессор

РАДИО ТЕЛЕВИЗЭЭР НЭВТРҮҮЛЖ БУЙ БУРИАД ЯСТНЫ СОЁЛ УРЛАГИЙН ТАЛААРХИ САНАЛ, БОДОЛ, СУДАЛГАА

Энэхүү сэдвийг хөндөхийн тулд олон хүнтэй уулзаж, санал бодлыг нь сонсож нэвтрүүлгийн судалгаа хийхийг зорилоо.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 30% нь хангалттай, 70% нь хангалтгүй гэсэн үнэлгээ саналыг өглөө.

Энэ гарсан саналыг хоёр талтай гэж бодож байна.

Нэгдүгээрт: Бүх радио телевизүүд Монголын 20-иод ястан, үндэстнээс нэг ястныг онцлон байнгын нэвтрүүлэг бэлтгэх бодлогыг баримтлахгүй тэгш нэвтрүүлэг бэлтгэх бодлогыг баримтлах нь зүйн хэрэг. Гэхдээ бид энэ боломжийг алдахгүй ашиглах хэрэгтэй байна.

Буриад ардын соёл урлагийн уламжлал, шинэчлэлийн нэвтрүүлгийг Буриад, Казак, Тува хэл дээр түүх, хэл соёлын нэвтрүүлэг бэлтгэдэг MN-2 телевизийн сувагтай нягт холбоотой, ажлын төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай байна. Монголд нийт 166 телевиз үйл ажиллагаа явуулж байна. Хөтлөгч, нэвтрүүлэгчийн хэлний асуудал хүндхэн байгаа боловч Монголын буриадууд бид бүгд хэлний асуудал энэ хэмжээнд байгаа шүү дээ. Хэлний асуудал Монголын бүх буриадуудад хүнд асуудал хэвээр байна.

Буриад сумдын сургууль, цэцэрлэгүүдэд БШУЯамтай хамтран “Буриад хэл аялгуу, түүх, зан заншлын сэдэвчилсэн төлөвлөгөөтэй цөөхөн цагийн атугай хичээл оруулдаг болох саналыг оруулж байна. БШУЯамтай Буриад Судлалын Академи хариуцан саналаа оруулж шийдвэрлүүлэх. Буриадын зан заншил, соёл, хэлний сургалтыг Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад танхим болон телевизээр сургалтуудыг явуулах. Буриад хэлний сургалтыг хэлний эрдэмтдээр бичлэг хийж телевиз, цахим хэлбэрээр явуулж болох юм.

“Алтаргана” наадмуудын үйл ажиллагаанаас дүгнэлт хийхэд залуу үе маань ардын дууг буриад хэллэгээрээ дуулчихаж байгаа ч ярианы хэллэгээр ярихаас ичдэг, нэрэлхүү байдал ажиглагддаг. Энэ нь 1930-аад оны хэлмэгдүүлэлттэй холбоотой авч энэ бодлоос аль болох хурдан ангижрах хэрэгтэй байна. Би буриад хүн гэдгээрээ омогшиж буриад хэлээрээ айж эмээлгүй харилцан ярьдаг болох.

Мөн “Алтаргана” наадмын үйл ажиллагааг номинаци бүрээр нь дэлгэрэнгүй бичиж, БӨСХСан фонд-доо авах, үе шаттайгаар нэвтрүүлэх. Энэ ажлыг БӨСХСан хариуцаж Телевизүүдтэй гэрээ байгуулж ажиллах. Үүний тулд Телевизүүдийн жилийн төлөвлөгөөнд тусгаж оруулах.

Одоогоор “Алтаргана” наадмын үйл ажиллагаа мэдээ мэдээллийн журмаар нэвтрүүлэхээс бус тухайн телевизийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй тул эфирийн цаг хомс байх нь дамжиггүй.

БӨСХСан жилийн төлөвлөгөөндөө Телевизүүдтэй хамтран Буриад ахуй зан заншлын сэдвүүдээр нэвтрүүлгүүд бэлтгэхээр тусгаж ажиллах. Монголын буриад сурын холбоо ч энд хамрагдана.

Буриадудын сэдэвтэй цөөхөн уран сайхны кино байдаг боловч киноны дүрүүд бүгд Монгол халх аялгуун дээр яригддаг, дуулдаг. Цаана нь буриад хөгжмийн аялгуу эгшиглэж байдаг. Жишээ нь: Таван жилийн өмнө зохиогдсон “Мойлхон” киноны дүрүүдийн хэллэгийг буриад хэл дээр хөрвүүлэх талаар олон хүний саналууд ирж байна. Үүнийг хэрхэн шийдвэрлэх, зохиолч, найруулагч, хөгжмийн зохиолчидтай нь санал солилцох – БӨСХСан, Буриад Судлалын Академи.

Буриад ардын ахуй, зан заншил, соёл урлагийн нэвтрүүлгүүдийг төлөвлөн график гарган үе шаттай нэвтрүүлгүүдийг бэлтгэн явуулах. Юуны өмнө хэлний асуудал... Хэл сургалтыг системчилэн явуулах. Сургалтыг явуулах асуудлыг БШУЯ-тай нэн яаралтай шийдвэрлүүлэх. Сургалт явуулахдаа танхимийн сургалт байвал нэн сайн. Түүх, хэл, зан заншлын нэвтрүүлгүүдийн цаг одоохондоо түлхүү байх санал оруулж байна.

Нэвтрүүлгүүд хэрхэн үүсэх нь БӨСХС, БСАкадеми бусад байгууллагуудын телевизүүдтэй төлөвлөгөөтэй, гэрээ байгуулснаар цаашид үргэлжлэх болно.

Буриад ардын дууны хувьд нутаг нутгийн аялуу байхаас гадна Хори, Ага нутгийн аялгууг түгээмэл дэлгэрүүлэх. Миний бодлоор одоогийн байдлаар Барга, Хамниган, Сонгоол хүмүүс буриад аялгуунд оруулан аялгууны хугалаа нугалаа өөрчилэх хэлбэр ажиглагдах боллоо. Энэ нь буруу биш боловч буриад ардын дууны нугалаа хугалааг сургах нь зөв болов уу гэж бодогдож байна.

Уучлаарай, хамт амьдарч ирсэн Барга, Хамниган, Сонгоол хүмүүсээ тэгж дуугарсан биш нийгмийн асуудал байжээ гэсэн ойлголт надад төрдөг. БНХАУ-ын Хөлөнбуйр аймгийн Эвенк хошууны зон олон 20-оид ястан ихэнхи нь буриад хэлээр ярьдаг юм билээ. Иймд бидний хэл соёлын асуудал нийтлэг болжээ. Иймд бид буриад гэсэн хэл соёлоо авч үлдэх нь хамгийн чухал асуудал.

Соёл урлагийн нийгэмд гүйцэтгэж буй үүрэг орчин үед улам өсөж, улс үндэстэн бүр өөрийнхөө онцлогийг хадгалан орших, хөгжин дэвжих үндэс нь соёл урлаг болж байна. Соёл урлаг энэ агуулгаараа Монгол улсад иргэний ардчилсан нийгмийг төлөвшүүлэн бэхжүүлэхэд, залуу хойч үеийг хүмүүжүүлэн хөгжүүлэхэд, монгол үндэстэн даяаршлын эрин зуунд бусдаас ялгаран тодрон оршиход онцгой чухал байр суурийг эзэлнэ.

BURIAD STUDIES

IV Боть

№4 (004)

2014

*Бодонгууд угай **Базарова Ц.Б.**,
хэлэ бэшэгэй эрдэмэй кандидат,
Түбэй хотын номой сан,
Улаан-Үдэ хото, Росси.*

ХАРИ ГҮРЭНЭЙ ЭРХЭТЭДТЭ БУРЯАД ХЭЛЭ ЗААЛГА ТУХАЙ

*Эхэ буряад хэлэмнай...
Арюун тунгалаг...
Булаг мэтэ дууһашагүй...
Эдэ хайхан мүнүүд манай түрэл хэлэн тухай.*

Манай буряад хэлээр һонирхоод, зорюута үзэхээс Америкһээ, Англиһаа, Румыниһаа, Финляндиһаа аспирантнууд, дээдэ зиндаатай эрдэмтэд ердэг. Буряадай гүрэнэй университетэй Үндэһэтэнэй гуманитарна институтда буряад хэлэ оролдосотойгоор үзөөд, тордиһогүйгөөр хэлэдэг болоод ошодог юм. Ганса хэлэ үзэдэг бэшэ, баһа буряад арадай түүхэ, ажабайдал, ёһо заншал, аман болон уран зохеол үзэнэ.

2000 онһоо эхилжэ, Буряад орон буряад хэлэ үзэхэ гэжэ зорюута ерэнэн хари гүрэнэй эрхэтэдтэ буряад хэлэ заагаабы.

Нэн түрүүн Финляндиһаа буряад хэлээр һонирхожо, үзэхэ, шудалха гэжэ зорюута манай нютаг ерэнэн, мэргэжэлээрээ тоо бодолгын багша **Арья Халттунен** болоно. Буряад, монгол хэлэнуудые шэнжэлһэн мэдээжэ финн эрдэмтэд Матиас Александр Кастрен, Густав Йон Рамстедт тухай мэдэхэ, буряад хэлэн финн хэлэнтэй олон талаараа дүтэрхы гэжэ мэдээ. Арья англи, немец, швед хэлэ мэдэхэ, энээнһээ гадна ород хэлэ Санкт-Петербургда, буряад хэлэ Улаан-Үдэдэ шудалаа. Агын тойрогой «Толон» гэжэ сониндо «Абьяас ехэтэй Арья тухай» гэжэ статья соогоо Арья буряадаар бэрхээр хэлэнэ, буряад хэлэниинь баян гэжэ сурбалжалагша тэмдэглэнэ.

«Баян даа буряад хэлэн» гэнэн буряад бэшэ, ондоо яһатануудай дунда үнгэргэгдэдэг республиканска фестиваль-олимпиадада 2012 ондо түрүү һуури эзэлһэн финн яһатан **Анитта Лепомаа** буряад хэлэ шудалалгада ундэр амжалта туйлаа гэхэдэ болоно. «Буряад хэлэн ехэ баян, гое, гүнзэгы. Би ехэ дуратайгаар тэрэниие үзэнэб. Жэлһээ жэлдэ буряад хэлээс мүлинэб. Ямаршые яһатан өөрын

хэлэтэй. Түрэл хэлээ судалыг»,- гэж финн яһанай Анитта Лепомаа буряадуудта хандан хэлээ. Тэрэ англи, швед, ород, буряад хэлэнүүдые эрхимээр мэдэхэ, түрэл финн хэлээ мэдээ аабдаа. Буряад хэлэн дээрэ эрдэмтэ элидхэл хэдэг. «Финн ба буряад хэлэнүүдэй параллельнүүд тухай» гэжэ статья «Бурятский язык и культура в условиях глобализации» гэжэ суглуулбарид Улаан-Үдэдэ 2005 ондо хэблээ. Буряад хэлэнэй үдэрнуудтэ хабаадажа, зарим буряадуудта жэшээ харуулдаг. 2012 ондо Түбэй хотын номой сан болон «Мир-Бурятия» гэжэ телекомпаниин суг проектээр буряад хэлэн дээрэ «Теледиктант на бурятском языке» гэжэ интернедээр бэшэхэ арга дурадхаабди. Анитта эндэ ехэ бэрхээр диктант бэшээд эльгээгээ. Мүнөө жэлшье октябрийн 16-нда Түбэй хотын номой сангай урилгаар Октябрьска районой 47 ажаһуугшад буряадаараа диктант бэшэжэ, мэдэсээ шалгаа. Элдэб наһанай (18-һаа 76 наһа хүрэтэр), элдэб мэргэжэлтэй эдэбхитэйшүүл сугларжа бэшэбэ. Анитта Лепома мүнөө жэлшье баһа найнаар бэшээ, жюри Аниттын найнаар бэшэһыень онсо тэмдэглээ. Буряад номуудые, «Буряад үнэн» сонин, «Байгал» журнал захил хэжэ уншадаг. Анитта Түнхэн нютагһаа уг гарбалтай буряад хүндэ хадамда гаража, эбтэй эетэй бүлэ болоо.

Америкын Холбоото Штадуудай Чикагска университетэй докторант, антрополог мэргэжэлтэй **Джастин Бак Кихадо** Буряад орон ерэжэ, буряад хэлэ шудалаа. Буряад Республикын радиодо буряадаар өөр тухайгаа, буряад хэлэн тухай хөөрөжэ, шагнагшадай һонирхол татаа бэлэй. Манай Буряад ороной шажан мүргэл тухай һонин шэнжэлгэ хээд, амжалтатайгаар докторско диссертацияа хамгаалаа. 2012 ондо Америкын академическэ этнологиин журналда хамба-лама Даши-Доржо Этигылов тухай статья бэшээ.

Америкын Холбоото Штадуудай Мичиганска университетэй докторант **Кэтрин Грэбер** Буряад Республикын сонинуудые уншажа, статьянуудай хэлэ шэнжэлээд, докторско диссертацияа хамгаалаа. Буряадаар бэрхээр хэлэдэг болоо, буряад хэлэн дээрэ эрдэмтэ статья бэшэжэ толилуулаа, элидхэл хээ. «Америкын Холбоото Штадуудта буряад ба монгол шудлал» гэжэ статьянь «Бурятский язык: исторические судьбы и современность» гэжэ суглуулбари соо хэблэгдэнхэй. (Улаан-Үдэ, 2009 он). Кэтрин тухай теле болон радио дамжуулганууд гараһан юм. «Ариг Ус» телекомпаниин «Мүнгэн сэргэ» гэжэ теле дамжуулгаһаа багахан хэһэг харабал, эндэ Кэтрин буряадаар ехэ найнаар хөөрэнэ, «Түрүүшын дуран» гэжэ дуу дуулана, үрээл хэлэнэ.

2006 ондо дэлхэй дээрэ суута Гарвардска университетэй магистр **Кристиан Пакорд** БГУ-да буряад хэлэ шудалаа. Мэргэжэлээрээ политолог.

Залуу хүбүүн, ехэл оролдосотой. Оро асуудалнуудай дайралдабал, тэрэнээ заабол ойлгожо абахые хүсэдэг. Жэшэнь, ерэнхаар гэжэ үйлэ үгэдэ залгалтадань юундэ удаан –а- бэшэ, удаан –а- бэ? Аялгануудай тааралдалай дүрим эбдэгдэнэ бэшэ гү г.м. «Буряад Үнэн», «Бурятия» сонинуудта интервью үгөө.

Английн эрдэмэй доктор **Джозеф Лонг** Германиин Макс Планкын социальна антропологиин институтнаа эльгээгдэжэ, буряад хэлэ шудалаа. Мэдээжэ Кембриджскэ университеттэ магистратура дүүргэһэн,

Джозеф Эрхуугэй можодо буряад арадай аман зохеол шэнжэлһэн, эрдэмтэ шэнжэлгэ хэһэн.

Буряад хэлэ үзэжэ байһан шабинараа манай факультедэй, институтдай оюутадтай уулзуулжа, буряадаар түрэл оронойнь дунда, дээдэ хургуули тухай, монгол хэлэнүүдые шэнжэлдэг эрдэмтэд тухай хөөрүүлдэг байгаабди. Джозеф Лонг 35-дахи дунда хургуулиин шабинартай уулзаа, буряад хэлэнэйнгээ мэдэсэ харуулаа.

Америкын Холбоото Штатуудай эрдэмэй доктор **Роберт Монтгомери** үнийнэй буряад хэлэ шудална. 1991 ондо түрүүшинхисэ Улаан –Үдэ ерээ. 2005 ондо США-даа англи хэлэн дээрэ манай буряад хэлэн, түүхэ, соёл тухай ехэ сэнтэй, гүнзэгы удхатай ном хэблүүлээ. Номой оролто статья соогоо иигэжэ бэшэһэнийнь найшаалтай:

Буряад арад зоной хэлэн ба соёл ходо мандтугай!

2012 ондо ерэхэдээ, буряад хэлэнэй грамматика ойлгохо гэжэ оролддоо.Энэ ехэ эрдэмтэй, монгол шудалагшадай дунда мэдээжэ, хүндэтэй хүн. Буряад хэлэ хэр зэргэ мэдэнэ гэшэб гэжэ Буряадай радиогой дамжуулга шагнабалнай, сэбэр буряадаар Буряад орон, Улаан-Үдэ хото, буряад хэлэн тухай хайса бэрхээр хөөрэнэ.Хадата Аха нютагһаа гарбалтай наһанайнгаа нүхэр Ешин-Хорло, 15-тай Энхэ Туяа гэжэ басаган тухайгаа баһа илдамаар сурбалжалагшын асуудалда харюусана.

Энэ элидхэл соо бүхы шабинар тухай хөөрэгдэбэгүй. Оролдосотой, бэлигтэй үшөө шабинар бии, эдэ Америкын түүхын эрдэмэй доктор **Мелисса Чакарс, Густавсон Лейф Джастин, Румынийн Джура Илие Мариус** болон бусад.

Хари гүрэнэй хүнэй манай буряад хэлээр һонирхожо, оролдосотойгоор үзэжэ байхада, тордиһогүйгөөр хэлэдэг болоод ошохондонь, ехэ хайн, омогорхомоор байдаг. Шабинарнай ганса хэлэ үзэдэг бэшэ, баһа буряад арадай түүхэ, соёл, ажабайдал, ёһо заншал, аман болон уран зохеол, шажан үзэнэ.

Эдэ шабинартаа буряад хэлэ заахада, бэлэн бэшэ, харюусалгатай. Тиигэбэшье һонин. Жэшээ, мэдүүлэл бүхэн тухайгаа бодохо хэрэгтэй. Росси, Буряад орон, буряад арадай түүхэ, соёл, ёһо заншал харуулһан текстнүүдые хэрэглэхэ гэжэ оролдонобди. Ном соомни, жэшээн, А.С.Пушкин, Ю.А.Гагарин тухай, Байгал, Буряад орон,Сагаалган, буряад арадай эдэе хоол, хубсаһан, Улаан талмай дээрэ болодог бүхэ барилдаан, хүмүүжэлгэ тухай бэшээтэй. Фонетикэ, грамматика тааруулжа үзэнэбди. Ехэл оролдосотой, заатагүй ойлгохо гэжэ оролдодог, бэлигтэй шабинар даа. Бултадаа буряад оронтой танилсажа, Байгал, Ивалгын дасан, зариманинь Алхана ошодог. Заабол буряад газетэ уншадаг, теле, радиодамжуулга харадаг, шагнадаг, буряад дуу шагнадаг, дууладаг. Буряад драмын театрта буряад зүжэг харадаг, Сагаалганда, Буряад хэлэнэй үдэрэй баярта ошодог юм.

Түрэл нютагһаа холо, холын хари гүрэндэ ерээд байһан залуушуул гэжэ мартадаггүйбди.

Холын хари нютагһаа зорюута буряад хэлэ шудалха гэжэ ерэжэ, амжалтатай шудалжа байхадань, нютагтаа байһан манай үхибүүд юугээрээ дутанаб? Хэлэ үзэхэдэ, бэлэн бэшэ, илангаяа үзэхэ дурагүй хаа. Бэлигтэй, ухаатай хүндэ бэлэн, тулюуршаг хүндэ хэсүү аабдаа. Тиигэбэшье буряад хүн хадаа түрэл хэлээ мэдэхэ ёһотой гэжэ эли.

Заабол засаг зургаанаа хараад байха бэшэ, өөһэдөөл хэлээ хамгаалха, аршалха, хүгжөөхэ ёһотойбди. Энэ асуудалаар гэр бүлын үүргэ сэгнэшгүй. Хэрэглэхэ сударнууд, уншаха номууд, сонинууд, шагнаха радиодамжуулганууд, хараха теледамжуулганууд, хужарлан омогорхохо театрнууд бии. Уянгата буряад хэлээ сэгнэжэ, үргэжэ ябаял даа!

Бальжинимаева Н.Н.

ОХУ-ын Буриад улс, “Мүнгэн товшо”

сайтын редактор

Белоусова М.Ю.

ОХУ, Москва хот

БУРЯАД ХЭЛЫЕ ХОЙТО ҮЕДӨӨ ҮЛДЭЭХЭД ИНТЕРНЭТИЙН ҮҮРЭГ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Энэ оной 11 сарын 22-23-да Монгол Уласын ниислэл Улаан-Баатарта “Буряад хэлэ-аялгуу хэрэглээнэй асуудалнууд” гэхэн гаршагтай эрдэм-шэнжэлгын хуралдаан болобо. Энэ хуралдааниие Монголоой Буриад Судлалын Академи, “Амин тоонто” түрэ бусын байгуулга, буряад хэлээр MN2 телевидениин дамжуулга, Монголдо байдаг Буряад Республикын түлөөлэгшэ эмхидхээ юм. Н.Н.Балжинимаева – ОХУ-ын БУ-ын “Мүнгэн тобшо” вэб хуудасны хүтэлэгшэ, сэтгүүлиин “Буряад хэлийг хойто үедээ эвлүүлэн үлдээхэд интернэтийн үүрэг чухал болох нь” гэсэн удхатайгаар хэсэн элидхэл танай анхаралда.

Аяа хайрата буряад монголшуудни амар мэндээ!

Монгол-Оросой мүнгэн хилэ мүшхэжэ, алтан хилэ алхажа ерээд, таанадай урда гараа хадаа энээхэн арбан минутын туршада сэдхэлдээ амин шухалаар ханажа, юу бодожо, ямар ажал хэжэ байханаа хөөрөхэмни. Бидэ буряад зон үри бээ үдхэжэ, үндылгэхэдөө эдэмнай бидэнэй дээдэ тээ ухаатай сэсэн, хүдэр бээтэй, эрдэм номтой ябаг даа, бидэнһээ үлүү дээдэ тээ жаргалтай амидараг даа гэжэ сэдхэхэдэг, буряад гэхэн аба эжын заяахан нэрээ хүндэлжэ, буряад сэдхэлтэй, буряад хэлэтэй, омогорхол дүүрэн ябаһай даа гэжэ мүрөөдэдэг, хайрладаг зон гээшэбди. Тээд энээхэн һүүлэй жэлнүүдтэ хэдэн үе хүмүүс түрэл хэлээ мэдэхэгүй үндыгээд байна шуу. Буряад хэлэ заабол һургуулида үзэхэ гээд гүрэнэй хуулида саарһан дээрэ сараа гаргажа бэшэгдээгүй байхадань, зөөлэшлөөд Буряад уласай зарим һургуулинуудта 9 һараһаа эхилээд буряад хэлэнэй хэшээлнүүд болуулагдаад байна. Олон багшанар ажалгүй үлээд байна. Депутатууднай 6 сарада хуули абаха аад, хойшолуулаад, мүнөө 12 сарда абаха гэжэ хойшолуулаад байна. Хуули соо заабол буряад хэлэ үзэхэ гэжэ абтаа һаань мүнгэн һомологдохо, засаг түрын талаһаа дэмжэлгэ, хандаса ондоо болохо юм ааб даа. Энэ бүхы асуудалнууд тухай би “Мүнгэн тобшо” гэжэ сайт дээрээ ходол бэшэжэ байдагби. Таанад олонхинь тэндэ уншаһан байхат.


“Мүнгэн тобшо” сайт манай Буриадта олон зон уншана, Монгол найхан оронхоо олон хүмүүс намда туналжа, дэмжэжэ байдаг, би тэрээндэ ходол баяртай ябадагби. Эндэһээ таанадай намайе дэмжэхэдэ засаг түрэ, депутадууд, албан тушаалтан аа-заа энэ хүгшэн дахяад юугээ бэшээ юм бэ гэхэ мэтээр этэржэ ханахагүй, аа энэшни хари гүрэндэ олон нүхэдтэй байна ха юм гээд анхаралаа хандуулха, шиидхэбэри абахадаа, бодолгото болохо гэхэ жэшээтэй.

Үеһөө үедэ дамжан ерэнэн, эжын уурагтай бидэндэ шэнгэсэн эхэ буриад хэлээ, түүхэ домогоо, үльгэр туужаяа, уран зохёолоо, зан заншалаа хойто үедөө үлдээхын тулада, юу хэхэ байгаа гээшэб, гараа хабсараад, миин нуужа байха аргамгүй, тиимэхээ энэ “Мүнгэн тобшо” гэжэ блог түрүүн байгаа, хоёр жэл болохоо байна, харин июлиин 6-һаа “Мүнгэн тобшо” сайт нээгээд иимэ ажал хэжэ байнабди.




Слайд № 1.
Түрүүшээр ото
буриадаар
бэшэдэг байгааб,
теэд түрэл
хэлээр уншаха
хүн тон үсөөн
байхадань, орос
хэлэндэ
оршуулаад,
толилолго
табихадамни,
электронноор
оршуулагдаад,
гурбан гол:
англи, франци,

немец хэлэн дээрэ хүмүүс уншаха аргатай болоно. Тиихэдээ минии зохёон байгуулһан “Мүнгэн тобшо” сайт бүхы дэлхэй дээрэ үргэнөөр дэлгэржэ хаа хаанагүй уншасатай болоо.



Слайд № 2. 100 дахин шагнанхаар, нэгэ дахин хараа һаа дээрэ гэдэг ааб даа. Энэ слайд харагты, буриад арадай түүхэ, соёл, урлаг, шажан, зан заншал, мэдэхээс ханаһан хүнүүд Японһоо эхилээд Америкэ хүрэтэр Мунгэн тобшо сайт үзэдэг, уншадаг байна гэжэ эдэ тоонууд харуулна.


Сайтыг үзэлэг



Слайд № 3. Хоёр хараагаа үлүү бэлдэжэ, ямар аргаар сайтын нюур шарай хүнэй харахада зохид болгохо гээшэб, ямар угалзаар шэмэглэжэ хүмүүсэй нюдэ буляама болгохо, ямар хубсааһа үмдэхүүлхэ юун тухай бэшэжэ удхатай болгохо, зоной анхарал эзэлхэ гээшэб гэжэ зорилго табяад ажалаа хэнэбди. Июлиин 15-аа ноябрийн 5 болотор Мүнгэн тобшо сайтыг 1796 хүн үзэһэн байна. 3555 дахин орожо хүмүүс үзэһэн, тийхэдээ 1 хүн үдэртөө 2 дахин харана гээшэ. Мүнгэн тобшо юундэ 3D гэжэ нэрэтэйб гэхэдэ эндэ толилогонууд, гэрэл зурагууд, видеобэшэлгэнүүд табигдана.



Слайд № 4. Мүнгэн тобшо сайтыг дэлхэйн 37 гүрэнүүдхээ хүмүүс сонирхоно.




Слайд № 5. 9000 гаран хуудас Орос гүрэндэ амидардаг хүмүүс уншана. Монгол оронһоо олон хүмүүс намайе уншадаг, дэмжэдэг юм. Америкэнээ олон зон байна. Тиихэдээ тэндэ нютаг оронһоо холо амидардаг, хари халуун газарта нютагаа ханаад, минии Мунгэн тобшо сайтда орожо гэрэл зураг дээрэ нютагаа хараад баярлаха, монгол дуугаа соносоод сэдхэлээ ханаха – иимэшүүл гээшэ ха. 100 гаран хүмүүс англи хэлээр уншадаг, Англи гүрэндэ 10 гаран хүн үзэдэг лэ дээ. Тиихэдээ тэдэш ондоо үндэстэн гээшэ ха гэжэ хананаб.




Слайд № 6. *Эмэгтэй 35.8%, Эрэгтэй 64.2%-тай үзнэ.* Олонхинь эрэгтэй хүнүүд үзэнэ. Эрэ хүн бүлын эзэн, аба хүн, эрэ хүн эрдэни гээд бидэ хэлэдэгбди, Тиигээд эрэшүүл засаг түрэ баридаг гээшэ, үхи хүбүүдээ хүмүүжүүлхэдэ абын үүргэ тон ехэ, тиимэһээ би энэ тоо харахадаа баясадагби.

Слайд № 7. Манай Буряадай Уласай Арадай Хурал намда иимэ баярай бэшэг саяхан барюулаа юм. Хэжэ байһан ажалыемни сэгнэхэдэнь, хүгшэн хүүгэд хоёр магтаалда дуратай улад ха юмбибди дээ. Баярланаб.

Бүхы наһанай хүмүүс




Слайд № 8. 18 наһанһаа 34 наһан хүрэтэр олон зон Мүнгэн тобшо сайт үзэнэ. Залуушуулнай манай ерээдүй гээшэ. Эндэ уншажа байхадань би баяртайб.



Оло дахин үзэдэг хүмүүс

Слайд № 9. Энээхэн 3 нара соо 100 гаран толилолго табигдаа. Үдэр бүри Мүнгэн тобшо сайтда хүнүүд нэмэжэл байдаг. Дунда зэргээр хүн бүхэн 5 минута үлүүтэй уншана. Нэгэ хүн ямар толилолго уншааб бү мэдэе аяар 17 минута уншанан байна.


Слайд № 10. Юун тухай эгээн ехээр сонирхоноб гэхэдэ, Буряад хэлэн тухай толилолгонууд тон ехэ анхарал татана. Дунда зэргээр 1 хүн 3 хуудас уншана, 1 хүн 7,2 хуудас уншасан байна. Буряадай суута уран зохёолшон Цэдэб Цырендоржиевай “Буряадууд гүбди, али нэрэгүй нэхытэнүүд гүбди” гэхэн толилолго тон ехэ анхарал татажа, түрүү һуурида гараа юм.



Буриад судлал №4 эрдэм шинжилгээний сэтгүүл


Слайд №11. Буриад уласда 167 үндэстэн амидарна. Тэдэнэй 64.9 хубинь – оросууд, буряадууд – 29.5 хубинь, бусад үндэһтэн 5.6 хубинь эзэлнэ.

Хэлэ мэдэлгэ



Слайд № 12. Буриад хэлэ 5 хүнэй 1 хүн мэдэнэ.

Сайтые сэхэ үзэлэг



Слайд № 13. Энэ оной 4 харда Буряад уласай иимэ вебсайдуудай тэмсээндэ 200 гаран хүмүүс дунда 2-дохи суури эзэлжэ лауреат болоо бэлэйб. Засаг түрэхөө иимэ шагналда хүртөө би. Мүнгэн тобшо блог фейсбук соо байха, сайтһаа олон мэдээсэл иишээ тиишээ орожо, хүмүүс энэ блог хонирхоһон зандаа.

Слайд № 14. Сайтын удха гүнзэгы болгохо, ямар шэглэлээр, ямар шэмэглэлтэй байха гээшэб гэжэ, үзэсэн хүнүүд сэдхэмжээ яагаад бэшэхэб, сайт руу яагаад оруулхаб, гэхэ мэтэ олон асуудалнуудые өө-мөөгүй хэхэ хэрэгтэ Москваһаа Марина Юрьевна Белоусова багшамни заабарилжа, хургажа, бурууемнай заһажа, хамһалсажа байдаг юм. Түрүүн эхилхэдээ, би ехэ зүрхэ алдаа һэнби, блог ябуулха нэгэ ондоо, харин сайт нээгээд мэдээсэлээ ходо шэнэлжэ байха гээшэ харюусалгатай хэрэг. Сайт гээшэмнай үнжэгэн сэсэгтэй жэшэхээр, уһалангүй, хананхалангүй, анхаралаа хандуулангүй байжа болохо үгы, нарай хүхөөр хүүгэдтэй жэшээлхээр, ходол эдеэлүүлхэ хэрэгтэй, ундалуулха хэрэгтэй. Норгожорхёо хаань хуурайлха хэрэгтэй, шэнэлжэ байха хэрэгтэй, хайрлаха хэрэгтэй, тиимэш бэлэн хэрэг бэшэ юмэ дээ. Хүнэй хонирхол татаа үгы хааш, хахуули хаяжа байгаагүй хааш, хүн дахяад шинии сайт уншаха үгы ха юм даа. Тиимэһээ би Марина Белоусовада шадахагүйб гэхэдэмни, шадахат, гээд лэ намайгаа урагшань жүдхүүлээд, дахуулдаг, хоюулаа “ганзага ниилээд” иимэ ажал суг хамта хэжэ байһан зон гээшэбди. Фейсбук соо олон зоноор танил болооб. Монголоор уншадаг, ойлгодог болооб.

Ямар юумэ хонирхонобши, тиимэ удхатай толилогонуудые хүмүүс эльгээхэ, жэгтэй һонин юумэ мэдэхэ болонош, хии юумээр харилсаад, хаанаш хүрэтэр бэшэлсэжэ байдаг энэ интернет гээшые гайхахажашье, гоёшоожошье, магтажашье хэлэжэл байдаг хүм даа. Буряад хэлээ хүгжөөхэ, үхибүүдтээ зааха гэбэл оршон үсын сагай эрилтээр энэ интернет гээшые хэрэглэжэ, богонихоноор, эли тодоор, гүнзэгы удхатайгаар дамжуулгануудые, видеобэшэлгэнүүдые бүтээгээд табиха, үхибүүд юу хонирхоноб тэрэниень лэ ойлгосотойгоор зохидхоноор хэхэ ёһотойбди.

Интернет гээшые дэлгэрүүлхэ, хаа хаанагүй байгуулха, нам шэнги настай хүнүүдтэ ойлгуулха, заагаад үгэхэ, тэдэнэр интернет хонирхоходоо, хүгшэрхөөш мартажархиха лэ, жаахан үхибүүд шудалаг лэ, иимэл зорилго урдаа табяад хүдэлхэ ёһотойбди. Эндэ һууһан хүн бүхэн буряад арадтаа ямар туһа нэмэри оруулаа гээшэбиб, ямар туһа хүргэхэм гээшэб, үри бээе, хүбүүд басагадаа, аша зээнэрээ эхэ хэлэндээ эльгэтэйгээр хүмүүжүүлхын түлөө ямар юумэ хэхэ ёһотой гээшэбиб гэжэ өөрөө өөртөө асуудал табижа, шэбшэжэ, зүрхэнэйнгээ шэмшэртэр һанаашалаял даа, буряад хэлэнэй түлөө, буряад арадай түлөө үнэн зүрхээс, сэбэр сэдхэлээ, хүсэ зоригоо зорюулаял даа гэжэ таа олониин уряалнаб!

Дондокова Ж.Ц.,

к.п.н., доцент Бурятский госуниверситет

ЯЗЫК ПЕРИОДИЧЕСКИХ ИЗДАНИЙ УСТЬ-ОРДЫНСКОГО БУРЯТСКОГО ОКРУГА НА БУРЯТСКОМ ЯЗЫКЕ

История периодической печати на бурятском языке в Иркутской области началась с газеты «Үүр» (Рассвет), издавался в 1920 г. Главным редактором газеты являлся Ярослав Гашек – чешский писатель-сатирик, драматург, фельетонист, журналист. Наряду с газетой «Үүр», Гашек был главным редактором газет «Штурм – Рогам» («Наступление») на немецком и венгерском языках, а также «Бюллетень политработника» на русском. Статьи в газету «Үүр», написанные Я. Гашеком, переводились на бурятский язык. На бурятском языке вышло всего три номера газеты «Үүр».

На сегодняшний день в округе и в целом в области единственная газета, которая издается на бурятском языке – газета «Усть-Ордын үнэн», издается с 1954 г. Первый номер газеты вышел 1 апреля 1954 года. Первоначально издавалась 3 раза в неделю тираж, которого составлял 2 тыс. экземпляров. В 1960-80-е годы выходила в печать под названием «Ленинэй туг» (Знамя Ленина). В 90-е газета выходит в печать под названием «Усть-Ордын үнэн». Информировать читателей по различным вопросам, рассказывает о наиболее значимых событиях округа, области, об их главных действующих лицах. Публикуются материалы по языку и культуре бурят, а также указы и постановления местных органов власти. За эти годы газета менялась, росла, развивалась в соответствии со временем, но всегда сохраняла свое главное предназначение – быть одной из хранилищ самобытной культуры и языка Приангарья.

Практически все рубрики газеты, выпускаемой в 60-70 годы, печатаются на бурятском языке. Например, «Мүнгэн хурим», (Серебряная свадьба), «Захил хэхээ яарагты» (Торопитесь сделать заказ), «Түрэл орон доторной» (Внутри страны), «Хүдэлмэрилэгшэдэй эдэбхи үүсхэл» и т. Д. Допускаются такие переводы как «...манай Россия Федерациин...», «... буряадай национально округой...», «...советскэ хуулинуудые точноор ба хэлбэрэлэтэгүйгөөр...», «Усть-Ордын культурын байшан» [Ленинэй туг, №148, 150, 151,]. Не смотря на не совсем корректный перевод все статьи рубрики печатаются на бурятском языке. Выходят в печать статьи ученых-бурятоведов, например Л.Д.Шагдарова «Хальмаг хэлэ

бэшгэй хүгжэлтэ», [Ленинэй туг, №130], не так активно, но печатаются стихи, рассказы, пьесы бурятских писателей и поэтов, например, Ц.Галсанова, В.Жалсанова, Ч.Цыдендамбаева, Ц.Дондогой, Д.Дамбаев, М.Осодоев. В 1970 году в 140 номере «Ленинэй туг» печатают стихи монгольских поэтов «Монголой уран зохёолшодой шүлэгүүд», С.Дашдэндэва, Д.Найманжина, Б.Явуухулана, Д.Намдага. [Ленинэй туг, № 140]. Из устного народного творчества лишь одна рубрика в номере 133 «Онъһон үгэнүүд». [Ленинэй туг, 133].

Адууша хүнэй гарта ташуур һайхан. *Э.Х.Галишев.*

После еды совершай небольшую прогулку,

делая движение телом.

Освежится дыхание и кровь,

оживятся раномерно сосуды. 98

В отдельных случаях гуляй по лесной прохладе

И приятному для души саду.

Этим развеешь мрачные чувства горя,

А душа и тело обретут спокойствие и радость. 103.

Буряад арадай үни саһаа сахижа ябаһан бэсын тамирай һургаалнууд элүүр энхэ, ута наһа наһалхын нэгэ үндэһэн болоно.

III. Элүүр ябахын гурбадахи нуури – үдэрэй журам сахилга.

Буряад арад урдандаа байгаалийн сагаар амидардаг байһан гээшэ ааб даа. Наранай гарахада бодохо, наранай ороходо унтаха. (Соблюдали режим природного биоритма) Энэмнай хүнэй бээдэ аргагүй хайн гээшэ ааб даа.

Мүнөө сагай эрдэмтэдэй шэнжэлэлгээр:

- хүн үдэшэ 10 сагһаа түрүүн унтаха;
- 10-2 сагай хоорондо бөөмнай шэмэ тэжээлээ абаха;
- 2-4 сагта эльгэн шуһаа шүүжэ, хайниинь зүрхэндэ ябуулха, мууень бөөрө, арһан, сууха дамжажа бэһээ гаргаха.
- 4-5 сагта бөөри, суухаа шээһээ газа тээшнь гаргаха;
- 4 сагыг үхэлэй саг гэдэг, давлени доро болохо, зүрхэниинь нула сохидог;
- 5-6 сагта һэрюун найрай саг (Зүүдэ зүүдэлхэ, һэрижэ байха);
- 7- сагта һэрээд эдээлхэ үе;
- 8 сагһаа зүрхэнэй сохисо шангаржа шуһанай эрьелтэ түргэдэхэ, бээын халуун дээшэлхэ.(шадал);
- 9 сагһаа шүдэ абаха саг, энэ үедэ бэе хайн байдалтай, үбшэндэ тэсэбэритэй.
- 10-12 саг тархи хайн ажаллаха саг;
- 13-14 сагта нойр хүрэхэ, бэе нуларха. Энэ үедэ амарха хэрэгтэй.
- 15-17 саг болотор эдээн шэнгэхэ үе, хүндэ;
- 19-21 сагай үе хайн. Ухаан бодол хайн хүдэлхэ, ном үзэхэдэ хайн.

Эрдэмтэдэй шэнжэлэлгэ хэрэглэн үхибүүдтэ үдэрэйнгөө журам табихыг заабал ехэл хайн.

Үргэһэ нойр хургаалай,
Үлэн гэдэһэн хэмжүүрэй.
Нойр үргэһэн хургаалай,
Нойтон гүзээн хэмжээнэй.

IV. Элүүр ябахын дүрбэдэхи нуури – сэдхэлэй амар.

Хүн бүхэн олоной нэгэн болоно. Би дэлхэйн ганса гайхамшаг гээшэб гэжэ бээс сэгнэжэ ябаха ёһотой. Бээ хайрлажа, сэбэрээр абажа ябаха, үбшэһөө хамгаалжа шадаха элүүр энхын дүрбэн нуури сахижа амидарха ёһотой. Элүүр энхэ амидарахада хайн хайхан сэдхэл эгээ шухала. Буряад зон сагаан хайн сэдхэл гээшыг ехэ сэнтэй гэжэ тоолодог байһан. Үри хүүгэдөө өөртөө зүбөөр хандажа, хүндэ зүбөөр хандажа, эхэ эсэгээ, аха захатанаа хүндэлжэ, хайрлажа ябахыг хүмүүжүүлдэг байһан заншалтай. Мүнөө үедэ арадаймнай алтан дуһаалай хургаалнууд сахигдахаа болижо, ургажа ябаһан үри хүүгэд урданайнгаа ёһо заншал мэдэхгүй үндыжэ ябана. Тиимэһээ үхибүүдтэ гэртэхиншыг, багшанаршыг хэлэжэ, заажэ байха ёһотой. Эхэ, эсэгэ гээшэ мание түрэхэн, үндылгэхэн эгээ аша ехэтэй, амиды бурхад гээшээ.

«Аба хүн хада, эжы хүн тала», « Эсэгэ тэнгэри мэтэ, эхэ дэлхэй мэтэ». * - гэжэ арадай сэсэн үгэнүүд бии. Эхэ эсэгийн аша туһыень харюулжа шадаһан хүн үгы. Хүндэлжэ, хайрлажа, хүгшэрхэ наһандань бэе сэдхэлынь найнаар тэжээжэ, ашынь харюулха хүн бүхэнэй уялга болоно.

Эжы абаяа гурбан зөөлөнөөр хүндэлөөрэйгты: унтариин, эдээнэй, үгын – гэжэ арадай үгэ бии гээшэ ааб даа. Аха дүүнэртөө, түрэл садандаа зүбөөр хандаха хэрэгтэй. Аха зоние хүндэлхэ, буряад зоной гол хургаалай нэгэн. Эдэмнай манай түшэлгэ, тэдхэмжэ «Түшэхэ түрэл хэрэгтэй». *«Угаа уһанда хаяагүй, гарбалаа газарта булагуй», « Наран шэнги нагаса, набшаһан шэнги зээ», «Түрэл зоной түһөө нэгэн» -буряад арадай хургаалай дээжэнүүд болоно.

Гал гуламтаяа, гэр байраяа хайрлажа хургаха. Гэр гээшэмнай манай хэрэм. Гэртээ жаргалтай хаа бэе найн, үбшэн хүрэхэгүй. Гүрэндөө, газар дэлхэйдээ, байгаалидаа ходо баярлажа, найнаар хандажа, хайрлажа ябаха хэрэгтэй. Ходо муу һанаа гаргажа, хараажа, үрээжэ, шэрээжэ байхада бээдэ муу. Урданай үбгэд, хүгшэд иигэжэ хэлэгшэ һэн – «Боро хараан болоходо, хараал шэрээл бү гаргагты!». Гэрэй эзэн, бүһэтэй хүн уужам сэдхэлтэй, холын бодосотой байха ёһотой. «Эрэ хүнэй сэдхэл эмээлтэ мори багтааха ёһотой» - гэжэ хэлсэдэг. «найн байнаб гээд ехээр бү баярлагты, муу байнаб гэжэ бү гомдогты» - гэжэ үбгэд, хүгшэд хүүгэдтөө хэлэгшэ һэн. Буряад зон үри хүүгэдтөө шангаар бадашажа, хараажа байгшагүй һэн. Хараахадаа зоригын эбдэхэ, зан абариинь муудхааха. «Дуугүйхэн нүдэндэшни шабхадуулжа хүн болоо һэмби гэжэ монгол дуушан дуулаа һэн» (Вампилова Долгор Дагбаевна–шэнэхээн буряад хэлээһэн)

Буряад зон урдандаа гурбан муу (10 хара нүгэл) хэхэгүй гэжэ оролдодог байгаа:

Бэсын гурбан нүгэл:

1. амиды юумэнэй гол таһалха;
2. хулгай хэхэ;
3. һальхайрха, һэбхирхэ;

Хэлэнэй 4 нүгэл:

1. худал үгэ;
2. хоб хэхэ;
3. шэрүү үгэ; (хоротой үгэ хэлэхэ, харааха);
4. Зальхай үгэ хооһоор хэлээ бүлюудэхэ, ямаршые туһагүй үгэ хэлэхэ)

Сэдхэлэй 3 нүгэл:

1. Хорото сэдхэл;
2. Хомхой хобдог сэдхэл;
3. Ондоо шажанда орохо, эльбэ хэхэ;

10 сагаан буян:

1. амитаниие алахые тэбшээд, амиинь абарха;
2. тулиһан, зобоһон зондо эдээ гү, али зөөри, мүнгэ үгэхэ;

3. һэбхирэнгүй, арюун сэбэрээр ябаха;
4. худал үгэ тэбшээд, үнэн үгэ үгүүлхэ;
5. хоб үгые тэбшээд, зохилдуулан үгүүлхэ;
6. шэрүүн үгые тэбшээд, зөөлэнөөр үгүүлхэ;
7. зальхай үгэ тэбшээд, номой үгшые үгүүлхэ;
8. хорото сэдхэлые тэбшээд, туһалха сэдхэлые үйлэдэхэ;
9. хомхой сэдхэлые тэбшээд, болюулжа шадаха;
10. буру үзэлые тэбшээд, үйлын үридэ этигүүлхэ. «Д.Аюржанаева»

Мүнөө сагай эрилтээр залиршагүй арадаймнай хургаалнууд элүүр энхэ амидархын үндэһэн хуури болоно. Энэ дүрбэн хуурийн алинийньше дутаажа болохогүй. Эдэниие найнаар баримталаад байгаа хаа хүн элүүр энхэ 100 жэл амидарха болоно.

Литература:

1. Агын буряадуудай урданай ёһо заншалнууд. Жугдурова, Батоева.
2. Анханаймнай хургаалнууд. Аюржанаева Д.
3. Заяанаймнай заншал. Сэрсэгмаа.
4. Ёһо сахибал, ёро халдахагүй. Гарма- Доди Дамдинов.
5. Э.Х.Галшиев «Бэлигэй толи».
6. Буряад, ород оньһон, хошоо үгэнүүд Л.Д. Шагдарова, М.П. хомонов.
7. Буряад зоной урданай хуудал байдалай толи. С.Д.Бабуев, Ц.Ц.Бальжинимаева
8. Информаторы: Вампилова Д.Д.
9. Дондокова А. С.
10. Дашеева С. Н.

Б.Мядагмаа

Дорнод дээд сургууль,

СССудлалын багш /магистр/

Б.Жигжидмаа

11-р сургуулийн багш

E mail: mydag_dds@yahoo.com

БУРИАД ЗОНЫ ҮР ХҮҮХДЭЭ СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЖ ИРСЭН АРДЫН ӨВ УЛАМЖЛАЛЫН ТУХАЙД

Абстракт:

Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн уламжлалд нилээд тогтвортой хэрэглэгддэг нэг үндсэн ухагдахуун бол “Гэрийн сургаал” юм. Манай ард түмэн энэхүү гэрийн сургаалаар үр хүүхдээ хар багаас нь чандлан сургаж, үүгээрээ бүхий л нийгмийн зан байдлыг суурь болгож ирсэн. Тиймээс бидний буриад зон олон гэрийн сургаалаар дамжуулан үр хүүхдээ хэрхэн хүмүүжүүлж ирсэн тухай буриадайнгаа баавай нарын үлдээж, тэмдэглэсэн зарим баримт материалд тулгуурлан энэхүү илтгэлийг бичихийг зорилоо.

Түлхүүр үг:

Буриад, өв уламжлал, хүүхэд, хүмүүжил, төлөвшил

Нэрт сурган хүмүүжүүлэгч К.Д.Ушинский “Сургууль нь хүмүүжлийн бүх талыг тэр бүр өгч чаддаггүй. Иймээс хамгийн амьд үнэмшил бүхий нь тухайн ард түмэн, үндэстэн ястны түүхэн явцад олгож байсан гэрийн хүмүүжил мөн” гэсэн нь ардын сурган хүмүүжүүлэх зүйн үүрэг, ач холбогдлыг тодотгож илрүүлж өгсөн байна. Үүнээс үзэхэд тухайн ард түмэн, үндэстэн ястнууд түүхэн хөгжлийн явцдаа олж авсан сургаал, хэлц үг, үлгэр домгоор дамжуулан үр ач нараа сургаж, хөгжүүлж, төлөвшүүлж, хөдөлмөр ахуйд сургаж байсан нь хүнээр хүн хийх ухааныг хэрэгжүүлж ирсний тод жишээ гэж үзэж болохоор байна.

“Хүнээр хүн хийнэ гэдэг нь хүүхдэд нийгмийн туршлага эзэмшүүлнэ” гэсэн утгатай бөгөөд энэ нь амьдралын хэм хэмжээг ойлгож хэрэгжүүлдэг болно гэсэн санааг агуулдаг. Иймд хүүхдийг хүмүүжүүлэхдээ томчууд амьдралын туршлага мэдлэгтээ үндэслэн үйл байдлаараа үлгэрлэх, үг яриагаараа сургамжлах замаар тухайн зүйлийг зөвшөөрч сургах эсвэл хориглож цээрлүүлэх аргыг хэрэглэдэг

байна. Уг илтгэлдээ судалгааны эш, баримт болгон ашигласан доорх үгнүүдийг задлан авч үзье.



Буянтай буурал өвгөдөөсөө өвлөж ирсэн буриад зонхоо амьдрал ахуйгаас нь урган гарсан, үр биеэ өсгөж хүмүүжүүлж ирсэн сургаал үгнүүдийг миний хоёр буурай авга ахай Ц.Базарсад, Б.Цэндэм авгайнгаа бичиж цуглуулсан дараах зүйр үг, сургаал үгнүүдийг задлан утгачилан үзвэл:

1. *Абаяа дахажа ажалда хура Ахаяа дахажа эрдэмдэ хура* - Хүүхдэд бага балчираас нь эхлэн хөдөлмөрлөж, эрдэм номд шамдах нь сайн сайхан амьдрала гэдгийг ойлгуулан, хүүхдийг ажилч хичээнгүй болгох нэг арга нь ахас ихэсээ хүндэлж, тэднийг даган ертөнцийн дээд доод тогтолцоог

ухааран ойлгох учиртай гэсэн санааг илтгэж байна. Хүүхдэд сурч хөгжих, хөдөлмөрлөх арга барилыг олгохдоо эцэг эх, ах дүү нар нь багаас нь аливаа ажлыг яаж хийхийг зааж тайлбарлаж өгөх, өөрсдөө дагуулан сургах, ямар ч ажлыг голохгүй хийдэг болгох, идэвх санаачлагыг нь хөхүүлэн дэмжих, аливаа ажлыг хичээнгүй нямбай хийх, хийж эхэлсэн ажлаа заавал дуустал нь хийх, ажил хийж буй хүнийг хүндэлж, туслах чанаруудыг төлөвшүүлэх нь ажилч хичээнгүй болж төлөвшихөд чухал үүрэгтэй.

2. *Сурахан хүн толон соо ябаха*

Сураагүй хүн манан соо ябаха – гэдэг нь толон соо гэдэг нь үүрийн гэгээгээр явах, сураагүй хүн манан дотор төөрч будилж явах гэсэн санааг илтгэх бөгөөд энэ нь эрдэм номд шамдаж сурсан хүн үүрийн гэгээ адил ажиллаж амьдарч, аливаа ажил хөдөлмөр, сурах үйл явцад суралцаагүй хүн манан адил орчинд амьдрахыг заан сургаж иржээ.

3. *Дэгэлые шинэһээни гамна*

Нэрээ залууһаани хайрлажа яба– гэдэг нь буриад түмэн нэр төрийг туйлаас эрхэмлэн хүндэтгэж ирсэний илрэл юм. Энэ сургаал нь “Нэр хугарахаар яс хугар”, “Нэрээ барахаар насаа бар”, “Хүн нэрээ тогос өдөө” гэх мэт үгтэй утга дүйх бөгөөд хүний нэр алдар, нэр төр ямар чухал болохыг үр хүүхдэдээ ойлгуулж хүн байхын утга учир нь нэр төртэйгээ шууд холбоотой гэж үздэг байсны жишээ юм.

4.Һайнтай муутай ни эдижэ

Һайхантай муухайтай ни үмдэж хубсаһатай явахаши – гэдэг нь хүн ямар ч орчинд амьдарч байсан аливаа зүйлийг голохгүй муу сайн, сайхан муухайг дэнсэлж явах нь эд баялагтай, сайн сайхан амьдралаа гэсэн санааг дээрх сургаалаар ойлгуулж иржээ.

5.Нюур нюрган хоёр, хоёр ондоо – гэдэг нь тухайн хүний нүүрийг харж байгаад хэлж ярих нэг өөр, нюрган буюу тухайн хүний байхгүйд нуруунд нь ярих нэг өөр гэсэн 2 санааг агуулах бөгөөд хүний нүүрийг хараад хэлсэн ярьсан зүйл нь нуруу буюу тухайн хүний талаар эзгүйд нь ярьсан зүйл хоёр нь зөрчилдөж болохгүй гэсэн утгаар сурган хүмүүжүүлж иржээ.

6.Табиха морийе ижилдинь

Хэлэхэ үгыг эзэндинь – гэсэн сургаал нь бэлчээрт тавих морийг өөрийн ижил сүрэгт нь тавьж, хэлэх үгийг эзэнд нь хэлж байх хэрэгтэй гэсэн утгаар ойлгуулж ирсэн ба хувь хүнтэй холбоотой үгийг зөвхөн тухайн хүнд нь хэлж, өөр хүнд ярихгүй хов живнээс холуур үгээ цэгнэж байх хэрэгтэй гэсэн санаагаар ухааруулж байжээ.

7.Үргэһэ нойр һанаанай

Үлэн гэдэһэн хэмжүүрэй – уг сургаалаар унтаж, идэх нь хэмжээ хязгаартай хүн өөрийнхөө сэтгэц ухамсраар хөтлөн жолооддог болохыг ухааруулж, хүмүүжүүлж иржээ.

8.Үбиинишье һаа элүүрээр

Үлэсхэлэнишье һаа садхалнаар явагты – Хүн өвдөж зовох, өлсөх цангахын алинд ч сэтгэлийн тэнхээтэй, тэвчээртэй, тэсвэр хатуужилтай, сэтгэл санаагаараа өөдрөг амьдарч явахыг ойлгуулж, сургаж ирсэн байна.

9.Улин хусаһан нохой ёрог

Уйлан хэлэһэн эхнэр ёрог – Маргалдаж муудалцаж, зөрчилдсөн ч уйлж нулимсаа харуулах нь асуудлыг сайжруулахгүй, илүү мууг ёрлохын шинж юм гэж сургаж иржээ.

10.Һула хаяһан сур

Дэмий хаяһан дээһэн – Залхуу, ажилч хичээнгүй бус байдлыг илэрхийлэх бөгөөд дэмий цаг өнгөрөөж явах хэрэггүй гэж ухаан суулгаж, үр хүүхдээ төлөвшүүлдэг байжээ. Сул хаясан сур, дэмий хаясан дээсийг хэн ч яаж ч ашиглаж болно. Дэмий дэл сул үг алдаж муу хүнд боомилгодох вий гэж сургасан сургаал үг.

Буриад зон олон үр хүүхдээ хөгжүүлж төлөвшүүлэхдээ амьдралын туршлага мэдлэгтээ үндэслэн үйл байдлаараа үлгэрлэх, үг яриагаараа сургамжлах замаар байнга нөлөөлж хүмүүлүүлж ирсэн байна.

Дүгнэлт

- Буриадууд нь үр хүүхдээ багаас нь сурган хүмүүжүүлэхдээ амьдрах арга ухаан, ажил хөдөлмөрт дагуулан хийлгэж, үлгэрлэн сургаж иржээ.

- Ахуйн соёл тэр дундаас хэл яриа нь их өвөрмөц аргадангуй зөөлөн аялгуутай, энэ нь оюун санаанд нь гүн гүнзгий хүрч нөлөөлөн хүмүүжлийн асар их нөлөө үзүүлдэг байна.

Ашигласан материал:

1. Эрдэнэцэцэг С., ред. Багш боловсролын үндэс УБ., 2010
2. Ширнэн Б., ред. Буриад судлал, УБ., 2008
3. Ичинхорлоо Ш., Хүүхдийн хөгжил, УБ., 2010
4. Цэцэгмаа С., Угаа уһанд хаяхагүй, Улаан –үд
5. Дамдинжав Д., Буриад Монголчууд УБ., 2009
6. “Нүүдлийн соёл иргэншил ба буриад монголчууд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл УБ., 2010

А. Оюунтунгалаг,
Доктор, дэд профессор
МУБИС, Багшийн сургууль

БАГШИЙН СУРГУУЛИЙН ТҮҮХЭНД БУРИАДЫН СЭХЭЭТНҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Abstract

Soviet Union Russian specialists and the Buriat intellectuals made big contributions to the preparation for the new teachers of Mongolia. They helped the Teacher's School not only to personnel, but also to prepare cultured, well-behaved teachers who will have a good knowledge of teaching methodology, the Russian language and international ethics.

Түлхүүр үг: угсаа гарал нэг, буриадын сэхээтнүүд, орос, зөвлөлтийн мэргэжилтнүүд, сургагч багш, эрдэмтэн багш, боловсон багш, орос школ, шинэ үеийн багш, шинжлэх ухааны мэдлэг, оросын болон дэлхийн соёл, боловсрол, гэрээ хэлэлцээр.

Монгол улсын гадаад харилцааны түүхэнд Монгол – Оросын харилцаа онцгой байр суурь эзэлдэг бөгөөд 2 орны ард түмнүүдийн сайн хөршийн харилцаа олон зуун жилийн түүхтэй. Энэхүү уламжлалт харилцаа XX зууны эхнээс шинэ агуулга хэлбэрээр баяжин тэлж, хөрш орнуудын нийгмийн амьдралын бүхий л салбарыг хамран хөгжжээ. Үүний тод илрэл нь хоёр орны харилцаа улс төр, эдийн засгийн салбарын зэрэгцээгээр соёлын салбарт улам өргөжин тэлж, шинжлэх ухаан – техникийн хэлхээ холбоо үүсэн бэхэжсэн явдал юм.

Монгол –Оросын 1912 оны Найрамдлын гэрээ болон 1921 оны 11 сарын 5-нд гарын үсэг зурсан Монгол–Орос улсын хоорондын найрамдлын барилдлагааг байгуулах тухай, Монгол ардын засгийн газар ба Зөвлөлийн засагт Орос улсын засгийн газрын хэлэлцэн тогтоосон гэрээ бичиг нь хоёр улсын хоорондын эрх тэгш харилцаа, хамтын ажиллагааны ерөнхий зарчмыг тунхагласан анхны баримт бичгүүд байв. Улмаар хоёр улсын 1946 оны гэрээ, Засгийн газар хоорондын эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах хэлэлцээрийг үндэслэн 1956 онд соёлын талаар, 1961 онд шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах хэлэлцээр тус

тус байгуулагдсан нь шинжлэх ухаан, боловсролын салбарын хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн гүнзгийрүүлэхэд үлэмж ач холбогдлыг үзүүлсэн билээ.

ЗСБНХУ-ын ШУА-ийн монголын комиссын хэд хэдэн протоколд хоёр орны харилцаа өргөн цар хүрээг хамарч байсныг илтгэж байгаа бөгөөд шинэ тутам батлагдаж, хэрэгжиж эхэлсэн дээрх гэрээ бичгүүдийн боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлэх талаарх заалтууд нь монголын анхны мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх үйлсэд тусгалаа олж эхэлсэн юм. Оросын засгийн газраас Монгол улстай боловсрол, шинжлэх ухааны талаар байгуулсан гэрээ хэлэлцээрээ хэрэгжүүлэх эхний үед монголтой угсаа гарал, хэл нэгтэй буриадын сэхээтэн, багш нарыг олноор хамруулан монгол руу явуулж ажиллуулж байснаас гадна монголчууд ч буриадчуудыг урьж ирүүлж байлаа. Энэ нь шинэ тулгар хөгжиж буй монголчуудад ихээхэн ач холбогдолтой чухал хэрэг байлаа. Монгол улсын анхны багш бэлтгэх сургууль Багшийн сургууль байгуулагдсан цагаасаа эхлэн буюу Багш бэлтгэх түр курс, Оюутны түр сургууль, Багш нарыг бэлтгэх сургууль гэх зэргээр нэрлэгдэж ирсэн үе үеийн түүхэндээ буриадын сэхээтнүүд, орос, зөвлөлтийн мэргэжилтнүүдийг урин ажиллуулж, тэднээс ихээхэн зүйлийг судалж, суралцаж ирсэн юм.

Багш бэлтгэх түр курсын үйл ажиллагааг 1922-1924 он хүртэл Дотоод яамны Сургуулийн хэлтсийн байцаагч, буриад Б.Ишдорж, Баатар нар хариуцан, багшаар ажиллаж байсан бөгөөд Оюутны сургуулийн анхны захирлаар орос улсын харьяат Данийл Алтаевич Абашеев (1924-1926 онд захирал байсан) уригдан ажиллаж байсан юм. Эрдэмтэн Д.А.Абашеев тус сургуулийн захирлаар ажиллаж эхэлсэн цагаасаа Буриад монголоос орос, буриад багш нарыг ирүүлэхэд ихээхэн анхаарал тавьж, европ ёсны эрдэм сурсан 5-6 хүнийг урин ирүүлж, улмаар 20 сургагч багштай болсон байна. 1920-иод онд ажиллаж байсан сургагч багш нарын дотор Эрдэнэбатхаан, Жамсраны Цэвээн, Хазгаев, О.Жамъян, Б.Ишдорж, Дашням, Буддарь, С.Шагж, Д.Цэвэгжав зэрэг тэр үеийн боловсролтой хүмүүс, буриадын сэхээтнүүд, Кисаев, Марикева зэрэг орос багш нар ажиллаж байсан бөгөөд дээрх буриадчууд нь угсаа гарал нэгт Монголын үндэсний ардчилсан хувьсгалын үйл хэрэг



Ishidorj (-1937?).

болон Засгийн газар, Судар бичгийн хүрээлэн, Ардыг гэгээрүүлэх яамыг эмхлэн байгуулж, хөгжүүлэх үйл хэрэгт гар бие оролцон зүтгэгсэд байлаа. Анхны багшаар ажиллаж байсан дээрх буриадын сэхээтнүүдийн гүйцэтгэж байсан ажил үүргийн заримаас дэлгэрүүлэн дурдвал:

Анхны багш Базарын Ишдорж

Базарын Ишдорж нь Өргөөд төрсөн буриад бөгөөд Эрхүүд багшийн боловсрол олсон, 1921 онд Москва хотноо Алс Дорнодын олон улсын ардын төлөөлөгчдийн анхдугаар их хуралд хэлмэрчээр оролцсон. 1922-1924 он хүртэл Дотоод яамны Сургуулийн хэлтсийн байцаагчаар

ажиллаж, энэ хугацаандаа Багш бэлтгэх түр курсын үйл ажиллагааг давхар хариуцаж байлаа. Тэрээр 1923 онд Нийслэл хүрээнд байгуулсан Ардын засгийн анхны дунд сургуулийн захирлаар ажиллаж, 1926 онд Гэгээрлийн сайд Эрдэнэбатхааны хамт Герман, Францруу анхны 35 монгол оюутныг авч явсан. 1927 онд Герман, Франц улсад сурч байсан монгол сурагчдын захирал, 1930 оноос Судар бичгийн хүрээлэнгийн жинхэнэ гишүүн, эрдэмтэн нарийн бичгийн дарга зэрэг ажил эрхэлж байжээ. Б.Ишдорж нь “Герман-монгол хэлний толь бичиг” 1928, “Монгол хэлний дүрэм” 1930, “Багш нарыг давтан сургах түр сургууль” 1930, “Монголын шинэ үсгийн заавар” 1931, “Унших дэвтэр” 1931, “Тооны ухааны товч тайлбар” 1931, “Монгол үсэг хэмээх дэвтэр” 1933, “Монгол хэлний яруу найруулга” 1934, “Хоёр үгийг хавсран бичиж болох эс тухай” 1935, “Монгол үсгийн сурах бичиг” 1936, “Шинэ толь бичиг гарсан тухай” 1937 зэрэг эрдэм шинжилгээ судалгааны өгүүлэл, сурах бичиг, гарын авлага бичиж хэвлүүлжээ. Мөн Ишдорж багш түмэн бодисын хичээлийн зүйлээс байгалийн шинжлэл гэдгийг найруулан монголчилж, бага дунд сургуульд заах хөтөлбөр, сурах бичгийн зүйлийг монголчлох ажилд нэлээд хүчин зүтгэсэн байна.



Анхны захирал Данийл Алтаевич Абашеев

Орос улсын харъяат Данийл Алтаевич Абашеев 1913 онд Буриадаас уригдан, Богдын хүрээнд ирж, анхны бага сургуулийг байгуулахад гар бие оролцон, тус сургуулийн монгол хөвгүүдэд 1918 он хүртэл хичээл зааж байсан монголын анхны сургуулийн багш юм. 1924 онд Монголд дахин уригдан ирж, 1924-1926 онд Оюутны сургуулийн анхны захирлаар ажиллаж байсан. Тэрээр хэл бичгийн ухааны эрдэмтэн бөгөөд олон ном зохиол, сурах бичгийг туурвиж, сургалтанд хэрэглэж байжээ.

Анхны багш Жамсраны Цэвээн

Жамсраны Цэвээн 1909-1910 онд “Азийн газарзүй” номыг орчуулснаар монголд соёл дэлгэрүүлэх ажлаа эхэлсэн гэдэг. Тэрээр Богд хаант Монгол улсын үед Гадаад яаманд орчуулагч түшмэл хийж байсан бөгөөд энэ үед (1914 онд) сургуулийн хэргийг Гадаад яаманд эрхлүүлэх болж, дэд сайд болон 2 түшмэлд хариуцуулсны нэг нь болж, сургуулийн хэргийг хавсран захирах болж, сургуулийн дүрэм хэмжээг тогтоон, орос, монгол үсгийн сургуулийг байгуулснаас гадна тус сургуульд орос үсгийн сургагч багшаар ажиллан, монгол хөвгүүдийг Эрхүү, Хиагт хотод илгээн, орос үсэг бичиг, хэлийг сургаж байжээ.



Олноо өргөгдсөний 11-р онд (1921) сургуулийн хэргийг Дотоод яаманд захируулах тухай Ардын засгийн тогтоол гарч, уг тогтоолд сургуулийн хэргийг үүсгэн явуулах зэргийг түргэлэн шийтгэх ба сургуульд чухал хэрэглэгдэх судар ном, шаштир түүх зэргийг бодолхийлэн зохиож үйлдэхэд эрдэмтэн түшмэл Жамсрановыг томилж, мөн сургуулийн хэргийг хамтатган эрхлүүлэхээр тогтоов гэсэн байна. Ийнхүү 1921 оноос Жамсраны Цэвээн Дотоод яамны сургуулийн хэлтэст ажиллахын хамт Багшийн түр курсийн үйл ажиллагааг давхар хариуцаж, сургалтын хөтөлбөр, ном, сурах бичгийг зохиож, сургуулийн дүрмийг зохион батлуулахын зэрэгцээ багшилж байлаа.

1923 оны 5-р сард Нийслэл Хүрээнд 4 сарын хугацаатай “Оюутны түр сургууль” байгуулж, тэр үед зааж байсан хичээл нь:

- | | |
|---|-----------------------|
| - Монгол бичиг | - Эдийн засаг |
| - Унших | - Монгол улсын түүх |
| - Үсгийн дүрэм | - Улсын эрх (төр эрх) |
| - Тооны ухаан | - Нягтлан бодох |
| - Түмэн бодис | |
| - Дэлхийн байдал | |
| - Бага насны хүүхдийг сурган хүмүүжүүлж сургах арга | |

зэрэг бөгөөд эдгээр хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичгийг бүгдийг Ж.Цэвээн буриад багш нарын хамт боловсруулж, зохиосон юм. Мөн сургалтын хугацаа дууссаны дараа тусгайлан төлөөлөгч, түшмэлийг томилж, сургагч нарын хамт шалган, тэргүүн, дунд зэргийн шалгагдсан сурагчдад сургуулийн хэргийг хавсарсан Дотоод Яамны тамга дарсан “Илэрхийлэх бичиг” олгон ажилд томилж байжээ. Энэ бүх ажлыг Ж. Цэвээн удирдан гүйцэтгэж байжээ. Энэхүү “Оюутны сургууль” нь Багш нарыг бэлтгэх сургуулийн суурь болсон юм. Энэ үед буриад багш нараас гадна Буриад хошуунаас хүмүүсийг элсүүлэн сургаж байжээ.

Анхны багш нарын нэг Эрдэнэбатхаан (Никита Федорович Батухан, нэр Эрдэнэ, овог Батхаан)



Эрдэнэбатхаан Эрхүү хотын багш нарын семинарт суралцсан мэргэжлийн сурган хүмүүжүүлэгч хүн юм. Тэрээр 1912 онд Ж.Цэвээний зөвлөснөөр Монгол оронд ирж Нийслэл хүрээний бага сургуульд багшлахын сацуу хувьсгалын үйл хэрэгт гар бие оролцон, 1921 оны 3 дугаар сарын 24-нд Монгол Улсын Засгийн газрын анхны нарийн бичгийн дарга болж, Гадаад явдлын яаманд орчуулагч, зөвлөх хийж байгаад

1921 оны 11 дүгээр сард МАН-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж, В.И.Ленинтэй уулзсан ажээ. Тэрээр 1921-1924 онд Судар бичгийн хүрээлэнгийн ажилтан, Дотоод явдлын яамны дэргэдэх бага сургуулийг хариуцсан хэлтсийн эрхлэгчийн ажлыг хашиж байгаад 1924 оноос Судар бичгийн хүрээлэн нь Ардыг Гэгээрүүлэх Яам

болон өргөжсөний дараа тус яамны хоёрдахь сайд болжээ. Эрдэнэбатхаан нь 1925 онд Орос, Франц, Герман зэрэг оронд оюутан сургах ажлыг санаачлан зохион байгуулж, Ардын засгийн анхны дунд сургуулийн анхны 35 сурагчийг Герман, Франц улсад удирдан авч явснаас гадна боловсролын байгууллагын үүсэл, хөгжлийн талаарх туршлагыг судлахын тулд ЗХУ, Герман, Франц, Итали зэрэг маш олон улсад ажлын айлчлал хийсэн байна. Эрдэнэбатхаан 1921-1929 онд монгол орон даяар нийт 300-аад сургууль байгуулах ажлыг удирдан зохион байгуулсан ба монголын ард түмнийг соён гэгээрүүлэх чиглэлээр олон арван өгүүлэл бичиж нийтлүүлж, Монгол хэлний сурах бичиг, Газарзүйн ном, Азийн улс орнуудын тухай ном, Монгол хэлний ярианы толь, Түүх-газарзүйн сурах бичиг бүтээжээ. Мөн хэвлэх үйлдвэр байгуулах, багш нарыг бэлтгэх чиглэлээр санаачлагатай ажиллаж байв. Энэ бүхний дүнд 1924-1929 онуудад шинэ Монгол улсын орчин үеийн боловсролын системийн үндэс суурийг тавьж чадсан юм. Тэрээр мөн Орос буриадад монгол бичгийн шинэ сургалтыг түгээсэн ажээ.

Ийнхүү уригдан ирсэн буриад багш нар Шинэ монголын боловсролын салбарт хүчин зүтгэж, шинэ сургуулиудад маш олон сурах бичгийг зохиож өгөөд зогсохгүй Багшийн сургуулийн багш нарт сургуулийн программ төлөвлөгөө хийх, сургууль удирдах арга, сургуулийн дотоод журам дэглэмийг зааж, багш хүн өөрөө боловсон ёс суртахууныг эзэмшсэн, ажил хөдөлмөрт идэвх зүтгэлтэй байвал сая бусдыг тийм болгон хүмүүжүүлж чадах учрыг өөрсдийн биеэр үлгэрлэж байлаа. Энэхүү уригдан ирсэн багш нарыг тус сургуулийн багш, сурагчид “*эрдэмтэн багш*”, “*боловсон багш*” гэх мэтээр нэрлэж байсан нь Оюутны сургуулийн 1926 оны 9-р сарын цалингийн цэснээс харагдаж байна. Үүнд: Цалингийн цэсэн дэх багш нарын нэрсэнд, Нийтийн түүхийн багш Эрдэмтэн багш Цэвээн Жамсранов, Дэлхийн байдал, түмэн бодисын ухааны багш Эрдэмтэн багш Батхаан, Хэмжих ухааны болон орчуулагч багш Боловсон багш Кинева, Боловсон багш Марикева гэх зэргээр бичсэн байна.



1924 оны Багшийн сургуулийн багш, оюутнууд



1925 он. Монголын бүх багш нарын анхдугаар
зөвлөгөөнд оролцогчид

Багшийн сургуулийн ахмад төгсөгчид дурсамжиндаа: “Буриадаас уригдан ирсэн мэргэжилтэн Санжин, Гомбоен нар “Түмэн бодис”, “Хүний биеийн анатоми” хичээлүүдийг сайхан зурсан үзүүлэн таниулах ашиглаж, маш ойлгомжтой заадаг байсан, мэргэжлээ бахдам сайн эзэмшиж, заах аргын их туршлагатай болсон эдгээр багш нараар хичээл заалгаж байсан маань бидний мэргэжлээ сонгоход зохих нөлөө үзүүлсэн” гэж өгүүлсэн байдаг. 1920-оод оны сүүлчээр ЗХУ-аас уригдан ирж ажилласан сургагч багш нар нь Шармун – 1929 – барималч, Ш.С.Кольцов -1929-хөгжим, Санжина -1928-1938 – тоо, А.С.Хандашкеев-1929 нар байлаа.

Мөн 1930 оноос орос, буриадын мэргэжилтэн багш нартай хамтран монгол улсад анх удаа Багшийн сургууль дээр Шинэ жилийн сүлд модны наадмыг тэмдэглэж, тэдний туслалцаатайгаар амьтдын баг буюу маск хийж, зүүж байснаа дурссан байдаг.

Уригдан ирсэн сургагч багш, мэргэжилтнүүд хэд хэдэн дугуйлан байгуулж, оюутнаар ширээ, сандал, номын тавиур, өлгүүр, төмөр хувин, хүрз, малтуур, сийлбэр, уран зураг, оёдол, нэхмэл, наамал хийлгэж, бүтээлээр нь улсын баяр наадмын /павильон/ үзэсгэлэн гаргаж, хөдөлмөрчдөд сурталчилж байсан гэжээ. Мөн хөдөлмөрийн багш Казанков орос савхин гутал хийх, уллах, эсгий гутал сэлбэх, гуталд зан тавих, ширээ сандал, хаалга цонх засах зэрэг хөдөлмөрт сурагчдыг сургадаг байсан нь туйлын тустай зүйл байв. Тодруулж хэлбэл, нүүдэлч малчин монголчуудын хувьд эдгээр ажил хөдөлмөрийг хийж, олон янзын бүтээл туурвиж, эд зүйлс хийх болсон нь цоо шинэ соёл нэвтэрч байсан хэрэг байлаа.

Үүнээс гадна хичээлээс гадуур драм жүжиг, утга зохиол, дуу хөгжмийн дугуйлангууд байгуулагдаж, дээрх дугуйланд суралцаж байсан сурагчдаас зохиолч Д.Сэнгээ, Д.Гармаа, П.Хорлоо, хөгжмийн зохиолч Гончигсумлаа, улсын гавьяат зураач Цэвэгжав, Чойдог, гавьяат жүжигчин Гомбодорж, Ринчин нарын олон арван авьяастнууд төрсөн нь буриадын сэхээтнүүд, сургагч багш нарын ач гавьяа билээ.

Дээр өгүүлсэнчлэн багш нарыг урьж ажиллуулж байснаас гадна оросоос хими, физик, биологийн кабинетыг тус сургуульд өгч, эдгээр кабинетуудыг 1932 онд театрын хойд талд барьсан Багшийн сургуулийн дан тоосгон байшинд байрлуулж, байгуулсан байна.

Түүнчлэн тус сургуульд ажиллах орос, буриад, зөвлөлтийн сургагч багш нарын тоо жилээс жилд өсч, суралцагчдын судлах шинжлэх ухааны мэдлэгийн хүрээ өргөжиж байсан нь дараах баримтаас харагдаж байна. Үүнд: 1938 оноос Багшийн сургуульд үзэх хичээлийн тоо 12 байснаа 27 болж нэмэгдэж,

1. Дэлхийн байдал
2. Орос хэл
3. СССР-ийн түүх
4. СССР-ийн Үндсэн хууль

5. Бүх холбоотын эв хамт намын түүх зэрэг хичээлийг шинээр үзэх болж, орос, буриадын мэргэжилтэн, сургагч багш нар заах болсон байна.

Мөн 1939 онд тус сургуульд сургагч багш нарын дэмжлэгтэйгээр Орчуулагчийн анги нээж, түүнд 30 оюутан суралцаж төгсчээ. Ийнхүү Монгол улсад багшлах боловсон хүчин бэлтгэхэд орос, буриад, зөвлөлтийн мэргэжилтнүүд ирж тусалж байснаас гадна 1920-иод оноос эхлэн Орос, буриадад монгол сурагчдыг явуулж, багш болон янз бүрийн мэргэжилтнүүдийг бэлтгэх болсон байна.

Тухайлбал, монголчуудыг сурган боловсруулахад Улаан-Үдэ хотын Монгол багшийн сургууль – РАБФАК асар их гүйцэтгэсэн юм. Гэвч Аугаа эх орны дайны жилүүдэд гадаадын олон оюутан сурагч Орос улсад байх аргагүй болж буцахад хүрч байсан бөгөөд Улаан-Үдэд 10 жил болсон РАБФАК-г 1941 онд татан буулгаж, монгол оюутнуудад хичээл зааж байсан газар зүйн багш Хашганова, Будаев, орос хэлний багш Олзоев, мэргэжилтэн Ричкова нарыг тэнд суралцаж байсан 140 оюутан, тэдний хэрэглэж байсан эд материал, хичээлийн хэрэгсэл, номын сангийн хамт шилжүүлэн авчирч, Улаанбаатарын Багшийн сургуульд нийлүүлсэн байна. Рабфакаас ирсэн хүүхдүүдийг Багшийн сургуулийн жинхэнэ анги, дунд ангийн багш бэлтгэх түр курст хуваариалан сургаж төгсгөжээ.



*Багш нарыг бэлтгэх сургуулийн нийт багш нар. 1943 он.
/МУ-ын Гавьяат багш Дондогийн Цэвэгмид, урд эгнээнд
зүүн гар талаас 2 дахь нь/*

Орос, буриад, зөвлөлтийн мэргэжилтнүүд тухайн үеийн монголын төр засгийн бодлого шийдвэрийн дагуу Багшийн сургуульд өгөгдсөн цаг үеийн шаардлагатай, чухал үүрэг даалгаврыг биелүүлэхэд нь тус сургуулийн багш нарын адил гар бие оролцон тусалж байсан юм. Тухайлбал, 1942 оны хавар багш нэн шаардлагатай болсон учир Өндөрхаан, Улаанбаатар, Алтанбулаг, Цэцэрлэг, Улиастай, Жаргалант хотуудад аймаг дундын 7-р анги төгсөгчдийн 45 хоногийн түр курс байгуулж, багш нар бэлтгэн гаргаж байсан байна.



Багш нарыг бэлтгэх сургуулийн нийт багш нар. 1944 он

Монголын багш нар ийнхүү орос, буриадын мэргэжилтнүүдээс ихээхэн зүйлийг сурч мэдэж, тэднээр дамжуулан дэлхийн соёл боловсролтой танилцаж, Оросын А.С. Пушкин, М.Ю.Лермонтов, М.Е.Салтыков-Щедрин, Л.Н.Толстой зэрэг нэртэй сонгодог зохиолчдын бүтээлийн зах зухтай танилцахаас гадна орос хэлний мэдлэгтэй болж байжээ.

1945 оноос манай улсын ерөнхий боловсролын сургуульд орос хэл заах болсон тул тэр даруйд Багшийн сургуульд уригдан ирсэн багш Андреновагийн удирдлагын дор оросын харьяат, монгол оронд төрж суурьшсан орос иргэдийн 40 шахам орос хүүхэдтэйгээр “Орос хэл бичгийн багш” бэлтгэх тусгай анги байгуулж, 3 жил суралцуулан төгсгөсөн байна.



1945 оноос Орос хэл бичгийн багш бэлтгэсэн нь

Мөн хожим 1980-аад оны эхэн үед орос хэлийг нэн чухалд тооцож байсныг үндэслэж, АБЯ-ны бодлого чиглэлийн дагуу 1983 онд тус сургуулийн III ангиудаас орос хэлэнд авьяастай хүүхдүүдийг шилж сонгон, 30 оюутантай “Бага ангийн орос хэлний багш”-ийн ангийг захирлын тушаалаар нээж, мэргэжлийн ангийн багшаар Нанжид, П.Гүндэгмаа нар ажиллаж байжээ.

1956-59 онд багшилж байсан Ц.Ринчин дурдатгалдаа: Багш ажилчдын бүрэлдэхүүн маань ч халх, буриад, орос, казак, хятад зэрэг олон үндэстэн ястнаас бүрэлдэж, эвсэг найртай ажиллаж байсан болохоор сурагчдад интернационалч хүмүүжил төлөвшүүлэхэд бодит нөлөө үзүүлж байсан нь дамжиггүй хэмээсэн нь үнэхээр зөв зүйтэй дүгнэлт бөгөөд багшлах боловсон хүчний талаар нэгийг бодогдуулж байна.

Багшийн сургуулийн 90 гаруй жилийн түүхэнд нийт 70 гаруй орос, зөвлөлтийн мэргэжилтэн үүнээс 20-иод буриадын сэхээтэн, багш нар ажиллаж байжээ. Үнэхээр тэд монголын багш нарыг бэлтгэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж, Багшийн сургуулийг багшлах боловсон хүчнээр хангахад төдийгүй мэдлэг боловсролтой, заах арга зүйтэй, орос хэлний мэдлэгтэй, боловсон ёс соёлтой, интернационалч хүмүүжилтэй, шинэ үеийн багш нарыг бэлтгэхэд агуу их хувь нэмэр оруулсныг нь үнэлж баршгүй юм.

Буриадын сэхээтнүүд, оросын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар зөвхөн Багшийн сургуулийн багш, сурагчид төдийгүй монголын ард түмэн оросын болон дэлхийн соёл, боловсролтой танилцаж, ард түмнээ бичиг үсэгт сургахад манлайлан оролцож, эх орондоо соёлын довтолгоог амжилттай хийж, улмаар өнөөдөр бичиг үсэг мэдэх түвшингээрээ доогуур орох Ази тивд оршдог ч Монгол улс хүн амынх нь 97% бичиг үсэгт тайлагдсан гэдгээрээ гайхагдаж байна. Энэ бүхэн буриадын сэхээтнүүд, буриад болон оросын мэргэжилтэн, сургагч багш нарын нөр их хичээнгүй хөдөлмөр зүтгэл, монголын ард түмнийг бичиг үсэгт сургах гэсэн хүчин чармайлтын ач гавьяа мөн. Мөн шинэ тулгар Монгол улсын боловсролын суурийг тавьж хөгжүүлэх энэхүү үйлсэд угсаа гарал нэгт буриадын сэхээтнүүдийг татан оролцуулж, тэдний мэдлэг боловсрол, хүчийг дайчилж байсан нь маш зөв зүйтэй хэрэг байлаа.

ХАВСРАЛТ

Уригдан ирж ажиллаж байсан буриадын сэхээтнүүд, багш нарын нэрсээс:

1924 он - Оюутны сургуулийн анхны захирал Д.А.Абашеев, 1924-1926

- Багш нар Цэвээн Жамсранов, Эрдэнэбатхаан, Хазгаев...

1928 он – Санжин 1928-1938 он, түмэн бодисын багш

1929 он – Шармун 1929 он

барималчин Гомбоен 1929-1930

1940-өөд он – К.А.Олзоев 1941-1945 он, орос хэлний багш

С.А.Хамаганова 1941-1943 он, математикийн багш

Дамчинов 1941-1943 он, сурган хүмүүжүүлэгч

Будаев 1941-1942 он

Ишханова 1942-1944 он

1983 – С. Бадусева

Ашигласан материал

1. Багшийн сургууль. Түүхэн товчоон (1922-2002) УБ. 2002
2. Багшийн сургууль. Түүхэн зургийн цомог (1922-2007) УБ. 2007
3. Монголын автономит үеийн сургууль. (1911-1920). УБ.1966
4. Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. (1921-1960). УБ.2011
5. МУБИС-ийн Багшийн сургуулийн музейн баримт бичгийн болон фото архив.
6. А. Оюунтунгалаг. Монгол улсын буриадууд. УБ.2004
7. УТА. Сх 23,д.1,хн.11. эх

Халбин овогт
Аюурын Самбуу,
доктор, профессор
Буриад судлалын академийн
дэд ерөнхийлөгч

МОНГОЛ ХҮНИЙ ХӨГЖИЛ УГИЙН БИЧГЭЭР ХӨТЛӨГДӨЖ БАЙЖЭЭ

Монголчуудын угийн бичиг бол дэлхийд гайхуулахуйц манай үндэсний соёл, түүх, оюуны үнэт өв юм. Доктор Б.Сумъяабаатар угийн бичгийг “монголчуудын тусгаар тогтнолын тунхаг, монгол түмэн юуг бусдад уусгахгүйгээр бидний үед авчирсан ачлалт ном, есөн эрдэнээр номоо бүтээгсдийн удам-монгол туургатан бидний оюуны соёлын хосгүй дурсгал юм. Өнгөрсөн үе үгүйгээр одоо үгүй, одоо үгүйгээр ирээдүй үгүй хэмээх аугаа санаа агуулсан гүн ухааны дэвсгэртэй бичиг, төрийн тэргүүнд харийн хүн орох хий зай гаргахгүйн баталгаа бологч судар, цус ойртож, бие бөлгөн, ухаан мунхаг, удамшлын өвчин согог бүхий үр ач нартай болохоос оmtгой, хуумгай үгүй сэргийлэгч, монгол айл өрх бүрийн өвөг дээдсээс нь уламжилж үлдсэн дархан хөрөнгө гэж ач холбогдлыг тод яруу тодорхойлж бичсэн байдаг. /1/

Угийг бичиг бол хүмүүний талаар үлэмж ихийг өгүүлэх шаштир бүлгээ. Тухайлбал, энэ нь садан төрлийн хүмүүсийн үе удмын тоог илэрхийлээд зогсохгүй дээд үе өвөг төрөлтэйгээ удмын үндсээрээ ямар холбоотой, нэг шугамын төрөл хүмүүсийн удам шинжийн онцлог, бүтэц бүрдэл, авъяас чадвар, оюун билэгт чанар, олныг татах, дагуулах гадаад эрхэм шинж, дүр төрх, бие бялдын хөгжил, зан харьцааны тал, зиндаа дэвийн хэмжээ зэрэг энэ бүхний дотоод чанарыг тодотгох, агуулга хэлбэрийг харуулах нэн олон зүйлийн мэдээллийг агуулагч, хүмүүн, овог, отгийн удам угсааг өөд нь өгсүүлэх, өнгөжүүлэхийг заагч зүйл билээ. /2/

Монголчууд нь хүн нийгмийн түүхэнд төрт улс, эзэнт гүрнийг цогцлоосон цорын ганц нүүдэлчин гэгддэг бөгөөд нийгэм болон хүний хөгжил, хүмүүний чадал чадавхийг өргөхийн чухлыг анзаарч тэгснээр хотлоороо угийн бичиг хэрэглэх, угийн бичигтэй байх учир зүй, ёс заншлыг анхлан үүсгэж мөрдсөн үндэстэн юм. Хүмүүн өөрийн амьдралын залгамжийг зориудын санаа орсон үргэлжлэлтэй болгоё гэснээр амьдралын тойрог, үе удмын залгал бүрд үр хүүхдийн хүч чадлыг ахиулсаар байгаад үндэстнээ бүхэлд нь хүчирхэг чадварлаг болгон

хөгжүүлэх үйл явц байна гэдгийг ойлгоод, түүний үүсгэл үндэс нь энэхүү угийн бичиг шаштар юм гэдгийг анхлан гаргасан. Энэ үед “тэнгэр заяат”, “нагацын тэнгэр”, “бэр авах зүг” зэрэг шинэ ойлголт нэр томъёо гарч энэ бүгд одоо шинжлэх ухааны үндэслэлээр тайлбарлагдаж болж байна.

“Судрын чуулган”-д дурьдаж байгаагаар монгол хүн өөрийн биеэс дээш найман үеэ нэрлэдэг. Тэд 9 дахь үеэ Элэгдсэн өвөг, 8 дахь үеэ Буденжарь буюу Буданшар, 7 дахь үеэ Дутсан хүн, 6 дахь үеэ Юүрхий (зүрх гэж буулгах нь ч бий) буюу юүрч бутарсан, 5 дахь үеэ Бод үхэр (том үхэр), 4 дахь үеэ Бод тур буюу том тур, 3 дахь үеэ Өвөг, 2 дэх үеийг Эцэг хэмээн нэрлэдэг байжээ. (7)

Хүнийг удам дагуулан хөгжүүлэхэд нөлөөлдөг олон хүчин зүйл бий. Энэ нь шинээр овог, хөхүүр үүсгэж генийн сангийн ялгааны эхлэл тавихаас авахуулаад тодорхой удамтны хувьд бэр авах зүг чигийг гаргах зэрэг орно. Энэ нь үр хүүхдийн генийн бүрдлийг сайнаар нийлүүлэх амьдралын практик гэсэн үг.

Удам угшлыг сайн бүрдэлтэй болгож өгснөөр үе үеийн залгал үр удамын хэмжээнд сайжрал өгөх олонлиг үндэс бүхий шинэ шинэ хувилбар үүсч түүнийг тогтворжуулан хам сайн удамшилтай болгож хүчтэй билэгтэй, хүний олон сайхан шинжийг өвлөсөн үрийн заяа буй болгодог байна. Бөртэ-чино, Бодончар богдын үр сад дээд тэнгэрээс гарал заяатай онцгой удам угсааныхан, бусад овгоос ялгарахыг хичээдэг, удамд сайн нөлөөтэй бүхнийг ашиглахыг эрмэлздэг байсан гэж эх сурвалжуудад бичигдсэн нь бий. Хүмүүний үе удам, шугам шугамын угсааны уг чанар бүрдэх, ахих дэвших боломж олгох, элит хэсэг ялгаран гарах нөхцөл тодорхойлогдсон байсан, тийм учраас угийн бичгийн нэг гол зорилго бол яах аргагүй хүнийг удам дагуулж хөгжүүлэх санаа агуулгатайгаар анхлан тавигдсан гэж болно.

Хүний удмын чанарт ясан болоод мах цусан шугамын генийн тодорхой бүрдлийг буй болгож хүмүүнийг удамжуулан хөгжүүлэх боломжтой гэдгийг монголчууд ойлгосон учраас угийн бичгийг манай тооллын 700-750 оны үед анхлан нийтээр мөрдөх болж тэгснээр өөрийн үндэстний сор сод буюу элит овогтонгуудыг 1000 он гэхэд жинхэнээр нь үүсгэн бүрдүүлж улмаар 1162 онд орой их эзэн Чингис хааныгаа тэнгэрлэгээр тохиолгон төрүүлэх заяа төөргийг бүтээсэн гэж болно. Өөрөөр хэлбэл, үндэстнийхээ оюун билэгтэй, төгс төгөлдөр төрмөл шилдгүүд, төрийн жолоо, түмний заяаг түшүүлэх элит лидерүүдийг угийн бичгийнхээ заалт заавраар тохиолгон төрүүлсэн, тиймээс ч нэгэн цаг үед монголчууд өөдөө явж өгсөж чадаж байсан юм.

Угийн бичиг гэхээр тайж нарын удам угсааны тухай зүйл гэж мунхаглаж байсан үед их номч Жамсрангийн Цэвээн ахайтан, билэг их гүүш Ренчин багш, нэрт их эрдэмтэн Х.Пэрлээ гуай нар угийн бичгийн талаархи судалгааг хувьдаа далдуур хийж байсан гэдэг бөгөөд тэр бүхний үргэлжлэлийг хойч үеийн залуу эрдэмтэн Б.Сумъяабаатар өвлөж өнгөлсөөр яваа билээ.

Доктор Б.Сумъяабаатарын гайхамшигтай нэгэн дүгнэлт бий. Энэ нь “Монголын нууц товчоо”-ноос өмнө монголчууд угийн бичгийг “узуурын бичиг” хэмээн нэрлэж байсан, ийм байх нь үг хэллэгийн хувьд зөв юм, узуурын бичиг нь монголчууд эрт үед ямар ч болов бичиг үсэгтэй байсныг харуулж байна” гэж дүгнэжээ. “Монголын нууц товчоо” номд Чингис эзнээс дээш 20-иод үеийн хэдэн арван хүний удам угсааг тэмдэглэж тэгэхдээ нэг айлын тэргүүлсэн, дунд, бага хөвүүдийн дэс дарааг алдагдуулалгүй зөв бичсэн төдийгүй тэдний салаа салбарыг хүртэл тоолж тоочин бичсэн нь яавчиг санаан зоргоор үйлдсэн бус, ямар нэгэн бичмэл эхийг харж байгаад нягт нямбай хуулсан нь илэрхий харагдаж байна гэж тэрбээр дүгнэсэн нь цаанаа шинжлэх ухааны олон санааг давхар агуулах бүлгээ.

Их хааны угийн бичгийг “Монголын нууц товчоо”-ноос авбал, Бөрт чоно-Батачи хан-Дамача- Хоричар мэргэн-Агужим Борахул-Сали Хажуу-Их нүдэн-Симсочи-Харчу-Боржигидай мэргэн- Торголжин баян-Добун мэргэн /Алун гоо/-Бодончар мунхаг, Хабич баатар- Мэнэн Түдүн- Хачи Хөлөг- Хайду- Бай Шонхор Догшин- Тумбинай Сэцэн- Хабул хаан- Барданбаатар- Есүхэй баатар- Тэмүжин Чингис хаан гэж бичигддэг. Тэд бүхний салаа салбарыг цааш нь бас ялган тэмдэглэсэн байдаг. Энэ бүхнийг холбон үзсэнээр үнэнхүү ихийг тайлан унших нөхцөл боломжтой бүлгээ. Ийм гайхамшигтай өв соёл энэ орчлонд үнэндээ ховор бизээ. Тэгэх тусам үндэстний удмын орой, хаан удмынхны үе үеийн хүмүүсийн залгал, удмын аргамжин хэлхээ, зиндаа хэмжээг бид одоо мэдэж үнэлж дүгнэж байгаа маань юутай завшаан билээ.

Угийг бичгийг айл өрх бүрд мөрдүүлж хөтлүүлэх санаа анх яаж гарсныг эхлээд нийгэм болоод хүмүүний уг удамшил генетикийн ойлголттой холбосон таниулга гэгээрүүлгээс эхлүүлсэн гэж бодном. Монголчууд эрт үеэс мал аж ахуйг хөтлөн авч явсан уламжлалтай учраас амьтны үржил, үржүүлэг, түүний удам угшлын талаарх ерөнхий практик мэдлэг өндөр байсан гэж ойлгогддог. Тухайлбал, амьд бүхэн сайнтай муутай төрдөг, амьтан бүхэн, түүний дотор хүмүүн ч бас амьдралын залгамж шинж тэмдгийн үндэс-удамшихуй-генийн сантай гэж, тухайлбал, хүмүүний шинж чанар бүрийг тус тусд нь удамшлын хүчин зүйл хариуцдаг, тэр бүгд хүнийг бүхэлд нь буй болгож бодигдуулдаг, энэ нь үеэс үед тогтвортой дамждаг, хүнийг ясан болоод мах цусан төрөл болгож шугам шугамаар нь ялган авч үзэж байсан, эх эцгийн удам генүүд хоорондоо янзбүрийн хосолбор үүсгэж болдог, ингэснээр үе удам бүхний шинж тэмдэг хувьсал өөрчлөлтөнд орох нөхцөлтэй, тэгвэл хүний шинж чанар дэвшил сайжралд орж болно хэмээн, энэ нь эцсийн эцэст хүмүүний сайн сайхан шинж чанар бүгдийг үндэстний генийн санд хуримтлуулан цуглуулж тодорхой удам шугамд нэгтгэн нийлүүлж, тэгснээр хүмүүнийг удам дагуулан хөгжүүлж улмаар ястан үндэстнээ бүхэлд нь дэвжээх нөхцөлтэй гэсэн үзэл санааг гаргаж тусгасан нь ойлгомжтой байгаа юм. Хойч үр садын ирээдүйг тэтгэх, хувь хүнд бол амьдралын хань ижлийг зөв сонгохоос эхлээд олон зүйлийн мэдлэг оюуны хуримтлал дээр энэ асуудлыг зөв тавилтайгаар

эхлүүлэхийн чухлыг заасан хэнд ч гэсэн гайхал төрүүлэм энэ бичиг бол үнэндээ дотроо агуу утга учиртай судар мөн юм. Угийн бичгийг хөтөлдөг болсноор онцгой сод сор хүмүүнийг тохиолдлын нэгэн хувилбар байдлаар бус удам дагуулж лавтайяа төрүүлдэг болгох хосгүй мэдлэгийг буй болгож чадсан юм. Монголчууд бид өөрсдөө энэ угийн бичгийн бүтээгдэхүүн, тийм учраас угийн бичгээ сэргээн хэрэглэвэл цаашид хүчтэй удамлаг явсан, тийм атлаа олон зуунд их хэлмэгдэлд орж дордсон, харин одоо уг удмын хүч чадлаа сэргээж, чадалтай үндэстний нэгэнд эргэн орж болно, тэрийгээ хойч хойчид хэвээр нь залгамжлан хадгална, үүнийг эс хийвээс улам уруудан доройтно гэдгийг түүхээрээ ойлгоод байгаа юм.

Юув гэхэд, Манж Чин улс монголчуудын гарал үүслийг мартагнуулах гэж юу хийж байв, удам угшлаар нь сөхрүүлэх доройтуулах гэж ил далд элдэв явуулга бодлогыг зуун зууны туршид хэрхэн хэрэгжүүлэв. 20-р зууны эхэнд монголын төр засаг ч бас оросын заавраар үндэстнийхээ хувь заяаны уг удмын үндэс угийн бичгийг нүд үзүүлэж, хүмүүсийн удам гарлыг албаар мартагнуулах бодлогыг илт үргэлжлүүлсэн байдаг билээ. Тэд угийн бичгийг зарлигдан хориглож өөрийн улс орны бичиг номын мэргид, тайж угсаатан, төрлийн дарга, настангууд зэрэг удмын хүч чадлаар олон зууны ялгарлаар гарсан шигшмэл зэрэг зиндаатай болсон хүмүүсийг хоморголон баривчилж устган хороосон билээ. Уг удмаараа хүн амын элит хэсэг болон ялгарч явсан үе үеийнхний сонгомол давхрагыг ингэж хөнөөх аймшигт цээрлэл социализмын үеийн хүн амын хоёр гурван үе буюу 70 орчим жил үргэлжилсэн билээ. Ингээд бодохлоор сүүлийн 400 жилийн туршид хүний болон өөрийн бүх хар хүчин монгол түмний мах цусаараа ойлгож мянга мянган жил амьдрал ахуйдаа хэрэглэж ирсэн удмын залгамж хэлхээ, түүнийг нөхцөлдүүлэгч оюуны их өвийг хумиж хамтад нь бүдэгрүүлэх, устгах, үндэстний их хувь заяаны хүч чадлыг унтраах оролдлого байнга хийж ирсэн байдаг билээ. Гэвч угийн бичгээ өнгөрсөн цөвүүн цагийг давуулж авчирч чадсан манай ард түмнийг үнэндээ агуу гавъяатай хүмүүс гэж хэлэх учиртай. Иймд эгэл ардын энгүй үнэт шүтээн, хүмүүний сайн сайхны заяаг өргөж өсгөдөг, их эзэн хаанаа тэнгэрлэгээр тохиолгон төрүүлж өгсөн энэ угийн бичгийг Их Монгол Улс байгуулагдсаны өндөр их ойгоор төрийн яамны хоймор, засгийн ордны зааланд хүндэтгэлтэйгээр залах нэгэн учиртайг үл тоомсорлосоор байгаад эгэл түмэн харамссаар байгаа. Хүний нандин бүхнийг дээдлэх, хүмүүнийг удмыг нь дагуулан хөгжүүлэхийн ач холбогдол, эх булагийн ундарга нь чухам хаана гэдгийг бүрэн гүйцэд ойлгохгүй байгаагийн нэгэн жишээ энэ гэлтэй.

Монгол Улсын хүн ам гэхэд 1918 онд 640 мянга байгаад одоогийн 2 сая 800 мянга болох энэ хооронд хүн амын дотор садан төрлийн удмын холбоо бий болж төрөл ойртолт ихсэж байгаа нь судалгаагаар тогтоогдоод байна. Энэ нь удмын улбаатай эрэмдэг дутуу, хөгжлийн элдэв гажигтай үр сад төрөх, олшрох хандлага үүсч байна гэсэн үг. Энэ бол аймшиг мөн. Дэлхийн хэмжээнд тарсан бүх монголчуудын бүлэг хэсгийн нийт хүн амын хувьд ч бас ийм аюул нүүрлэж байгаа

болов уу. Хэрчигдэж тасарч, цөөн цөөнөөрөө тархан амьдарч байгаагийн нэг гай нүүрлэж эхэлж байна гэсэн үг. Хэрэв монголчууд бүгдээрээ нэгдмэл, нийтээрээ байсан сан бол ийм аюул байхгүй байсан байх. Арын долоо, өврийн таван отгийн урианхан, жалайр, бэсүүд, элжигэн, хатагин, хонхэрээд, баарин, олхонууд, горлос, сартуул, хэрэгүд зэрэг олон аймгийн нэгдэл, гарал цус ялгаатай хүмүүсээс бүрдэж байсан Зүүн монголын 6 түмний нэгнээс бүрдэлтэй Халх түмэн гэхэд л бид одоо ийм байдалд ороод байна.

Коммунист засаглалтай Орос, Хятад хоёрын цаад бодлого монголыг угсаатных нь хувьд задлахын тулд ястан гэдэг нэг ойлголтыг гаргасан байдаг. Энэ нь монголчуудад наалдаж ирэхдээ Монгол хэмээх энэ улсад олон ястан байдаг, тэд уг үндсээрээ ялгаа заагтай гэсэн онол болж тавигдсан. Харин одоо овгоо сэргээгээд харж үзвэл бид бүгд цөмөөрөө л монгол гэсэн нэг үндэс угтай гэдэг нь мэдэгдэж байх ажээ. Овгоороо бол шарнууд, хэрэйд, боржигин, жалайр, хонгирад, бодонгууд, гөрөөчид, халбин болж тэгснээр халх, буриад, өвөр монгол, дөрвөд, захчин мэтийн нэр томъёо хэрэггүй болоод байна. Ястан гэдгийг их гүрний коммунистууд гаргаж, түүнийг нь Монголд дагуулан буулгаж авсан юм байна. Тэгээд нэг угсааны баруун болон зүүн хязгаарын, бас өмнөд, хойдох монголчуудыг дунд нь ялгаж салгаж ястангууд гэж нэрлээд зориудаар нэгэн ангилал буй болгожээ. Энэ бол монголчуудыг нэгдэхээс болгоомжилсон гадныхны бодлогын үр нөлөө гэдэг нь ойлгомжтой болж ирж байна. Үнэндээ бид үндэс нэгтэй саглагар ганц мод мөн, энэ нь овгоороо ил байна. Үүнийг хүмүүс одоо ойлгох хэрэгтэй. Овгоороо, гарбал үндсээрээ бид нэг л үндэстний улс гэдгээ батлаад байгаа авч одоо ястан гэж ойлголтоор монгол угсаатан нэгнийгээ харь элэгтэн өөр гарбалтан мэт санаж хоорондоо нийлэх нэгдэхээ хязгаарлаад явснаас болж эрүүл саруулаар өсөн үржих замаа алдаж эхэлжээ гэж болно.

Энэ бүхнээс үзэхэд монголчууд бүгд нийлж нэгдэж амьдрах ёстой гэсэн нэгдсэн монголын үзэл санаа үнэндээ бидний хувьд зөв, монгол үндэснийхээ удмын санг хадгалах, хүмүүсийнхээ оюун билгийг хөгжүүлэх, зиндаа чадлыг нь нээж өргөх гэсэн холын ирээдүй бүхий зөв үндэстэй үзэл санаа, зөв бодлого байжээ гэж ойлгогдож байна. Монголчуудыг эргэж нэгдүүлэх гэсэн нэгэн үеийн оролдого болох панмонголизмын үзэл санаа зөв байж, энэ нь өнөө ч чухал хэвээр байна. Энэхүү үзэл бол бүх Монголчуудын үе үеийн хүсэл, Монгол үндэстний хамгийн эрхэм бодлогын нэг, тиймээс ч хүн ардын сэтгэл зүрхэнд амьд байгаа. Харин цус төрөл ойртоод байгаа энэ үед илүүгээр ойлгогдож байна. Харин Шинэ Монгол гэсэн үзэл нь бидний хувьд хүлээж авах аргагүй онол гэдгийг дашрамд хэлмээр байна. Одоо хүнийг удамжуулан хөгжүүлэхийн зарим асуудлыг бичсү.

Удамших хувьслыг ашиглаж хүнийг удам дагуулан хөгжүүлэх боломж бий.

Энэ үндсийг угийн бичиг тайлбарлаж заавар өгч чадна. Тухайлбал, генүүд хромосомд ямар байршил, байрлал бүхий байхаас хамаарч тэдний хоорондын

харилцаа, нөлөөлөл үүсэх процесс явагдах бөгөөд энэ бүхэн нь хүн хүний шинж чанар хэлбэр, дүр төрхийг тодорхойлдог анхны шат болно. Полимери буюу олон ген нийлж нэг шинжийг үүсгэдэг генээр нөхцөлддөг шинж, тэр нь үе удам тутамд ямагт давамгайлан илэрч гардаг, бас заримдаа сайн тохирол тохиолыг нэгтгэж нэмснээр илүү сайжрал олдог онцлог удамшил юм. Ийм угшилтай удмынханы үр хүүхэд нь бүлэг сүргээрээ бүгд сайн сайхан шинж чанартай төрөх хандлага, давамгай заяатай байх бүлгээ.

Хүний угшил удам, бие даасан тусгаар ген гэгч байдаг л юм бол түүний шинж чанарын хувьсал явагдаж байх ёстой гэдэг нь логик сэтгэлгээний үүднээс ойлгомжтой. Хүн, түүний удам угшил генийн хослол хоршлоор хувьсалд орж байдаг гэвэл хүмүүний 46 хромосомд орших 40000 генүүд шинээр үүсгэх хосолбор, хувьслын явцад сайн муугаараа ялгаран бодьгалын шинж чанарын ялгаа бүхий хүмүүний зиндааг гарцаагүй үүсгэх ёстой. Үнэндээ амьдрал тийм л байдаг, учир нь нийгэм бол хүмүүний тэр дээд зиндаа чадал чансааг буй болгоход нөлөөлж дараа нь эргүүлэн ашиглахыг эрмэлздэг учиртай юм.

Генийн ангид эвсэл хэв шинжийг ашиглаж хүнийг удамжуулан хөгжүүлэх боломжтой. Байгаль өөрөө олон зуун жилийн турш амьтан, хүний удмын сан дотор генийн ижил эвсэлт шинж чанарыг хязгаарлах механизмыг барьж, харин ангид эвсэлт шинж чанар нөхцөлдүүлэх олон үндэст бүтцийг бодож олсон гэхээр байдаг юм. Хүн дээр бол уг чанарын үр дүнд биемахбод өсгөлүүн хөгжил, эд эрхтний эрчимтэй үйл ажиллагаа, орчны хатуу ширүүн нөхцөлд дасан зохицох чанар, тэсч үлдэх чадвар зэрэг давуу талыг олно гэсэн үг юм.

Үр сад ямар нэгэн талаараа эх эцгээсээ илүү чанарыг авч төрөх удмын үндэс бүтэцтэй байх биологийн үзэгдлийг гетерозис гэдэг. Энэ нь бүх амьтанд түгээмэл байдаг зүй тогтол, онцгой нэгэн үзэгдэл. Биологийн эл онцлог бол амьтны генийн тодорхой үндэс язгуураар үүдэн нөхцөлдөж гардаг. Ийм маягаар гарах генийн хослол бас өөр хоорондоо нөлөө үүсгэхдээ хүний шинж чанарын үзүүлэлтийг ахиулан нэмж тэгснээр тэр хүн онцгойрох эсвэл илүү бодь хөгжилтэй болох, эсвэл цаашдын нэгэн ахиц дэвшлийг үүсгэх дотоод үндэс боломжийг тавьж өгөх магадлалтай.

Шинж тэмдгийн эерэг хувьсал, хүний шинж чанарын эерэг хөгжлийг дэмжих нь зөв.

Хүний бие, оюуны хөгжлийг дэмжихэд үл удамшдаг ашигтай хувирал өөрчлөлтүүдийг ашиглах боломж бий. Хүний бие, оюуны хөгжилд амьдралын орчин нөхцөл нөлөөлж хүнийг олон талаар бага ч болов өнгө байдал, эрч хүчээр нь засч өгсүүлэн өөрчлөх боломжийг олгодог. Жишээлбэл, хүүхдийг өсгөлүүн өсгөх, эрүүл чийрэг бие бялдартай болгон хөгжүүлэх, эрүүл мэндийн сайн дархлаа суулгах зэрэг боломж их бий. Орчны нөхцөл нөлөөгөөр гардаг шинж тэмдгийн өөрчлөлт, өгсөх уруудах үзүүлэлтийг нийтэд нь модификаци өөрчлөлт гэдэг. Амьдралд нэн өргөн хүрээтэй байдаг болохоор ийм модификаци өөрчлөлтийг

хүмүүс үнэндээ сайн мэддэг билээ. Энэхүү зохих ач холбогдолтой зүй тогтлыг амьдралд ашиглахын чухлыг энд нуршин хэлэх нь илүүц бизээ. Эерэг модификаци өөрчлөлтийн хэмжээ хязгаар бол уг биемахбодид заяагдсан гаднын нөлөөг хариулах шинжийн хүрээ хэмжээний түвшингээс хамааралтайгаар илэрдэг. Жишээлбэл, хүүхдийг ид өсөлтийнх нь үед түүний хөгжих явцыг дэмжих боломжит бүхнийг, тухайлбал, хоол унднаас авахуулаад орчны таатай нөхцлийг зөв бүрдүүлэх, тохируулах юм бол тэр хүүхдийн бие оюуны хөгжил нь дотоод генийн өгөгдлөөсөө бүр илүү болж бүрэн дүүрнээр гарах юмуу түүнээс ч давж гардаг гэсэн үг юм.

Нийгэмд хүний эерэг модификацийг түүний хөгжилтэй холбож хувь хүний ашиг тусын тулд утга учиртай болгон ашиглах боломжтой. Угийн бичигт бөх хүний удмыг түүний 15 үе дагасан шаштираар нь, хурдан мориныхыг 20 үе удмаар нь авч үзэж шинжилдэг байсан гэж нэгэн буурал ярьсан нь үнэндээ зөв юм.

Энэ бүхнээс үзэхэд угийн бичиг, шаштарыг бүх нийтээр сэргээн мөрдөх нь монголчууд бидний хувьд зайлшгүй чухал зүйл, монголчуудын хүний хөгжлийн үзэл номлолын суурь гэж ойлгох хэрэгтэй. Орчин цагт улс үндэстэн өөрийн хүн ардын хүч чадал, билиг оюунаар өрсөлддөг, төрмөл лидерүүдээ төрүүлэхийг эрмэлзэх болсныг бид ч анзаарахгүй анхаарахгүй хэрхэн өнгөрүүлж болох билээ. Гегелийн хэлснээр хүн төрөлхтний түүхийн сүнс болж явсан монголчууд бид одоо дэлхийн хоцрогдлын хонхор болох тийшээ хандаж байгаа нь үнэндээ зохисгүй, иймд хүмүүнээ удамжуулан хөгжүүлэхэд анхаарч угийн бичгээ одоогийн нөхцөл байдалтай уялдуулан шинжлэх ухааны үндэслэлтэй болгож зөвөөр хэрэглэх шаардлагатай болоод байна.

Эцэст нь онцлон хэлэхэд, Монголчууд амьдрал ахуйдаа нэвтрүүлж зуу зуунд хэрэглэж ирсэн угийн бичиг бол тухайн хүмүүн, түүний ураг төрлийн угшил гарал, удмын холбооны тухай асар ихийг хэлэхийн зэрэгцээ бас уг хүний хойч үеийг удам судраар нь хүч чадалтай бие оюун бүхий, өнгөлөг мөнгөлөг болгон хувьсгаж, хувиргаж тэгснээр улс үндэстнээ бүхэл нэгэн болгон нэгтгэхийн ул үндсийг агуулагч, хүнээ хүчирхэг, угсаалаг болгох гэсэн агуу санааг агуулдаг билээ гэж хэлэх байна.

Ашигласан ном зүй

1. Сумъяабаатар Б., Буриад монголчуудын гарал үүсэл, түүхийн зарим асуудал. Э/ш-ний бага хурлын материалын эмхэтгэл. 2000.
2. Самбуу А. Тэмүжин Чингэсийг тэнгэрлэгээр төрүүлсэн монгол удам ген. УБ. 2008
3. Монголын нууц товчоо. Хоёр дахь удаагийн хэвлэл. УБ. 1957.
4. Галсан Т. Буриад язгуур домгийн товчоон. УБ. 1998.
5. Дашням Лу. Есүхэй баатар. Хаадын сан. УБ. 2002
6. Далай Ч. Хамаг Монгол. УБ. 1996.
7. Дашням Л., Монголчуудын “урагийн бичиг”-ээ хөтлөх соёл. УБ. 2012

Б.Чинзориг

Улаан-Үд хот.

БУИС-ийн аспирант

XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛЫН БОЛОВСРОЛД БУРИАД СЭХЭЭТНҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ НЭМРИЙГ СУДЛАХ ТУХАЙД

1990 онд Монгол улсад цагаан морин жилийн Ардчилсан хувьсгал ялж Үндсэн хуулиар олгогдсон эрх чөлөөгөө тунхагласаар даруй 20 гаруй жилийн түүхийг ардаа үлдээжээ. Энэ хугацаанд монголчууд өнгөрсөн түүхийн бодит үнэнийг мэдэх, шинээр эрэлхийлэх зэрэг түүхийн зангилаа асуудлуудыг судлах их ажил өрнөсөн гэхэд хилсдэхгүй болов уу. Өнгөрсөн 100 жилийн түүхэнд Монгол оронд гурван томоохон хувьсгал өрнөж, тус бүртээ шинэ ололт амжилтыг бататган бий болгосон байна.

1911 онд Үндэсний Эрх Чөлөөний Хувьсгалын үр дүнд Богд хаант Монгол улс байгуулагдсанаар хүн амын боловсролын түвшин нь доогуур, ядуу буурай орон байсан бөгөөд тулгамдсан олон зүйлүүд байсны нэг нь үндэсний боловсон хүчин бэлтгэх асуудал байжээ.

Энэ үеэс монголчуудын оюун санааны өөрчлөлтөнд үндэсний ухамсар сэргэх хандлага ажиглагдаж тухайн үеийн Монголын Засгийн газраас багш бэлтгэх сургуулийг байгуулах талаар зохих шийдвэрүүдийг гаргаж байв. Ингэснээр Монголын Засгийн газрын хүсэлтээр Нийслэл Хүрээнд анхны бага сургууль, улмаар Багш бэлтгэх түр курс зэргийг үүсгэн байгуулсан байна. Энэхүү анхны бага сургуулийг үүсгэн байгуулахад оролцсон буриад сэхээтнүүдийн оруулсан хувь нэмэрийн талаар сүүлийн үед эрдэмтэд, судлаачдын анхаарлыг зүй ёсоор татах болсон нь сайшаалтай юм.

Мэдээж энэхүү үйл хэргийг анхлан санаачлагч нь Ж.Цэвээн байсан хэдий ч түүхэнд бичигдэж үлдээгүй олон сэхээтнүүд байсан нь архивийн баримт материалаас илэрхий болох нь дамжиггүй юм. 1922 онд төр засгийн шийдвэрээр Нийслэл хүрээнд бага сургуулийн багш бэлтгэх хоёр жилийн тусгай сургуулийг нээснээр хүн төрөлхөтний хөгжлийн шатнаас хоцрохгүйн тулд хүн ардаа бичиг үсэгт сургах их үйл эхэлсэн байна. Энэ нь хожмын багшийн сургуулийн эх үндсийг тавьсан түүхэн үйл хэрэг байв. Багшийн сургуулийн анхдагчид нь Ж.Цэвээн,

Б.Эрдэнэбатхаан, Г.Буддарь, Д.Цэвэгжав, Г.Шагж зэрэг хожмын манай үндэсний сэхээтнүүдийг төрүүлэх алдар гавьяатай эрдэмт багш нар байжээ. Эдгээр багш нараас Монголын гэгээрлийн яамны сайд болсон Б.Эрдэнэбатхаан нь тухайн үеийн хөгжлөөр тэргүүлэгч баруун европын улс оронд залуу оюутан сургаж мэргэжилтэн бэлтгэхэд ихээхэн анхаарч багагүй хувь нэмрийг оруулсныг дараах архивын баримт материалд дурджээ. Үүнд:

Ардыг Гэгээрүүлэх Яамны Ерөнхий хэлтсээс Монгол Ард Улсын Засгийн Газраа өргөн илгээв. Мэдүүлэн явуулах учир: Эдүгээ харъяат яамны гуравдугаар хурлын хоёрдугаар зүйлд Элчин сайд Буянчуулганаас Герман, Франц хоёр улсад хэл бичгийн зэрэг сургуульд тус тус арван таван хүүхэд явуулахаар болсон учрыг удаа дараа мэдэгдэж гүйцэтгэн шийтгэмүй хэмээснээр, манай яамнаас ёсоор төсөвлөн зохих газраа явуулсны дараа, Засгийн Газрын дөчин хоёрдугаар хурлын арван гуравдугаар зүйлд ёсоор болгон баталсан ба орлого, зарлагын комиссоос төсөвлөснийг батласан тул, эл сургуульд их төлөв дунд сургуулийн тэнцэх хүүхдээс томилон явуулахыг завдан буй нь энэхүү хүүхдийг мөнхүү хоёр улсад хүргэн аваачиж, тэдний улсуудын аль зохих сургуулиудад хэрхэн оруулж сайнаар тохинуулан суулгах ба, бас хэл мэдэхгүй тул урьдаар тусгай сургууль болгон байгуулж бэлтгэх болзошгүй, бас ч дотоод байдлыг хэрхэн журамлаж байгуулах тухайн тогтоол, дүрэм, гэрээ зэргийн явдлыг тус тусын сургуулийн хэргийг эрхлэх газрууд буюу багш нар лугаа хэлэлцэн тогтоохоор сургуульд хэрэглэх бичиг дэвтэр, зураг юм авах хийгээд, бүх дэлхийн зургийг монголчилж хэвлүүлэн ирэх, бас буцаж ирэх замын зуур Ленинград, Москва, Эрхүү, Үд хотуудад буй сургуулийн Монгол сурагчдын байдлыг шалган үзэх зэргийн явдал бүхий нь урьд Герман зэрэг газраа явж байдлыг мэдсэн ба чадахыг бодож харъяат яамны сайд Эрдэнэбатхаан, дунд сургуулийн Монгол үсгийн багш Авирмэд нарыг томилон явуулах учрыг гаргаж Ерөнхий хэлтсээс Засгийн Газраа явуулж гүйцэтгүүлэхээр тогтов хэмээжээ. Иймийн тул үүнийг Монгол Ард Улсын Засгийн Газраа өргөн мэдүүлээд тогтоон шийтгэж эрхлэх ажаамуй.

Үүний тул өргөн илгээв.

Арван зургаадугаар он /1926/ нэгэн сарын арван таван. Дугаар 16.

Эрхэлсэн түшмэл, төлөөнөө Баяр хэмээжээ.

Энэхүү шийдвэрийн учраас Монголын тэр үеийн сэхээтнүүдийн олон төлөөлөл бүхий хүмүүс эрдэм боловсролыг эзэмшихээр алс холын нутгийг зорьж 1930-аад оныг хүртэл суралцаж байгаад харамсалтай нь түүхийн хүнд хэцүү үе тохиож эх орондоо буцаж ирсэн тохиолдол ч түүхэнд бичигдэн үлджээ.

Дээр өгүүлсэн Багш бэлтгэх түр курсийн анхны захирлаар Д.А.Абашеев / 1924-1926 он/ Буриад Монголоос уригдан ирж ажиллаж байв. Мөн Хазгаев, Санжин, Гомбоен, К.А.Олзоев, С.А.Хамганова, Ишханов зэрэг олон сэхээтнүүд уригдан ирж ажиллаж байсан нь гарал угсаа нэгтэй буриад сэхээтнүүдийн

хичээл зүтгэлийн ачаар өнөөгийн боловсролын түвшиний хөгжилтийн үндэс суурийг баттай тавьж чадсан явдал юм.

Ийнхүү дан ганц 1911, 1920-иод оны түүхэн үйл явдлын нөлөөгөөр өнөөдрийг хүртэл хугацаанд Монголын боловсролын дунд, их, дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх үйл хэрэгт олон арван буриад сэхээтнүүд өөрсдийн мэдлэг чадварыг зориулж байсан нь түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг юм.

Өнөө үед Монголын боловсролын түүхийг судлах нь зайлшгүй боловч хэдийгээр цөөн тооны боловч эрдэмтэд, судлаачид энэ сэдвийг анхааралдаа авч судалгааны эргэлтэнд оруулж байгаа нь сайшаалтай юм.

Д. Цэдэнжав,
доктор, дэд профессор
Монгол улс, МУБИС, ГХС,
В. Д. Патаева
к.п.н, доцент,
ОХУ, Буриад улс, БГУ_

БУРИАД БӨӨГИЙН ЗАН ҮЙЛ, ҮГ ХЭЛЛЭГ

Монголын томоохон ястангуудын нэг болох буриадууд түүх, соёлынхоо ороо бусгаа хөгжлийн үед янз бүрийн сүсэг бишрэл, шашин шүтлэгтэй байжээ. Монголчууд эрт дээр үеэс шүтэн биширч, хөгжүүлэн төгөлдөржүүлсэн шашин бол бөөгийн шашин бөгөөд түүний дотор буриад бөөгийн шашин нь төгс систем болон хөгжиж иржээ. 17-р зууныг хүртэл буриадын олон овог ястан дотор бөөгийн шашин ноёлж байлаа. Бөөгийн шашинтай зэрэгцэн түүний өмнөх үеийн зан үйлийн хэлбэр болох Тэнгэр, Газар, Нар, Гал, Усанд шүтэх ёс жаяг оршин тогтнож байлаа. Хүний ахуй амьдрал байгалийн үзэгдлээс шууд хамааралтай байж, түүний өмнө хүчин мөхөс гэдгээ хүлээн зөвшөөрсөн байдал бөөгийн шашинд тусгагдсан байдаг.

Бөөгийн шашныхан байгалийг амьд болгон, түүний үзэгдлүүдийг тахин шүтсээр иржээ. “Олон зууны турш буриадуудын бодит байдалд хандах шашны хандлага нь ахуй амьдралын хэв маяг, нийгмийн харилцааны хувиралтаас дам хамааран өөрчлөгдөж байлаа. Жишээ нь, эртний буриадууд ан агнуураас мал аж ахуй эрхлэх хэвшилд шилжих үеэр, байгалийн хүчинд шүтэх хүй нэгдлийн сүсэг бишрэл нь голдуу байгал, цаг агаарын үзэгдэлд шүтэн мөргөж, тэр үеийн хүний амьдралын хамгийн чухал зүйл болох бэлчээрийн мал аж ахуйд шаардлагатай өвс ногоог ургуулдаг хур бороог илгээгч Тэнгэр бурхандаа шүтэх байдлаар илэрч байсан юм. Иймээс ч Тэнгэр бурхандаа цагаан идээгээрээ цацал өргөдөг болсон билээ”¹.

И.А.Манжигеев цааш нь бичихдээ “бөө мөргөл бол шүтлэгийн тодорхой систем, харин бөөгийн шашин нь шашны үзэл баримтлал юм. Хүй нэгдлийн нийгэм задрах үед сүсэг бишрэлийн эртний хэлбэрүүд өөрчлөгдөж, системтэй шүтлэг болон хувирсан бөө мөргөлийн мөн чанар нь бөө нар өөрийн өвөг дээдэс, тэднийхээ сүнсийг тахин шүтэхэд оршиж байлаа.

Бөөгийн мөргөл нь бөөгийн өмнөх үеийн зан үйлийг бүрэн устгаагүй бөгөөд түүний байгалийн үзэгдлийг тусгасан онцлог шинжүүдийг унтраагаагүй байна. Бөө

мөргөлөөс өмнө байсан овог аймгийнхаа гал, нутгийн уул ус тахих, байгалийн үзэгдэлд шүтэн бишрэх зан үйл бөөгийн шашинтай нийлээгүй ч гэсэн оршин тогтнож, бөөгийн шашинтай өрсөлдөж хүч хүрэхгүй ч гэсэн шүтлэгийхээ хүрээг өргөжүүлж байлаа”².

Хүй нэгдлийн үеийн хүн хүрээлэн байгаа орчноос бүх зүйлээрээ хамаарч, байгалийн хүчний өмнө хүчин мөхөсдөж байсан тул өөрийн эрхгүй түүний өмнө сөгдөж байсан юм. Тэнгэрийг гэрэл, дулааныг илгээгч гэж үзэн, *огторгуйн мянган бурхад* амьдардаг онцгой ертөнц гэж үздэг байж. Ингэж тэнгэр шүтэх ёс үүсчээ. Тиймээс ч бүх буриадуудын гол шүтээн нь *Хан-Хюрмас Тэнгэри* билээ. Монгол ардуудын гол туульс болох “Абай Гэсэр” туульсыг тэнгэр бурхадын амьдралын тусгал гэж үздэг.

Тэнгэр шүтээнээс гадна оршин сууж амьдрал залгуулдаг тэр нутгийн уул ус, газар шороо, ой мод, нуур хөндийг тахин шүтэх явдал бий болжээ. Мал аж ахуй хөгжихийн сацуу буриадууд оршин суугаа газар орноо дээдлэн шүтэж, - *үтэгэй эжэд* (газар орны эзэд) [түнхэн аялгаар – *эжэн*, буриад уран зохиолын хэлээр³ *эзэн*, халхаар⁴ *эзэн*, халимагаар⁵ *эзэн*]-эд тахил өргөдөг болжээ. *Эжсин* гэдэг үг, түүний олон хэлбэрүүд *эджин*, *эзэн* нь монгол хэлэнд “гэр бүлийн тэргүүн”, “гэрийн эзэн”, “юмны эзэн”, “эзэн, хаан” гэсэн утга агуулдаг. “Үүнээс харахад “ээгнэх ёс” нь хувийн эзэмшилтэй шууд холбоотой гарч ирсэн бөгөөд, зарим эзэд газрыг ганцаарчлан эзэмших эрхтэй болж байсан тэр үеийг тодорхойлж байна. Бөөгийн сүсэг бишрэлтэй хүмүүсийн төсөөлөлд ээгнэх ёс нь хүмүүсийн хоорондох бодит харилцааг нэг ёсондоо бурханчлан бататгасан ёс болгожээ”⁶ гэж Т.А.Бертагаев бичсэн байна.

Хүй нэгдлийн хүн байгалийн бусад үзэгдлийг шүтэн бишрэхийн зэрэгцээ амьдралын эх булаг болсон галыг онцгойлон тахиж ирсэн бөгөөд *гал тахих* явдал буриадуудын дунд их дэлгэрсэн байдаг.

Хавар, намар болоход буриадууд *Эх газартаа* онцгой тахил өргөдөг. Энэ зан үйлийг *тайлган* гэж нэрлэдэг бөгөөд *тайх* гэсэн үйл үгнээс үүссэн байна. Энэ нь газар орныхоо эздийг баясган, өөрсдийн амь, амьдралыг хамгаалж явахыг тэдэнд даатгаж байгаа явдал болно (И.А.Манжигеев)⁷.

Монголоор *овоо тахих*, халимагаар *ово тьякхе* гэдэг. Харин Тунхэн нутгийн буриадууд энэ зан үйлийг *обоо тасилга* гэдэг. Л.Л.Абаева энэ нэр томъёоны утга зүйн талаар бичихдээ “Обоо (бур. “*обоо*”, монг. “*овоо*”, тиб. “*лабцзе*”) нь овоолсон чулуу гэсэн утгатай бөгөөд энэ газар орны эзэн эсвэл өөр бурхадад (нас барсан бөөгийн сүнс, хүчирхэг эзэн хаан, аль нэг омог аймаг, бүлгийн дээд язгууртан, домгийн баатруудад) зориулан тахилга үйлдсэн газарт овоо босгодог. Эртний энэ ёс заншил буддизм, тэр бүү хэл бөөгийн шашин үүсэхээс нилээд өмнө Төв Азийн бүх ард түмний (түвд, монгол, түрэг г.м.) дунд өргөн тархсан байна”⁸. И.А.Манжигеев⁹ овоо нь бөөгийн тахилгын ёсыг бурханы ёс болгон өөрчилсөн нь бөөгийн шашинтны дотор өөрийн шашныг дэлгэрүүлэхийн тулд шарын шашны

санваартан нар бөөгийн зарим зан үйлийг өөрийн шашинд тааруулан зохицуулалт хийхэд хүрсэн байна. Жишээ нь, уул давааны дээр овоо тахилган гэж нэрлэсэн хуучин тайлган хийсэн газарт тахилга хийдэг болжээ гэж зөв тэмдэглэсэн байдаг.

Олон эрдэмтэн (Т.М.Михайлов, К.М.Герасимова г.м.) буриадын тайлганы талаар бичсэн байдаг. И.А.Манжигеев тайлганы зарчмын гол асуудлуудын талаар бичихдээ: "... тайлганыг омгийн ахлагч нар гүйцэтгэдэг байжээ. Тайлган нь бөөгийн шашнаас өмнөх зан үйл учир хуучин уламжлал ёсоор бол тахилгад бөөг оруулдаггүй байв. Айлын эсвэл бөөгийн гэрт үйлдэгдэх бөөгийн ёс заншлаас, бүхэл бүтэн овог аймаг хамтран тахидаг тайлганы ялгаатай тал нь гэвэл өндөр уулын орой дээр газар хийдэг. Үүнээс гадна тайлганы үеэр янз бүрийн овог, аймаг, бүлгүүдийн дунд сур харвах, бөх барилдах, морь уралдах зэрэг тэмцээн явуулж баяр хийдэг байжээ. Тайлган нь *сасали бариха, далга бариха, хурылха* зэрэг зан үйлээс бүрдэнэ. Бурхадтаа дээжлэн өргөдөг сүүнийхээ архийг тайлганд оролцогчид *сасали бариха* үйлийн дараа хуваан уудаг ба *хурылха* гэдэг үйлийн дараа тахилгад өргөсөн малынхаа махыг *хуби* болгон мөн л хувааж авдаг байв. Тайлганд зориулан худалдан авсан мал, сүүний архины жилийн зарлага нэг айлын жилийн орлогын 20% болдог байжээ. ... Буриадуудын тайлганы мөхөх явц тариачны аж ахуйг бүх нийтээр хамтралжуулах хөдөлгөөн эхэлснээс үүдэлтэй"¹⁰. Тайлган эсвэл овоо тахих үйл нь монгол үндэсний бүх ард түмэнд байжээ. "Уул овоогоо тахих халимагуудын ёс заншил "ова тахилган" гэдэг уламжлал болгон жил болгон тахидаг зан үйлээр илэрдэг байв. Энэ "ова тахилган" нь уул овооны дээр өндөр газар хийдэг байсан байна. Ихэнх эрчүүд өндөрлөг газар байрласан талын овоонууд руу явдаг байжээ. Хамгийн өндөр газрыг сонгон авч мод хатгаад, тус газрын "эзэн – сахиус" гэгддэг цагаан өвгөн(цаган авга)-ний дүрсийг гурилаар хийж тавьдаг байна. Энэ "ова тахилган" зан үйл нь Монгол, Буриадад байдаг зан үйлээс онц ялгагдахгүй юм.

Бүх нийтийн шашингүй үзэл ноёлж, шашинтай тэмцэж байсан он жилүүдэд "тайлган" бараг устан алга болжээ. Зөвхөн сүүлийн жилүүдэд ард түмний дунд шашин шүтлэг сэргэн мандасны ачаар тайлган хийх болж овог, удмынхаа зан үйлийг сэргээн олон нийтээрээ мөргөл үйлдэх явдал зохион байгуулагддаг болжээ. Түнхэний буриадууд хамтран "*обоо тасилга*" гэдэг зан үйлээ олонд алдартай, их мөргөлийн газар болсон *Шаргай нойон* ба *Буха нойон баабайн* овоон дээр хийдэг байна. Түнхэн нутгийн бүх тосгод, суурингуудаас мөргөлчид ийшээ ирдэг болжээ.

Бөөгийн шашинд нутаг бүр, овог, аймаг бүр, нэг удам угсааныхан өөр өөрийн тахидаг шүтээнтэй, тэдгээрийн тухай өөр өөрийн домогтой. Хонгодор овогтны тахиж байсан бурхан шүтээний талаар ямар ч мэдээ байхгүй. Түнхэний буриадуудын шүтлэгийн талаар судалгаа хийсэн К.М.Герасимова¹², хонгодор овогтны өөрийн нь шүтдэг байсан сахиус, зан үйлийг тогтооход бэрхшээлтэй байгаа боловч Түнхэний хонгодоор овогтнууд ихэнхдээ булагат овогтны нэгэн адил зан үйлийг гүйцэтгэж, шүтэх тахих нь адилхан байжээ. Түнхэн нутаг бүхэлдээ тахилга, шүтлэгтэй газраар элбэг бөгөөд, тэдгээрийн тухай олон домог, яриа,

түүхийг түнхэнийхэн ам дамжуулан ярьсаар иржээ. К.М.Герасимова¹³ Түнхэн нутгийг буриадын бөө мөргөлийн гол бурхад оршин суудаг нутаг, Түнхэний Саян уулсыг барууны хаадын буудаг газар гэж нэрлэжээ.

Цааш нь бидний хээрийн судалгаагаар цуглуулсан Түнхэний буриадуудын бөөгийн аман зохиолын үгсийн сан, янз бүрийн бурхан сахиусны нэр, түүний тухай ойлголт, бөөгийн зан үйлийн зүйлийг тэмдэглэсэн угсаа-хэлсудлалын үгсийн сангийн нэгжүүдийг авч үзье.

Бөө, удаган (түнх. *Одигон*) гэдэг нэр томъёоны үүсэл гарлын талаар эрдэмтэд ихээхэн маргалддаг. Халх., бур., халим. – *бөө*, монгол бичгээр *бөге* – бөө гэдэг. Энэ талаар надад хамгийн ойр дөт нь В.И.Рассадины үзэл баримтлал юм. Тэрээр *бөө*, *удаган* гэдэг үгсийн гарал үүслийг түрэгт хамааруулсан нь хүй нэгдлийн үеийн тахилга шүтлэгийн талд монгол, түрэг ард түмний эрт дээр үеийн харилцаа холбоог харуулж байна: “Монгол хэлний *бөге* нь эртний түрэг хэлний *бөг* “мэргэн”, “ухаант мэргэн” гэдэг үгтэй тун ойролцоо бөгөөд түрэг үг нь илүү эртнийх болж байгаа нь нэг язгуурын олон үг байгаатай холбоотой (эртний түрэг үг *бөгүн* – “ойлгох, ухаарах”, *бөгүш* “ойлголт, ухаарал” нь эртний түрэгийн *бөг* “ойлгох, ухаарах” гэсэн үгнээс гаралтай). Харин монгол хэлний бөө (бөге) гэсэн үг нь тусгаарлагдсан, ганцаардмал байна. ...Монгол хэл, аялгуунуудын материалыг үндэслэн бидний бүтээсэн дотоод загвараар бол баруун буриадын *одигон*, доод Үдийн буриадын *идаган*, дагуур хэлний *ядаган* “удаган” болон хуучин монгол бичгийн хэлний *идуган*, *нидуган* нь *идуган* гэсэн эртний хэлбэрээс үүдэлтэй бөгөөд энэ нь бүр эртний *ыдуган* гэсэн хэлбэрээс *ы* (сүүлдээ *и*) хэлний хугаралын хуулиар хувиран өөрчлөгдөж *удаган*, *удган* хэлбэр үүсчээ. Харин эртний *ыдуган* хэлбэрийг түрэгийн *от* “гал” гэснээс үүдэлтэй гэж хэрхэвч үзэж болохгүй. Энэ *идуган* (*ыдуган*) гэдэг үгийн үндэс нь эртний түрэгийн *ыдук* “ариун гэгээн”¹⁴ гэсэн үг байж болох тухай Г.Д.Санжеевын дэвшүүлсэн таамаглал бидэнд илүү оновчтой санагдана.

Удха (*утха*) гэдэг үг буриад уран зохиолын хэлэнд: 1. Удам, гарал үүсэл, 2. Залгамж чанар гэсэн утгыг илэрхийлдэг бол Манжигеевын номонд¹⁵ бөөгийн залгамж холбоо, үе залгамжлах, бөө нарт тэдний өвөг дээдсийн дамжуулж байгаа шидэт хүчин чадалд итгэх итгэлийг хэлсэн байдаг. “Бөө болох хамгийн чухал, нэгдүгээр зэргийн нөхцөл бол бөөгийн удам угсаа, үндэс язгуурыг илтгэсэн “утха” байх ёстой. Утха нь хэд хэдэн хэлбэр байна: эцгийн удам дагасан “*халууни утха*”, өвөг дээдсийн овгийн гарал угсааг хадгалан авч яваа гарвал; эхийн удам дагасан “*хари утха*” харь овгийн ирмэл гарвал; *нэрьеэр утха* – тэнгэр гарвал (Аянгад цохиулан нас барагчдын удмын хүн бөө болох бөгөөд энэ нь удам дамжихгүй); дархан удмын гарвал болох *дархан утха* гэж байх ба дархан хүнийг тэнгэр таалсан гэж үздэг байснаас гадна зарим дархан удам дамжсан мэргэжлийн бөө болдог байлаа; *буудал утха* гэдэг нь тэнгэрээс буусан чулуу, солирын хэсгийг олсон хүн бөө болдог байжээ. ...Хамгийн чухал, нэр хүндтэй нь эцгийн удмын гарвал, дараа нь эхийн удмын гарвал ордог байжээ. Багагүй чухал, нэр хүндтэйд дархан удмын

гарвал ордог байсан юм”¹⁶. Түнхэн нутагт бөө удамтай хүнийг хэлсэн “*удхатай хүн*” гэсэн холбоо үг бий. Ийм хүнээс айж, түүний хэл ам, хараалаас болгоомжилж байдаг юм.

Сагаани бөө, харын бөө буюу цагааны болон харын бөө гэж байдаг. Хамт олны онго тахилга болох *зэгэтэ-аба* гэдэг тахилгын үед гол бөө гэгддэг “галши” болон тахилгын бусад тэргүүлэх бөө нар нийгмийн онцгой дээд давхрага үүсгэдэг байсан ба шашны төдийгүй улс төрийн хүчирхэг нөлөөтөй байжээ. Бөө нь цэрэг-дайчин, анчин байхаас гадна мэргч–төлөгч, шүүгч байсан юм. “Бүх нийтээрээ мал аж ахуй эрхэлдэг болсон үеээс эхлэн цагааны бөө(*сагани бөө*), цагааны удган (*сагани одёгон*) гэж гарч ирсэн нь түрүү үеийн омог бардам удирдагч бөө нарыг харын бөө (*харайн бөө*), харын удган (*харайн одёгон*) гэж нэрлэхэд хүргэжээ. ... Цагааны бөө гарч ирсээр хүнийг золигт гарган тахил өргөх явдал аажмаар багасч, хүний оронд гэрийн тэжээмэл мал адгуусаа өргөх болжээ. Энэ үед шашны янз бүрийн зан үйл хийхдээ хоолны чухал бүтээгдэхүүн болох сүүг ашиглах болжээ”⁷.

Бөөгийн ёс заншлын хэлбэр нь олон янз бөгөөд тодорхой дэс дараалалтай байдаг. Тогтмол ба заавал гүйцэтгэгдэх байдлаар нь Т.М.Михайлов¹⁸ бөөгийн зан үйлийг дараах байдлаар ангилжээ: 1. Нэг удаа заавал хийгдэх; 2. Заавал, тогтмол хийгдэх ба тогтмол биш хийгдэх (өвөг дээдсийнхээ сахиус сүнсэнд мөргөх); 3. Заавал биш, тогтмол ба тогтмол биш (янз бүрийн түвшний ээж-сахиусан нартаа мөргөх зорилгоор ариун догшин газар тахих), харин тахил өргөхийг уламжлалт (байнгын) и тохиолдлын (шаардлагатай үед) гэж хуваажээ.

Нэгдүгээрт хэсэгт нь хүний амьдралын үе, жилийн ямар нэг үетэй холбон, уламжлал болгон заавал хийдэг, нийгэм хамт олноороо болон гэр бүл, хувийн зан үйл орно. Хоёрдугаарт хэсэгт, хүний өвчин зовлон, малын үхэл хорогдол, гал усны аюул, аянга цахилгаанд цохиулах, ажил хэрэгт хүнд зүйл тохиолдох, муу зүүд, мэргч-төлөгчийн тайлал гэх мэтийн санаандгүй явдлаас болж хийдэг зан үйл орно. Бөөгийн үйл олон талтай, сүсэгтний амьдралын бүхий л талыг хамарна.

“*Хадта муркхэ*” гэдэг зан үйлийн *хад* гэдэг үгийг *отхан* гэдэг үгийн олон тооны хэлбэр гэж И.А.Манжигеев¹⁹ тайлбарласан байна. Гэвч *хад* гэдэг нэр нь *хада* (уул) гэдэг үгтэй ижилсэн, ойлголтууд нь нийлэн зан үйлийн нэгэн ёслол болно. Түнхэн нутгийн шүтлэг тахилгын газруудыг *нойон*, *баабай*, *таабай*, *теэбээ* гэсэн нэр томъёогоор хэлэгддэг. Сүүлийн хоёр нэр томъёо нь төө (үтөө) – ахмад, *баабай* – эцэг, *шибиш* – ээж (*төө баабай* ба *төө шибш*) гэдэг үгсийн хувиралаар үүсчээ.

“Барууны гол хатууд болох Шаргай ноён, Буха ноён нарын тухай Түнхэний буриадуудын домгууд, балаганы ба кудины буриадуудын ижил утгатай домгуудтай ерөнхий ижил тал ч байна, онцгой ялгарах тал ч байна. Юуны түрүүн хэлэхэд, эдгээр гол бурхадын үүсэл гарлын талаар нэгдсэн санаа байхгүй байна. Түнхэн аймгийн янз бүрийн сум, районы мэдээлэгч нарын хэлж ярьснаар, Шаргай нойон нь Хухэ тэнгэрийн хүү, зүгээр тэнгэрийн хүү, Урхан тэнгэрийн хүү, 99 тэнгэрийн хүү, зүгээр л баатар, Хурмастын цэргийн баатар, Энэтхэгийн бөө, харин Буха нойон нь

Эсеге Малан тэнгэрийн хүү, Саган Мунху тэнгэрийн хүү, 99 тэнгэрийн хүү, Энэтхэгийн бөө, Түнхэн нутагт бурханы шашин дэлгэрүүлэхээр илгээгдсэн Энэтхэгийн 300 баатруудын нэг гэх зэргээр тайлсан байна. Түнхэний буриадууд домогтоо эдгээр бурхадын талаар өөрийнхөөрөө өгүүлдэг. Хамгийн сонирхолтой баян нь Буха ноёныг тахих зан үйлтэй холбоотой домог юм. Эдгээр домгуудад эртний зүйлүүд нь сүүл үеийн хэлбэр, өөрчлөлтөд орсон байдаг.

Түнхэний буриадуудын домгуудад булагатуудын дээд өвөг гэж үздэг Буха ноёны тухай гарвалзүйн утга нь хадгалагдсан байдаг. Гэвч энэ нь гол биш. Хөх Буха ноён ба цоохор Тарал эрэн Буха хоёрын тэмцэлийн үйл явдлын талаар боловсруулалт хийсэн нь анхаарлыг татаж байна. Хүтийн буриадуудаас ялгаатай нь Түнхэнийхэн энэ түүхийг зарим газар зүйн онцлогтой нь заан өгүүлдэг. Кудины буриадуудын домогт Буха ноён эрэн цоохор бухтай байлдахын тулд Байгал нуурын хойт эргээс өмнөд эрэг хүртэл сэлэн ирдэг. Харин Түнхэнийхний домогт Буха ноён нь тэнгэрээс ямар нэг тодорхойгүй өмнөд зүгт буудаг, эсвэл тэнгэрээс өөлд монголчууд руу буугаад, тэндээс хойшоо Түнхэн руу ирдэг байна”²⁰.

Түнхэний буриадуудын домогт Шаргай ноён цэрэг дайны зорилготой, хамгаалах үүрэгтэйгээр шарга морио чарганд хөллөн – *шарга морёор ябадаг Шаргай нойон баабай* – өөрийн эзэмшлээ тойрч явдаг. Энэ нутгийн буриадуудын аман домгоор бол нутгийн ардууд руу уулгалан довтолсон монголын Сөөхэр ноёныг Шаргай ноён *Тамси баряаша* гэдэг газар ялсан тухай өгүүлдэг. М.Н.Хангалов бичихдээ: Барууны хаадын дотор гол хүн болох Хан-Шаргай домог ёсоор “тэнгэрээс, Халша-Ула уулын орой дээр зэр зэвсгээ агсан, хүлэг морио унан бууж ирсэн. Түүний баруун талд Харасай-зарин, зүүн талд Хан-Хургай-нойон нар *хоёр жолоши* хоёр хажуугаар зогсон морийг нь барина. Энэ хоёр жолооч Хан-Шаргай-ноёнд үнэнч байхаа тангараглан суман доор мөргөжээ. Түүнээс гадна Хан-Шаргай-нойон суман доор тангараглан хурим найрын онгон болсон Тулман-Саган-нойон өвгөнийг туслагчаараа урин авчирчээ”²¹.

Дээр цагт бөө нар өөр хоорондоо тасралтгүй тэмцэл явуулан дайсагналцаж байсан тухай бөөгийн дуудлагад өгүүлдэг. Бөө нар ардын аман зохиолыг сайн мэддэг байсан гэдэг билээ. Зарим бөө нар баатарлаг туульсын бүтээлийг сайн мэддэг, өөрсдөө ч хайлдаг байжээ. Үүнээс харахад бөөгийн шашин туульс хоёрын дунд шүргэлцэх цэг байдаг ба ижил, зэрэгцсэн зүйлүүд ч бий (жишээ нь, барууны 55 тэнгэр, зүүний 44 тэнгэр). Бөөгийн аман зохиолын домогт бөөгийн удам угсаа, язгуур, түүх, гарал үүслийн тухай өгүүлдэг. “Бөөгийн дуудлага, өөрийн гэсэн тодорхой хэлбэртэй, ихэнх нь эхлэл, туульсын хэсэг, гуйлт, төгсгөл гэсэн хэсгээс бүрддэг байв. Бөөгийн дуудлагын агуулгад голдуу: бодитой амьдарч байсан хүмүүсийн нэрс, бурхан, сахиус, овог аймгийн дээд өвөг, бөөгийн язгууртай холбогдон үйл явдал өрнөж байсан нутгийн газар зүйн байрлалууд; хувцас хунар, гэр орон, сууцны дүрс зураглал, бурхан, сахиус, заяач, онгодын иддэг хоол, хөдөлмөрийн зэвсэг, зэр зэвсэг, овог, аймаг, тэр бүү хэл нийгмийн гарал үүсэл;

зарим түүхэн үйл явдлын тухай дурсамж зэрэг ордог. Бөөгийн дуудлага өөрийн гэсэн өнгө, ая, хөгтөй, дуулж, шүлэглэж, найраглал маягаар уншиж гүйцэтгэдэг байв. Бөөгийн дуудлага нь хөгжимтэй хавсрах нь цөөнгүй: хэц цохин, бөөгийн хувцсанд өлгөөтөй жижиг хонх, төмөр зүйлсийг хангинуулан, зангаж дохих, нүүрээ өөрчлөх зэрэг үйлдэл хийнэ”²².

Түнхэний буриадуудын бөөгийн дуудлаганд юуны түрүүнд *Түнхэнэй табан хад* буюу *Түнхэнэй табан хуиэтэн* – түнхэний таван хүчтэнийг дуудна: 1. *Хэрэни тэбхэр* – “ширээ уул” гэж нэрлэгддэг тэв тэгш оройтой уул, 2. *Шаргай нойон баабай* буюу *Бурхан баабай* – Шабарта уулын эзэн, 3. *Бурэн хаан* – Мүнхэ Сагаан буюу Мүнхэ-Һарьдаг (Мунко-Саридак)уулын эзэн, 4. *Буха нойон баабай* буюу *Ринчен хаан* – Улгэй нутгийн эзэн, 5. *Алтан Мундарга* буюу *Улаан Һасюуһан* – түнхэний нүцгэн уулсын эзэн. Сэлэнгийн хөндийн хамгийн тахилгатай газрын нэг болох Бурин-хан, Түнхэний Мунко-Саридак уулын эзэн Бурин-хан-тай нэг ижил нэртэй нь их сонирхолтой.

Түнхэний таван хадын эздийг дайлж цайлах ёс гүйцэтгэсний дараа бөө нутгийн онгодыг: - *үтэгэй үбгэдтэ*, газар нутгийн эздийг (*үтэг* – газар орон, *үбгэд* – өвгөд) оруулна. Өвөр байгалийн буриадууд *сабдаг*, буриад уран зохиолын хэлээр – *сабдаг*, халимагаар – *өвгүд авһад* гэдэг. “Овог аймгийн хамгийн алдартай сахиус, хүндэтгэл заавал үзүүлэх ёстой зүйл нь тэнгэрт хальсан өвгөд дээдэс, бөө нарын сүнс, онгод бөгөөд түүнийг “*үбгэд*” гэдэг. Бөөгийн шашны үзлээр бол өвгөд нөгөө ертөнцөд очоод, дээд зэрэглэлийн бурхадтай ойр дотно харьцах боломжтой болж, өөрийн удам, үр хүүхдээ сахин хамгаалах, туслах боломжтой болдог. Тэдний энэ халамжийг байнгын өргөл барьцаар бэхжүүлж болно”²³. Монгол ардуудын дунд хамгийн их дэлгэрсэн *Цаган-Эбуген* бурхан хүний дүрээр гарч ирдэг гэж В.Э.Очир-Гаряев²⁴ бичсэн байна. Цагаан өвгөний энэ дүр халимагын “Джангар” туульсад “*Делкен эзн цаһан өвгн*” буюу дэлхийн эзэн цагаан өвгөн нэрээр гардаг.

Газрын эзэн гэдэг нь бодитойгоор амьдарч байсан хүмүүсийн (амьд байхдаа ямар нэгэн зүйлээр тодорч гарсан бөө, энгийн хүмүүсийн) сүнс гэдэг билээ. Нутаг бүрт “эздийг” нь шууд дууддаг байна. Жишээ нь: Хужир, Шимки, Кырен, Нуган зэрэг тосгоныхон өөрсдийн омгийн сахиусандаа мөргөдөг: 99 шошоологууд, *Хонгоодор ехэ таабай* – Агуу их дээд өвөг Хонгодор, *Хушууни Сэдэй таабай* – Сэдэй өвөө, *Тужайн Сэбэг таабай* – Тужийн эзэн Сэбэк өвөө, *Могой-Горхони таабай Поосон таабай* – Могой горхины эзэн Посон өвөө, *Дармай ехэ теебэе Жаргал хатан* – Дармай их эмээ Жаргал хатан, *Хужарай ехэ теебэе* – Хужирын их эзэн эмээ, *Нугайн ехэ таабай Алсын хубуун Ошор* – Нугын эзэн Алсын хүү Ошор гэх мэт.

“*Хада тасилга*” гэдэг тахилгын үед уул хадад зориулан өндөр газар үндэр *һан* (*һан*, уран зохиолын буриад хэлээр *сан*) сан тавьдаг. Нутаг нутгийн онгон сахусанд сан өргөхдөө янз бүрээр өргөдөг. Жишээ нь, үтэгэй үбгэдэд сан тавихдаа намхан

сан тавьдаг. Түнхэний олон газар “хада тасилга” ёслолын үеэр нутгийн хад, эздийг тахихаас гадна *Эрхууе эжэн Эмниг сагаан нойон* буюу Эрхүү голын эзнийг тахидаг.

“*Албан хадта муркхэ*” буюу “*Алба хэхэ*” гэдэг энэхүү бөөгийн ёслолоор ивээлт онгон сахиусандаа өргөл өргөхдөө хөвгүүдтээ зориулдаг бөгөөд тэднийг өвчин эмгэгээс хамгаалан, урт удаан настай байгахыг гуйн мөргөдөг байна. Энэ ёслолыг үйлдэхдээ Түнхэнийхэн Ринчин-хандаа ханддаг юм. “*Алба хэхэ*” ёслолыг Түнхэнд 13 наснаас хийж эхлэнэ. Энэ ёслолыг бөө, хонь төхөөрч, тахил өргөх махыг нь зөв тавьж чаддаг туршлагатай туслагчтай цуг үйлдэнэ. Энэ ёслолыг И.А.Манжигеев²⁵, хүй нэгдлийн зан үйлээс хадгалагдан үлдсэн, хөвгүүд, залуучуудыг эрийн цээнд хүрч байгааг тэмдэглэн үйлдэх нэгэн ёсны сорилт болсон зан үйлийн үлдэгдэл гэж үзсэн байдаг. Хувьсгалын өмнөх үеийн бөө мөргөлтөй буриадуудын аж ахуйд ихээхэн хохирол учруулдаг нийгмийн үндэс нь бага насны хүүхдийн нас баралт байлаа.

Албан гэдэг үгийг И.А.Манжигеев²⁶ үгчлэн орчуулж уран зохиолын буриад хэлээр “алба, үүрэг” гэж буулгажээ. Магадгүй, *албан* гэдэг үгийн шилжсэн утгаар салхин цэцэг (уран зохиолын буриад хэлний *албан* гэдэг үгийн хоёрдахь утгыг хар) өвчнийг нэрлэж, хүн бүр энэ өвчний сахиусанд өргөл барьж, тахил өргөх ёстой байсан байх. Бид Буриадын бусад нутгуудад ийм ёслол олж үзээгүй учир энэ нь зөвхөн Түнхэний буриадад хадгалагдан үлдсэн байж болзошгүй гэж үзэж байна. Одоо үед охидын тэнгэрт ч бас мөргөдөг болжээ. Энэ ёс заншил хоёр хэлбэрээр – *сагаагаар* (цагаагаар) и *хараар* (хараар) – явагдана. *Сагаагаар* гэдэг нь зөвхөн цагаан идээ, мөнгөөр, тахил өргөж, харин *хараар* бол хонь төхөөрч өргөл барина. Энэ үеэр онгод, сахиусыг хүндлэн тахил өргөхдөө цайлах, дайлах ёсыг хатуу баримтлана: өргөлийн махны ясыг нь хугалж болохгүй, махыг үеэр нь эвдэнэ; хоолой, уушиг, толгой, хөл сүүлийг нь арьстай нь авна. Эхлээд махаа чанаад, дараа нь *гурбан зүрэм (ороймог)* – ороомог хийнэ. “*Далга*” гэдэг ёслолын үед махны зарим хэсгийг үлдээнэ. Дараа нь “*табан заһал*” – таван засал гэдэг зан үйлийн нэг хэсгийг хийнэ: хонины арьсыг толгой, хөлтөй нь газарт дэлгэн тавиад хар зүйлээр бүтээж, толгой дээр нь таван хэрчим зүсэлт хийгээд, шар тос түрхэж, дараа нь баруун хамарт нь арц, зүүн хамарт нь өвс хийнэ. Хажуу талд нь тэвш дээр махыг нь амьд үеийн байрлалаар байрлуулж, *далга* тавиад хуһан түүргэ – залуу хусны мөчир хатган, “*зурмадан*” – бөс давууны өөдөс уяад:

Хуһан түүргэ буулгажа,

Хуби заяа эринэбди.

Хус модыг босгож,

Хувь заяагаа эргүүлэе.

Энэ ёслолын эхэнд бөө Түнхэний таван хаддаа мөргөл үйлдээд, хонио бэлэн болсны дараа Албан хадта мөргөн идээ зооглохыг хүснэ. Түлээгээр ширээ хийгээд дээр нь идээ будааг тавиад дээрээс нь яс, арьстай толгой хийж бүгдийг шатаана. *Зурмадан* гэдэг үг уран зохиолын буриад хэлэнд байхгүй, харин *түүргэ* гэдэг үг

уран зохиолын буриад хэлээр “тайлганд оролцогчдын өмнө хатгадаг жижиг хус мод” гэсэн байна. Сүсэг бишрэлийн зан үйлийн нэг хэсэгт хус модыг хэрэглэдэг ёс байна. И.А.Манжигеев үүнийг ойт хээрийн бүсэд ихэнхдээ амьдран суудаг буриадын өвөг дээдсийн хувьд хус мод бол тэдний амьдралд их дэлгэрсэн мод байсантай холбон үзэж байна.

“Ангарын аманда муркхэ” – Ангарын эхэнд мөргөх ёслол. *Аман* гэдэг нь эхэн гэсэн утгаар ойлгох хэрэгтэй. Түнхэн нутгийнхан өөрийн районоос гарч явахдаа Ангарын аманда буюу *Ангарын эжэн Ама Сагаан нойондо* (Ангарын эхний эзэн Ам цагаан ноён) мөргөх ёслол үйлддэг. Бөө нар Ангар мөрнийг ариун тахилгат гол гэж үздэг. Энэхүү булагатын ёслол, Буха нойон баабай, Шаргай нойон баабай зэрэг ёслолын адил бүх буриадын зан үйл болжээ. “Эрт дээр үеээс Байгал нуураас Ангар мөрөн гадагш урсан гардаг амны бөө чулуунд мөргөл үйлдэх божба ёслол хийдэг байжээ. Энэ божба бол их хүчирхэг эзэн гэж үздэг бөгөөд буриад бүр шүтэн биширч, айн сүрддэг учир онцгой тохиолдолд мөргөл үйлддэг байна. Домог ёсоор бол эрт дээр нэгэн цагт одоогийн Бөө чулууны ойролцоо Гуртэ-Зарин гэдэг нэртэй том бөө байсан бөгөөд загас барин амьдардаг байжээ. Нэгэн удаа тороо тавьж яваад усанд унаж нас баржээ. Нас бараад энэ бөө Ангар мөрний эхэн газрын эзэн болон суужээ; үүнээс гадна тэр барууны тэнгэрүүдийн тоонд оржээ”²⁸.

“Гүйдэг гаргалга” зан үйл. Хүн нас барсны дараа түүний сүнсийг “гүйдэг” авч оддог гэж ярьдаг. Ламын сургаалд ийм ойлголт байхгүй, буриад уран зохиолын хэлэнд ч тохирох үг үгүй. *Гүйдэг* гэдэг үг нь *гүйхэ* – гүйх гэсэн үйл үгнээс үүссэн байж болзошгүй. Бөөгийн шашны энэ үзэгдлийн талаар Т.М.Михайлов бичихдээ: “Хүмүүст байнга хор, хөнөөл авчирч, өвчин зовлон илгээдэг, хүний зам мөрийг төөрүүлж, хурга, тугал алдаг, хүний сүнсийг авч явдаг – *дахабари, ябадал, гүйдэл, боохолдой* гэх мэтийн чөтгөр шуламтай холбогдсон төсөөлөл буриадын нилээд аймгуудад устаагүй байна”²⁹ гэжээ. Түнхэний шүтлэгтэй буриадчууд “гүйдэг”-ийг үхэл тараадаг хүчтэй сүнс гэж үздэг бөгөөд авч явсан хүний хойноос түүний төрөл садангаас 49 хоногийн дотор дахин хоёр-гурван хүнийг авч одохыг шаарддаг тул түүнээс ихээхэн болгоомжилдог байна. Зарим нь түүнийг үхсэн хүний хоёрдох сүнс гэж үздэг. Төрөл садан болон хөршийн хэн нэг нь нас барвал шөнө босгоныхоо доор хутга, сүх ирийг нь гадагш нь харуулан тавьж хонодог. Лам нар “гүйдэг”-ийг ямар айлд орохыг тодорхойлон, арга хэмжээ авахыг зөвлөдөг байна. “Гүйдэг” чөтгөрийг хөөн зайлуулах ёслол үйлдэхдээ ширээн дээр будаа, архи, сүү, ус тавьдаг. “Гүйдэг” рүү ус асгаж:

Хара уһаар ундалжа ябахаи, хари,

Юундэ эндэ байнаи?

Гайхан түрэлөө бэдэрэ,

Шэнэ бэээ шэнэлэ,

Эндэ муу ёротой хүнүүд байна,

Шамай хотигоор хадхаха,

Буугаар буудаха, ташуураар ташуурдаха,

Яба! Хари! Хари!

Хар усаар ундаалж яв, харь.

Юунд энд ирсэн юм чи?

Сайхан төрлөө эрж хай,

Шинэ биеэ шинэл.

Энд муу ёртой хүмүүс байна,

Чамайг хутгаар хатгана,

Буугаар буудна, ташуураар ташуурдана.

Яв! Харь!Харь!

Сүнс дуудах буюу **“*хүнэһэ дуудаха*”**. *Хүнэһэн* – гэдэг нь хүний оюун санааны хоёрдахь бие, халхаар – сүнс, халимагаар – сүнс. Манай өвөг дээдсийн үзэл бодлоор бол хүний сүнс түүний унтаж байх хооронд биеийг нь орхин гарч, хааяагүй тэнэн явахад, унтаж байгаа хүн зүүд зүүдэлдэг гэдэг байжээ. Хүний зүүд зүүдлэх үед болон их айн цочих үед чөтгөр, шуламууд түүний сүнсийг авч оддог гэдэг. Сүнсгүй болсон хүний бие суларч, нойрмог, бүх зүйлд хайнга, хайш хэрэг ханддаг болж өвчилдөг. Хэрэв сүнсийг нь яаралтай дуудан биенд нь оруулахгүй бол сүнсгүй хүн удаан амьдарч чадахгүй үхдэг байна. Хүний сүнсийг авч оддог тухай бөө ч, лам ч хэлдэг. Сүнс дуудах энэ зан үйлийг сүнсгүй болсон хүний төрөл, ойр дотнын хүмүүсийн хажууд хийдэг. Хоол хүнс, хувцас бэлдээд хаалга нээж түүнийг дуудна:

Ерэ наашаа, гэртээ оро!

Юундэ зайжа ябанааи?

Гэртэсюулини хүлээжэ байна,

Оро, эдээлэ, хубсала...

Наашаа ир, гэртээ ор.

Хаагуур тэнэж явна вэ?

Гэрийнхэн чинь хүлээж байна.

Ор, хоол ид, хувцасла...

Хэрэв сүнс дуудуулж байгаа хүн, эсвэл түүний төрөл төрөгсөд уйлж, нулимс гаргавал сүнс нь биедээ орлоо гэж үздэг байна. Зарим үед бөө сүнсийг нь дахин дахин дуудах хэрэг гардаг нь сүнс “эсэргүүцэн” биедээ орж өгөхгүй байдагтай холбоотой гэнэ.

“*Аб гаргалга*” – гэдэг нь хорлолыг зайлуулах зан үйл юм. *Аб* – уран зохиолын буриад хэлээр ид шид, хараал, жатаг, хорлол гэсэн үг; холбоо үг нь *аб жэб*; *аблаха* – хараал хийх.

Хүн ихээр өвдөх, эсвэл “замаа алдаж” эхэлвэл, тэр хараал жатаганд өртөж, *абд орж*, *аблуулаа* гэдэг байна.

Энэ үед бөө **“*тарим*”** гэдэг зан үйлийг үйлдэнэ. “Тарим бол ардын эмнэлгийн зарим зүйлтэй хавсран үйлддэг, өвчнийг илааршуулан зайлуулах тарни, шэвшлэгэ

юм. Буриад бөөгийн ёсонд 2 янзын тарим байжээ: 1) *гал тарим* (галан шившлэгэ) – улайсгасан төмөр юм уу, халаасан чулуугаар өвдөж байгаа газрыг нь хайран, уншлага, шившлэгэ хийдэг; 2) *уһан тарим* (усан шившлэгэ) – халуун ус эсвэл буцалсан усанд багц өвс дүрээд, түүгээрээ өвчтний өвчин газар, хавдарыг ороолгохдоо мөн л шившлэгэ уншдаг”³⁰.

“Гал тарим”-ын ёслол үйлдэх үеэр бөө улайстал халаасан төмрийг шүлстэй хэлээрээ долоож, хүний өвчтэй газрыг үлээж, нулимдаг нь бөөгийн ид шидэд итгэх итгэлийг сүсэгтэн олонд төрүүлдэг байжээ. Улайссан халуун төмрийг нүцгэн гараараа барьж авдаг бөө ч байдаг. М.Н.Хангаловын олж авсан мэдээгээр, буриадад есөн янзын тарим байсан гэнэ. “Аб гаргалга” зан үйлийн үед зөвхөн эмчлэх аргыг хэрэглэдэг байсангүй. “Аб гаргалга” ёслолын үеэр бөө нар янз бүрийн илбэ үзүүлж, өвчтөн болон оролцогчдыг ховст (гипнозод) оруулдаг байв.

“Угаалга” – угаалга. *Угаалга* гэдэг үг нь *угааха* гэдэг үйл үгнээс үүсчээ. Барууны буриадын аялгаар энэ зан үйлийг *уһан будля*, *булгаадаһан* гэдэг нэр томъёогоор хэлэгддэг. Буриад бөөгийн ёс жаягт бөөгийн угаалга буюу “*бөөгэй угаалга*” гэдэг бөөгийн биеийг үе үе угаах ёслол байдаг. Ямар нэг ёслол үйлдэх үед хүнд байсан муу зүйлүүд бөөгийн биед халдан үлддэг бөгөөд түүнийг цэвэрлэх ёслол юм.

Түнхэний буриадууд “угаалга” ёслолыг хүн “бузартаж” өвчилсөн үед хийдэг. Ёслолыг үйлдэхдээ эхлээд булагын уснаас авчирч буцалгана. Долоон өөр модны (нарс, шинэс, тэрэлж, хуш, хус, жодоо, тавилгана) мөчир авчирч бооно. Голын өөр өнгийн долоон чулууг улайсган, буцалж байгаа ус руу хийнэ. Бөө бөөлж байхдаа буцалсан усанд боолттой мөчрөө дүрэн өвчтний нүцгэн биеийг ороолгоно. Үүний дараа түүнийг арц уугиулан ариутгаж, архиар шүршинэ. Заримдаа бөө нар халуун чулууг нүцгэн гараараа барих тохиолдол ч гардаг байлаа.

Түнхэний буриадуудын бөөгийн ёслол нь агуулга, хэлбэрээрээ бусад баруун буриадуудынхаас иймэрхүү байдлаар ялгагддаг боловч үүрэг нь ижилхэн байдаг. Бөөгийн ёслолын нэр томъёо нь голдуу алар аялгууд тун ойрхон боловч нийт буриадын шинжтэй. Үүний сацуу авиазүйн (сагаани бөө, тамси баряаша, Улаан һасюуһан, хада тасилга, эжэд) болон үгсийн сангийн (Хонгоодор таабай, Дармайн теэбээ, зурэм, зурмадаһан г.м.) онцлог ялгаанууд дайралддаг.

Ном зүй:

- 1 Манжигеев.И.А. Бурятские шаманистические и дошаманистические термины. М., 1978. С. 8-9.
- 2 Там же. С. 8.
- 3 См.: Бурятско-русский, словарь под ред. К.М.Черемисова. Улан-Удэ, 1973. Здесь и далее ссылки на литературные бурятские термины взяты из этого источника.

- 4 См.: Орос-монгол толь. Улан-Батор, 1982. Здесь и далее ссылки на современные монгольские термины взяты из этого источника.
- 5 См.: Эрдниев.У.Э., Калмыки. Элиста, 1970. Здесь и далее ссылки на калмыцкие термины взяты из этого источника.
- 6 Очир-Гаряев.В.Э. Культ гор у монгольских народов // Вопросы сравнительной этнографии и антропологии калмыков. Элиста, 1980. С. 141.
- 7 См.: Манжигеев.И.А. Указ. Соч. С. 69.
- 8 Абаева Л.Л. Культ гор и буддизм в Бурятии. М., 1992. С. 67.
- 9 См.: Манжигеев И. А. Указ. Соч. С. 61. Там же. С, 69.
- 10 Очир-Гаряев В. Э. Указ. Соч. С. 140.
- 11 См.: Герасимова К.М. Культ обо как дополнительный материал для изучения этнических процессов в Бурятии //Этнографический сборник. Улан-Удэ, 1969. Вып. 5. С. 122.
- 12 См.: там же. С. 115.
- 13 Рассадин В.И. Об этимологии некоторых бурятских шаманистических терминов // Банзаровские чтения, посвящ. 170-летию со дня рождения Д. Банзарова. Улан-Удэ, 1992. С. 127-128.
- 14 См.: Манжигеев И. А. Указ. Соч. С. 75.
- 15 Михайлов Т. М. Бурятский шаманизм. Новосибирск, 1987. С. 95.
- 16 Хангалов М. Н. Собрание сочинений. Улан-Удэ, 1959. Т. 1. С. 87-89.
- 17 См.: Михайлов Т. М. Указ. Соч. С. 65-66.
- 18 См.: Манжигеев И. А. Указ. Соч. С. 83.
- 19 Герасимова К М. Указ. Соч. С. 115-116.
- 20 См.: Хангалов М. Н. Указ. Соч. С. 175.
- 21 Очерки культуры Бурятии. Улан-Удэ, 1972. Т. 1. С. 107.
- 22 Михайлов Т. М. Указ. Соч. С. 36.
- 23 См.: Очир-Гаряев В. Э. Указ. Соч. С. 138.
- 24 См.: Манжигеев И. А. Указ. Соч. С. 15.
- 25 См.: там же.
- 26 Романова Е.Н. Культ предков в контексте обряда ысыах // Банзаровские чтения... С. 79.
- 27 Хангалов М. Б},,, Указ. Соч. С. 187.
- 28 Михайлов Т. М. Указ. Соч. С. 230.
- 29 Манжигеев И. А. Указ. Соч. С. 70.

Эрдынеева А.Д.

г. Улан-Удэ

ЭТИМОЛОГИЯ И СЕМАНТИКА ОЙКОНИМОВ БУРЯТСКОГО ЯЗЫКА

Исследования сложной и многогранной проблемы этногенеза сибирских народов актуальны и сегодня. Безусловно, объединенными усилиями разных специалистов: археологов, этнографов, лингвистов проводится большая работа. В представленной статье рассматриваются этимология и семантика ойконимов бурятского языка в сравнении с другими монгольскими, некоторыми тюркскими, тунгусо-маньчжурскими языками, которые активно употреблялись и употребляются этносом.

В лексике современного бурятского языка, принадлежащей к алтайской семье, имеется значительное количество слов, связь формы и значения которых не понятны носителям языка, поскольку структура слова не поддается объяснению на основе действующих в языке моделей его образования. Исторические изменения слов затемняют первичную форму и значение слова, а его знаковая природа определяет сложность реконструкции первичной мотивации.

В этом плане вызывают интерес этимология и семантика устойчивых в бурятском языке терминов *айл* и *аймаг*, имеющие параллели во всех группах алтайской языковой семьи. Рассмотрим семантику данных терминов:

айл (бур.) – 1. Семейство, семья; юрта, дом; 2. Зап. *Айл*, группа юрт (или домов), улус, сельская община; *айл тосхон* селение, населённый пункт; 3. Соседи, жители одной общины; в сочетании люди, население; *айл аймаг* собир. Община с её членами, люди. В словаре Ц.Б. Цыдендамбаева дан диалектный термин *аали* (мн. *Аалид*) зап. 1. Строение, постройка, здание; *шэнэ аалид* новые стройки; *аали ахы*, *аали барилга* парн. Строения, постройки (хозяйственные); жилье; *аали гэр* парн. Дом со всеми хозяйственными постройками; 2. Недвижимое имущество. 2. Ср.: *айл* (халх.) – 1. Айл, группа юрт; 2. Семья, семейство; юрта, дом, двор, хозяйство; *айл орх* двор, хозяйство, дом; *айл гэр* семья, семейство; 3. Соседство; *айл аймаг* живущие по соседству; 3. *Эл [ээле]* (калм.) – 1. Айл, хотон; селение; 2. Уст. Собир. Семья, семейство; 3. Уст. Двор, хозяйство; 4. Собир. Соседство, соседи.

В монгольском языке, как пишет Т.А.Бертагаев (1974, с. 44), *айл* (*ал*) – одна или две-три семьи, остановившиеся в данной местности для жительства, а в

бурятском – небольшая группа или несколько десятков родственных семей, образовавших селение. Традиционный вопрос бурят при знакомстве: *ямар айлайши?* – из какого ты селения? Также у азиатских и кавказских народов лексема *аул* обозначает деревню, селение, поселок; оседлое или кочевое сборище жилищ; собрание изб, хат, мазанок, землянок, сакль или шалашей, шатров, балаганов, юрт, кочевых кибиток.

В работе известного тюрколога, алтаиста В.И.Рассадины «Фонетика и лексика тофаларского языка» (1971) дан синонимический ряд из 18 слов: тоф. *А:!* группа юрт; семейство; двор, хозяйство; др.-тюрк. *А=!!* загон для скота; алт. *Айыл*, тув. *Аал* селение, аул; дом; хак. *Аал* селение, деревня; як. *Ыал* двор, жилой дом, отдельная семья; селение; тур. *А=il* кошара; туркм. *Агыл* стойло, загон, овчарня; тат. *Авыл*, башк. *Ауыл*, каз. *Ауыл* деревня, аул; кирг. *Айыл* аул, группа юрт близких родственников, (уйг.) *авул*, (узб.) *овул*, аул; // староп.-монг. *Аул* сосед, соседство; селение, аул; юрта, дом; ойр. *Ажил* сосед, соседняя юрта. Семантика лексемы *айл* в монгольских языках дана выше. Таким образом, слово *айл* с его фонетическими вариантами (*аал*, *ээл*, *аул* и т.д.) в лексике жилищно-поселенческого комплекса монгольских и тюркских народов аналогично по значению.

Н.Л.Жуковская определяет термин *айл* (монг.) так же, как группу родственных семей, ведущих общее хозяйство, совместно кочующих и располагающихся в определённом порядке на общей стоянке (1988, с.188).

Этимологический анализ слова «*айл*» показывает, что оно восходит к первичному корню «*ай*», означающему «собирательное множество». Морфема *-л* означает «собирательное множество разумных существ» и как самостоятельный аффикс в современных монгольских языках встречается редко, например, зап-бур. *Дээд -γγ -л* «верховские» (*дээдэ* «верхний», *-γγ-* соединительная гласная), бур. *Баяш-уу-л* «богачи». Ср. *Монго-л* как этническое наименование народа. Так, в слове *айл* – бур. «совокупность родственных семей, родовая община» (отметим, что бурятские селения до сплошной коллективизации состояли из семей одного рода или родственной группы), монг. «семья, семейство» (общины давно распались и редко соблюдался обычай поселения родственными группами) и «группа юрт» корневая часть *ай-* находится в несомненном генетическом родстве со словом *ай* «совокупное множество».

В «Большом академическом монгольско-русском словаре» (БАМРС) под редакцией Г.Ц. Пюрбеева, изданном в 2001 г., который отличается от всех ныне известных более полной и качественно новой информацией о монгольском слове, лексема «*ай*» многозначная: *категория, часть, группа, род, тип, класс, сорт* и в сочетании *ай түмэн* или *үй түмэн* – «бесчисленное множество».

«В обновлении и в образовании слова существенную роль играет его значение: смысловые филиации и сдвиги. Начнем с определения образования слова путем изменения его значений, отводя на второй план процесс семантического

обновления слова, который может оказать влияние на лексико-стилистическую и грамматическую денотацию в языке. Имеются в виду изменения окраски слова, его переосмысление» (Бертагаев Т.А., с. 38).

Сдвиги в значении слова, иногда почти неуловимы: постепенно создается основа для появления нового значения, противоположного первичному, и новое ответвление значения приближается к конечному значению, с каждым разом вбирая в себя что-то новое, всё отдаляясь от начальной позиции. Первичные значения во многих случаях исчезают, забываются и даже иногда не восстанавливаются путем научного этимологического анализа, поэтому в языке мало слов с полярными и отдаленными значениями, или же значения так расходятся, что слова кажутся генетически не связанными. От значения «загородка для овец» производным является уже «хлев для скота» (где скот, там и стойбище кочевников), а это уже повлекло за собой значение «несколько стойбищ или аилов из родственных семей». В бурятском языке «небольшая группа или несколько десятков родственных семей, образовавших селение, а в монгольском языке *айл (ал)* «одна или две-три семьи, остановившиеся в данной местности для жительства».

Проф. У-Ж.Ш.Дондуков отметил, что словообразовательная модель на аффикс – *м (-ма)* в бурятском, а также в других монгольских языках образует только существительные, которые по отношению к производящей основе означают орудие, средство и опредмеченный предмет или объект действия. Монгольский отглагольный словообразовательный аффикс –*г* образует имена существительные, обозначающие предметы, объекты результата совершения действия. От глагола *аймаглах* «классифицировать по сортам и группам» *ай- ма- г* «группа селений, район, род, вид, подвид» и т.д.

Аймаг (бур.) – 1. Аймак, район; *аймаг түрэ* район, аймак; 2. Аймачный центр; *аймаг айл* – собир. Семьи с одной родословной; 3. Уст. Род; поколение, группа, *аймаг зон*: а) группа людей б) собир. Народность; Ср.: *аймаг* (халх.) – административная единица; племя; *монгол аймагууд* монгольские племена.

Буряты, являясь билингвами, наряду с термином *аймаг* в данном значении употребляют также заимствованное из русского языка слово *район*, которое издавна бытует в современном бурятском языке.

Таким образом, анализ устойчивых терминов бурятского языка *айл* и *аймаг* показывает, что данные лексемы имеют старомонгольское происхождение от первичной основы –*ай* «совокупное множество» посредством словообразовательных моделей на аффиксы –*л (ай-л)*, –*ма*, –*г (ай-ма-г)* и являются устойчивыми, широкоупотребительными в лексике жилищно-поселенческого комплекса (далее ЖПК) бурят, а также других монгольских и тюркских народов.

Термины ЖПК бурят Байкальского региона, находящиеся в тесной зависимости от общественного уклада, показывают, что изменения их значений целиком определены изменениями жизненных условий этноса.

Далее рассмотрим лексему **отог**, который претерпевает лексико-семантические изменения в бурятском языке: 1. **Отог** (бур.) – 1. **Отог байра** балаган (на покосе), шалаш; 2. Ист. «**оток**», род, клан; **отогоорхин** сородичи (принадлежащему к одному клану); Ср.: **отог** (халх.) түүх. – 1. **Отук** (административная единица в дореволюционной Монголии); волость; *шавийн отог* шабинский отук; 2. Род, племя, поколение, клан; **отог** II ан. Артель охотников. **Отог** III огнище. **Отг [отъг]** (калм.) – ист. **Оток** (административная единица в дореволюционной Калмыкии); **отуу** (староп.-монг.) – род, поколение; **отай** (др.-тюрк.) – шатер, жилище < др.-тюрк. **Ота**.

Для сравнения приведем перечень словарных статей термина **отог** из исследований В.И.Рассадины: **oday** (тоф.) временная стоянка, охотничий стан в тайге (обязательно с костром); (тув.) **одаг** очаг; костер, охотничий стан, бивак; (кирг.) **отоо** походная юрта; юрта новобрачных; (хак.) **отак** шалаш; (як.) **отуу** шалаш; становище; костер в поле; (туркм.) **отак oda** комната; (уйг.) **отак** юрта; охотничья сторожка; (ойр.) **отуг, отак** племя, община; нация; (совр. Монг.) **отог** огнище; артель охотников; род, клан (1971, С. 210).

У Ф.К.Комарова в «Словаре русской транскрипции»: **отор** пастбище, осенний загон, временное летовье; **отордур** временное пребывание; **оттук** место, богатое травой; сезонное пастбище оленей; покосное место; **оту отуу** шалаш из сена, устраивается на период сенокоса; полевой балаган; становище, место привала, стоянка; костёр; эвенк. **Оту** временная стоянка в пути (урм.), стойбище (олкм.); эвенк. (с.) **оту** шалаш.

Как показывают исследования (более 20 словарных статей лексемы **оток**), данный термин имеет древнетюркскую этимологию. Локус функционирования слова **отог** широк: монгольские, тюркские, тунгусо-маньчжурские языки. Следует отметить, что в современном бурятском языке функция данного термина сузилась и употребляется в значении временной стоянки таёжного полевого балагана у охотников (*ангуушадай отог*), или на период сенокоса (*үбһэшэдэй отог*). Также в связи с возрождением национальных традиций, обычаев бурятского народа историзм **отог** активизировался в прежнем значении «род, клан, племя». **Отогоорхин** сородичи (принадлежащие к одному роду, клану); *сартуул отогойхид* принадлежащие к роду сартулов; *хуасай отог* хуасай род.

Известно, что у аборигенов Байкальского региона административно-территориальным объединением до Октябрьской революции был **хотон**.

Этот вид поселения имел вид маленьких деревушек, расположенных на значительном расстоянии друг от друга. В каждом таком поселении насчитывалось примерно восемь-десять дворов. Большей частью в **хотоне** объединялись малые, разделённые семьи, вышедшие когда-то из одной большой патриархальной семьи, пишет Р.Б. Рандалов (1965, с. 55).

Хото(н) (лит. Бур.) - 1. Загон, стайка, хлев; **хото шэбээ** парн. Загон, загородка (для скота); **гахайн хотон** зап. Свиарник; 2. Стойбище, становище; **хотон айл** группа айлов, стоянка. Ср.: **хот** (халх.) – 1. Город; яриа. Град; **гурван давхар хот** тройная городская стена 2. **Хотон**, группа юрт (совершающая совместно перекочевку); **хоёр хот айл** две группы юрт; 3. Стойбище, загон для скота; ограда, ограждение; **айлын хот** загон для скота; 3. **хотн [хотън]** (калм.) – хотон; село; деревня; **хотн дунд хо цаһан куукн сууна** – посреди хотона сидит светлолицая девушка (загадка) (беш печь).

В том значении, о котором говорит Ю.В. Рандалов, слово **хотон** употребляется в речи мухоршибирских и бичурских бурят, и оно заимствовано их соседями – семейскими. **Баруун хотондо айлиад бууба** – в западный хотон приехали гости. **Шэнэ хотондо гэр барихам** – построю дом в новом хотоне. Следует отметить, что в современном бурятском языке термин **хото(н)** полисемичен: 1) стайка; 2) деревня и т.д.

Из всего сказанного явствует, что слово **хотон** монгольского происхождения и определяется оно следующим образом: **хотон** когда-то кровно-родственная, а затем территориальная община, совместно кочующая и ведущая общее хозяйство; в позднем Средневековье, как отмечает Н.Л. Жуковская, – посёлок и даже город. В присаянском говоре бурятского языка **хотон** «стайка» (**тугалаа хотондо хаагты** «теленка закройте в стайку»).

В старину в монгольском языке бытовала ещё одна лексическая единица, которая функционально и семантически соответствовала хотону – **баг хуучир** (низовая административная единица в сельской местности МНР); **сум бурт 6-10 баг байдаг** в каждом сомоне бывает от 6 до 10 багов.

Среди приведенных ойконимов в современном бурятском языке сравнительно редко употребляется лексема **тосхон**. 1. **Тосхон** (лит. Бур.) - селение; **тосхон айл** парн. Селение, посёлок; **хото тосхон хоёрой хоорондохи илгаа** различие между городом и деревней; 2. Ср.: **тосгон** (халх.) – село, деревня; посёлок, селение; **гацаа тосгон** хорш. Деревня, селение, посёлок; **ходоо тосгон** хорш. Деревня (как социальная категория); **ходооний тосгон** поселение сельского типа; **тосгон айл** хорш. Деревня, село; 3. **Тосхлц [тосхъяцъ]** (калм.) – сооружение, постройка; **ус уулгдг тосхлц** водопроводные сооружения.; **тосхач [тосхълһън]** и др. От **тосхх** 1) строительство, стройка. Также следует отметить, что в терминологии ЖПК бурят бытуют заимствованные лексемы **деревня, село, сэлээн (селение)**. **Зундаа деревнидэ зохид даа** летом в деревне прекрасно, **тэрэл селоодо байдаг** в том же селе живёт.

Деревня – это в узком исторически сложившемся в русском языке значении небольшое сельское поселение (более мелкие носители название выселков, починков, хуторов, заимок и т. Д.; в широком же смысле понятие **деревня** охватывает весь комплекс социальных, экономических, культурно-бытовых, природно-географических

особенностей и условий жизни. *Деревня* как социально-экономическая категория отличается от города. Этимология термина **село**: происхождение: др-русск., ст.-слав. **Село** общеслав. **Selo** индоевроп. Корня в значении «жилое помещение»; родственны: др-верх. – нем. **Sal** – обитель, жилище; лат. **Solum**- почва и др.

По сравнению с калмыцким языком в лексике бурятского языка малоупотребительно слово **селеэн** (*селеэнгээрээ найрлаабди* праздновали всем селом). Данная лексема не обнаружена в бурятском и монгольском словарях, зато зафиксирована в калмыцком: **селэн** 1. Селение, село; **баахн селэн** небольшое селение; 2. Посёлок, поселение.

Наряду с традиционными терминами, обозначающими сельские поселения бурят, бытуют также исконно бурятские слова **хүдөө, гол**. **Хүдөө** - 1. Худон, сельская местность; провинция; 2. 1) сельский; *хүдөөажахы* сельское хозяйство; там же даётся определение термину **гол**- I река, долина реки; *гол голрой нохойн дуун ондоо, айл айлай хүүрын ондоо* (старинная пословица) в разных долинах и собаки лают по-разному, в различных улусах и говорят по-разному: что ни город, то нор, что ни село, то обычай.

Говоря о территориально-административном устройстве нашего края, необходимо отметить, что в 1923 г. Была образована Бурят-Монгольская АССР в составе РСФСР, что создало благоприятные условия для национально-государственного строительства и национальной консолидации бурят. В 1958 г. Республика была преобразована в Бурятскую АССР, а с 1991 г. Стала Республикой Бурятия.

В современной бурятской и халха-монгольской лексике ЖПК наиболее употребительно слово **нутаг**. **Нутаг** (лит.бур.) – 1. Родное место, родные кочевья, родной улус; **түрэн нутаг** родное место; **хари нутаг** чужбина; местность; 2. **Нутаг нуга** парн. Родные места; булг. Улус, местечко; ср.: **нутаг** (халх.) - 1. Родное место; родные кочевья; родина; **торсон нутаг** родина; 2. Территория; *дэвсгэр нутаг* территория; 3. Местность. **Нутг [нутъг]** (калм.) ист. – 1. Родное место, родина, родной улус; **торсн нутг** родина, родное место; 2. Фольк. Владения; 3. Кочевье, место откочёвки.

В сочетании с лексемой **тоонто** семантика общемонгольского термина **тоонто нутаг** изменяется: сужается, конкретизируется. **Тоонто** (досл.) послед, плацента, детское место. Второе значение этого слова – место рождения, колыбельная земля, малая родина. Исходя из второго значения слова Г-Д. Нацов считает, что оно произошло от слова «тооно» - светодымовое отверстие, окно юрты, суффиксы **-то, -той** означают «обладание» (1995, с.155). Совершение обряда **тоонто тайха** знаменовало захоронение своеобразного жилища новорожденного, которое было и останется на всю жизнь хранителем, покровителем этого ребёнка.

В наше время, когда идёт возрождение народных традиций и верований, *тоонто* в судьбе бурята и других монголоязычных народов имеет большое значение. Почитание *тоонто* способствует благополучию всех и каждого. Безусловно, у данных этносов существует обряд – *тоонтоёо тахиха*.

Кроме вышеназванных слов, относящихся к поселениям, в современном бурятском языке сравнительно активна лексема **орон**, издавна употребляемая во всех монгольских языках в нескольких значениях. В данном случае эта словарная единица интересует нас в значении «страна», «родина». Термин **орон** в сочетании с другими словами меняет своё значение. **Орон** (лит. Бур.) - часто с последующим *турэ* страна; *эсэгэ орон* отечество, *эхэ орон* родина, *орон дэлхэй* (или *нутаг*) парн. Местность. Ср.: **орон** (халх.) – I. 1. Жилище, кров; *суудаг орон байр/ орон байшин/ орон сууц* хорш. Кров, жилище, квартира, жилой дом; помещение; *орон гэр* хорш. Кров, жилище, юрта, дом; *орон сав* хорш. Помещение, жилище, здание; *орон сууцны нохцол* жилищные условия; 2. Прибежище. **Орон** II 1. Страна, государство; край; местность; *газар орон* хорш. Земля, страна, место, местность; 2. Территория; *орон нутаг* хорш. А) периферия; территория, район, места; б) страна, *торсон орон нутаг* родные места, родина; *хүдөө орон нутаг*; *худон* сельская местность. 3. **Орн [орън]** (калм.) – страна, держава, государство; *орн-нутг [орън-нутъг]* парн. Страна, держава, государство. В лексике монгольских языков данная лексема устойчива и занимает важное место.

Особый тип ведения хозяйства у бурят вносил определённые коррективы в процедуру выбора места для поселения. Сезонные миграции, осуществляемые два-четыре раза в год, стали по существу причиной возникновения как минимум двух способов «культурного освоения» пространства – при формировании летнего поселения и зимника (вид перемещений, который стал наиболее распространённым в конце XIX в.).

В бурятском языке сохранились названия поселений, образованные аффиксальным способом от названий четырёх времён года: *үбэл – үбэлжөөн*, *хабар – хабаржаан*, *намар – намаржаан*, *зун – зуһалан*. Зимние стоянки назывались *үбэлжөөн*, летние – *зуһалан*, осенние – *намаржаан*, весенние – *хабаржаан*.

Үбэлжөөн 1. Лит. Бур., ср. Окин. *Гбэлзоон* // *обэлзоон*; 2. Халх. *Овэлжөө*; *овэлжих* – зимовать < *овэл* – зима, калм. *Үвлэн, увлэх* – зимовать < *увл* – зима, 3. Стп.-м. *Ebuljige* – зимовка < *ebulgi*=зимовать < *ebul* зима. Общебурятское слово *зуһалан*, тунк. *Зуһаха* – проводить лето, летовать *зун* – лето, калм. *Зусли* – летник, летнее стойбище, *зуслх* – летовать, халх. *Зуслан* – летник, летнее стойбище, *зусах* – летовать, стп.-м. *Jusalang* – летник, летнее стойбище < *jusagu* – летовать < *jun* – лето.

Число кочёвок зависело от состояния пастбищ, кормовых и охотничьих угодий, количества стад и табунов. В XIX в. наиболее обычными стали перемещения с зимника на летник, хотя у некоторых этнических групп бурят

Байкальского региона всё ещё бытовала традиция круглогодичных циклических кочёвок. В Западной Бурятии, в частности, у аларских, тункинских бурят, ввиду отсутствия обширных степных просторов издавна установился обычай зимне-летних сезонных перекочёвок, что обусловило формирование у них постоянных зимних и летних поселений. Каждая родовая группа, как отмечает К.М. Герасимова, располагала определённой территорией, на которой имела свои постоянные зимники и летники.

Слово *зуһалан* бытует в современном бурятском языке в несколько расширенном значении – летнее местожительство вообще (независимо от того, содержится там скот или нет), т.е. и в значении летнего стойбища (со скотом) и в значении дачного места (без скота). В лексике тункинских бурят *зуһалан* употребляется в первоначальном значении, ибо процедура перемещения со скотом на летник у них сохранилась, а термину *үбэлжөөн (үбэлзөөн)* синонимична лексема *гол* в значении «центр, центральная усадьба». *Голһоо зуһалан хүрэтэр харгы һайн* – От центра до летника хорошая дорога. В речи же городских бурят данное слово бытует в значении «дача». Вместо лексемы *зуһалан* молодежь предпочитает заимствования из других языков: *дача, фазенда*. Фактически *фазенда* (португ. *Фазенда*) в Бразилии – крупное поместье, земельное или скотоводческое; то же что *асьенда, эстансия*.

Необходимо отметить, что в последнее время в бурятском языке, в частности в СМИ, вместо заимствования *область* употребляют архаизм *можо*. Например, *Эрхүүгэй можо* – Иркутская область, *Шэтын можо* – Читинская область. Рассмотрим семантику данного термина:

Можо 1. Бур. III уст. Область; автономно **можо** автономная область; 2. Халх.-монг. **Муж** а) область; провинция; губерния; департамент; *олон аймаг муж* провинции; *муж хязгаар* хорш. Область, край; б) зона; 3. Калм. **Межэ** граница; рубеж; *орн нутгин межэ* государственная граница // гл. *Межэлх (межэлхе)* граничить. Лексема **межа** зарегистрирована и в словарях русского языка в значении «граница земельных участков». Отсюда следует, что общемонгольский термин **можо** – **муж** – **межэ** широко употребляется в русском языке в том же значении. Как отмечает Д.Д.Нимаев, во 2-й половине XIX в. Из Иркутского округа выделились Балаганский и Верхоленский округа (**тойрог**). В Забайкалье в 1856 г. Были образованы Баргузинский, в 1863 г. – Селенгинский, в 1872 г. – Троицкосавский округа. На основе Нерчинского возникло 4 основных округа – Читинский и Нерчинско-Заводской и др.

Термин **тойрог**, образованный от глагола *тойрохо* «обходить или объезжать вокруг чего-л.; окружать», в лексике современного бурятского языка бытует наряду с заимствованием «округ». Аналогично **округ** (образован от глагола «окружать») обозначает: 1. Административно-политическое, хозяйственное, военное и т.д. подразделение государственной территории. Например, **национальный округ**. 2. То

же, что округа (устар.). Значения терминов *тойрог* и *округ* в русском и бурятском языках аналогичны.

Заимствованное из русского языка слово *республика* имеет латинское происхождение: *respublica* – общественное дело; государственный строй < *res* – государство и *publicus* – общественный, народный. На лексику бурятского языка как и других монгольских языков оказали влияние не только тюркские, тунгусо-маньчжурские и русский языки. Таким образом, из лексики поселений бурят (около 450 слов), которые войдут в специальный словарь, здесь мы рассмотрели наиболее часто употребляемые термины: *айл* – дом, семья, группа домов, юрт, населенный пункт; *аймаг* – район; *улус* – селение; *нютаг* – родное место, родные кочевья, родина; *орон* – страна, родина; *зуһалан* – летник, *үбэлжөөн* – зимник и т.д. Рассмотренная нами лексика даёт основание утверждать о ее подвижности, которая стимулируется современным обществом. Механизм языковых изменений обусловлен внутренними, присущими языку бурят закономерностями, способствует перестройке языковой системы, их обогащению новыми элементами.

Резюмируя вышесказанное, следует отметить, что ойконимы бурятского языка, исследуемые в диахроническом аспекте в большинстве своём имеют общемонгольскую этимологию и активно употребляются этносом. Например, *орон*, *нютаг*, *аймаг*, *можо* и т.д. Лексема *айл* в различных фонетических вариациях в активном словаре не только монгольских, но и многих тюркских народов: якутов, тувинцев, киргизов, уйгуров и др.

В бурятском, халха-монгольском, калмыцком языках и бурятских диалектных ответвлениях семантика основного словарного фонда аналогична. Такие термины, как *тосхон*, *хошуун*, *үбэлжөөн* и др., стали малоупотребительны и вошли в разряд архаизмов, историзмов. Диахронический анализ термина *хото(н)* констатирует следующее: слово *хот* в монгольском языке первоначально означало «огороженное место для скота», от данного значения производным, считает Т.А. Бертагаев (1974, с.41) «хлев для скота» (где скот, там и стойбище кочевников». Далее – несколько стойбищ, аилов из родственных семей, которые, в свою очередь, образовали «кочевой поселок» > «поселок с торгово-административным центром» > «город» и *ниислэл хото* «столица». Изменения в реальной действительности способствовали семантическому изменению данной лексемы.

В современном бурятском языке термин *хото(н)* употребляется в четырех значениях: 1. В литературном бурятском языке – *хото* «город»; 2. *Ниислэл хото* «столица»; 3. В присаянском говоре – *хотон* «хлев для скота, стайка»; 4. В говоре тугнуйских бурят – *хотон* «группа домов, селение».

Также необходимо отметить, что лексемы *хотон*, *селеэн*, *хошуун* и др. Являются терминами-индикаторами и входят в состав сложных ойконимов, например, *Хүхэ-хото*, *Нурселение*, *Хошуун-Узуур* и т.д. Говоря о тюркизмах, следует отметить, что термин *улус* в значении «поселение» употребляется в

калмыцком и халха-монгольском языках, а в лексике бурят он отсутствует. В современном бурятском языке в первоначальном значении бытует термин древнетюркского происхождения *отог* > *ота* > *ота* = «шатер, жилище». Бур. *Отог* – временная стоянка, балаган, шалаш. Например, *ангуушадай отог* «охотничий стан». В последнее время с возрождением духовной культуры бурят, национальных традиций, обычаев слово *отог* употребляется в значении «род, племя, клан».

Таким образом, лексикологические исследования являются неотъемлемой частью историко-сравнительного изучения языков, первые поиски генетической общности которых начинаются, по существу, с лексических сопоставлений. Безусловно, такой подбор убедительных параллелей необходим для проникновения в сущность особенностей развития лексики бурятского и других языков алтайской семьи.

ЛИТЕРАТУРА

1. Бертагаев Т.А. Лексика современных монгольских языков.- М., 1974. – С. 367-368.
2. Герасимова К.М., Галданова Г.Р., Очирова Г.Н. Традиционная культура бурят. – Улан-Удэ: Бэлиг, 2000. – 144 с.: ил.
3. Дондуков У-Ж.Ш. Развитие лексики монгольских языков. Кн.1. – Улан-Удэ: Издательский дом «Буряад үнэн», 2004. – 288 с.
4. Дондуков У-Ж.Ш. Развитие лексики монгольских языков. Кн.2.- Улан-Удэ: Издательский дом «Буряад үнэн».2004. – 270 с.
5. Древнетюркский словарь /676 с./ - Л.: Наука, 1969.
6. Калмыцко-русский словарь (26000 слов) / под ред. Б.Д. Муниева / Калмыцкий науч.-исслед. Институт языка, литературы и истории при Совете Министров Калмыцкой АССР.- М.: Русский язык,1977. -768с.
7. Комаров Ф.К. Словарь русской транскрипции терминов и слов, встречающихся в географических названиях Якутской АССР. – М.,1964. – 135 с.
8. Котвич В.Л. Исследования по алтайским языкам. – М., 1962. – С. 351.
9. Лексикологические исследования монгольских языков: сб. Ст. – Улан-Удэ: БФ СО АН СССР, 1998.- 192 с.
10. Монгольско-русский словарь / под общей ред. А. Лубсандэндэва. Около 22 000 слов. – М.: Государственное издательство иностранных и национальных словарей, 1957.
11. Нацов Г.-Д. Материалы по истории и культуре бурят. Ч.1 / Введ., перевод и примеч. Г.Р. Галдановой. – Улан-Удэ, 1995.
12. Нимаев Д.Д. Проблемы этногенеза бурят. – Новосибирск, 1988.
13. Пюрбеев Г.Ц. Толковый словарь традиционного быта калмыков. – Элиста: Калмыцкое кн. Изд-во, 1996. – 176 с.

14. Рассадин В.И. Влияние тюркских и тунгусо-маньчжурских языков на формирование лексического состава бурятского языка // Актуальные проблемы современного монголоведения. – Улан-Батор, 1987. - С. 169-183.
15. Рассадин В.И. О тунгусо-маньчжурских элементах в монгольских языках // Этнокультурные процессы в Юго-Восточной Сибири в средние века. – Новосибирск, 1989.- С. 145-152.
16. Цыдендамбаев Ц.Б. Заметки об этнических и языковых контактах бурят и эвенков // Языки и фольклор народов Севера. – Новосибирск, 1981. – С. 70-91.
17. Этнокультурная лексика монгольских языков: сб. Ст. – Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 1994. – 179 с.

-oOo-

Гурав. АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

М.Одмандах,

БСА-ийн ерөнхийлөгч, доктор

БИЧИГТ ЦАГААН ЧУЛУУНЫ ЭРЭЛД

Оршилд өгүүлэх нь

Буриадын зөнч мэргэн Молон¹ багшийн айлдсан лүндэнд Бичигтийн цагаан чулууны тухай анх дурдсан нь буриад хүмүүсийн эрлийн үзүүрийг тийш нь хөтөлсөн юм. Өвгөд дээдэс маань тэрхүү цагаан чулуутай газрын өмнө зүгт гарч тогтохын тулд Байгал далайгаа чухамхүү орхиж, нүүсэн гэж бодохоор ямархан учрал тохиолоор бидэнд өвлөсөн итгэл үнэмшил вэ?

Хэлмэгдүүлэлтийн хар шуурга ч гэсэн явж явж өвөг дээдсийн сургаал, зөн билгээр их нүүдэл хийсний... гор байсан юм. Тэд юуны төлөө ингэж нухчин даруулсан бэ, яагаад тэд элэг нэгт монгол нутагтаа нүүж ирсэнийхээ төлөө гашуун гэсгээл хүлээсэн бэ, яагаад тэд зөвхөн наран ургах дорно зүгийг барин нүүдэллэсэн бэ, 1000 жилийн түүхтэй “Заян наваа” дуу ямархан учиртай вэ гээд түмэн асуулт, буман эргэлзээ миний тархинд эргэлдэх болсоор багагүй хугацаа өнгөрчээ.

Хэдэн жилийн өмнө нэрт орчуулагч Д.Бадамням ахтай хөөрөлдөж байхад анх Бичигтийн цагаан чулуу нээрээ хаана байдаг бол гэсэн бодол төрж билээ. Түүнийхээр бол Дашбалбар сумаас хойхно хилийн наана байдаг гэх. Өвгөн түүндээ итгэлтэй биш ч гэлээ тэнд байж магад гэж итгэж явдаг аж. Хүмүүс байнга л хайж байдаг юм байна даа гэж бодоод л өнгөрч билээ.

Ингэхэд яагаад заавал “Бичигт цагаан чулуу” гэж. Бичигтэй мөртлөө цагаан чулуу хаа сайгүй л байдаг ч гэлээ тэр бичгэнд л их учир байх ёстой. Эсвэл билэгдэж хэлсэн билэгдэлт дүр, утга байж ч болох. Мөн лүндэнд дурдсан Эгэрийн /Эхэрийн ч байж болох М.О./ цагаан тал нутаг хаана байна вэ. Энэ нь явж явж буриадын язгуурын уугуул нутгийн талаарх эрэл ч байж болох юм. Заян наваа, Бада Ёго гэдэг

¹ Балдагарын Молон өнөөгийн Оросын Холбооны Улсын Буриад улсын Яруунын аймгийн нутаг Эгэтийн адагт 1768-1853 онд төрсөн хори буриад хүн. Хори буриадын Худанын дацанд шавилан сууж, хожим 1795 онд Анаа дацан байгуулагдахад элдэв тушаал эрхэлж байгаад, ном эрдэмд нэвтэрч Гавжийн дамжаа барьсан байна. Зөнч мэргэн, буриадын хүмүүсийн оюун санаанд хамгийн их нөлөө үзүүлсэн хүний нэг. Буриадын монголруу хийсэн их нүүдэл ч түүний оролцоо, зөн билгээр хийгдсэн болохыг олон баримт нотолдог. Зохиогч.

газар орон хаана байна вэ? Бид тэр газрыг олж чадах уу? Гээд буман асуултын хариулт өнөө хэр бүрхэг. 1990-ээд оноос хойш буриадын сэхээтнүүд, эрдэмтэн судлаачид, олон нийт ч ялгаагүй мянган жилийн түүхтэй “Заян наваа” дуугаа эргэн нэг санаж, их эрлийг эхлүүлж, сонины дугаар дамжуулан цуврал нийтлэл бичиж, түүнийг нь манай сонинууд, тэр дундаа “Дал” сонин хэдэн дугаар дамжуулан хэвлэж байлаа. Монголын эрдэмтэд ч уг газрын тухай өөрсдийн таамаглал дэвшүүлж, судалгааны өгүүлэл бичсэн нь бий. Эрдэмтэн Н.Лхагвадорж¹, профессор С.Ишбалжир² нар томоохон өгүүлэл бичиж, уг газрын талаар өөрсдийн саналыг дэвшүүлж, баримтаар баталсан байдаг. Мөн зохиолч Г.Жамсранжав³, буриадын зохиолч Ц.Д.Цыбикжав⁴ нарын зэрэг олон хүн өөрсдийн саналыг дэвшүүлж гаргасныг та бүхэн үзэж болно. Энэ дууны түүхт үндэсийг мөшгөн хөөж, газар нутгийг баттай тогтоож чадвал буриад хэмээх хор монголчууд, хориудын үндсэн нутгийг бид олж болох юм.

Молон багшийн лүндэнд дээрх Заян нава, Бада ёго гэсэн нутгийн тухай байхгүй ч гэлээ ямар нэгэн сэмжээр холбоотой байхыг бас үгүйсгэх аргагүй. Хүн төрөлхтөн анхнаасаа аль сайхан нутгийг шилж сонгон нүүдэллэж, хожим нь өөрсдийн өнөөгийн буй газар нутагтаа эзэн сууж, өмчирхсөн болохоос бус байгалаасаа тэр газарт төрж, тэндээ суурьшаагүй нь лавтай юм. Тийм болохоор буриад түмний язгуурын нутгийг олно гэдэг тийм ч амархан ажил биш болох нь энэ олон жилийн эрэл хайгуул, эрдэмтдийн судалгаанаас харагдаж байна.

“Бичигт цагаан чулуу” гэж Молон багшийн лүндэнд буусан газар орны тухай эрэл хийсэн талаараа энд өгүүлэхээр зориглов. Бидний сонирхлыг татаж байгаа олон бичигт нэртэй, бичгийн дурсгал бүхий газар орон байгаа хэдий ч хайж байгаа газар маань хараахан биш бололтой юм. Энд би сонирхолтой хэд хэдэн баримт түшиж, өөрийн санал дэвшүүлэх гэж оролдсон болно. Эрэл үргэлжилсээр л...

Бичигт нэртэй газрын тухайд эргэцүүлэхүй...

Бичигт нэртэй газар монгол оронд хаа сайгүй л тааралдах аж. Гэхдээ нэг сонирхолтой зүйл нь монгол орны зүүн өмнө зүгээс эхлээд баруун тийшээ, Сүхбаатар, Дорноговь хүртэл үргэлжлэх газарт хэд хэд тааралдах нь анхаарал татаж байна. Дорнод аймгийн Халх, Нөмрөгийн сав нутагт Ханчандмань уулын зүүн суганд Бичигт толгой уул гэдэг газар байдаг ажээ. Нутгийнхны хэлж буйгаар бол “Бичигтийн хясаа” ч гэж нэрлэдэг байна. Мөн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигтийн боомт гэж нэрлэгдсэн газарт хилийн зурвас, хилийн багана бүхий Бичигт уул, мөн ар дор нь Бичигт толгой, Дарьганга сумын тэндэх Сөдөтийн

¹ Н.Лхагвадорж “Заян Наваа буриад дуу ба буриадудын уг гарвал” өгүүлэл. Буриад судлал №1.

² С.Ишбалжир “Буриад гэж хэн бэ?” Буриад судлал №1. 2008. 125-р талд

³ Г.Жамсранжав “Наян -Наваан зөвхөн мянганы дуун төдий бус” Дал сонин.

⁴ Ц.Д.Цыбикжав “Заян нава” болон “Нууц товчоо” нийтлэл “Дал” сонины 2002 оны №145-д

Бичигтийн цагаан чулуу зэрэг газрууд одоогоор бидний тогтоосноор хил дагуу байна. Тэдгээр чулуунд хятад, төвд болон монгол бичгийн олон дурсгал хадгалагдаж байна. Хэдийгээр бичигт гэж нэрлэдэггүй ч олон тооны бичиг дурсгал бүхий уул толгод, хад чулуу монгол оронд зөндөө байдаг нь манай орон эртнээс нааш бичгийн соёлын үнэт өв, чулууны номыг хадгалж ирсэн хосгүй гайхамшигт нутаг болохыг илтгэн харуулж байна. Үүний хамгийн сонгодог дурсгал нь “Чингисийн чулууны бичиг”¹ юм. Судлаач Ч.Жанчив², археологич, нэрт эрдэмтэн Д.Баяр³, академич Л.Болд⁴ нарын зэрэг манай нэртэй судлаачид эртний бичгийн дурсгалуудыг олон жил судалж, дагнасан судалгааны өгүүлэл, ном хэвлүүлсэн байдаг. Тэд монгол оронд байгаа бичиг соёлын дурсгалуудыг бараг бүхэлд нь хамарсан судалгааг хийсэн боловч зарим эртний бичээс нь нээгдээгүй байгаа гэхэд болно.

Бичигт нэртэй газар орны тухайд ном сурах бичиг, лавлах тольд төдийлөн тусгаадаагүй байна. “Монголын нэвтэрхий толь” /УБ., 2000/ бичигт Дорнод аймгийн Матад сумын зүүн урд хэсэгт оршдог “Бичигт тал”, Халхгол сумын нутгаар урсдаг Нөмрөг голын савд оршдог “Бичигт толгой уул”, Төв аймгийн Бүрэн сумын нутагт байдаг “Бичигт улаан хадны бичээс”, Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт “Бичигт ханангийн бичээс”, Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын “Бичигтийн даваа” гэсэн тавыг нь л тэмдэглэсэн байгаа нь учир дутагдалтай мэт санагдана. Судлаач Д.Боролзойгийн тэмдэглэснээр Булган аймгийн Бүрэгхангай сумын “Бичигтийн хадан хошуу”, Бугат сумын “Бичигт гарам”⁵, мөн монгол бичгийн олон дурсгал хадгалагдаж байгаа цөөнгүй газрыг шинээр нээж, шинжлэх ухааны эргэлтэнд оруулсан байна. Эдгээрийг Монгол орны газрын нэрийн толь бичигт огт дурдаагүй байна. Бидний тогтоосноор дан бичигт нэрээр эхэлсэн газар

¹ Монгол бичигт чулуун номын хамгийн эртнийх нь 1225 оны үед хамаардаг, эрдэмтдийн дунд “Чингисийн чулууны бичиг” хэмээн алдаршсан гэрэлт хөшөө билээ.

² Ё.Жанчив, Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд, УБ 2005, Дөрвөлжин бичгийн дурсгалууд зэрэг эртний монгол бичиг соёлын судалгааны гол гол бүтээлийг туурвисан манай нэртэй судлаачийн нэг байсан юм. Орчин үед дээрх эрдэмтний олж судлаагүй шинэ шинэ нээлтүүд хийгдэж, бичиг үсгийн түүхийн судлагаа улам баяжсаар байна.

³ Сүлдүс овогт Довдойн Баяр нь 1946 оны 5-р сарын 11-нд Улаанбаатар хотод Ардын хувьсгалын партизан, хилийн цэргийн дэд хурандаа Ц.Довдойн гэр бүлд мэндэлсэн. 1954-1965 онд арван нэгэн жилийн нэгдүгээр дунд сургуулийг төгсөөд, 1965-1967 онд Оросын Ленинград хотод Телевизийн курсэд суралцан ирж, 1967-1970 онд Монгол Телевизэд цахилгаан үүсгүүрийн механикчаар ажиллан, Монгол Телевизийн анхны тулгын чулууг тавилцахад оролцож байсан. 1970-1974 онд УБДС-ийн Түүх-Газарзүйн ангийг дүүргээд, 1974-1975 онд УБДС-д багш, 1975 оноос ШУА-ийн Түүхийн Хүрээлэнгийн Археологийн секторт эрдэм шинжилгээний ажилтан, 2002 оноос Археологийн Хүрээлэнгийн Дундад зууны секторын эрхлэгч, 2006 оноос Улаанбаатар Их Сургуулийн Археологийн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байв.

⁴ Л.Болд “БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс” (Түрэг бичгийн дурсгал) I боть. Редактор: Түүхийн ухааны дэд эрдэмтэн Д.Цэвээндорж, УХГ, УБ., 1990.

⁵ Д.Боролзой “Бичигтийн нууц” УБ, 1998. “Бичигт хошууны бичээс” “Оюуны хэлхээ”, Боть II, (04), УБ 2009, “Хоёр монгол бичээс” өгүүлэл Хэл зохиол судлал сэтгүүлийн Боть 2 (34), 1-22 дэвтэр, УБ., 2009, 62-66.

нутаг цөөнгүй байх бололтой. Гэхдээ өмнө нь ямар нэгэн тодотгол бүхий “бичигт” нэртэй газрууд ч байгааг тэмдэглэн хэлэх хэрэгтэй.

Монголын нэвтэрхий толь бичигт дурдсанаар “бичигт” нэртэй газарт эртний чулуун, хүрэл, төмөр зэвсгийн үеэс эхлээд хожмын улсуудын бичиг дурсгалууд олноор хадгалагдан байдаг ажээ. Ингэж үзэх юм бол бидний сонирхоод байгаа Нөмрөг дэх “Бичигт толгой уул” нэртэй газарт учир тайлагдах нууцлаг нэгэн бичээс байх нь эргэлзээгүй. Нөмрөгийн сав газрын бичигт ууланд эртний монгол бичгийн дурсгал байх магадлалтай гэж таамаглаж болох юм. Эрдэмтдийн судалгаанаас харахад “бичигт” нэртэй газарт ихэвчлэн монгол бичгийн дурсгал хадгалагдаж байгаа нь бидний сонирхолыг татаж, дээрх саналыг дэвшүүлэх боломж олгож байгаа бөгөөд бичээс байх аваас монгол бичгээр бичсэн, хар бэхээр хулдсан байхыг үгүйсгэхгүй. Дорнод аймгийн нутгаас Түрэгийн үеийн бичээс өнөө хэр бараг олноогүй нь тэд уг нутагт төдийлөн амьдарч байгаагүйтэй холбоотой байх. Түрэг бичээсийг судласан ном товхимолд Дорнодоос зоосон дээр бичигдсэн түрэг бичээс олдсон болохоос бус хад чулуу, хөшөөн дээр үлдээсэн түрэг бичиг алга байгаа нь сонирхолтой байна.

Гэхдээ дээрх таамагтаа эргэлзэх нэгэн зүйл байна. Учир нь монгол орны хоймор болон төвийн нутгуудаас олдсон бичигт ууланд ихэвчлэн монгол бичиг, соёмбо, төвд бичгийн дурсгалууд хадгалагдаж байгаа бол нутгийн өмнө зүгийн бичиг бүхий ууланд Нангиад, ханз бичиг байх нь түгээмэл байгаа тул бид буруу таамаглал дэвшүүлж байх магадлалтайг энд цохон тэмдэглэе. Сүхбаатар аймгийн Дарьгангын Сөдөтийн “Бичигтийн цагаан чулуу” гэх газарт байгаа бичээс нь Нангиад, ханз бичиг бөгөөд Мин улсын үед хамаарах бололтой гэдгийг саяхан үзсэн манай судалгааны багийнхан тэмдэглэсэн байна. Тиймээс хайж байгаа Нөмрөгийн бичигт толгой дээр эртний ханз бичиг байж болох юм гэсэн таамаглал хийхэд хүрэв. Мөн өөр нэг таамаг нь эртний хадны сүг зураг ч байж болох талтай. Хэдийгээр манай судлаачид монгол орны хадны сүг зургийг дийлэнхийг нь олж судалсан хэдий ч мэдэгдээгүй үлдсэн байхыг ч үгүйсгэх аргагүй.

“Вэй улсын бичиг, Гурван улсын ойллогын Когурьогийн тэмдэглэл дэх “Хылхын гол, Буйр нуур” гэсэн хоёр усны нэр болон “Газар нь үржил шимтэй, уул ус тохиромжтойг харж хотлоё гэснээр усны хөвөөнд суурьшив” гэсэн мэдээ зангийг мөшгин судалж, Хүннү гүрний бутралын дараахан Солонгосын дээд өвөг Пүйө аймаг МЭӨ 59 онд одоогийн Монгол Улсын Дорнод аймгийн нутаг Буйр нуур, Халхын гол гэдэг газарт (уртраг 120-125⁰, өргөрөг 43-45⁰) нутаглаж улсаа байгуулж байсан түүхтэй болохыг монгол эрдэмтэн таван үндэслэлээр тогтоож, Пүйө нь Төв Азийн малчин аймаг байсан гэдгийг зургаан үндсэн баримтаар нотолсон”¹ байдаг.

¹ Өнгөрсөн зун буюу 2011 оны 7-р сарын 29-нөөс 8-р сарын 7-ын дуустал Дорнод аймгийн нутаг болон Сүхбаатар аймгийн нутгаар Улаанбаатар дээд сургууль экспедици зохион байгуулахад Дорнод сургуулийн зүгээс судлаачийн хувиар оролцов. Удирдамжийг УБДС-ийн Монгол судлалын төвийн судлаач, доктор Той.Галсан багш боловсруулан, түүний дагуу аяллаа зохион байгуулсан. Уг удирдамж

Иймд мөн Нөмрөгийн Бичигт толгой уулан дээр ямар нэгэн бичээс байгаа бол дээрх улсын үед хамаарах эртний бичээс байхыг ч бас үгүйсгэхгүй байна. Халх нөмрөгийн сав газарт дуртай хүн нь хөл тавьдаггүй онгон дагшинаараа үлдсэн цөөхөн газрын нэг гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй. Тийм болохоор түүх, археологийн судалгааны эргэлтэнд ороогүй сонин сайхан газар нутаг байх ч магад юм.

Ямартаа ч Молон багшийн лүндэнд дурдсан “Бичигтийн цагаан чулуу” хаана байгааг эрэн хайх эрлийн ажил дөнгөж эхэлж байна. Ямар учраас өвгөний зөнд орсон, учир утгатай газар орон бэ гэдэг нь бидний сэтгэлийг соронзон мэт татсаар.

Тэмдэглэвэл зохих нэг зүйл байна.

Тэр нь “Монголын нэвтэрхий толь”-д /2000/ Дорнод аймгийн Матад сумын нутагт байх, сумын төвөөс зүүн урагш чиглэлд гэж тэмдэглэгдсэн “Бичигт тал” гэдэг газар юм. Молон багшийн лүндэнд “...Наран гарах зүгт Бичигт цагаан чулуу гэж байх. Тэр чулууны бичиг нааш харсныг нь цавчаад, цааш нь харуулаад байх ба дахиад эргэлдээд цааш харж байх ба тэр чулууны цааш эргэгсэн Эгэрийн /Эхэрийн ч байж болох юм. М.О/ цагаан тал гэж нутаг байх. Тэнд нүүхэд гурван жил болоод хүрэхэт. Тэнд хүрсэн хүн хүн болох, мал мал болох...”¹ гэж айлдсан байдаг. Тэрхүү газар нь энд тэмдэглээд байгаа “Бичигт тал” юм биш биз гэсэн бодол ч бас төрж байна. Нутгийн учир мэдэх хүмүүсээс сураглавал нэгийг мэдэж болох байх. Эгэрийн тал хаана байна вэ гэдгийг эрэн хайх нь “бичигтийн цагаан чулуу”-г олох шижим байж болох ч талтай.

Матад сумын “Бичигтийн тал”-ын тухай нутгийн хүн, сэтгүүлч Л.Хэрээ гуайг миний өрөөгөөр орж ирэхэд сурагласан чинь тоймтой зүйл мэдэхгүй байлаа. Өөрөө Матадын баруун биеийн хүн учраас сумаас зүүн тийшээ газар сайн мэдэхгүй ч гэлээ нутгийн газар мэддэг хүнээс уг газрын талаар сураглаж өгөхөөр болоод гарав. Гэтэл 2 цаг орчмын дараа надруу утсаар залгаж, сумаас зүүн тийш 90 орчим км газарт эртний монгол бичээс бүхий хадан хавцалтай газар байдаг тухай мэдээ дуулгав. Ингээд өвгөнийг ирэхэд түүний учрыг тодруулж авлаа. Л.Хэрээ гуайд нутгийн өвгөн, сумын бригадын дарга, багийн даргыг насаараа хийсэн, 62 настай Лувсанцэрэнгийн Баатарчулуун гуай баттай сураг гаргаж өгчээ. Уг газар нь хуучин сумын төв Хадан хөв гэдэг газраас зүүн зүгт 60 гаруй км, одоогийн шинэ Матад сумын төвөөс 90 км орчимд Хайлаас бүхий жалганд эртний монгол бичгээр бичсэн дурсгал бүхий “Ёндонгийн улаан хад” гэдэг газар бий гэнэ. Тэр бичээсийг нутгийнхан төдийлөн мэддэггүй. Хүн уншиж судлаагүй байгаа бололтой юм. Нутгийнхны хэлснээр дээр үед бүдүүн Амбаа гэдэг хүн уншсан юм гэнэ лээ. Түүн

дээр энэхүү баримтыг тэмдэглэн аяллын нэг гол чиглэл болгон авсан юм. Бид Буйр нуур, Халх голын нийлэх уулзварын өмнө талд нэгэн сэргэлэн дэнж олж, тэнд эртний хот байсан байж болох газар гэж сонгон авахад тэнд хүн чулуу байсан юм. Тэр нь дорно зүгийн хүний хийц бүхий, язгууртан хүнийг дүрсэлсэн бололтой хүн чулуу байсан. Уг газарт бид дурсгалын бумба булж, шав тавин тэмдэглэсэн.

Зохиогч.

¹ Молон багшийн лүндэн хийгээд буриадууд

дээр ямар үг байгааг мэддэггүй ажээ. Тэр нь өндөр ургасан хайлааснаас өндөр гэж бодохоор барагцаалбал 8 орчим метр өндөр элгэн хадан хясаа юм байна. Бичиг бичсэн газар нь цуулж байгаад талбай засаж бичиг бичсэн мэт харагддаг. Хадны дээд хэсэгт бичсэн учраас хүмүүс нэлээд авирч байж унших боломжтой. Газраас хүний нүдээр шууд унших боломж багатай газарт байрласан ажээ. Уг бичиг нь “худам монгол бичгээр хар бэхээр” бичигдсэн байгаа тухай хэллээ.

Үүнийг “Дорнод аймгийн нэгдсэн лавлах” номын хуудаснаас шүүрдэн үзвэл Матад сумын танилцуулгын хэсэгт “...Хайлаастын булш бичээс. Сумын төвөөс зүүн хойд зүгт 50-иад км, Хайлаастын бичигт амны Ёндонгийн худгийн зүүн урд талд байх ургаа өндөр хадны хойд талын гадаргуу дээр хоёр хэсэг газар хар бэхээр төвд, монгол үсгээр бичсэн бичиг бий. Мөн худгийн хойд урд хамар дээгүүр ганц нэгээрээ таруу орших цөөнгүй булш бий”¹ гэж бичсэн байх агаад мөн “... Буян-Өндөр баг: Хайлаастын бичигт хад. Сумын төвөөс зүүн хойд зүгт 45 км-т хар бэхээр босоо монгол бичиг болон эртний бичээсээр бичсэн бичиг бий. Хойд дээр нь 20 орчим бамбай хэлбэрийн хиргэсүүртэй. Урд талд нь 1 км орчим жалганы хойд өндөр дээр 10 орчим бөөрөнхий булш байдаг...” гэж нэлээд тодорхой бичсэн байна. Энд тэмдэглэгдсэн Хайлаастын булш бичээс, Хайлаастын бичигт хад нь хоёр өөр, тус тусдаа, гэхдээ ойролцоо байдаг газар бололтой. Эхнийх дээр нь төвд, монгол үсгээр, харин сүүлийнх дээр нь монгол бичиг болон эртний бичгээр бичсэн гэсэн байгааг бодоод үзэхэд хоёр өөр газар гэж ойлгогдож байна.

Ямар ч гэсэн бидний сонирхолыг татаад байгаа бичиг дурсгалууд, эртний булш хиргэсүүр Матад сумын нутагт, тэр дундаас сумын төвөөс зүүн зүгт голдуу байгааг дээрх лавлах номонд дурдсан байгаа нь миний анхаарлыг татаж байна. Хайлаастын бичигт хад гэж нэрлэгдсэн газарт монгол бичиг болон эртний хэлээр бичигдсэн бичиг байгаа гэдэг мэдээ нь тун сонирхолтой байна. Эртний бичиг судласан ном шүүрдэн үзэхэд энэ талаар мэдээлээгүй байна. Мэдээлсэн байсан ч би олж үзээгүй байхыг ч хэлж мэдэхгүй байна.

Ямар ч байсан миний эрлийг мухарлах сонин баримтууд олдсоор байх ажээ. Бидний бодож байгаагаар Эгэрийн, за Ээрэм ч байж болох тал нутаг Дорнод монголын өмнөд нутаг тэр чигээрээ мөн билээ. Тэрхүү бичгийг уншиж тайлбал сонин дүгнэлт хийж болмоор байна. Аливаа зөн билэг, лүндэн гэдэг бол барин тавим үгээр бус ёгт, далдалсан утга илэрхийлж байдгийг ч бид мартаж болохгүй бөгөөд түүний цаадах гүн нарийн утгыг тайлж унших нь эрлийн үзүүрийг хайш нь чиглүүлэхээс ихээхэн хамаатай зүйл гэж бодож байна. Түүний лүндэнд болон бусад богдуудын лүндэнд дан билэгдэлт ёгт утгаар зарлигласан байдгийг ч бид санах хэрэгтэй. Тийм болохоор бид заавал “бичигт цагаан чулуу” хайж байгаа маань буруу байхыг ч хэлэх аргагүй байна.

¹ “Дорнод аймгийн нэгдсэн лавлах 2010-2011” 225-р талд байх сумын түүх дурсгалт газрын танилцуулганд байна.

Бичигтийн цагаан чулууны эрэлд

Энэ эрэл санаандгүйгээр эхлэх болсон юм. Хэдэн жилийн өмнөөс оюуны минь мухарт хадгалаастай явсан нууцхан хүслийг өдөөх нэгэн шалтгаан гарлаа. Гэхдээ энэ эрлийг ийм амжилттай болж, намайг үүгээр өвчлүүлнэ чинээ санаагүй явж билээ. Уг эрэлд нэгдсэнээр буриадынхаа их түүхийн талаар өмнөхөөсөө ихийг уншиж, шинэ шинэ баримт, мэдээгээр өөрийгөө цэнэглэж чадлаа.

Үүнийг орхин цааш өгүүлэх нь...

Өнгөрсөн хавар Улаанбаатар дээд сургуулийн Монгол судлалын төвд ажиллаж байгаа нутгийн баавай, доктор Той.Галсантай ажил төрөл ярилцаж байх зуурт Дорнод аймгаар эрдэм шинжилгээний экспедицийг хийхээр төлөвлөж байгаагаа хэлэв. Тэдэнтэй эрлийн үзүүр, сургийн зангийг нийлүүлэн, Дорнод дээд сургуулийн зүгээс хамтарч ажиллахад бэлэн тухайгаа хэлээд салсансан. Яагаад ч юм бид хоёрын яриа Молон багшийн лүндэн, түүний зөнгөөр хэлэгдсэн Бичигтийн цагаан чулууны тухайд шилжсэн юм. Баавайн сэтгэлд тэр үг байнга хадаатай явсан нь миний бодож явдагтай яг таг таарч, ямар үйлээр нэгдэн нийлэх нь тэр вэ. Бид хоёрын зорилго, хүсэл мөрөөдөл нэгдэх нь тэр.

Той.Галсан багштан өвөл нутгаараа явахдаа Халх нөмрөгийн тусгай хамгаалалттай газрын дарга Р.Үнэнбат ахтай уулзаж, бичигтийн хад байдаг тухай дуулсан байлаа. Эндээс бидний эрлийн үзүүр эхлэх учиртай байжээ. Учир нь миний өвөг дээдэс¹ 1917 онд хойноос нүүдэллэн ирэхдээ Халхын гол, Буйр нуурыг чиглэн,

¹ 1916 оны өвөл Дэлхийн нэгдүгээр дайнд явсан Ага, Цүүгэлийн цэргүүд нутагтаа ирж, тэднийг удирдан зохион байгуулж явсан Нанжины /Бардаашийн/ Санжаа, Очирын /Тума/ Цэрэнжав нар нутгийн 200 гаруй өрх айлг авч Монголруу нүүжээ. Энэ нүүдэл 1917 оны хавраас эхлэн Онон голын хойгуур нутаглаж байсан хүмүүс урагшаа нүүж Улзын гол, Голын цагаан хүрчээ. Мөн оны эцэс 1918 оны эхээр Угтам уул, Их, бага Бүрхээр дамжин Галын гол хүрч, 1919 оны намар Ачит бээсийн нутаг Туг уулын /Одоогийн Булган сумын нутаг/ орчмоор Хэрлэн голыг гарч Ёст бэйсийн хошууны нутаг Хундар ууланд хүрчээ. Цагаантны цэргээс айсан тэд 1919 оны өвөл Дорнод Монголын их тал Мэнэн орж өвөлжжээ. 1920 оны хавар дорно зүг нүүж Хэрлэн голыг Алтан эмээлийн гүүрээр гарч Баргын далай нуурын баруун талаар тойрч зүүн урагшаа явж Хуйн гол, Енгүнэй манхан, Бухын шил, Дөч уул хүрсэн байна. 1905 оны үед Улирэнгэ, Хуандайгаас орж ирээд Имэн гол, Шинэхээнд байсан буриад, хамниган айлууд 1920 оны зун баруун талаас очиж Хуйн голоор нутаглаж байсан хүмүүстэйгээ нийлж 350 шахам айл өрх болж мөн оныхоо өвөл Монголын зүүн өмнөд хязгаараар орж иржээ. Нүүдлийн өмнөд хэсэг нь Сэцэн хан аймгийн Эрхэмсэг бэйсийн хошууны /Одоогийн Халхгол сум/ нутаг Хандгайн голоор, хойт хэсэг нь Илдэн гүний нутаг Халх голын Хөх өндөр, Буйр нуурт нүүж иржээ. Тэдгээр айлууд Хаяа эргэсэг, Таван ташгай, Хунт, Ёнгор, Үйзэн, Бухсайгаар өвөлжиж, Эрхийн гол /Одоогийн Алтан гол/-ын эхэн хүртэлх их манхнуудад малаа төллүүлж хаваржсан байна. Энэ айлууд нь хожим нь Гүү-Азаргын манхан, Эрхийн Цагаан-Овоо, Их, бага Нарт, урагшаа Дэгээ, Нөмрөгийн гол хүртэлх уудам нутагт тархан суурьшижээ. Эдгээр айлуудыг төвхнүүлэх, нутаг гүйх хэргээр 1921 оны Ардын хувьсгалын дараах намар нь Нанжины Санжаа ноён, Содномын Раднаабазар гэдэг хүнтэй 4 тэмээн тэргээр Нийслэл хүрээ орж, явсан хэргээ амжилттай бүтээн 10 жил суух зөвшөөрөл авч 1922 оны хаврын тэргүүн сард нутаг орондоо эргэж иржээ. Ингэж буриадууд олон жилийн нүүдлийн эцэст тус нутагт суурьшсан түүхтэй. Г.Батболд, Б.Чинзориг нарын “Сэтгэлд мөнхөрсөн Цагаан-Овоо сум” /2005/ номонд дэлгэрэнгүй өгүүлсэн байгаа. Зохиогч.

цаашлаад Халх, Нөмрөгийн үзэсгэлэнт сайхан байгальтай нутагт суурьшсан байх юм. Тэдний хувьд чинээлэг, бас боловсролтой, тухайн цагтаа элитүүд байсан тул ямархан учраар өмнө зүгт зүтгэсэн нь дээрх бидний эргэлзээг тайлах олон шижмийн нэг ч байх магадлалтай. Манай дээдсийн нүүдлийн талаар Дорнод нутгийн эгэл ажилчин, жолооч Баатарын Ёндон гуай “Хувь заяаны яргуй” хэмээх сайхан роман хэвлүүлсэн байдгийг та нар мэдэх байх.

Энэ тэмдэглэлийг бичиж байх явцдаа өмнө нь бичигтийн цагаан чулууны тухай хөөрөлдөж байсан Д.Бадамням ахтай утсаар ярьж, зарим зүйлийг арай тодорхой болгож авлаа. Түүний өгүүлэх нь: “... Би Дашбалбар сумын уугуул хүн. Би багадаа Их, бага Доргон толгойн тэнд өссөн хүн. Доргон толгой нь Дашбалбар уулын баруун талд Улзын голын хойд тал гол руугаа хатгаж орсон хошуу байдаг юм. Хүүхэд байхдаа тэнд тоглож наадаж өссөн дөө. Тэгэж байхад их Доргон толгойн оройд том хүний өндөртэй шахуу овоо байдаг байв. Овооны ёроолд дөрвөлжин цагаан чулууны өнцөг харагдаж байдагсан. Ноднин би /2010 онд бололтой. М.О/ төрсөн нутагтаа очиж, овоон дээр гарсан чинь овооны чулууг тарааж хаяад үгүй хийсэн байлаа. Нөгөө дөрвөлжин цагаан чулуу алга болсон байсан. Миний бодлоор түүнийг бичигтийн цагаан чулуу байж магад гэж таамаглаж байсан юм. Тийм цагаан чулуу бол тэр хавьд байхгүй. Тэгэхээр хойно нь байх Цагаан чулуут гэдэг газраас хүн авчирч, түүнийг засаж, дээр нь бичиг бичсэн байх гэж бодож байна. Гэхдээ би Шилдэй зангийн тухай болон хилийн овоо тогтоож байсан тухай бичсэн өгүүлэлдээ саналаа бас дэвшүүлсэн байгаа...” гэж хэлэв. Түүний бичсэн “Шилдэй зангийн баатарлаг, эмгэнэлт дууны учир” өгүүлэлд “... “Хори буриадын хураангуй түүх” гэдэг нэр нь үл мэдэгдэх зохиогчийн бичсэн сурвалж бичигт Ширавнимбуугийн бичсэнийг бараг хэвээр нь давтаад, “Засуул тэргүүтэй Шилдэй зангийн элч нар хилийн дээс тавих газрыг сонгон бичигтэй цагаан чулуугаар тэмдэг тавьсан” тухай дурджээ”¹. Гэхдээ энэ нь хилийн дагуух бүх овоонд тавьсан гэж үзвэл барагцаалбал 100 орчим овоо босгосон байх талтай.

Юу гэвэл Оросын төлөөлөгч элчин, тойрогийн захирагч Ф.А.Головин, Чин улсын бүрэн эрхэт төлөөлөгч Сонгот нар 1689 оны 8-р сарын 27-нд “Нерчугийн гэрээ” гэгчийг байгуулж, дараа нь Оросын элчин сайд С.Л.Владиславич-Рагузинский Манжийн бүрэн эрхэт төлөөлөгч Чабина, Тэгүт, Тулишен нар 1727 оны 10 сард Хиагтад хэлэлцээ хийж Соёны нурууны Шавийн даваанаас Эргүнэ голын Абагайтын толгой хүртэл хил тавих гэрээ² байгуулсан байдаг. Энэ хил

¹ Буриад судлал сэтгүүлийн анхны дугаарт /2008/ бичсэн тэр өгүүллийнхээ 10-р тайлбартаа Д.Бадамням гуай “Тэмдэг тавьсан “бичигт цагаан чулуу” хаана байгаа нь тодорхойгүй. Хилийн цугам болохоор сонгосон газарт тэмдэг тавьсан бол ганц газар тавиагүй байх ёстой. Хэрвээ тийм аваас “бичигт цагаан чулуу”-ны нэг нь Улзын голын хойт биед орших Доргон толгойн оройд байгаа байх” гэж бичсэн байна. Түүнийхээр бол бичигт цагаан чулуу нь овооны тэмдэг тавьсан чулуу байж магадгүй ажээ.

² Орос, Манж хоёр улс монголчуудыг хувааж авсаны дараа хилээ тогтоох их ажил өрнүүлж, түүндээ буриадуудыг ихээхэн хэмжээгээр хохироож, элэг нэгт ахан дүүсээс нь салгасан байдаг. Уг гэрээний

хязгаараар монголчууд манжийн эрхшээлд, хоричууд буюу хожим буриад үндэстэн болон төлөвшсөн бидний өвөг дээдэс Оросын эзэн хааны харьяанд бүрэн орсон байдаг. Тийм болохоор түүний лүндэнд айлдсан “бичигтийн цагаан чулуу” нь хилийн овоо босгосон газарт “*нутгийн заагийг тодорхойлсон бичээс бүхий зассан цагаан чулуун хавтан байсан байж болох юм*” гэдэг таамгийг нэрт орчуулагч Д.Бадамням гуай дэвшүүлсэн хэрэг. Энэ нь зөв ч байж болох. Учир нь зөнч мэргэн Молон багш нь хил тавьснаас бүр сүүлд нь төрж, амьдарсан хүн учраас буриадууд эрх чөлөөт амьдралын эх орон нь төрөлх монголчуудтайгаа нэгдэн нийлэх ёстой гэсэн түүний үзэл бодлын илэрхийлэл ч байсан магад юм л даа. Уг лүндэнд “... бидэ хойто ороной оростой тэнцэхгүйбди...”¹ гэж хэлсэн байдаг. Үүнээс харсан ч өвгөн багшийн хувьд орос хүмүүс, тэдний соёл таалагдахгүй байжээ гэдэг нь илт харагдаж байна. Тийм болохоор Оросын хил тогтоосон газраас гарахыг хойч үедээ захисан захиас гэж ойлгож болно.

Саяхан манай сумын унаган хүвүүн, нэрт орчуулагч МУСГЗ Г.Амар ахтай утсаар хөөрөлдөж, бичигт цагаан чулууг эрэн хайж байгаагаа дуулгахад сонин мэдээ хэлэв. Түүний ярих нь “...Миний бодлоор заавал бичигтэй цагаан чулуу байх ёстой биш гэж боддог. Бичигтэй мөртөө цагаан чулуу хаа сайгүй л байдаг. Өмнөговь аймгийн Сэврээ сумаас зүүн урагш 6 км-т метр орчим өндөртэй бичигтэй цагаан чулуу байдаг юм байна лээ. Түүнийг манай нэрт археологич Наваан гуай судласан юм. Ногоо тасалж бичигийг нь арчихад ногооны шүүс сийлсэн бичгийн оромд орж бичиг нь тодордог юм байх. Энэ нь манай археологчидын хэрэглэдэг арга гэнэ лээ. Түүнийг үзэхэд руни бичиг байсан гэж дурсаж байсан. Тэгэхээр ийм бичигтэй цагаан чулуу манай орны хаана ч байх магадлалтай учир хэлэхэд хэцүү. Судалгаа сайн хийх хэрэгтэй, бидэнд мэдэгдээгүй сонин баримт архивт ч байхыг үгүйсгэхгүй шүү дээ. Би тэр бичигт цагаан чулуу гэдгийг Молон багш симболизмоор хэлсэн гэж боддог шүү” гэж хэлэв. Энэ нь ч бас үнэний талтай болохыг бид мартаж болохгүй. Түүний лүндэнд:

“Тахай жилд газар хөдлөх

Нохой жилд ноёд хөдлөх

Худалч хүн хойморт суух

Үнэнч хүн үүдэнд суух

Өнгөт ертөнцийн цаг болох

Уггүй хүн ноён болох

Ундигүй сүхээр түлээ хагалах...

Тивийг дүүртэл түмэр могой гүйх

Газар дээгүүр гал могой гүйх...” гэх мэтээр аливаа болох үйлийг далд утгаар, билэгдэлт чанар шингээж илэрхийлсэн байдаг.

тухай олон өгүүлэл хэвлэгдсэн бөгөөд Э.Батжавхлан, Д.Бадамням, Д.Дамдинжав нарын зэрэг судлаачид тусгай өгүүлэл хэвлүүлсэн.

¹ “Молон багшийн лүндэн” гар бичмэл эхийн хуулбарын 2-р нүүрний 3-р хэсэгт ингэж бичээтэй буй.

Ингэж ургуулан бодож, баримт түшин таамаглал дэвшүүлэх олон баримт байгаа ч гэлээ жинхэнэ бодит баталгаа бас биш юм. Одоогоор бидэнд мэдэгдээд байгаа баримт, хүмүүсийн ам дамжсан яриа, зарим таамаглал дээр үндэслэн шинжлэх ухааны таамаг дэвшүүлж байгаа тул үнэн бодит явдлаас хол зөрөөтэй, буруу байхыг ч хэлж мэдэхгүй байна.

Өнгөрсөн зуны эрдэм шинжилгээний экспедицийн гол зорилгын нэг нь саявтархан бидэнд мэдэгдээд байгаа Халх, Нөмрөгийн бичигт толгойг очиж үзэх байсан юм. Манай бүрэлдэхүүнд УБДС-ийн ерөнхий захирал, профессор Чой Ги Хо, профессор Ц.Шагдарсүрэн, профессор Б.Сумьяабаатар, Той.Галсан, Ч.Лутчимэг, Г.Батзаяа, Солонгосын зохиолч Чхонь Чхи Лйөн, Шинь Тхе Чхөл, докторант П.Батчулуун, орчуулагч, жолооч, хөтөчөөр М.Бямба, жолоочоор Чоёндэмбэрэл, туслахаар Жавхлантөгс нар болон Дорнод дээд сургуулиас миний бие жолооч Т.Ганбаатарын хамт, Халх Нөмрөгийн сав нутагт газарчлахаар Р.Үнэнбат нар нэмэгдэж, нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан билээ.

Бид харамсалтай нь зорьж гарсан газраа байгалийн саад бэрхшээлээс болоод хүрч чадаагүй юм. Өнгөрсөн зуны их усан борооноор Халх Нөмрөгийн сав нутаг, гол нуурууд үерлээд машин байтугай морьтой, явган алинаар нь ч явах боломжгүй байсан учир хэдийгээр бидэнд төвөөс авсан зөвшөөрөл байсан боловч Сүмбэрийн отрядаас бидэнд цааш нэвтрэх боломжгүй гэдгийг сайтар тайлбарласан тул яаж ч чадсангүй. Ингээд эхний эрлийн үзүүр мухардсан ч гэлээ бид хүмүүсээс нэлээд мэдээлэл болж авч чадав.

Нөмрөгийн заставын даргаар олон жил ажилласан хүний яриагаар бол тэнд ямар нэгэн бичээс байж болох ч тэд мэдэхгүй гэлээ. Гэхдээ тэр газар нь хадан хясаан тогтоцтой, хүний хөл хүрэхэд бэрх газар гэнэ. Тийшээгээ зөвхөн морьтой, эсвэл явганаар ойртохоос бус машинтай явна гэж саналтгүй гэнэ. Ер нь тэнд хүн хүрч үзээгүй, хэцүү бэрх бартаатай учир хилийн цэргийнхнээс өөр хүн зориглож явдаггүй юм байна. Энэ нь миний дээр таамагласан эртний овог аймаг болох Когурйөгийн үеийн Пүйө аймгийн үед холбогдох ховор нандин дурсгал үлдсэн байх магадлалтай юм. Тэд Халхын гол, Буйр нуураар урагш нүүдэллэн өнөөгийн Солонгосын хойгт нутаглах хүртэл уртын нүүдэл хийсэн тул хэзээ нэгэн цагт энэ нутагтаа эргэж ирэхийг бэлэгдэн нууц тэмдэг үлдээсэн байх ч юм билүү?

Эс бөгөөс Хүннү гүрний задарлын үе, түүнээс хойшхи бүх л цаг хугацаанд Татарууд болон Эзэн Чингисээс эхлээд дүү Хасар тэргүүтэн олон монголчууд уг газарт идээшин суурьшиж байсан тул тэндээс бидний түүхийн чухал үеийг илтгэсэн ховор нандин дурсгал олдохыг ч байг гэх газаргүй байна. Очиж үзээгүй, байр байдлыг нь мэдэхгүй байгаа тул одоохондоо ийм таамаглал дэвшүүлээд үлдээе.

Нөмрөгийн уулс нь Их хянганы нурууны хойд тал, үргэлжлэл учир үзэсгэлэнт сайхан байгальтай, буриад түмний нутаглаж явсан онгон дагшин газар орон билээ. Манай Цагаан-Овоо сумын буриад зон олон 1931 оныг хүртэл уг газарт амьдарч,

1923 онд Халх Нөмрөгийн буриад хошууг¹ байгуулан төвхнүүлж, амьдарч байсан байна. Гэтэл Японы түрэмгийлэгч нараас хил хязгаарлуу үе үе өнгөлзөж, ард олны дунд хов цуурхал дэгдэж, хил хязгаар түгшүүртэй болоход Тамсагбулагт ардын цэргийн 15-р морьт хороог байгуулан хилийг чандлан сэргийлж, харуул манаа чангатгаж, Халх Нөмрөгт амьдарч байсан буриад нарыг нутгийн гүн рүү Хэрлэн голруу татах шийд гарчээ. Ингэж Халх Нөмрөгт 10 гаруй жил идээшин суусан буриад нар нутгийн гүнрүү татагдах болсон байна. Ингэхдээ анхлан Хэрлэн голын хойд биед Хөгнийн шилийн энгэр Бүдүүний булагт их нүүдэл түр саатаж, нэгэн шинэ нутагт ирсэн учир сумын захиргааг байгуулж Яргайт гэж нэрлэсэн байна.

1931 онд Яргайт сумыг татан буулгаж, Улз голын буриад хошуунд нэгтгэсэн боловч дээрх өрх айлууд тэр нутгаасаа төд удалгүй дахин нүүж Мөнххаан уулын хошууны нутгийн зүүн хэсэгт Эрдэнэ гүн, Хөвчийн жонон вангийнхантай хаяа нийлэн нутаглаж байсан байна. Тэдгээр иргэд өвөлдөө өнтэй орохын тулд Вангийн цагаан уул, бүр баруун тийшээ Егүзэр хутагтын нутаг одоогийн Эрдэнэцагаан сумын зүүн хэсгээр хүртэл нүүдэллэн амьдарч байсан байна. Зарим айл нь хойшоо нүүлгүй тэндээ Егүзэр хутагтын шавь болон шингэсэн байдаг байна. Хэрвээ сумын зүүн талаар нутаглаж байгаа айлуудаас сураглавал Халх Нөмрөгөөр нутаглаж байсан буриадуудын үр удам гарч магад юм байна лээ. Энэ шижмийг дагаад бид яах вэ гэдгээ зөвлөлдөж байгаад Эрдэнэцагаан сумын Бичигтийн боомтын тийшээ очиж үзэх нь зөв гэсэн шийд гаргаж, бүгдээрээ замын хүзүүгээ тийш нь сунгалаа.

Дорнод монголын өмнөд хилд Бичигтийн боомт гэдэг газар байгаа нь ямар нэгэн учир байх ёстой гэж бодож тийшээ явсан маань ч зөв байлаа. Бид тэнд ямар нэгэн бичээс байх ёстой гэж таамаглаж байсан маань ч нутгийн хүмүүсийн яриагаар батлагдсан юм.


Ингээд Эрдэнэцагаан суманд аяллын багийнхан аяны дөрөө мулталлаа. Нутгийн таньдаг мэддэг хүмүүсийг сураглаж, Отрядын даргаас хил явах зөвшөөрөл авах хэрэг гарлаа. Тэгтэл манай аймгийн Баян-Уул суман дахь ...-р хилийн отрядын даргаар ажиллаж байсан хурандаа Н.Батхүү шинэхэн томилогдоод очсон байж таарах нь тэр. Юун сайн юм. Той.Галсан багш, Р.Үнэнбат ах бид гурав тавиад буулаа даа. Нутгийн улсууд уулзаад ажил төрөл ярьж, зорилгоо танилцуулан хил явах зөвшөөрөл олж авлаа. Тэгтэл Бичигтийн заставын даргаар ажиллаж байсан

¹ Халх Нөмрөгийн буриад хошууг анх Нанжины Санжаа ноёны хойд нутгаас дагуулан нүүж ирсэн 300 гаруй өрх айлтайгаар байгуулж, хурлын тэргүүн даргад Н.Санжаа ноёныг санал нэгтгэж сонгож, мөн итгэмжит 12 хүнийг хурлын төлөөлөгчөөр, 12 хүнийг цагдаагийн албанд тохоон томилсон байна. Тус хошууг анх 4 сумтайгаар зохион байгуулж, Сүмбэр сумын даргаар Мөнхийн Очир, Могойт сумын даргаар Галданы Бадраа, Улирэнгэ сумын даргаар Дарьжавын Лхам /Аана/ нарыг сумын ардын хурлаас томилжээ. Сүмбэр сумын даргаар сонгогдож байсан Мөнхийн Очир нь миний өвөг эцэг болно. Зарим номонд Мөнхжөөний гэсэн байдаг ч халхаар бол Мөнх юм. Миний өвөг эцэг Халх, Нөмрөгөөс хойшоо Хэрлэн рүү нүүгээд хэд хэдэн удаа сум, нутгийн захиргааг байгуулахад оролцож, Эрвээхэй Галуут сумын түр захиргааг байгуулахад анхны даргаар нь сонгогдож байсан, тухайн үедээ бичиг үсгийн өндөр боловсролтой, ардын захиргааны ажилд идэвхтэй оролцдог хүн байжээ. Хожим нь 1937 онд хилс хэргээр цаазлуулсан. Зохиогч.

Бадамжаргал гэж шижигнэсэн ахлах дэслэгчийг бидэнд газарчингаар өглөө. Хилийн застав явж байх замд сонин сайхан уул нурууд, шовх шовх өндөрүүд тааралдах нь миний бодосноос огт өөр аж. Бид тал хээр байх юм бодсон чинь бишээ. Хангайрхуу газар юм. Энд алдарт хутагтын буга үржүүлж байсан Лхачинвандад уул сүрлэг агаад сүрдэм. Замд дайралдах уулсын нэрийг асууж сураглахад Араат нэртэй уул байсан нь бидний сонирхолыг улам татлаа. Энэ холд манай буриад нэртэй уул тааралдана чинээ санаагүй билээ. Учир нь “Араат” гэдэг нь буриадаар “үнэг” гэсэн үг юм. Орчуулбал “Үнэгт уул” гэсэн үг. Мөн Барчин уул гэж байна. Энэ нь мөн л буриад үг. Манайхан Парчин гэж хэлдэг. Ийм мэтээр тэр газар орны нэрийг мөшгин хөөвөл сонин сайхан баримт олон олдох шинжтэй. Энэ нь дээр бидний хэлсэн буриад зон энэ нутгаар ирж нутаглаж, нүүдэллэж байсны баталгаа юм.

Хилийн застав, шалганы зүүн талд хилийн зурвас дунд Бичигт уул, түүний ар доор нь Бичигт толгой гэдэг газарт бид хүрэлцэн очиж судалгаа хийлээ. Очсон тэрхүү толгод том том үхэр чулуу, багахан хэмжээний элгэн хадан хясаанаас бүрдсэн, жижигхэн толгод. Судлаачид тус тусдаа бичгийн эрэлд гарсан боловч олз омог маруухан байлаа. Хожуу дуулах нь ээ бид жинхэнэ бичээс бүхий газрынхаа хойд талын толгод дээр хайгуул хийгээд буцсан байв. Угтаа хилийн дундын бүс, 1048 тоот хилийн багана байрлах өндөр уулыг Бичигт уул гэдэг байсан юмсанжээ. Гэвч бид хилийнхэнд явдал учир таарвал Бичигт уулан дээр байдаг бичээсний зураг авч илгээхийг хүссэн билээ. Тэр Бичигт уул нь монголын талд байдаг юм байна. Хэрвээ Хятадын талд орсон бидэнд судлах боломж гарахгүй байх даг шүү. Маниас өмнө манай нэрт судлаачид судлан тодорхойлсон болохыг үүнийг бичиж дуусах үедээ олж сонсов. Энэ тухай ард цухас өгүүлсү.

Бичээс хайх явцдаа бичиг байж болох 2 газрыг олж тогтоогоод түүн дээр ажиглалт судалгааг хийлээ. Тэгэхэд хясааны дээд талын урагшаа харсан элгэн хаданд бичиг байсан байж магадгүй гэсэн таамаг гарч, тандан үзэхэд борооны усны ховил, эртний бичиг, дүрс бичээс нь алин болох нь мэдэгдэхгүй бүдэг бадаг дүрс харагдаж байв. Бид 16 цаг 17 минутын орчимд Б.Сумьяабаатар, Х.Лутчимэг бас миний бие нийлээд бид гурвын олж харснаар ийм хэлбэртэй зүйлс байна. Үүнд:



Ийм дүрс байгаа бөгөөд түүний доод талд нь хажуу талд нь доош нь бичигдсэн гэмээр иймэрхүү дүрсүүд байна лээ.



Тэнд явсан олон хүн үүнийг бичээс байх гэдэгт итгэлтэй байлаа. Уг нь бид тодорхой бичиг олно гэдэгтээ итгэж байсан юмсан. Гэтэл бид буруу газраа очсон бололтой. Гэхдээ энэ нь уншин тайлбал ямар ч утгатай, нууцлаг эд байж болохыг одоогоор хэлж мэдэхгүй байна. Судлаачид та бүхэн уншин тайлах буй заа. Бидний бичигт цагаан чулууны эрэл энд хүрээд зогссон ч гэлээ олон сонин сайхан баримт олж, цаашдын судалгаандаа хэрэглэх шинэ шинэ санааг олсон билээ.

Бидний очиж чадаагүй бичигт ууланд Манжийн үед холбогдох бичээс байдаг тухай хүнээс дууллаа. Бичигт уулын судалгааг манай архелогийн тэргүүлэх судлаачийн нэг байсан нэрт эрдэмтэн Д.Баяр¹ багш хийсэн байдаг тухай Сүхбаатар аймгийн Музейн захирал Ж.Жаргалсайханаас сонсов. Тэрбээр эртний хүн чулууг судлан эрдмийн зэрэг хамгаалахаар ажиллаж байгаа юм байна. Түүний хэлэх нь “Ханзаар бичсэн бичиг байдаг гэсэн. Нэг талд нь **“Энд Энх-Амгалан хаан ялалт байгуулав”** гэсэн бичиг бий аж. Гэтэл хажууд нь **“Энд Манжийн цэргийг Монголчууд энд бут цохив”** гэсэн утга бүхий бичээс бас байдаг гэж эрдэмтэн

¹ Д.Баяр 1991 онд “Каменные изваяния Восточной Монголии (Дорнод Монголын Чулуун хөрөг)” сэдвээр түүхийн ухааны дэд эрдэмтэн, 2001 онд “Монгол нутаг дахь хүн чулуун хөшөө” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж, 2003 онд Улаанбаатар Их Сургуулийн профессор цол хүртэж, 2007 онд Германы Археологийн Хүрээлэнгийн сурвалжлагч гишүүнээр сонгогджээ. Монгол-Зөвлөлтийн түүх-соёлын хамтарсан экспедици, Монголын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн “Хархорумын шинжилгээний анги”, “Дорнод Монголын хүн чулуун хөшөө судлах”, Монгол-Японы “Гурван гол”, Монгол-Солонгосын хамтарсан “Дорнод Монголын судалгаа”, ЮНЕСКО-гоос зохион байгуулсан “Эртний Хархорум хотын турийг хадгалж хамгаалах” төсөл, Монгол-Германы “Хархорум хотын судалгаа”, Монгол-Туркийн “Монгол нутаг дахь Түрэгийн үеийн зарим хөшөө дурсгалыг судлах, сэргээн засварлах, хадгалалт хамгаалалт”, Казахстан улстай хамтарсан археологийн төсөл зэрэг 30 гаруй төслийн хээрийн шинжилгээний ангид оролцон ажиллаж, нэлээдийг нь Монголын талаас удирдан зохион байгуулж байв. Тэрээр Монголын дундад зууны археологийн дурсгалыг голлон судалж, хүн чулуун хөшөөний зэрэгцээ Хөшөө Цайдам дахь Түрэгийн алдарт жанжин Куль-Тегин, Билгэ хааны тахилын онгоны цогцолбор дурсгал, Монголын эзэнт гүрний нийслэл Хархорумын Цогт их сүмийн гэрийг малтан судлах ажлыг удирдаж байсан. Түүний судалгааны ажлын үр дүн нь эрдэм шинжилгээний салбарт төдийгүй түүхийн сэдэвт уран зохиол, дүрслэх урлаг, тайз дэлгэцийн томоохон уран бүтээл туурвихад гол тулгуур баримт болсоор байгаа юм.Тэрбээр “Монгол Улсын түүх” 5 ботийн үндсэн зохиогчийн нэг бөгөөд ганц сэдэвт зохиол 8, хамтын бүтээл 10 гаруйг туурвиж, эрдэм шинжилгээний 200 гаруй өгүүлэл, илтгэл бичсэн бөгөөд түүний бүтээлүүд ОХУ, Япон, БНСУ, БНХАУ, Турк, ХБНГУ, Унгар, Казахстан зэрэг оронд орчуулагдан нийтлэгдэж байсан. Тэрбээр 1974 оноос УБДС, МУИС, Улаанбаатар Их Сургуулийн түүх, археологи, антроплогийн салбарын оюутан, аспирант нарт хичээл зааж, хээрийн шинжилгээний дадлагыг удирдаж, олон арван оюутны төгсөлтийн ажил, магистрын диплом, дэд докторын диссертацийг удирдан хамгаалуулжээ.

Д.Баяр гуай тайлсан ажээ. Монголчууд цөөн цэрэгтэй очиж, Манжийн хааны цэргийг хиартал цохисон тул түүний дурсгалд зориулан бичсэн байх” гэж хэлэв. Энэ үнэн бол бидний судалгаанд төдийлөн хамаагүй болж таарах нь. Тиймээс уг бичээсийн талаарх нэрт эрдэмтний тайлсан бүтээлийг олж унших хэрэгтэй байна. Бичигт хадан дээрх бичээсүүд нь түүхийн тодорхой үйл явдлын гэрч болж, түүний баримт нотолгоо болгон бичиж үлдээсэн байдаг байна.

Судалгаа хийж байх хугацаандаа өөрийн мэдэхгүй байсан шинэ шинэ мэдээ баримт олж, хүмүүсийн яриагаар баталгаажуулж байлаа. Анх бичиж эхлэхдээ Бичигт хадны эрэл маань ийм өргөн хүрээг хамарсан, томоохон өгүүлэл болно гэж бодож байгаагүйг энд дурдах нь зөв байх. Эрдэмтдийнхээ өмнөх үеийн судалгааг сайтар нягтлан үзэх нь хожмын бидэнд ихээхэн чухал болохыг энэ ажлыг хийх явцдаа сайтар ойлгосноо нуугаад яахав.

Эрдэнэцагаан сумын нутагт эртний хиргэсүүр, хүн чулуу зөндөө байдаг боловч буцах замдаа үзье гэтэл газар мэдэхгүйн улмаас очиж чадаагүй болно. Цаашид бид Халх, Нөмрөгийн Бичигт толгой ууланд гарч бичээс хайх, түүний нууцыг тайлах үлдээд байна. Одоогийн миний олж тогтоосноор Матад сумын зүүн, зүүн хойно шахуу байгаа гэж тэмдэглэгдсэн тэрхүү Хайлаастын бичигт хадыг судлавал, тэнд байгаа эртний монгол бичээсийг тайлан унших нь шинжлэх ухаанд шинэ сонин мэдээ болох болов уу гэж найдна. Учир нь надтай явсан нэрт эрдэмтэд тэндхийн бичээс байдгийг дурдахгүй байсан нь хүмүүс төдийлөн очиж судлаагүй болов уу гэсэн бодол төрүүлж байна.

Хайлаастын бичигт хад болон Халх Нөмрөгийн Бичигт толгой уулан дээрх ямар нэгэн бичээс нь түүхийн нууцыг хадгалсан, хүмүүсийн анхаарал татсан сонин сайхан бичээс байгаа гэдэгт гүнээ итгэж байна.

Эрлийн явцыг нэгтгэн дүгнэвэл

Эрэл үргэлжилж байна. Бичигтийн цагаан чулуу хаана байна, ямар бичээс байгаад эрдэмт хүний зөн билэгт өртсөн болохыг одоогоор тогтоох боломжгүй байна. Гэхдээ дээр бид хэд хэдэн үндэслэлээр таамаг дэвшүүлж, баримтаар санаагаа лавшруулан гаргасан билээ. Хэдийгээр таамаг боловч баримт түшиж хийсэн тул нэлээд бодитой байх гэдэгт итгэлтэй байна. Олон янзаар таамаглах нь бодит дүгнэлтэнд хүрэх боломж олгоно гэж найдаж байна. Дээр өгүүлсэн баримт дээр үндэслэн дараах дүгнэлтийг урьдчилсан байдлаар хийж байна. Үүнд:

1. Монгол орны уудам нутагт эртний бичиг дурсгалын олон баримт байдаг бөгөөд Бичигт нэртэй газар орон цөөнгүй байна. Энэ нь монголчуудын бичиг соёлын өндөр боловсролтой ард түмэн байсныг илтгэн харуулахын дээр цаг үеийн нөхцөл байдал, нүүдлийн соёл иргэншил, бичиг баримтыг байнга хадгалж хамгаалж чадахгүй байдлаас болоод чулуун ном, хад чулуу, хөшөө дурсгалд ном бичгээ сийлэн үлдээдэг байсан уламжлалтай байжээ.

Тиймээс бичигт нэртэй газар болгонд ямар нэгэн эртний бичээс байх нь түгээмэл байгааг ингэж тайлбарлаж болох юм. Мөн түүхийн он цагийн гэрч болгон бичиж үлдээдэг байсан нь өмнө нээгдсэн бичээсүүдийн утгаас бүрэн харагддаг.

2. Бичигт нэртэй, бичигт гэдэг үгээр тодотголтой цөөнгүй газар орон монгол орны зүүн өмнөд хилээс эхлэн, барууншлах тусам тааралдаж байгаа нь бидний анхаарлыг татаж байна. Энэ нь монголчууд газар нутгаа сахин хамгаалах, бичиг соёлоо хадгалан үлдээхдээ өөрийн нутгийн аль тохиромжтой газарт нь бичиж үлдээдэг байсан эртний соёлын ул мөр мөн.
3. Молон багшийн айлдсан бичигтийн цагаан чулуу нь одоогоор хаана байгаа нь тогтоогдоогүй боловч хэд хэдэн таамаглал дэвшүүлж болохоор байна. Энэ нь, нэгдүгээрт, Орос, Манж хоёр улсын хэлэлцээрээр хил тогтоосны дараа босгосон хилийн овооны доор нь бичигт цагаан чулууг булж, дээр нь хилийн овоог босгосон байх гэсэн баримт дээр түшиглэн, бидний хайж байгаа газар нь хилийн зурвас дагуу байх магадлалтай байна. Энэ нь Молон багшийн лүндэнд гарч байгаа үг хэллэг, түүний үзэл бодлоос нь ингэж таамаглах боломж олгож байна. Гэхдээ лүндэнд гурван жил болоод хүрнэ гэсэн нь ямар учиртай болохыг бодох хэрэгтэй байна. Байгал далайгаас нааш хэд хоног явахыг тооцож үзэхэд сонин л байна. Удаах таамаг нь Матад сумын зүүн хойд талд байх Хайлаастын бичигт хадан дээрх монгол бичээс болон эртний бичгийг тайлан уншвал ямар нэгэн сонирхолтой дүгнэлт хийж болох юм. Энэ нь бичигт хад мөн байх магадлалтай бөгөөд Эгэрийн цагаан тал нь Мэнэн байсан байж болох юм гэсэн таамаглал дэвшүүлж байна. Сүүлд нь хэлэхэд Халх Нөмрөгийн сав газарт байгаа Бичигт толгой уулан дахь бичээсийг судлан тодорхойлох нь дээрх бүх таамаглалыг батлах, эсвэл няцаах гол гогцоо болно гэж үзэж байна. Бичигтийн цагаан чулууны эрэл нь дан ганц бичиг хайх төдий эрэл бус Буриадын язгуурын нутгийг эрэн хайх өргөн далайцтай ажлын нэг хэсэг болно гэдэгт итгэлтэй байна.
4. Эрдэнэцагаан сумын Бичигтийн боомтын бичигт уулын бичээсийг судласан хүмүүсийн яриа, тайлбараар бидний Молон багшийн лүндэн дэх бичигт цагаан чулуу биш болох нь тодорхой байна.
5. Молон багшийн лүндэн дэх “Бичигтийн цагаан чулуу” гэсэн хэллэг нь Бичигт уул гэхээс илүү тусгай бичээс бүхийн хавтан чулуу байх магадлал хамгийн өндөр байна. Монголын их уудам тал нутагт ээрэм сайхан тал зөндөө буйг бодолцож үзсэн ч зөнч өвгөн Молон багш Монгол нутагтаа та бүхэн хүрч очих нь хамгийн чухал шүү гэдгийг далд утгаар илэрхийлсэн байх магадлалтай байна. Тиймд бичигт цагаан чулууг хилийн дээс тэмдэг тавьсан бичээс бүхий чулуу байхыг ч үгүйсгэхгүй.

6. Зөнч хүмүүсийн лүндэн нь билэгдэлт утга бүхий, далд утгаар санаагаа илэрхийлсэн байдаг тул “Бичигт цагаан чулуу” гэж бодит зүйлийг хайх нь буруу ч байж магад. Түүний лүндэн нь амьдралд барагхан нь таарч байгаа туйлын үнэн бөгөөд дан далд, ёгт утгаар хэлсэн байгааг тооцон үзэж, судалгааны ажлаа тийш нь чиглүүлэн хийсвэр билэгдэлт ойлголт хэмээн үзэж тайлбар хийх нь зөв байх магадлалтай байгааг энд дурдсу.
7. “Бичигт цагаан чулуу”-ны тухай судалгааг нарийвчлан хийж ямар утга, учиртай болохыг тогтоох нь буриад судлалд оруулах ихээхэн том хувь нэмэр болох тул бусад эрдэмтний хүчийг дайчлан хамтарсан томхон судалгааг хийх шаардлагатай байна. Архивын баримт, бидэнд олдоогүй сонин сайхан баримт Буриадад, ОХУ-д бас манай Үндэсний архивт хадгалагдан байгааг хэн эс мэдлээ. Тиймд судлаачдад судлан тодорхойлох их ажил өмнө нь хүлээж байна.

Эрэл үргэлжилж байна...

Чойбалсан хот.

2011 оны 10-р сарын 30.

15.⁰⁰ цагт ажлын өрөөндөө бичиж дуусгав

-oOo-

Дөрөв. ОРЧУУЛГА

Мунко-Бато Нимаев
Өвөрбайгалийн хязгаар,
Агын буриадын тойрог,
Могойтын район

ШИЛИЙН ГОЛЫН БУРИАД ГЕНЕРАЛ

Ага нутгийн өсч торнисон Очирын Цэрэнжавын Эринчиндорж Өвөр Монголын Шинэхээн нутаг руу дүрвэн гараад улмаар Хятадын гоминдааны армийн Шилийн голын семийн (чуулган) цэргийг захирсан хошууч генерал болсон тухай түүх өгүүлье.

Өнөөдөр Буриадын ард түмний түүхийн хуудаснуудад байсан цагаан толбодыг арилгах ажил алхам алхмаар хэрэгжиж байна. Үүний зэрэгцээгээр Буриад нутагт үүссэн улс төрийн их хэлмэгдүүлэлт болон иргэний дайн зэргээс амь тэмцэн дүрвэж гарсан ямар ч гэм хор хийгээгүй шударга хүмүүсийн нэр алдрыг үнэн зөвөөр сэргээн дурсах ажил ч бас явагдаж байгаа билээ.

Очирын Цэрэнжавын Эринчиндорж 1898 онд Өргөө (одоогийн Улаанбаатар)-д төржээ. Түүний эцэг Цэрэнжав тэр үед Петроградын алдарт маарамба-дипломатч Петр Бадмаевын Өргөө дахь худалдааны пүүсийн даамлаар ажиллаж байжээ. Тэрбээр Эринчиндоржийнхоо таван настай байхад нутаг буцаж Урд Агад төвхнөн мал маллах болов. Эринчиндорж найман настайдаа Чита хотын бага сургуульд орж дараа нь Гимназын бэлтгэл курсэд суралцахын зэрэгцээгээр үйлдвэрийн мэргэжлийн сургууль төгсгөжээ. Тэгээд Өвөрбайгалын хоршооллуудын нөхөрлөлийн нарийн бичгийн даргын туслагчийн үүрэг гүйцэтгэх болов.

Эринчиндорж 1915 онд Петроград очиж Их сургуулийн дорно дахин судлалын факультетэд элсэн ороод, нагац ах алдарт Петр Бадмаевын суух болжээ. Эринчиндоржийн ээж Петр Бадмаевын ах Бадмын Ампилын охин байсан юм. 1917 оны хувьсгалт үйл явдлуудын улмаас Эринчиндорж нутаг буцаж удалгүй Багшийн түр сургууль төгссөн боловч багшлах ажил хийсэнгүй. Агын аймгийн захиргааны газрын хэлтсийн дарга, Агын хошууны захиргааны санхүү аж ахуйн хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байв.

1918 оны хавар Агын хошууны захиргааны даргаар сонгогдов. Тэрбээр гэнэтхэн бүх гэр бүл, аж ахуйгаа аваад өөрийн ах Дашравданыхтай хамт монголруу нүүн Улзын голд хүрч тогтжээ. Ноцтой их шалтгаан байсан учраас тийнхүү нүүсэн хэрэг. Түүний дүүг Тавхайн Дугарын цэргээс оргон зайллаа гэж барон Унгерн дааж давшгүй их төлбөр нэхсэн юмсанж. Хэрэв төлөхгүй бол бүгдийг чинь хүйс тэмтэрнэ гэж сүрдүүлсэн байна.

Улз голд ирээд удаагүй байхад араас нь хадам эцэг Гончигжавын Цэрэнжав Догой нутгаасаа ирээд жирэмсэн байсан эхнэр Цэвэлмааг нь авч буцжээ. Тиймээс Эринчиндорж 1920 оны зун эхнэрээ эргэхээр Ага нутаг очиход нь Тавхайн Дугар баривчилаад, дүү Балдоржийгоо авчирч өг, эсвэл төлбөр төл гэж шаарджээ. Бэлэн мөнгө хөрөнгөгүй явсан Эринчиндорж аргаа барахдаа төлбөр төлнө гэсэн ам өчиг өгөн мултраад Улзын голд ирж зуу гаруй агт морь цуглуулав. Түүнийгээ аваачиж тушаасан байна.

Гэвч Улз голд тайван байдал удаан тогтсонгүй. Улз голыг өгсөж явсан барон Унгерн залуу эрчүүдийг хүчээр цэрэгтээ татан түйвээж эхэлжээ. Эринчиндорж бароны цэрэгт орохоос зугтаахдаа дүү Балдоржоо дагуулан Хятадын хил даван Манжуур өртөөнд очив. Тэнд хэсэг хугацаанд сууж байтал нь 1922 онд Агын аймгийн захиргааны элч нэхэж ирээд “Чита хотод хэвлэгдэх “Новая жизнь” сэтгүүлийн хариуцлагатай эрхлэгч болно уу” гэсэн урилга гардуулжээ. Ийм хүндтэй урилга хүлээн авсан Эринчиндорж гэр бүлээрээ Ага нутагтаа буцаж ирээд уг ажилд оров. Тэнд байхдаа Буриадын хувьсгалт хорооны томилолтоор Хууль зүйн оройн курсийг дүүргэжээ.

Буриад-Монголын Автономит Бүгд Найрамдах Улс байгуулагдахад Улаан-Үд дэх “Буриад-Монгольская правда” сонины хариуцлагатай нарийн бичгийн даргаар томилогдов. Энэ ажлынхаа зэрэгцээ Наркомпросын (Гэгээрлийн ардын комиссаруудын газар) харьяаны “Буриздат” (Буриадын хэвлэлийн газар)-ын ерөнхий эрхлэгчийн үүргийг хавсарч байлаа. Тэнд хоёр жил зүтгэж байтал эхнэр нь хүндээр өвчилсөн учир Ага нутгаа буцаж малын ажил эрхлэх болов.

Энэ үеэр байгуулагдсан “Советский торговый флот” гэдэг хувь нийлүүлсэн нийгэмлэгийн захиргаа Эринчиндоржийг дээд боловсролтой, худалдааны туршлагатай гэдгийг мэддэг тул түүнийг тээврийн конторын даргаар томиллоо. Тэр контор нь Бооржоос Монголын Баянтүмэн (одоогийн Чойбалсан) хүртэл ачаа тээвэрлэдэг байв. Энд ажиллаж байтлаа 1927 оны зун гэнэт гэр бүлээрээ сэмхэн нүүгээд хил давжээ. Ингэж сэмхэн нүүсэн шалтгаан нь “Советский торговый флотоос” хэдэн зуун рубль зээлдэж аваад, түүнийгээ төлөх чадваргүй болсон явдал байх гэж таамаглагддаг. Тэднийх Манжуураар нүүдэллэн явсаар Хайлаар хот орчмын Шинэхээн нутагт хүрчээ. Тэнд нутгаасаа дүрвэн ирсэн 300-гаад буриад айл нутаглаж байв. Эринчиндорж тэнд эхлээд наймааны ажил эрхэлж хэдэн малтай болжээ. Жилийн дараа Баргын вице-губернатор гүн Гүй Фу-гийн захиргааны зөвлөгчөөр томилогдов.

1929 онд Манжуурын төмөр замын дагуу их үймээн самуун дэгдэсний улмаас Шинэхээнд нутаглаж байсан 120 орчим айл Өвөр Монголын өмнөд нутаг руу нүүхээр шийджээ. Энэ хэсэг айл хамгийн сүүхээтэй, нэр хүндтэй Эринчиндоржоор удирдуулан Хянганы их уулс, ой тайга, намаг балчигтай хүнд бэрх замыг туулан Өвөр Монголын Шилийн гол чуулганы Зүүн Үзэмчин хошууны Үлэгүй гол гэдэг газарт хүрэв. Шинээр нүүж ирсэн буриадуудыг бусад газраас ирсэн айлуудтай нийлүүлээд засаг захиргааны нэгж болгон даргаар нь Эринчиндоржийг тавьжээ. Түүнээс хойш энэ хэсэг айлыг “Эринчиний буриадууд” гэж нэрэлдэг болсон байна.

Түвдийн Банчин Богдын хүсэлтээр Шилийн гол чуулганы захиргаа ба нутгийн тайж нар тэр хэсэг айлыг “Шарын шашны буриад нийгэмлэг” гэж өөрчлөн нэрлээд даргаар нь Эринчиндоржийг хэвээр үлдээв. Манжуур болон Шилийн голын чуулган Японы цэрэгт эзлэгдэсний дараа “Шарын шашны буриад нийгэмлэг” буюу “Банчин Богдын шавь” нар 1934 онд Буриад хошуу болон өөрчлөгдсөн боловч дарга Эринчиндорж нь Японы цэрэг бууж өгтөл дарга хэвээрээ байсан бөлгөө.

Түвдийн Банчин Богд 1934 онд нас баржээ. Энэ үед Буриад хошуунд байсан Банчин Богдын 1200 толгой хонь, 30 үхэр, 30 адуу түүний гэрээслэл ёсоор Эринчиндоржийн хувийн өмч болов. Түүнээс гадна Эринчиндорж 1934 онд Тяньцзин хотод 60 үнээтэй, сүү махны ферм худалдан авсан байв. 1936 онд тэр фермийг Японы тал хураан авчээ. Гэвч Эринчиндоржийнх 1945 оны дайн эхлэх үед 4500 хонь, 400-аад үхэр, 300-аад адуу, 120 тэмээтэй байв. Квантуны арми бууж өгсний дараа тэр Буриад хошууны даргаар дахин сонгогдоод албан ба амин ажлаа есөн гэрт явуулдаг болсон байв.

Хятадад иргэний дайн эхлэв. 1946 оны зун Гоминданы цэрэг идэвхтэй давшиж Хаалган, Жэхэ, Долоннуур хотууд болон олон тосгон сууринг эзлэн авчээ. Эхний үед буриадууд дайны үйл ажиллагаанд оролцдоггүй байснаа яваандаа гоминданыхныг дэмждэг, Хятадын коммунист намаар удирдуулсан Ардын чөлөөлөх армийг эсэргүүцдэг болсон байна.

Энэ үеэр Эринчиндорж хошууны захирагчийн үүрэгт ажлаа Манж-Го улсын генерал Үржин Гармаевын төрсөн дүү Гарамын Радна-Дазад шилжүүлээд өөрөө Гоминданы цэрэг байрлаж байсан Долоннуур хот оров. Тэнд түүнийг Шилийн гол чуулганы дарга Сүнжин Ванчиков, дэд дарга Буд-Балам, Авга нар омгийн тайж Балган-Сурды, Махаанд нарын зэрэг хүмүүс хүндэтгэн хүлээж авчээ. Тэд нар түүнийг Шилийн голын чуулганы элч болгон томилоод, Бээжинд сууж байсан Монгол овогтны дээд захирагч Дэ-Ван (Дэмчигдонров)-д илгээв. Эринчиндорж Дэ-Ван болон гоминданы засгийн газарт Шилийн гол чуулганы засаг ноёд гоминданы засгийн газарт үнэнчээр зүтгэхэд бэлэн харин Мао Цзедуний дэглэмийг эсэргүүцэх болно гэдгийг мэдэгдэх ёстой байв. Үүний зэрэгцээ Дэ-Вангаар дамжуулан Нанкины засгийн газрын гишүүдтэй холбоо тогтоон улмаар Шилийн голоос Хятадын Ардын чөлөөлөх армийг гаргах цэргийн тусламж гуйх үүрэг хүлээсэн байв. Ийм чухал үүрэг хүлээсэн Эринчиндорж 1946 оны 11-р сард Бээжин орж Дэ-

Вантай уулзан Шилийн голын засаг ноёдын хүсэлтийг биечлэн дамжуулав. Тэр үеэрээ Монгол-Түвдийн хорооны Бээжин дэх хэлтсийн даргатай танилцан түүгээр дамжуулж Чан-Кайшийн Бээжин дэх албаны дарга Ли Цзун Жентэй холбоо тогтоов. Эринчиндорж түүнтэй уулзаж зөвшилцөөд Шилийн голын асуудлаар Хятадын умард хэсэг дэх гоминданы цэргийн ерөнхий командлагч генерал Фу Цзо И-д учир явдлаа мэдэгдэн түүнээс тусламж гуйх нь зүйтэй гэдэг дүгнэлт хийв. Чан Кайшийн албаны дарга Ли Цзун Жен Шилийн голынхонд бололцоотой бүх тусламж үзүүлэхээ амлаад энэ асуудлаар улсын дээд удирдлагад илтгэнэ гэж мэдэгджээ.

Эринчиндорж 12-р сард Хаалган хот ороод Цахар хошууны захиргаагаар уламжлуулан генерал Фу Цзо И-тэй уулзан. Шилийн голын чуулганы ноёдын хүсэлт бүхий бичгийг гардуулав.

1946-1947 онд Шилийн гол хавьцаа Хударанга, Даш, Журамт, бага Гармаев нарын удирдсан хэд хэдэн отряд коммунистуудын эсрэг тэмцэж байв. Генерал Фу Цзо И 1947 оны эхээр тэр хэдэн отрядыг нэгтгэн нэг хүчирхэг бүлэг болгосон тушаал гарган төв штабыг нь Хаалган хотод байгууллаа. Удалгүй Эринчиндоржид хошууч генерал цол олгон Шилийн голын чуулган дахь Хятадын гоминданы армийн бүлэглэлийн даргаар томилов. Орлогчоор нь хурандаа Гармын Радна-Даза, Хударанга хоёрыг томилжээ. Тэд цөмөөрөө энэ албан тушаалдаа 1949 оны 1-р сар хүртэл, өөрөөр хэлбэл гоминданы армийн Бээжин дэх бүлэглэл бууж өгөх хүртэл ажилласан юм.

Эринчиндорж 1949 оны 12-р сарын 14-нд Чита мужийн Улсыг аюулаас хамгаалах яамны харьяа шоронгийн эмнэлэгт нас баржээ. Түүнийг оршуулсан газар тодорхойгүй. ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн 1989 оны 1-р сарын 16-ны зарлигийг үндэс болгон Чита мужийн прокурорын газрын тогтоолоор түүнийг цагаатгажээ.

Эринчиндоржийн баривчлагдах үед эхнэр Цэвэлмээ нь хүнд өвчтэй Бээжинд байсан бол хоёрдох эхнэр Дэмид нь хүү Нямдоржтойгоо хамт Ванемяо (Улаан хот)-гийн шоронд хоригдож байв.

1920 онд төрсөн Гоминданы армийн хурандаа асан Юндэндорж хүү нь 1950 онд баривчлагдан Өвөр Байгал хязгаарын Дотоод хэргийн яамны цэргийн шүүхээр 25 жил хоригдох ялаар шийтгүүлээд, Магадан, Тайшет зэрэг газруудын ГУЛАГ-уудад ял эдлээд суллагдсан боловч түүнийг гадаадын иргэн хэмээн үзээд 1956 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу хөөн гаргажээ. Юндэндорж тэнд очоод бас л хоригдон зовж зүдэрсээр саявтар нас баржээ. Хүү Ананд нь Оросын Холбооны Улсад оршин суух эрх олж аваад Ага нутагт хэсэг хугацаанд мал маллан сууж байв. Бага охин нь хөх хотод аж төрдөг ажээ.

Монголд үлдсэн эцэг Туманы Цэрэнжаваасаа Эринчиндорж 1947 оноос хойш ямар ч мэдээ авсангүй. Ах Дашравдан нь 1927 онд нас баржээ. Дүү Балдоржийн тухай мэдээ 30-аад оноос хойш бүрэн тасарчээ. Түүний Лхам (профессор Цэвэгийн Гомбожавын эхнэр), Норжмаа гэдэг хоёр эгч нь Зөвлөлт Холбоот Улсад аж төрж

байв. Лхам эгч нь баян професорын эхнэр байсан гэдгээр хавчигдаж байсан бол Норжмаа хэлмэгдэн Нарымын хязгаарт цөллөгдөөд мод бэлтгэх ажил хийж байв. Түүний охид бас л Нарымын хорих газраар дамжжээ. Харин Эринчиндоржийн авга эгч Цэвээний Янжмаа, Ламжав хоёр 2009 он хүртэл Агын Могойтын районд энх тунх аж төрж байв.

Эринчиндорж Гоминданы армид алба хааж байхдаа Чан Кайшийн хөрөнгөтний засгийн газрын талд Хятад улсын Ардын чөлөөлөх армийн эсрэг тэмцэж байсан тухайд гэвэл ойлгомжтой юм. Харин мөрдөн байцаах албанаас түүнийг Зөвлөлт Холбоот Улсын эсрэг гэмт хэрэг үйлдсэн, тухайлбал 1920-оод онд Тавхайн Дугарын отрядад алба хааж байсан (тус отрядын штабын даргаар хоёрхон сар ажилласан), атаман Семеновын цэрэгт ороод Өвөр Байгалд зэвсэгт тэмцэл хийж явсан, бас япон болон америкийн тагнуулын албатай хамтран ажиллаж байсан гэж буруутгадгийг нягтлан тодруулж, хөдөлбөргүй баримтуудаар нотлох нь чухал байна. Тавхайн Дугар л гэхэд аль хэдийн цагаатгагдсан юм билээ.

Эцэст нь хэлэхэд ганц Эринчиндорж төдийгүй ер нь улс төр, эдийн засгийн хавчлага хяхалтад дарамтлуулж төрж өссөн өгөөж баян нутгаа булаалган дайн самууны хөлд нэрвэгдсэнээс амар тайван амьдрал эрэлхийлэн дүрвэж гарсан буриадуудыг Зөвлөлт Холбоот Улсын заналт дайсан мэтээр үздэг байв. Жишээ нь Монгол Улсад байсан буриадуудыг 1930-аад онд яаж хэлмэгдүүлснийг хэлэхэд л хангалттай. Гэтэл тэд ЗХУ-д байтугай ямар ч улс гүрэнд хор хөнөөл учруулаагүй, харин ариун цагаан хөдөлмөрөөрөө аж төрөн үнэн ч шударга зан чанараа хадгалсаар үндэснийхээ уламжлалт ёс зан заншилыг харь үндэстний дунд ч өндөрт өргөж явааг үл тоомсорлож болно гэж үү. Тиймээс буриадын ард түмний түүхээс улс төрийн учир шалтгаанаар аль нэг хуудсыг нь таслан хаяж болохгүй нь мэдээж. Тийм цаг ч улиран оджээ.

***“Угай зам”сониноос орчуулсан Буриад Улсын
соёлын гавьяат зүтгэлтэн Ж.Цэвээний нэрэмжит
шагналт сэтгүүлч Моотгон Дарийн Бадамням.
2013-12-25***

-oOo-

Тав. ХӨРӨГ, ТЭМДЭГЛЭЛ

Г.Гантогтох –

МУИС-ийн МХСС-ийн багш,
доктор /Sc.D/, профессор

М.Одмандах –

МУБИС-ийн МоСС-ийн багш,
доктор, БСА-ийн ерөнхийлөгч

БАРУУН ДОЛООН БУРИАДЫН УТГАЛААЧ Л.ГАЛБААБАДРАА ОТОЧ ЛАМБУГАЙ



Баруун буриад түүхийг утгалан хойч үедээ өвлүүлэн үлдээх, монгол судлалд орхигдсон цагаан зайг нөхөхийн тулд ухамсарт амьдралаа зориулж яваа, ХХI зууны эрдэмт лам оточ Л.Галбаабадраа гуайг манай буриад түмэн андахаа больжээ. Түүний нөр хичээнгүй хөдөлмөрөөрөө бүтээсэн ном бүтээлүүд нь бидэнд мартагдан орхигдсон алс бөглүү Хөвсгөлийн их тайгаар нутагтай баруун долоон

буриадын гайхам түүхийг нүднээ ил, гарт баригдах, уншуур сайтайгаар бидэнд хүргэж байгаа нь олзуурхуштай.

Энэ эрхэм таабайтай би 2008 оны хавар танилцах боломж бүрдсэн билээ. Бид дөнгөж Буриад судлалын академийг үүсгэн байгуулж байсан цаг. 3-р сарын эхээр Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотод Хотгойд, Дархад, Буриадын судлалын талаарх эрдэм шинжилгээний хамтарсан хурлыг хийхээр болж бидний хэсэг нөхдийг урьж билээ. Ингэж л манай академийн хэсэг нөхөд болох Г.Батцэрэн, Д.Ханджав, Д.Дашдаваа, Г.Гантогтох, Л.Оюунцэцэг, М.Одмандах, М.Ариунжаргал нарын судлаачид, Дархад судлалын нийгэмлэгийнхэнтэй хамтран алсын замд гарч хоймор нутаг Хөвсгөлд хөл тавих завшааныг бүрдүүлсэн хүн бол оточ ламбугай Л.Галбаабадраа гуай байлаа. Харин Г.Гантогтох багш маань Л.Галбаабадраа

ламбугайн бараг хар бага залуугийн сүрхий найзууд, номын барилдлагатай ах дүүс, номын садан явж ирснийг тэгэхэд л мэдэж билээ.

Бид “Хотгойд, Дархад, Буриад судлалын асуудлууд” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг хамтран зохион байгуулж, тухайн үед аймгийн засаг даргаар ажиллаж байсан Б.Батхүү туйлаас талархалтай дэмжиж, өдөржин хуралдсан хурлыг өглөөнөөс орой хүртэл тэвчээртэй суун сонордож, их ажлыг эхлүүлсэн хүмүүстээ талархаж байсныг санаж байна. Ингэж л буриадынхаа төлөө, үндэс соёл, угсаа гарвал, уламжлалт анагаах ухаанаа түгээн дэлгэрүүлэх, үр хойчдоо өвлүүлэх их ажлыг амжуулж явна.



Зураг дээр: Хөвсгөл аймгийн Мөрөн хотод болсон “Хотгойд, Дархад, Буриад судлалын асуудлууд” сэдэвт хуралд Улаанбаатар хотоос оролцогчид зарим зохион байгуулагчдын хамтаар. 2008 оны 3-р сар.

Галбаабадраа ламтан 1947 онд Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр суманд Шошоолог овогт аав Лувсандорж, ээж Донгоо нарын гуравдахь хүү болон Харнүдэн гэдэг газарт зуны дэлгэр цагт төрсөн. Эцэг эхээс эгч, дүү дөрвүүлээ. Том эгч Савгандай, бага эгч Долгоржав, отгон дүү нь Гэндэндарам. Ээж нь өнөөдөр 106 насыг зооглож, үр ач нараа тойруулан Хөвсгөл аймгийн Мөрөн хотод тэнхлүүхэн

аж төрөн сууна. Ээж Норовын Донгоо нь идэр залуугаасаа нэгдэл нийгмийн малыг маллаж, нэгдэлд саальчин, малчин хийж насныхаа тэтгэвэр суусан буянтай буурал.

Тэрбээр 1957 онд 10 настайдаа Цагаан-Үүр сумынхаа дунд сургуульд орж, 1961 онд 4-р анги дүүргэж, 5-р ангид элссэн боловч өөрийн хүслээр малчин болохоор эцэг эхийнхээ хамтаар хөдөө суусан байна. Гэвч ном эрдэмд, тэр дундаа бурхан шашны номыг сонирхох сонирхолд нь эцэг, эхийн хэн нь ч саад хийсэнгүй. Нутгийнхаа эрдэмт лам нарын нэг байсан Лүдэв гэвшээр 1964 оноос төвд ном заалгаж, нутгийнхандаа адлагдах шахуу явсан байна. Гэвч түүний бурхны зурсан төөрөг, тавилангаар номын садан сайхан хүмүүстэй учирч хожмын өдөр сайн лам, маарамба болох эхлэл тавигдсан нь юутай завшаан билээ.

Тэрбээр өөрийнхөө туулж өнгөрүүлсэн амьдрал, намтрын хураангуйг “Хөвсгөлийн буриадууд” номондоо шигтгэн хэлхсэн байгааг энд товчлон хүргэх нь зөв гэж бодно.

Ингэж хүүрнэсэн байна “...Би Цагаан-Үүр сумын нутагт өндөр уулсаар хүрээлэгдсэн өргөн Үүрийн голын хөвөөнд “Хар нүдэн” хэмээх газар XVI жарны улаагчин гахай жилд ард Лувсандоржийн гурав дахь хүүхэд болон мэндэлсэн. Ээж минь намайг туйлын хүнд зовлон зүдгүүр эдэлж өсгөсөн, үрийнхээ төлөө халуун, хүйтэн, нойртой, нойргүй, өлсөх цангах, өдөр шөнийг ялгахгүй шахуу ядрахаасаа няцахгүй зүтгэж хайрлаж, өвчин тусч уйлж, орооход уулзаагүй хүн, яваагүй газаргүй болж дэмий гайхахдаа Гэндэнжамц таабайн ээж Хорол гуай, хар тарничин Сахьяа /ягаан таабай/-г залжээ. Замдаа өрөөсөн дөрөө хэвтэхэд төрийн хишиг төмрийн өөдөс гэж их олзуурхан авч хол явалтай, ховор хүн болж магадгүй гэсээр ирэхэд миний амьсгал мэдэгдэхгүй байсан гэдэг. Тэд бушуу түргэл гэж юм төхөөрүүлж аваад гурван орой дүүгүүрдэж намайг хүн болгож Муу нохой гэсэн нэр хайрласан гэж зуу гарч байгаа ээж минь хуучилдаг...”¹ гэж бага насаа дурссан байна.

Энэ хорвоод их зүйлийг бүтээх нэгнийг нутгийн эрдэмт өвгөд, хөгшид амийг нь тэтгэж, хүн болгосон байна. Юмны учрал, тохиол, хувь тавилан гэж ийм ажээ. Түүний аж амьдралын зам хэрхэн эргэж, буян ном, бурхны шашны үнэнч хувраг болсон тухай нэгэн сурвалжлага, нийтлэл өдөр тутмын сонинд гарсан байна. Тэрхүү сонинд нийтлэгдсэн өгүүллийг бид хэвээр нь оруулж, шигтгээ хийж, энэ хүний тухай тодорхой танилцуулах болно.

Буриадынхаа төлөө, тэр дундаа монголын буриадуудын дотроос төдийлөн ялгараад байдаггүй баруун долоон буриадынхаа төлөө их зүйлийг бүтээх, соёл, уламжлалаа хадгалан үлдээхийн төлөө энэ биеэ элэгдтэл зүтгэж байгаа эгэлгүй нэгэн ховор хүн бол Галбаа ах юм. Лам болсон цагаасаа л бурханы шашин, түүний дотроос уламжлалт анагаах ухаанд шимтэн суралцсан цагаасаа л монголынхоо үүх

¹ Л.Галбаабадраа “Багшаараа бахархахуй” дурсамж өгүүлэл. “Хөвсгөлийн буриадууд” УБ., 2012. 83-р талд.

түүх, буриад түмнийхээ оюуны соёлын өвийг судлан сурвалжлах, эмхтгэн цуглуулах, хойч үеийнхдээ өвлүүлэн үлдээх ажлыг эхлүүлж, өдгөө хүртлэх хугацаанд олон арван бүтээл, аман зохиолын эх хэрэглэгдэхүүнийг хэвлүүлэн олон түмний хүртээл болгосон гавьяатан.

Галбаабадраа ламбугайн туурвисан Түнхэн, Санагын буриад аман аялгууны хэрэглэгдэхүүн нь агуулга өргөн, үүнд шашин сүм хийдийн үүх түүх, бөө мөргөлийн Даян дээрхийн шүтээн хийгээд Бух ноён баавайн домог хууч, бөөгийн тамлага, дуудлага, дурдлага, буриад ардын дуу, еэхэр бүжгийн дууны яруу найраг, суух хуурын домог, аман түүхийн сурвалж тэргүүтэн арвин материал агуулсан “Хөвсгөлийн буриад ард түмний соёлын өв, суух хуур, ёохор хатирах дуут бүжгийн түүвэр” /Мөрөн, 2009/, “Даян дээрхийн хүрээ ба Санагийн хүрээний товч танилцуулга” /Мөрөн, 2004/, “Наян нэгэн цацлай аялгам хайхандаа” /Мөрөн, 2002/, “Хөвсгөл нутгийн буриад ардын дууны түүвэр” /Мөрөн, 2005/, “Хөвсгөлийн буриадууд” /УБ., 2012/ зэрэг номыг бүтээж туурвисан нь эдүгээ олдохуйяа чухаг аман билиг болохын учир судлаач нар бүтээл туурвилдаа ашиглан номзүйдээ оруулж, МУИС-ийн Монгол хэл соёлын сургуулийн нутгийн аялгуу судлал, угсаа хэл шинжлэл зэрэг хичээлийн унших номын жагсаалтанд зүй ёсоор орж оюутан, магистрант, докторант нарын судалгааны хэрэглэгдэхүүн болж байдаг юм.

Галбаабадраа ламбугайн их арван ухааны нэгэн салбар тэжээх, анагаах ухааны талаар бүтээсэн туурвил уламжлалт анагаах ухааны ховор чухаг ном судруудыг эх бичгээр нь хэвлүүлсэн явдал анагаах ухааны хийгээд шашны ухааны сургуулийн шат шатны оюутан судлаачдын гарын авлага болж, сайн оточ эмч нарыг төрүүлэх хийгээд, өрнө дорнын анагаах ухааны үндсийг хослуулах болон монгол эмнэлэгийн хөгжилд ном буяны өглөг болон хурж байна. Сонгодог монгол бичгийн хэлний тэжээх ухааны салбарын хэрэглэгдэхүүн болсон “Монголын уламжлалт арга заслууд” /УБ., 2010/, “Уламжлалт анагаах ухаанд суралцагчдын гарын авлага” зэрэг цуврал номуудыг “Сонгодог монгол бичгийн хэл” хэмээх хичээлийн унших хэрэглэгдэхүүн болгож уншуулдаг юм. Галбаабадраа ламбугайн тэжээх ухааны ном шастир агь тарнийн ёсонд боловсорсон эмч, оточ мөн бөгөөд түмэнд хүргэсэн тус нь цаглашгүй, улсын номын сангийн төвд номын фондын ажилтан байх үеэс нь бид танилцаж, үр хүүхдүүдийг маань өлгийтэй байхаас нь өсгөлцөж, манцуйтай байхаас нь маналцсан найж нь байсан юм. Найж гэж юу гэсэн үг вэ гэвэл өлгийтэй, манцуйтай нялх хүүхдийн сүнс сүлдрийг дааж, өвчин эмгэгээс сэргийлэн, адын хорлолыг хариулж, хэрэв өвдөж ороовол эмнэж домнодог лам, бөө, аргачин ачтаныг найж гэдэг. Манай отгон охин Туул аав ээжтэйгээ цуг Хөвсгөл аймагт 2013 оны зун найждаа очиж золгосон юм.

Галбаа ламбугайн тухай тэртээ 1998 онд “Өнөөдөр” сонинд Б.Энхтуяа гэж сэтгүүлчийн бичсэн “Ринчен докторын өөд нь татсан эрдэмт маарамба” гэсэн тэмдэглэл хэвлэгдсэн байна. Энэ тэмдэглэл, ярилцлагад түүний талаарх тодорхой

ойлголтыг цогцоор нь гаргаж чадсан тул энэ удаагийн тэмдэглэлдээ мөн ашиглаж, бүхлээр нь оруулж байна.

Үүнд өгүүлэх нь:

“... Маарамба багш эдүгээ нас дал гарсан ч ухаан санаа цэцэн тунгалаг, сургах хэлэх нь эрдэнийн чулуу амнаас нь унах мэт. Бага залуу Галбаабадраа багшийн үгийг чихний тосгуурт шингээж, сүсэг сэтгэлээр бурханчлан шүтнэ. Багшийн нэр Чойжамц Ханд чин вангийн хүрээнд сууж байсан түүхтэй. Түүний унаган шавь Галбаабадраа улаа бутарсан царайтай, уулын мэт өндөр чилгэр биетэй, зан төвшин, сүсэг бат, сурах мэдэхийн хорхой зүүд нойрыг хулжааж зүрх сэтгэлийг гижигдсэн хөвүүн.

Хөдөөгийн хүүхдүүдийн нэгэн адил хар багадаа эхийгээ хормойдон өсч бага, дунд сургуульд сурч, дараа нь хөдөө гаран мал маллан, эцэг эхдээ тус нэмэр болж, бригадын холбоочин хийж хэвлэл шуудан түгээж явжээ. Авга ах Лүдэв гэвшээр түвэд ном заалгаж, зөнөг тэнэг хоёр бурангуй суртлын буруу ном үзлээ хэмээн зэмлэгдэхвий гэж сэрэмжилж байх үест үхэрчин хүүгийн хувь заяаны тохирол бүрдэж эртний буян ерөөлөөр эрдэмтэн Ринчен, Сумьяабаатар, Шагдарсүрэн, Лувсанжав нар Лүдэв гэвшийнд дөрөв тав хонож хуучлан саатах нь тэр ээ. Галбаабадраа ном судар цуглуулж яваа тэдгээр эрдмийн багш нарт өөрийн цуглуулсан ном судраас өгч номын садан болов. Нэгэн өдөр бригадын шуудан авахаар сумын төв орвол Ринчен доктороос өөрт нь ирсэн захиа байв. Тэр захианд:

“Галбаабадраагийн амар мэндийг эрнэм!

Энэ оны таван сарын 26-нд бичсэн захиагий тань аваад одоо хүртэл хариу бичиж завдаагүйдээ аргагүй учраа тайлбарлалтай боллоо. Миний бичих төлөвлөгөө маш их болоод, энэ оны эхээр ирсэн гадаадын эрдэмтний захианд одоо хүртэл хариу бичиж чадаагүй сууж байнам. Долоон сарын сүүлээр Чехословакийн Карл вангийн аршаанд суухаар онгоцоор нисэн очиж, тэндээс буцаж ирээд, зүүн аймагт шинжээний анги дагуулан явах байснаа төлөвлөгөөнөөс гадуур эртний Хөх түрэг улсын хөшөөний бичиг зураг хуулж буулган нэгэн ном болгох ажил гараад Ар-Өвөрхангай, Булган, Төв, Увс, Ховд, Баян-Өлгийгөөр явж, энэ арван сарын шинэдээр буцаж ирээд хэвлэлд байгаа миний Монгол бичгийн хэлний зүйн гуравдугаар дэвтэрийн үсгийн алдаа мадагийг хянан үзэх, бас дөрөвдүгээр дэвтэрий нь хэвлэлд өгөх ажил гүйцээх гэж, тэгээд сая явж олсон хадны бичиг үсгийг нэг ном болгох мэтийн ажилд дарагдан, долоо хоногт нэг орой захианы хариу бичих гэж нэг хоёр цаг суудаг боллоо.

Сумьяабаатар, манай хэл зохиолын хүрээлэнд ажлаа хийсээр байгаа. Сая Хэнтий Дорнодоор явах шинжээний ангиар яваад ирсэн. Шагдарсүрэн ирэх жил сургуулиа төгсөх байх. Лувсанжав надаар удирдуулсаар энэ жил Унгарт дэд эрдэмтний зэрэг хамгаалаад ирсэн. Одоо их сургуульд багшилж байгаа.

Орос бичгийн хэл юу урд мэрийн сурууштай байна. Тэгвэл их учир бий. Орос хэл сурахдаа заавал ярианы хэл гэх хэрэггүй. Манай эрдэмтэн лам нар, төвд хар хэл

мэдэхгүй мөртөө төвдийн ямар ч их номтой хүний биширмээр ном зохиол төвд номын хэлээр хийдэг байсантай адил орос бичгийн хэл мэдээд, орос хэлээр байдаг ном үзэж мэдцээ өндөр өргөн болговол тулга тойрсон хэдэн ярианы үг мэдэж авах нохой хялбар. Дутуу хагас мэнд здоровын хэдэн үгтэй хүнийг орос хэл мэддэг, түүгээрээ эрдэм мэдлэгээ зузаатгадаг гэж үзэж болохгүй. Орос ном үзээд, утга санаагий нь ухаарах нь орос хэл сурсны нэгдүгээр шат болно. Тэгээд, номы нь үзсээр байтлаа өөрөө бичиж чаддаг болно. Тэгэхэд ярианы хэл гэдэг өөрөө аманд орж ирнэ.

Би ирэх жил танай аймгаар явах санаатай. Ажлын зав юу болдогийг одоо мэдэхгүй, тэр тухайд нь шийднэ. Аав эжсийдээ мэндийг хүргээрэй. Миний хаяг: Улаанбаатар, шуудангийн хайрцаг 119. Ринчен доктор” гэж өгүүлснийг уншаад хойтон хот ороорой гэснийг санаж эцэг, эхдээ хэлээд нийслэлийн дүг амьдралын жолоо залав.

Ринчен доктор залуу хүүг талархан угтаад Чой.Лувсанжавт,

-Улаанбаатар хотод амьдарч, ном үзэхэд нь тусал гэж тушаажээ. Чой.Лувсанжав түүнээс,

-Чи ямар ном үзэх хүсэлтэй вэ гэж асуухад

Галбаабадраа

-Би лам болох хүсэлтэй гэж хариулснаар Гаадан хамбын багш Гандан хийдийн гэвш Иштавхай ламд шавь оруулжээ. Тэр завшаанаар номын далай, хайлсан тугалга мэт багшийнхаа илүү гэрт суун, өглөө өрх татан цай чанаж, үдэш хоол бэлдэн хөлийг нь хучиж, ус түлшийг дөхүүлэн, өдөр нь төмрийн заводад ажиллаж, орой нь 20 дугаар сургуулийн аравдугаар ангид суралцаж байв. Эрдэм номын үсгийн утгыг тайлж, шид бүтээлийн ван жанан хайрласан багш нь эдүгээ цөвүүн цагийн түмэн амьтанд тустайг болгоож Чойжамц маарамба шавь оруулжээ. Чойжамц маарамба нутаг орны тухай асууж ярилцаад Уялгын харуул, Даян дээрхийн хүрээний хүн болохыг сонсоод ихэд баясаж өөрийн тухай хуучлав.

-Миний эцэг, эх олон хүүхэд гаргасан боловч тогтоогүй, Даян дээрхийн хүрээнд эргэл мөргөлөөр очиж асуусанд хоёр сайхан хүүхэдтэй болно, санаа зоволтгүй гэсэн юм гэнэ лээ. Нэг нь би шүү дээ гээд инээмсэглэхэд насны их атираанд дарагдсан нүүрэнд нь жаргалтай бага насны гэгээн инээмсэглэл тодроод ирэв. Иштавхай лам Чойжамц маарамбад хандаж ярихдаа,

- Би ч өөрийгөө асруулж тойлуулахаа бодвол явуулмааргүй л байна. Өвчин зовлон, үхэл хагацал нүүрлэсэн цөвүүн цагт амьтны тусад хичээж, аль болох олон амьтанд туслах нь дээр болов уу гэж бодоод маарамба болгохоор шийдлээ гэж хүүрнэв. Чойжамц маарамба ч эмийн дөрвөн үндэсний язгуурын үндэсээс (зажууд) эхлээд айлдав. Залуу хүү өглөө оройд нь номоо заалган, өдөр нь эмийн заводын зохион бүтээх товчоо, Ботаникийн хүрээлэн, Улсын төв номын санд Төвд номын фондод ажиллаж байв. Улмаар ерээд оноос Зүүн хүрээ Дашчойлон хийдэд шавилан сууж, хуралд хурж, буян номын үйлд алжаал ядралыг огоорон зүтгэж байгаа ажээ.

Олноо хүндлэгдэж шүтэгдсэн Галбаабадраатай уулзаж ярилцсан яриагаа одоо толилуулья”¹ хэмээн бичсэн байна.

Эндээс үзвэл Гандан хийдийн сүүлчийн шахуу эрдэмт лам нарын шавь болж, номын авшиг хүртсэн азтай нэгэн. Тиймдээ тэр сурсан мэдсэнээрээ ард олондоо тус хүргэж, гадаад улс орнуудад ч гэсэн дорно дахин, тэр дундаа Монголын уламжлалт анагаах ухааны өв уламжлалыг сурталчилан таниулахад тодорхой хувь нэмэр оруулж, үүрэг гүйцэтгэсэн эрдэмт маарамба нарын нэгэн билээ.

Тэрбээр залуудаа хийгээгүй ажилгүй, үзээгүй номгүй гэж болно. Лам болохын төлөө хамаг цагаа зарцуулахын хажуугаар оройгоор 10 жилийн боловсрол эзэмшиж, өдөрт нь төмрийн заводод ажиллаж, тодорхой хэмжээгээр амьжиргааны мөнгөө олж, хүний дайтай аж төрөхийн төлөөнөө их зүйлийг үзэж, Гандан хийдийн сүүлчийн эрдэмт лам нараас номын авшиг, жанан хүртэж, өөрийн хэр хэмжээгээр хойч үедээ өвлүүлэхийн төлөө чармайх шулуун дардан замаа өөрийн идэвх зүтгэлээр л олж авсан ажгуу.

Өөрийн тухай “...Эмийн заводод зохион бүтээх товчоонд ажиллаж байв. ШУА-ийн харьяа Ботаникийн хүрээлэнд гадаадаас авчирсан эмийн ургамал тарьж байлаа. ШУА-ийн харьяа Улсын нийтийн номын сангийн Түвд номын фондын эрхлэгч, зүүн хүрээ Дашчойлон хийдэд Маарамба лам, гэсгүйн алба хашиж байв. Эм гоо сайхны “Монос” компанид эмч байлаа. Польш улсад монгол эмчээр хоёр жил ажилласан. ОХУ-ын Санк Петербург хотноо Буддын шашны Гүнзинчойной дацангийн ширээт Данзанхайвзингийн урилгаар очиж ажилласан. Бүх оросын буддын шашны тэргүүн Иволгийн дацангийн ширээт хамба лам Дамба Аюушеев шавийн урилгаар Буриадын олон районы дацангуудад эм барих ном зааж байв. Залууд гадаадад нэлээд явлаа.

Хотод байртай, зуу гарч байгаа ээжийгээ асарна. Өөрийнхөө төрсөн нутаг Даян дээрхийн хүрээг 1998 онд сэргээсэн. Сургуулиас завсардсан хүүхдүүдэд ном зааж лам нараа бэлтгэсэн. Донжи ладу цаной мойди Чимэдрэгзэн багш Мөрөнд жодын хурал гаргаарай гэсний дагуу Жагар ламын Жодын хурал байгуулсан. Хүүхдүүд маань Гандантэгчилэн хийдэд болон шашны сургуульд сурч байна. Зарим нь Ээ ламын жодын хуралд хурж байгаа. Төрсөн нутагтаа хувиараа 2011 онд жодын хурлын сүм бариулж хурал номтой болгон хүлээлгэн өглөө. Хэлмэгдсэн лам, хар хүмүүсийн хойчийн буянд зориулж гэрэлт хөшөө, 230 см өндөр цагаан гантиг чулуунд Мандшир бурхан бүтээсэн. Олон түмний тусын тулд “Хөвсгөл цай”-ны жор гаргасан. Өвөр монголд хэвлэгдсэн монгол номноос хөрвүүлж таван хошуу малын хануур, зүү, төөнүүрийн ном, мөн таван хошуу малын эрхтнээр хүн эмнэх арга, хонины далны мэргэ, элдэв сонин зүйл багтаасан ном гаргалаа. Зун нь

¹ Бямбажавын Энхтүяа “Ринчен докторын өөд нь татсан эрдэмт маарамба” тэмдэглэл. “Өнөөдөр” сонин. 1998.03.04. “Даян дээрхийн хүрээ ба Санагын хүрээний товч танилцуулга” бүтээлийн 93-97-р талд.

Наранбумбатын рашаанд хануур, самнуур, эм тан барих, ном айлдах зэрэг ажилтай байна даа.

Миний багш нар чинь оройн дээд чандмань эрдэнэ шиг эрдэмтэн мэргэд. Энэ биеэрээ бурхан ухаантай багш нар байв. Намайг багш нартайгаа цуг байхад 1970-1980-аад оны сайд дарга, эрдэмтэн мэргэд өдөр шөнөгүй цувдаг байлаа. Би нүдээ аньж байх биш баргий нь таньдаг боллоо. Сүүлдээ намайг хүртэл зүгээр байлгахгүй янзтай болов. Үүнийг аймгийн номын санд алба хашдаг С.Нямжав цуг ажилладаг байсан сайн мэднэ. Тэр үеийн таньдаг хүмүүсийн хүүхдүүд аав ээж маань захидаг байсан гээд далай үзэх нэрийдлээр таныг эрж хайж, зорьж ирлээ гээд амар мэнд мэдээд буцахад нь баярладаг. Сайн багш нартай учирсан ч амьдралд ташуураад олигтой сураагүй боловч багш нар шид бүтээлийн элдэв увидас хайрлахдаа гар хоосон орхиогүй. Энэ яваа нас эцэс хойтдоо хэрэгтэй гэж амаар болон номоор ван жанан лүн хайрлан бясалгаж яваарай гэж захисан. Хүмүүс намайг түүх хэл бичгийн багш бол, чи чадна, оруулаад өгье гэж шаардсан ч ороогүй. Анхны багшийн зарлигаас гажаад яахав гэж бодоод дээд мэргэжилтэй хүнээс өөрцгүй цалинтай явлаа. Лам багшийн зарлиг гэсэн үг...”¹ гэж хүүрнэсэн байна. Арга ч үгүй биз. Орон нутагт социализмын хатуу цагт бурхны ном үзэж явахад нь эрдэмт багш Ринчин өөд нь татаж, өдий зэрэгтэй явах зам мөрийг нь тэгшилж өгсөн тул түүнээс хэрхэн гажих. Мөн номын багш нарын айлдвараас хазайж яаж болох билээ.

Галбаабадраа ламтаны хөдөлмөр зүтгэлийг үнэлж, төр засгийн олон шагналаар урамшуулжээ. МУСТА, ОХУ-ын Буриад улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Эрүүл мэндийн тэргүүний ажилтан, Ард түмний Соёлын гавьяат зүтгэлтэн, төрийн дээд шагнал “Алтан гадас” одон болон бусад ойн медалиудаар шагнасан байна.

Тэрбээр олон тооны шавь бэлтгэж, тэд нь багшийнхаа үйлсийг нэр төртэй үргэлжлүүлж яваа аж. Түүний шавь нараас Энэтхэгт Утай Гүмбэн, Гомон дацанд сууж, олон жил ном бясалгаж, эрдмийн оройд гарцгаажээ. Тухайлбал, шавь Дэмбэрэл нь Энэтхэгт уламжлалт эмийн ном судалж ирээд одоо Монгол улсын их сургуульд багшилж байгаа бол шавь Буяндэлгэр нь түвд хэлний орчуулгын чиглэлээр нарийн мэргэшиж, одоогоор Ганжуур, данжуурын орчуулгын эрхлэгчээр ажиллаж байна. Мөн нэг шавь Жавзандорж нь Энэтхэгийн алдарт Гомон дацанд чойрын чиглэлээр 20 гаруй жил суралцан одоогоор анги дамбын лам хийж байна. Тэрбээр олон шавьтай болж, Энэтхэгт 20 шахуу жил сууж байна. Ингэж түүний олон арван шавь нараас номын дээд эрдмийг сурч, багшийн үйлсийг үргэлжлүүлж яваа аж. Мөн түүний шавь нараас Хөвсгөл аймгийн Даян дээрхийн хүрээний ловон лам П.Цэрэн-Очир, Цагаан-Үүр сумын хийдийн тэргүүн лам Гарамын Гаадан зэрэг олон шавь нь нэр төртэйгөөр бурхан шашны үйлсийг дэлгэрүүлж яваа ажээ.

¹ Л.Галбаабадраа “Багшаараа бахархахуй” дурсамж өгүүлэл. “Хөвсгөлийн буриадууд” УБ., 2012. 85-р талд.

Даяар монголынхоо хоймор нутаг Хөвсгөл аймагт аж төрөн суугаа Санаг, Түнхэний буриад зон хэл аялгуу, хэв заншил, хувцас өмсгөл, суух хуур хөгжим, туульс үлгэр, түүхт домог, түүхэн замнал, ёохор бүжиг наадам, дуу хуураараа буриад зоныхоо дунд өвөрмөц онцлогтой бөгөөд өв соёлоо үеэс үед өвлөн хадгалж, үр ач нарынхаа залгамжаар бадруулан дэлгэрүүлж ирсэн баялаг өв сантай, дэлгэр их хуримтлалтай, далай баян түүх домог, аман билэгтэй, оюун төгс ард түмний нэгэн билээ. Энэ их түүхт түмний эрдэмт хөвгүүдийн нэг болон төрсөн Галбаабадраа ламбугай бурхан номын буян хийж, уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлэхийн ялдамд уг гарвалт түмнийхээ тухай ч харамгүй сэтгэлээр баринтаглан олны хүртээл болгож яваа нь үнэхээр их гавьяат үйлсийн нэгэн билээ.

Түүний бүтээлүүд:

Өгүүлэл, нийтлэлүүд

1. Даян дээрхийн агуй “Ертөнц” сонин. 1990.10.28. №9.
2. Бурхны шашны үзэл номлол “Эрх чөлөө” сонин. 2002.10 сар. №30.
3. Өдөр бүр диян бясалгал хийхдээ унших дасгалууд оршибай “Эрх чөлөө” сонин. 2003.01 сар №2.
4. Хөвсгөл нутагт буриадын суух хуур дэлгэрч буй нь “Буриад судлал” II боть, №2 (002) эрдэм шинжилгээний эмхтгэл. Редактор, доктор /Ph.D/ Б.Ширнэн, эмхтгэсэн М.Одмандах, Ч.Чинзориг. УБ, 2009. 94-96-р талд.
5. Санагын хүрээний манба дацаны маарамба нарын эрдмийг цухас дурдах нь “Буриад судлал” II боть, №2 (002) эрдэм шинжилгээний эмхтгэл. Редактор, доктор /Ph.D/ Б.Ширнэн, эмхтгэсэн М.Одмандах, Ч.Чинзориг. УБ, 2009. 186-189-р талд.

Бүтээлүүд

1. Баруун долоон буриад ба Санагын дацангийн товч түүх. 1995 он.
2. Наян нэгэн цацлаа аялгам хайхандаа. 2002 он.
3. Даян дээрхийн хүрээ ба Санагын хүрээний товч танилцуулга. 2004 он.
4. Уламжлалт анагаах ухаанд суралцагчдын гарын авлага. Цуврал – 1. 2005 он.
5. Хөвсгөл аймгийн буриад зоны суух хуурын сургалтын буриад дууны түүвэр. 2008 он.
6. Бурхан шашны түүх үргэлжилж байна. 2006 он.
7. Уламжлалт анагаах ухаанд суралцагчдын гарын авлага. Цуврал – 2. 2006 он.
8. Хөвсгөл нутгийн буриад ардын дууны түүвэр. 2005 он.
9. Уламжлалт анагаах ухаан, таван хошуу малын хануур, зүү, төөнүүрт суралцагчдын гарын авлага. Цуврал – 3. 2008.
10. Хөвсгөлийн буриад ард түмний соёл өв, суух хуур, ёохор хатирах, дуут бүжгийн түүвэр. 2009 он.

11. Уламжлалт анагаах ухааны дом засалд суралцагчдын гарын авлага. Цуврал – 4. 2009 он.
12. Монголын уламжлалт арга заслууд. Цуврал – 5. 2010 он.
13. Уламжлалт анагаах ухаан, элдэв арга заслууд. Цуврал – 6. 2011 он.
14. Шамбалын орны байдал хаадуудын үе хийгээд зорчихын ёс арга зам нугуудыг үзүүлсэн судар энэ болой. 2011 он.
15. Жодын ёсны авшиг өгөхийн нүүр таниулга хийгээд сажа ёс үлгэр зургууд. 2011 он.
16. Хөвсгөлийн буриадууд. 2012 он.
17. Mongolian tibetology series VII-IX. Galbabadraa lama's archive. 2013.

Моотгон Дарийн Бадамням

Орчуулагч, судлаач,
Монгол улс

ИХ ЭМЧ БУДЖАВЫН САНЖМЯТАВ БУЮУ САНЖМЯТАВ БУДАЖАПОВИЧ ЦЫБИКТАРОВ (1877-1921)



Анх түүхийн хичээл заалгаж байхад намын анхны нууц бүлгэмүүдийн тухай яриа үүсэхэд Кучеренко¹, Кембержевский², Цыбиктаров гэдэг гурван хүний нэр заавал дурдагддаг байж билээ. Тэд ямар хүмүүс байсан юм бол гэж саяхнаас сонирхон баримт материал сөхөж үзвэл Кучеренко Өргөө дэх орос-монгол хэвлэх үйлдвэрийн үсэг өрөгч, Кембержевский Өргөө дэх Оросын худалдааны байгууллагын захидал зөөгч байсан бол Цыбиктаров нь Оросын консулын газар болон харуулын цэргийн орон тооны эмч байжээ.

Энд бид Буджавын Санжмятавын тухай өгүүлэхийг хүслээ. Сэлэнгийн Хиагт нутгийн Цыбиктаров буюу буриадаар Цэвэгдарын хүү, Өвөр Байгалийн хасаг цэргийн засуул Буджавын найман хүүхэд төрсний нэг нь Санжмятав байв. Эцгийнхээ эрт нас барахад мал хөрөнгө багатай, бэлэвсэн эхийнхээ гар дээр үлдсэн найман хүүхэд бага балчраасаа ажил хөдөлмөр эрхлэн амьдралынхаа замыг хөөх болжээ.

Санжмятав өөрийн идэвх оролдлогоор Селенгинск дэх цэргийн орос-монгол сургуульд нэг жил, Троицкосавскийн Алексеевийн байгалийн ухааны сургуульд гурван жил суралцаад дараа нь Чита хотын ахлах гимназийг 1899 онд амжилттай дүүргэжээ. Тэр гимназид сурч байхдаа хэдийгээр “түүхийн ухааныг илүү сонирхдог байсан ч гэсэн эмч болохыг хүссэн байна”³. Тэгээд Санжмятав Орос орны шилдэг дээд сургуулиудын нэг Петербургийн цэргийн анагаах ухааны дээд сургуулийг амжилттай дүүргээд буриадуудын дотроос их эмчийн диплом гардан авсан анхны хүмүүсийн нэг болов. Цэргийн эмч болсон Санжмятав нутагтаа буцаж ирээд Орос-Японы дайны жилүүдэд Нерчинск үеэздийн Агчаа хотын цэргийн эмнэлэгт 1904 оноос 1906 он хүртэл ажиллажээ. Тэр үед эмч цөөн, өвчтөн шархтан олон байв. Санжмятав цэргийн эмнэлэгт үндсэн ажлаа хийхийн зэрэгцээгээр Өвөр Байгал мужийн эмнэлгийн хэлтсийн байцаагчийн хүсэлтээр 1906 оноос Агчаагийн бүх хүн

амд эмнэлгийн тусламж үзүүлэх болов. Дараа нь 1907 оноос 1909 оны хавар болтол Их Хүдэр сууринд ажиллав. 1909 оны хавар Буджавын Санжмятавыг Өргөөд суугаа Оросын консулын газрын их эмчээр томилон явуулав.

Энэ бол Өргөөд сууж байсан Оросын консул Я.П.Шишмарев⁴, В.Ф.Люба⁵ нарын тавьдаг шаардлагыг хангасан доктор байв. Жишээ нь, Шишмарев Өргөөд суугаа консулын газарт орон тооны их эмч томилон илгээнэ үү гэдэг асуудлыг ГЯЯ-даа удаа дараа тавьсны хариуд “Хөрөнгө байхгүйгээс гадна консулын газарт их эмчийн орон тоо байхгүй. Тэнд байгаа эмч харуулын цэргийн орон тооны эмч учраас бид танайд эмч илгээх боломжгүй” гэсэн албан бичгийг 1906 оны 11-р сарын 18-нд хүлээн аваад 1907 оны 1-р сарын 9-нд дахин “Консулын газрын албан хаагчид болон Азийн орнуудын дотроос энд хамгийн олноороо суурьшсан орос хүмүүст, мөн монголчуудад үйлчлэх их эмчийн орон тоог консулын газарт бий болгохыг хүсэж байна. Миний тооцоолсноор бол томилолтын их эмчид 6000 рубль, бага эмч болон амбулаторийн гэрэлтүүлэг, түлшид нийтдээ ердөө 52500 рубль хангалттай. Өргөөг их эмчгүй байлгаж үл болно” гэдэг шаардлага тавьжээ. Өргөөд ажиллах эмч монголчуудын амьдралын нөхцөл, ёс заншил, зан байдал, хэлийг мэддэг, бас монгол түвд уламжлалт эмнэхүй ухааны төсөөлөлтэй хүн байвал зохино. Эндхийн хэлмэрчид, ялангуяа орчуулагчийн сургуулийн сурагчид анагаах ухаан, анатомийн мэдлэг мөхөс тул эмч өвчтөн хоёрын хооронд хэл залгуулахдаа учир дутагдалтай байдаг гэж тэр үзэж байжээ.

Санжмятав хэдийгээр европ боловсролтой, анагаах ухааны тусгай мэргэжил эзэмшсэн, туршлагатай их эмч боловч хэл болон ахуй байдлаараа монгол хүн байв. 1909 оны тэр хавраа л Санжмятав Өргөөд орос, монгол, хятад хүмүүсийг эмчлэх багавтар суурин эмнэлэг байгуулав. Үүнд Орос-Хятад банкны захиргаа болон Оросын “Коковин ба Басов” пүүсээс хандивласан 4000 рублиэр дүнзэн байшин худалдан аваад түүнийгээ эмчийн өрөө, мэс засал, аптека, эмэгтэйчүүд, оросууд, монголчуудын тус тусын тасагтай жинхэнэ эмнэлэг болгон хувиргажээ. Эндээ тэр амбулаторийн үзлэг хийдэг байв. 1909 оны 10-р сарын 3-ны өдөр эмнэлэг албан ёсоор нээгдэв гэж Я.П.Шишмарев 1909 оны 10-р сарын 24-нд ГЯЯ-нд мэдээлсэн байдаг. Эмнэлгийн нээлтэд Манжийн амбан олон бараа бологчдынхоо хамт оролцжээ. Мөн 1909 оны зун эмчийн мэргэжилтэн Зигертийн удирдлагаар эмийн сан нээгдээд төрөл бүрийн эм худалдаалах болов. Энэ нь Санжмятавт ихэнх цагаа амбулатори эмнэлэг хоёртоо зориулах боломж олгожээ.

Их эмч Санжмятав хэрхэн ажиллаж байсныг дараах баримтаас харж болно. Үүнд 1909 онд ганцхан сарын дотор амбулаторид 1100-1400 гаруй өвчтөн хүлээн авч үзлэг хийсний 200-гаад нь орос, 300 нь хятад, 700-гаад нь монгол байв. 1909 оны 5 сараас 12 сар хүртэл эмнэлэгт үзүүлсэн хүний тоо 2611 байсан бол 1910 онд хэвтэж эмчлүүлэгчдийн тоо 1767, үйлчлүүлэгчдийн тоо түүнээс хамаагүй олон болсон байв. 1911 онд хэвтэж эмчлүүлэгчид 4458, үзлэгт хамрагдагсад 10261 байсны 433 нь орос, 3399 нь хятад, 6429 нь монгол байв. 1912 онд 6703 хүн хэвтэж

эмчлүүлжээ. Докторт үзүүлсэн хүмүүсийн ихэнх нь монголчууд байгаа нь тодорхой байна. Энэ бол Санжмятав монголчуудын дунд ихээхэн нэр хүндтэй хүн байсны нэг баталгаа юм. “Тэр маш богино хугацаанд монгол, хятад хүмүүсийн төдийгүй манж, монгол захиргааны итгэл хүлээх болсон хүн. Эндхийн монгол, хятад бүх хүний ярьдаг монгол хэлэнд сайн, эндхийн ахуй амьдралыг сайн мэддэг байсан нь түүнд их дөхөмтэй байв. Өргөө, түүний орчмын ардуудаас гадна нөлөө бүхий томчууд, лам нар, төвдүүд ч Санжмятав эмчид биеэ үзүүлэхээр ирдэг болсон. Манжийн амбан яамныхаа түшмэдүүд болон ойр орчмын монгол, хятад хүмүүсийг долоо хоногт нэг удаа эмчид үзүүлэх зөвшөөрөл авсан, цэцгийн тариа хийхэд зориулан яамандаа авсаархан амбулатори байгуулсан байв. Эндхийн ажлыг Цыбиктаров л хийдэг” гэж Шишмарев 1909 оны 10-р сарын 24-нд ГЯЯ-нд мэдэгджээ. Санжмятавыг Өргөөд ажиллаж эхэлснээс хойш 4 жилийн дараа Эрхүүгийн “Сибирь” сонинд: Шарайд⁸ гэдэг нэрээр ийм нэгэн тэмдэглэл нийтлэгдсэн байна: “Ихээхэн нэр хүндтэй болсон эмч тэргүүлж байгаагийн ачаар энэ шинэ эмнэлэг хэдийгээр лам нар эсэргүүцэж байгаа ч гэсэн монгол, хятад хүмүүсийн сэтгэлийг амархан татах болов. Өвчин эмгэгтээ шаналж зовсон угсаа гарал нэгтэндээ анхаарал халамжтай ханддаг Санжмятав европын анагаах ухааны нэр хүндийг лам нар болон тэднийг бишрэн шүтэгчдийн нүдэн дээр дөрөвхөн жилийн дотор зохих хэмжээнд хүртэл өргөж чадлаа. Одоо зөвхөн жирийн монголчууд төдийгүй хутагт хувилгаад, хан ван нараас эхлээд мяндагтан лам нарын зэрэг хүн амын дээд давхрагынхан Санжмятавт хандах нь цөөнгүй боллоо. Гайхалтай сайн эмчийн тухай алдар цуу говьд ч торохоо больжээ. Өргөөгийн эмнэлгийн тухай “Оросын бүдүүн эмчийн тухай” (Санжмятав бадриун тавир биетэй хүн байв) магтаалын үгийг Өргөө хавийнхны төдийгүй Өвөр монгол хүний амнаас ч сонсож болно” гэжээ.

Санжмятав Монголд 12 жил ажиллажээ. Оросын нэг ч эмч энд ийм удаан ажилласан удаа байхгүй. Энэ хугацаанд тэр мянга мянган хүнийг эмчилж, олон ч хүний амийг аварчээ. Тэр өөрийн үйл ажиллагаагаараа анагаах ухаанд итгэх итгэлийг зөвхөн өвчтөндөө төдийгүй маарамба лам нарт ч олгосон байна. Ахмад маарамба нар түүнийг оточ нарын зөвлөлгөөнд урьдаг ба залуу маарамба нар түүгээр анатомийн хичээл заалгахыг хүсч байв.

Ц.Б.Санжмятав энд хангалттай урт хугацаагаар ажиллахдаа монголчуудын эрүүл мэнд, өвчин эмгэгийн ерөнхий нөхцөл байдлыг сайтар судалжээ. Санжмятав өөрийн олон жилийн ажиглалтын тухай 1919 онд ярьсныг И.М.Майский “Орчин үеийн Монгол орон” номдоо: “Монголчууд бол бие махбодын хувьд мөхөж буй ард түмэн гэх манай үеийн зарим судлаачдын үзлийг Цыбиктаров няцааж чадсан юм. Монголчууд бие бялдрын хувьд чийрэг, булчин шөрмөс нь уян зөөлөн, мэс засал даах чадвар сайтай, наркозыг зарим тохиолдолд бараг хэрэглэхгүй байж болно, шарх шалбархай нь амархан эдгэдэг гэж батлан хэлдгээс гадна Монголын хүн ам нэлэнхүйдээ тэмбүү яртай гэдэг үзлийг ч няцааж байсан юм. Энэ өвчин Өргөө,

түүний орчмын лам нарын дунд голдуу тархсан байснаас бус хөдөөгийн малчдад энэ өвчин бараг байгаагүй гэсэн юм. Нүүдлийн онцгой нөхцөл байдалтай монголчуудад тусдаг өвчин Оросын хүн амд тусдаг өвчнөөс ялгаатайг Цыбиктаров гярхай ажигласан байна. Үүнд монгол хүүхдүүд голцуу гэдэс дотрын өвчнөөр өвдөх нь элбэг бол орос хүүхдэд бараг толгой дараалан тусдаг улаан эсэргэнэ (скарлатин) энд байхгүйтэй адил. Томчуудад ходоод муудах (махыг түүхийгээр иддэгээс), хэрх (байнга даарч хөрснөөс), шамбарам (морь зайдан унадгаас), нүдний өвчин, хамуу мэтийн өвчин элбэг тохиолддог бол зүрхний өвчин, сүрьеэ бараг байхгүй гэх мэтээр Цыбиктаров батлан хэлдэг нь бодит үнэн учраас өмнөх ам дамжсан таамаглалыг няцааж байгаа юм”⁹ хэмээн тэмдэглэн үлдээсэн байдаг.

Хаант засаг монголчуудыг байтугай өөрийн ард түмнийг эрүүлжүүлэхэд их хөрөнгө зарах бодолгүй байсан бол Зөвлөлт засаг тусгаар тогтносон Монгол оронд эдийн засаг, улс төр, соёлын нөлөөгөө хүчтэй болгохыг эрмэлзэж байв. Үүний нэг чухал зүйл нь хүн амд эмнэлгийн тусламж үзүүлэх явдал байв. Өвөр Байгалийн эмнэлгийн байцаагч А.В.Воскресенский Эрхүүгийн захиргаанд илгээсэн албан бичигтээ: “... би дөнгөж сая Өргөөгөөс Цыбиктаровын илгээсэн захидлыг хүлээн авлаа. Тэр захидалдаа, энд эмнэлгийн тусламж жигтэй их шаардагдаж байна. Хамгийн их дэлгэрсэн өвчин бол тэмбүү, хоёрдугаарт хамуу мэтийн арьсны өвчин орно гэжээ. Хэдийгээр монголчууд анагаах ухаанд их итгэдэг болж байгаа ч мэс заслын болон нүдний эмчид итгэл муутай байна. Эхний үед эмнэлгийн тусламж үзүүлэх зохистой арга бол нүүдлийн отряд ажиллуулах явдал юм гэж Цыбиктаров үзэж байгаа юм. Отряд төвлөрөх газар нь Өргөө байх бөгөөд Цыбиктаров тэнд бүх заавар зөвлөлгөөг өгөөд сайн хэлмэрчээр хангах болно. Хэлмэрч муу бол хамаг хэргийг баллах ажээ. Отряд Өргөөд сар хэртэй ажиллаад хөдөө явж ажиллана. Хөдөө явах унаа хөсөг, орон байрыг Засгийн газар хангах юм байна...”¹⁰ гэжээ. Энэ үеэс эхлээд эмч нарын отрядууд хөдөөгүүр аялан явж малчин ардуудад эмнэлгийн тусламж үзүүлэх болжээ.

Санжмятав олны хүндэтгэл хүлээсэн сайн эмч байсны зэрэгцээгээр олон нийтийн ажилд ч идэвх зүтгэлтэй оролцдог нэгэн байжээ. Орос оронд гарч байсан олон өөрчлөлт хувиралт, хувьсгалын нөлөөгөөр Өргөөд сууж байсан оросуудын дунд ч элдэв эсэргүүцэл тэмцэл гарч байсан нь мэдээж. 1917 оны эхээр Өргөөд Оросын харьяат 2000 гаруй хүн сууж байв. Нийгмийн үндсэн бүлгүүд болон улс төрийн гол гол урсгалууд энд төвлөрсөн байсан учраас улс төрийн хамгийн ширүүн тэмцэл энд өрнөдөг байжээ. Энэ тэмцлийн үр дүнд 1917 оны 3-р сарын 12-13-ны өдрүүдэд Өргөөд суурьшсан цагаач оросуудын нийтийн хурлыг зарлан хуралдуулаад “Өргөөд суугаа орос хүмүүсийн гүйцэтгэх хороо” гэгчийг байгуулжээ. Хорооныхоо даргад 13 хүний нэр дэвшүүлээд нууцаар санал хураахад консулын эмч Санжмятав Цыбиктаров сонгогдсон баримт бий¹¹. Тэр үед Өргөөд гарч байсан “Ургинский листок”¹² сонинд: “Ажилчин албан хаагчдын эвлэлээс Цыбиктаровыг манай эх оронд ардчилсан тогтолцоог бэхжүүлэхийн төлөө тууштай

тэмцэгч, хөдөлмөрчин олон түмнийг жинхэнэ хамгаалагч гэж тодорхойлов” гэж бичсэнээс үзвэл үйлдвэрчний эвлэлийн зүтгэлтэн байсан бололтой. Мөн тэр сонин гүйцэтгэх хороог “захиргааны эрхийг хууль бусаар булаан авлаа”, “Хаант засгийн байгууллагын үүргийг” гүйцэтгэх дээд шатны албан тушаалуудыг “өөрийн дуулгавартай хүмүүстээ хуваарилан олгов” гэх мэтээр буруутгаж байв. Жишээ нь “Анитра” гэдэг хүн “Шувууны үүр” гэдэг шог зохиолдоо гүйцэтгэх хороог тун хорсолтойгоор дүрсэлсэн байв. Үүнд тахилгат уулын хормойд байх “тэжээвэр хийгээд нисдэг” бас нүүдлийн шувуудын хашаагаар Өргөө дэх оросуудыг төлөөлүүлжээ. Тэр уулын оройд харцагын үүр байсан бөгөөд шувуудад эрх чөлөө олгомогц харцага нисэн оджээ. Харцагын оронд шар шувууг шувуудын захиргаатай хамт суулгаж гэнэ. Тэнд нь годгонуур хөх цөгцөгий, лагс том цацагт хяруул, нисэх тавилангүй тахиа байна. Үүнийг шувуудын захиргаа гэх бөгөөд тэд шувуудын хүзүүн дээр зайдлан суучихаад хаант засгийнх шиг бодлого явуулах болж гэнэ. Шувуудын зарим нь нөгөө эрх чөлөө гээч юм хаана байна гэж өгүүлэл тавихад, зарим нь үүрийг маань л бүү эвдээсэй гэж залбирах болов. Иймд бүргэдийн үүрээс нөгөө захиргааг жаахан угзрахад хамаг шувууд захиргаанаас холдоод, ганц цацагт хяруул үлдэхэд түүнийг мануухай болгожээ...”¹² гэсэн бол “Эндүүрэл” гэдэг тэмдэглэлд: “Манай оронд ардчилсан тогтолцоог бэхжүүлэхийн төлөө цуцалтгүй тэмцэгч, хөдөлмөрчин хүн бүрийн эрх ашгийн төлөө элдэв хар хүчний эсрэг цогтой тэмцэгч Цыбиктаровыгаа алсын замд үдэж мордуулахад хүрэлцэн ирнэ үү” гэсэн зарлал нийтлүүлээд байхад өөр нэг нийтлэлд ажилчин, албан хаагчдын эвлэлийг хайр найргүй хараан зүхжээ. Зохиогч энэ зарлалын үг болгонд эгдүү нь хүрчээ. “Цыбиктаров ардчилсан тогтолцоог яаж бэхжүүлсэн юм? Хөдөлмөрчин хүн бүрийн эрх ашгийг хамгаалж элдэв хар хүчний эсрэг цогтой тэмцсэнийг юугаар батлах юм? Тэр хар хүчнүүд гэгч нь хаана байгаа юм? Зөвхөн хөдөлмөрчдийг зовоодог байсан юм уу? Хөдөлмөрчин хүн бүр хэзээ эрхээ алдсан? Тэр нь яаж илэрч байсан юм? гэх мэтээр асуугаад, тийм хар хүч байгаагүй, харин Цыбиктаров салхин тээрэмтэй тэмцэж байсан юм” гэжээ. Энэ бол тэр үед Өргөөд байсан оросуудын дунд улс төрийн тэмцэл өрнөж байсны жишээ, Санжмятав тэдний дотор ямар үүрэгтэй байсны баримт мөн болай.

Гамингийн үед Санжмятавын байдал ямар байсан тухай мэдээ баримт олдсонгүй. Харин Барон Унгерний үед Санжмятав хэрхсэн тухай Д.П.Першин “Барон Унгерн. Урга и Алтан-Булак” (Самара, 1999 г. стр. 118, 122-123) “...Унгерн Өргөөг эзэлсний гуравдахь өдөр¹¹ Өргөө дэх цагаач оросуудын ахлагч хүн явуулаад, генерал Ефимов, Сулейманов нартай хамт Баронтой очиж уулзаад хотод үүсээд байгаа нэн чухал асуудлуудыг орос иргэдийн нэрийн өмнөөс ярилцан, тэдэнд ашигтайгаар шийдвэрлүүлэх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орлоно уу гэж хэлүүлжээ. Тэгээд маргааш өглөө нь өөрөөр хэлбэл хот чөлөөлөгдсөний дөрөвдэх өдрийн өглөө 10 цагт Консулын дэнжид цуглараад Маймаачин орох ёстой байсан тул би тийшээ явж байтал замд нэг хүн туусан хоёр хасаг цэрэг тааралдав.

Зэрэгцээд очвол туугдаж яваа хүн нь консулын газрын эмч Цыбиктаров байв. Би докторыг тэргэндээ суулгалаа. Цэргүүд эсэргүүцсэнгүй. Ихэд айж бухимдсан доктор энэ муу амнаасаа л боллоо. Согтуугаар элдэв юм донгоссоныг минь нэг хүн матсан байх гэж байна. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ороод Унгернтэй уулзахаар явааг минь мэдээд намайг өмгөөлж хамгаалаарай гэж гуйлаа. Би зөвшөөрөлгүй яах вэ. Өргөөний оросуудын тэргүүлэх хүмүүс докторын буруудсаныг мэдээд түүнийг өмгөөлөх хамгаалах хэрэгтэй гэж тохиролцож байсан юм. Түүгээр ч барахгүй би доктор Цыбиктаровтай дотно нөхөд, бас “Гүйцэтгэх хорооны дарга” болоход нь хамт ажиллаж байлаа. Харин согтуугаар дэмий балай юм чалчдаг байснаас бус үнэндээ бол маш энэрэнгүй өрөвч зантай, орос боловсролтой, үнэнч шударга буриад сэхээтэн байсан юм. Өсвөр насны дөрвөн охинтой байсан. Еврей эхнэр нь ноднин жил нас барсан юм.

Консулын дэнжид хүрэхэд маань хүмүүс угтаж уулзаад Барон Унгерн Маймаачиндаа байхгүй, хэзээ бий болохыг хэн ч мэдэхгүй, магад өнөө орой Өргөөд тэргүүлэгчдийн байранд ирэх байх гэхэд би тэнд үлдэхэд Цыбиктаров туугдан цааш хөдөлсөн билээ.

Маргааш өглөө нь, өөрөөр хэлбэл хот чөлөөлөгдсөний тавдахь өдөр Маймаачин орлоо. Хааяагүй хасаг цэргүүд, морь, тэрэг хөлхөлдөнө. Хасаг цэргүүдийг хувцсаар танихын аргагүй. Харин папах малгайгаар нь хасаг цэрэг юм байна гэж тааварлахаар.

Тэдний царай зүс ч янз янз. Янз бүрийн арьс өнгөтэй, янз янзын зүс царайтай олон үндэстэн ястны хүмүүс үзэгдэнэ. Унгерн өөрөө тевтон гаралтай герман хүн байхад туслагч нь үнэн алдарт шашин шүтдэг, Резухин гэдэг орос хүн, арын албаны дарга нь Сулейманов гэдэг сунит шашинт татар хүн, бас нэг орлогч нь Жамбалон гэдэг лам байх жишээтэй.

Бидний очиход Баронтой уулзах гэсэн монгол ноёд, лам, энгийн ардууд, оросууд олон байсан тул штабын даргаар нь хэлүүлээд нэг цагийн дараа уулзахаар боллоо. Энэ хооронд бид штабын байр, Бароны суудаг өрөө хоёрыг үзлээ. Аль аль нь тохь тух гэх юм юу ч байхгүй бохир заваан гэж жигтэйхэн байлаа. Наасан цаас нь урагдсан цонхоор жавар сэнгэнэнэ. Төмөр зуухны элч өрөөг дулаацуулж чадахгүй байгаа нь мэдээж. Өрөөний тавилга гэвэл ханз (дороосоо халдаг ор), нэг хуучны ширээ, хоёр гурван мухар сандал төдийхөн.

Туслагч нь хүрч ирээд Барон хүлээж байна орцгооно уу гэлээ. Дээрхтэй ижилхэн нэг өрөөнд орлоо. Өлөн хир суусан шаравтар хүрэн өнгийн монгол цамцтай, мөрөн дээрээ генерал мөрдөстэй, өндөр туранхайвтар хүн биднийг угтлаа. Бид мэндэллээ, Барон хариуд нь хурдхан толгой дохиж байна. Суу гэсэнгүй, суух сандал ч байсангүй,

Барон: “Юу гэж явна?” гэлээ. Би яг л илтгэл тавих гэж байгаа юм шиг бичиг цаасаа гаргаад, тодорхой нэг асуудал тавьсныхаа дараа хариу хэлэхийг нь хүлээдэг байв. Барон асуудлыг анхааралтай сонсоод, ямар асуудал байснаас хамааран бүтэх

эсэх хариуг тэр дор нь өгч байв. Нийтдээ арваад асуудал байсан байх. Жишээ нь хотод гал түймэр, дээрэм тонуул их байна. Иймд хотын орос иргэд өөрсөд дундаасаа найдвартай хүмүүсийг гарган гал түймэр, дээрэм тонуулаас жирийн иргэдийг хамгаалах сайн дурын бүлэг байгуулах зөвшөөрөл олгоно уу гэдэг асуудал байв. Энэ асуудалд Барон хариулахдаа, энэ талаар би шийдвэр гаргасан. Элдэв үл бүтэх явдлаас сэргийлэх сайн дурын бүлэг байгуулах тухайд гэвэл би хотод журам сахиулах комендант томилсон. Тэр л энэ асуудлыг бүрэн хариуцна гэлээ. Сайн дурын бүлэг байгуулах тухай асуудал бүтэлгүй болоход еврей нарын тухай асуудал тавилаа. Цэргүүд еврей нарыг эр эм, хүүхэд багачуудыг ч ялгалгүй алж устгаж байгаа нь тодорхой болсон байв. Еврей нарын тухай дурдаж эхлэнгүүт Барон миний үгийг таслаад “орхи” гэдэг ганцхан үг хэллээ. Барон ууртай байгаа бололтой хэсэг дуугүй сууснаа: “Цааш нь гэж дуугарав. Би Цыбиктаров эмчийн тухай ярьж эхэллээ. Гэтэл Барон миний үгийг бас таслаад, “наад хүн чинь үхсэн” гэлээ. Энэ үгийг сонсоод бидний сэтгэл хямарсныг мэдсэн бололтой: “Читад нэг хурал дээр большевикууд, эрх чөлөө энэ тэр гээд сүйд майд болж байхыг би сонссон гэж тун хайхрамжгүй хэлсэн билээ” гэсэн энэ баримтын талаар ямар нэгэн тайлбар хийх шаардлага үгүй биз ээ.

Зүүлт:

1. Кучеренко Михаил Иванович 1906-1908 онд цэрэгт алба хааж байхдаа цэргүүдийн үймээнд оролцож байжээ. Дараа нь Эрхүүд хэвлэх үйлдвэрийн механикчаар ажиллаж байгаад 1912 онд Өргөөд уригдан ирж, Консулын газрын орос-монгол хэвлэх үйлдвэрийг угсрах ажил хийгээд, тэндээ механикч, үсэг өрөгчөөр ажиллаж байгаад 1921 онд Барон Унгернийхэнд алагджээ. Даревская Е.М. “Сибирь и Монгол” УБ., 1911, нүүр. 256
2. Гембержевский Яков Васильевич шуудангийн ажилтнуудын ажил хаялтанд оролцсоны учир Эрхүүд найман жил шоронд суугаад улсын чухал байгууллагуудад ажиллах эрхээ хасуулсан тул 1914 онд Өргөөд ирж Оросын экспортын нөхөрлөлийн салбарт нягтлан бодогчоор ажиллаж байгаад 1921 онд Барон Унгернийхэнд алагджээ. Мөн тэнд.
3. Читийн гимназийн сурагч Санжмятавын хувийн хэрэг. ГАЧО, ф.61, оп.1, д.101, л.1-43
4. Шишмарев Яков Парфентьевич (1833-1915) Троицкосавск хотод төржээ. Төрөл садныхны нь ярьснаар бол өвөг эцэг нь монгол хүн байсан бөгөөд залуу насандаа Байгаль хавиар нутаглаад удсан орос айлын охинтой суусан гэдэг. Эцэг нь Хиагтад монгол хэлний орчуулагчаар ажиллаж байжээ. Яков Шишмарев Троицкосавскийн орос-монгол сургуулийг 1849 онд төгсөөд, Хиагтын захиргаанд ажиллаж байхдаа Хиагтын сургуулийн захирал К.Ч.Крымскийгээр заалган хятад, манж хэл сурчээ. 1856 онд Дорнод Сибирийн генерал губернаторын хятад, манж хэлний орчуулагчаар

томилогдоод ажиллаж байх хугацаандаа үүргээ гарамгай биелүүлсний төлөө хоёр удаа одонгоор, насан туршдаа жил бүр 500 мөнгөн рубль авах шагналаар шагнагджээ. Тэгээд 1861 онд анх Өргөөд Оросын консулын газар байгуулагдахад консулаар томилогдоод 50 жил ажилласан Я.П.Шишмаревт Богд гэгээн Сонгинод зуслангийн газар олгоод зандан аяга бэлэглэжээ. Даревская Е.М. “Сибирь и Монгол” УБ., 1911, нүүр. 119.

5. Люба Виктор Федорович 1886 онд Петербургийн их сургуулийн Дорно дахины факультет төгсөөд 1890-1904 онд Өргөө дэх Оросын консулын газарт орчуулагч, 1905-1908 онд Консул, 1908-1911 онд Улиастай дахь консул., 1911-1973 онд Өргөө дэх ерөнхий консул, 1913-1915 онд Ховдод консулаар, нийтдээ Монголд 25 жил дипломат ажил хийхийн зэрэгцээ Хүрээний орчуулагчийн сургуульд багшилж байв. Олохонуд Содовын Бадарчи “Богд хааны амьдралын он дарааллын товчоон”. УБ., 2000, нүүр. 195.
6. Д.Б. Улымжиев “Нерушимая дружба Советского и Монгольского народов” Улан-Удэ, 1961, нүүр.7.
7. Даревская Е.М. “Сибирь и Монгол” УБ., 2011, нүүр. 111
8. Шарайд “Медицинская” помощь монголам в Урге Сибирь, 1912, 16 июля. Ж.Цэвээн үүнийг бичээд нэрнийхээ оронд овгоо тавьжээ.
9. Майский И.М. “Современная Монголия” Иркутск, 1921, нүүр. 30-31
10. “Ургинский листок” 1917, 5 июня.
11. Барон Унгерн гамингуудыг Өргөөгөөс хөөж гаргаад 1921 оны 2 дугаар сарын 3-нд хотыг бүрэн эзлэн авсан байв.

-оОо-

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

*А.Самбуу
Д.Цэдэнжав*

БУРИАД ХЭЛНИЙ ӨДӨРТ ЗОРИУЛСАН ДУГУЙ ШИРЭЭНИЙ ЯРИЛЦЛАГА

*(Буриад хэлний өдөрт зориулсан дугуй ширээний ярилцлагад
оролцогчдын санал, бодол)*

Улаанбаатар хот

2011 оны 12-р сарын 18.

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод Буриад хэлний Өдөр зохиогддог болсноос хойш нилээд хэдэн жилийн нүүр үзлээ. Олон ч хүн цугларч, буриад хэл, соёлоо хэрхэн хадгалан авч үлдэх, цаашид хөгжүүлэх арга замын талаар ярилцдаг боллоо. Ингээд энэ жилийн буриад хэлний Өдөрт зориулсан дугуй ширээний ярилцлагад оролцсон зочид төлөөлөгч, эрдэмтэн мэргэд, жирийн хүмүүсийн хэлсэн үг, гаргасан саналаас нь товчлон мэдээлж байна. Үг хэлсэн хүмүүсийн нэр, овгийг нь орхин, гаргасан ерөнхий санал, шүүмжлэлийг товчлон сийрүүлбэл:

- ✓ Буриад хэлний өдрийг Орос орны олон хотуудад, тухайлбал, Улаан-Үд, Эрхүү хотууд, Усть-Орда, Агын буриадын үндэсний тойргуудад өргөн дэлгэр тэмдэглэдэг болсон нь буриад хүмүүс бидэнд их сайхан санагдаж байна.
- ✓ Улаанбаатар хотод болж байгаа энэ жилийн Буриад хэлний Өдрийн үйл ажиллагаанд Улаан-Үд, Эрхүү мужийн төлөөлөгчид оролцож байгаа нь буриад зон олны хоорондын харилцаа улам ойртож байгаагийн шинж тэмдэг юм.
- ✓ Дугуй ширээний ярилцлагад оролцогчид монгол туургатан ард түмэн дэлхий дээр хамгийн их тарж суурьшсан зоны нэг бөгөөд, маш олон улсад хуваагдан амьдарч байна. Тэдний хоорондын холбоо, хэлхээ их сул байгаа. Иймээс монголын буриадууд олон газар суурьшин амьдарч байгаа буриад үндэстнүүдийн хоорондын харилцаа холбоог ойртуулан бэхжүүлэх саналыг бүрэн дүүрэн дэмжиж байна.
- ✓ Монгол улсаасаа алс хол уулын монгол түүхэн нутагтаа оршин сууж байгаа хэсэг бүлэг буриадуудын хувьд хүн цөөхнөөс болж ирээдүйд цус ойртох

аюул нүүрлэж магадгүй байгаад монголын буриадууд сэтгэл их зовниж байна. Иймийн тулд “Алтаргана” мэтийн найр наадам байнга зохион байгуулж, хол ойрын буриад монголчуудыг нэгтгэн зохион байгуулж байх нь бидний ирээдүйд, үр хүүхдүүдэд маань чухал хэрэгтэй байна. Эдгээр наадам, уулзалтууд нь буриад зоныхоо соёл, ёс заншил, хэлээ хадгалан үлдэх, хөгжүүлэхэд асар их ач холбогдолтой байна.

- ✓ Монгол гарвалтай бүх үндэстнүүдийг “умард монголчууд”/буриадууд/, “төв монголчууд” /халх/, “өрнөд монголчууд” /ойрд/, “өмнөд монголчууд” /өвөр монголчууд/ гэж нэрлэх нь зүйд нийцэж байна гэж монголын буриадууд үзэж байна. Энэ нь монгол гэсэн түүхэн нэрээ дэлхийд улам цуурхуулж, буриад, халимаг, халх гэдэг нь үнэндээ бүгд нэг үндэстэн – монголчууд юм байна гэдгийг дэлхийн олон нийтэд харуулан ойлгуулж, монгол нэрээр нь хэлж, ярьж хэвшүүлэхэд тус дөхөм болох байна. Мөн 1953 оноос өмнө хэрэглэж байсан “Буриад монгол” гэсэн нэрээ дахин сэргээх хэрэгтэй байна.
- ✓ Монголын эрдэмтдийн зарим хэсэг нь буриадын төвийн сонин хэвлэлд орос үг өргөн хэрэглэгддэгт ихэд санаа зовниж, сэтгүүлч, идэвхтэн бичигч нар баялаг арвин буриад, монгол үгээ аль болох өргөн дэлгэр хэрэглэхийг санал болгож байна.
- ✓ Монгол үндэсний удам угшил, түүх соёл, хэл, уран зохиолын судалгааг олон орны эрдэмтэн мэргэд, мөн газар газрын буриад зон, сонирхогч нарыг өргөн оролцуулан хамтарсан аялал, шинжээний анги зохион явуулахыг бид бүхэн дэмжиж байна.
- ✓ Дэлхийн хамаг монголчуудын түүхэн ариун голомт нь Улаанбаатар нийслэлтэй Монгол улс мөн учир цаашид бүх монголчуудыг ойртуулан соёлоор нэгтгэхийн тулд олон газар оронд суугаа монгол үндэстнүүдийн хоорондын холбоог бэхжүүлэн ойртуулах санаачлага, үүргийг Монгол улс өөр дээр авах ёстой.
- ✓ 20-р зуунд дэлхийн хамаг монголчуудаас Ази, Европын өндөр боловсрол эзэмшсэн буриад монголчууд монгол үндэсний нэгдлийн төлөө хөдөлгөөнд их идэвхтэй хушуучлан оролцож, тэмцэж явсан юм. Түүний хамгийн шилдэг охид, хөвгүүд энэ үйл хэргийн төлөө өөрийн амь, амьдралаа зориулж байлаа.
- ✓ 20-р зууны нармай монголын төлөө үзэл санаа, хөдөлгөөн нь үнэн хэрэгтээ түүхэн монгол нутаг орон дээрээ оршин суугаа монголчуудын үндэсний эв нэгдлийн төлөө, эх оронч хөдөлгөөн байсан юм гэж монголын буриадууд үзэж байна. Үүний мөн чанарыг зарим их гүрнүүд гуйвуулан үзсээр байгаа нь харамсалтай. Иймээс энэ бол гүнзгий судлах түүхэн газарзүй, угсаатны зүйн чухал асуудлын нэг мөн юм.

- ✓ Буриад хэл ойрын ирээдүйд мөхөн алга болно гэсэн НҮБ-н ЮНЕСКО-ийн мэргэжилтнүүдийн гаргасан дүгнэлтийг сонсоод бид тун харамсаж байна. Буриад хэл бол үнэн хэрэг дээрээ эртний монгол хэлний хэлзүйн болон үгсийн сангийн асар их баялгийг өөртөө агуулсан монгол хэлний нэг хэсэг юм. Монголын Их Гүрэн байгуулагдахаас өмнө алтан ургийн бүх гишүүд /Чингис хаан ч мөн адил/ эртний монгол хэл буюу одоогийн хори-буриад аялгаар ярьдаг байжээ. Ингэж буриад хэл нь дэлхийн хувьд түүхийн үнэт хэл болж байгаа юм. Ийм ч учир ЮНЕСКО энэ хэлийг устан алга болохоос урьдчилан сэргийлэх онцгой арга хэмжээ авах ёстой.

Что говорят монгольские буряты

*(Высказывания участников дискуссии за круглым столом,
посвящённым ко Дню бурятского языка)*

В Улаанбаатаре традиционно стал организоваться “Круглый стол”, посвящённый ко Дню бурятского языка, который собирает многих. Это мероприятие дает участникам возможность получать информацию по многим вопросам и дискутировать и разделять мнениями между собой и высказывать идеи для развития связи и контакта между бурят-монголами.

- ✓ Нам приятно узнать что подобное мероприятие тоже организуется в городах России, в Иркутске, Улан-Уде и Аге, в центре бурятского национального округа.
- ✓ Нам приятно отметить, что в этом году на нашем Улаанбаатарском круглом столе приняли участие представители из Улан-Уде и Иркутска.
- ✓ Участники нашего круглого стола разделяют мнениями, что монгольская нация – это самая разбросанная и разделённая по миру этнос. Но они пока имеют слабо налаженную связь между собой. Поэтому монгольские буряты поддерживают идеи за установление близкой связи между бурят-монгольскими диаспорами.
- ✓ Некоторые диаспоры, особенно в отдалённых от Монголии, имеют очень малое количество людей. Это плохо для жизни будущих поколений потому что оно приведёт весьма серьёзный генетический риск в сближении крови в процессе их размножения. Это тоже беспокоит монгольских бурят. Понимая эту проблему мы каждый раз одобряем инициативу по организации международных событий, подобных как “Алтаргана” фестиваль, которая большую роль играет во встрече и в сближении бурят-монголов из разных районов мира. Каждое такое мероприятие привлекает большое количество участников, особенно молодёжь из разных диаспор, чему мы очень рады.

- ✓ Монгольские буряты считают правильным назвать всех этносов монгольского происхождения, подразделяя их как “северные монголы” (буряты), “центральные монголы” (халхасцы), и “южные монголы” (внутренние монголы). Это значит, что этносы монгольского происхождения в мире должны восстановить своё историческое название как “монголы” и официально это должны признать, это надо заявлять чтобы об этом повсюду и все знали и приняли это. Также правильно восстановление названия “бурят-монголы” как оно было раньше до 1953 года.
- ✓ Определённый круг учёных Монголии предлагает Улан-Удинцам чтобы они по своей возможности старались уменьшать в публикациях на бурятском языке включение русских слов, а вместо них подобрать подходящие слова из богатого общее-монгольского лексикона.
- ✓ Монгольские буряты одобряют совместное проведение различных мероприятий такие как экспедиция, исследования по древней генетической истории этносов монгольского происхождения с участием учёных из разных стран и диаспор.
- ✓ Историческая родина монголов всего мира- это есть Монголия со столицей “Улаанбаатар”. Поэтому Монголия должна брать на себя инициативу в проведении мотивации для установления контакта между всеми монгольскими диаспорами мира, чтобы в дальнейшем сблизился этот народ.
- ✓ В XX веке за единство монгольской нации самую активную борьбу вели бурят-монголы, одна из более образованных групп среди монголов в мире. Лучшие её сыновья и дочери посвятили свою жизнь этому.
- ✓ Монгольские буряты считают, что на самом деле панмонгольские идеи и движение есть как патриотическое движение монголов за единство одной нации. Только некоторые большие державы искажали её суть. Это нуждается глубокому исследованию.
- ✓ Для нас досадно слышать прогноз специалистов ЮНЕСКО ООН, что бурятский язык на ближайшем будущее будет исчезаться. Этот, на самом деле, древно-монгольский язык является исторически ценным, сохранившим в себе все грамматическое правило и словарное богатство общее-монгольского языка. В действительности, до создания “Монгольской империи” все члены семьи “Алтан ураг”, включая самого Чингис-хана, общались на древно-монгольском языке, т.е. на нынешнем хори-бурятском языке. Таким образом, бурятский язык является особо исторически ценным языком для мира. Поэтому даже ЮНЕСКО должен выделять особое внимание чтобы этот язык не стал вымершим.

**What about say mongolian buryats on the ub's
“round table” discussion**

In Ulaanbaatar has traditionally organize a “Round table” dedicated to the Day of the Buryat language, which attends many people. This event gives participants the opportunity to receive information on many issues and discuss and share ideas among themselves and express ideas for the development of communication and contact between the buryat-mongols.

- ✓ We are pleased to learn that such same event is also organized in the such cities of Russia, as irkutsk, Ulan-Ude, and Agee, in the center of the Buryat National District.
- ✓ We are pleased to note that this year Ulaanbaatar’s “Round table” was attended by honored representatives from Ulan-Ude and Irkiutsk, cities of Russia.
- ✓ Participants in our round table shared the view that the Mongolian nation- is the most scattered and divided the world diaspora. But they are poorly established link between them. Therefore, the Mongolian buryats support the idea of establishing a close connection between the buryat-mongolian diaspora.
- ✓ Some of the diaspora, especially in remote Mongolia, have a very small number of people. This is bad for future generations because it will lead a very serious genetic risk in bringing the blood defection the process of reproduction. It also worries Mongolian buryats. Realizing this problem every time we welcome the initiative of organizing international events, such as “Altargana” festival, which plays an important role in the meeting and in the connection of the buryat-mongols from around the world. Each such event attracts a large number of participants, especially young people from around the diaspora, which we are very happy.
- ✓ Mongolian buryats believe the correct name of all the ethnic groups of Mongolian origin, dividing them as “the northern Mongols” (buryats), “central Mongols” (khalkhs), and “southern Mongols” (inner Mongols). This means that the ethnic groups of Mongolian descent in the world to restore its historic name as the “Mongols” and officially it must recognize a need to declare about it everywhere, and everyone knew and accepted it. Also, the restoration of the right of the name “buryat-mongols” as it once was before 1953.
- ✓ A specific range of scholars of Mongolia offers to Ulan-Ude people that they have tried to reduce the possibility of its publication in the buryat language inclusion of Russian words, but instead find the right words from the rich-general of the Mongolian lexicon.
- ✓ The Mongolian buryats approve the joint organization of various events such as an expedition to study the genetic history of ancient ethnic groups of Mongolian

origin, with the participation of scientists from different countries and the diaspora.

- ✓ The historical homeland of the Mongols of the world, it is the Mongolia with capital of Ulaanbaatar. Therefore, Mongolia should take the initiative in carrying out the motivation for establishing contact between the Mongolian diaspora all over the world to further approached the people.
- ✓ In the twentieth century for the unity of Mongolian nations most active struggle waged buryat-mongols, one of the more educated groups among the Mongols in the world that time. The best of her sons and daughters have devoted their lives to it.
- ✓ Mongolian buryats believe that in fact pan mongol idea and the movement were a patriotic movement for the unity of the Mongols one of the nation. Only a few big powers distort its essence. It needs deeper investigation.
- ✓ For us unfortunate to hear forecasts of experts UNESCO UN that the buryat language (one branch of Mongolian language) is one of endangered languages and in the near future will disappear. This is, in fact, the ancient Mongolian language is historically valuable, retains all rules of grammar and dictionary, the total wealth of the Mongolian language. In fact, before the creation of “Mongol Empire”, whole members of “Golden Family”, including most of Genghis khan, spoke to the ancient Mongolian language, ie. At the current khori-buryat language. Thus, the buryat language is historically very valuable language to the world. Therefore, even UNESCO should devote special attention to the wide language did not become extinct.

*(From the Minute of the discussion has released and
translated into English by A. Sambuu)*

БУРИАД ХЭЛЭНЭЙ ҮСГЭЛДЭР, МҮНӨӨДЭР, ҮГЛӨӨДЭР

(Буриад хэлэнэй олон улсын өдөрт зориулсан бага хурал, ярилцлага)

2012.12.08.

Улаанбаатар хот

2012 онд буриад хэлний олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд доктор Г.Цэцэгдарь захиралтай “Антаон Мостарт монгол судлал”-ын төв дэмжин тусалж, хурлын байр, бусад боломжоор хангаж, академич Д.Төмөртоогоо захиралтай “Монгол судлалын төв” ивээн тэтгэж, санхүүжүүлэн МУИС, МУБИС, УБИС, ШУА-ийн зарим хүрээлэнгүүд болон ОХУ-ын БУИС-ийн эрдэмтэн судлаачид оролцож, буриад хэлний өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар чөлөөт ярилцлага зохион байгуулж, санал шүүмжлэл өрнүүлэв.

“Буриад аялгууны толь бичиг”-ийг тойрсон хэлэлцүүлгийг зохион байгуулж, зохиогч хэлшинжлэлийн шинжлэх ухааны доктор /Sc.D/, профессор Г.Гантогтох “Буриад аялгууны толь” гэсэн илтгэлийг хэлэлцүүлж, буриад хэлний өнөөгийн байдал, тархац, хүн амын дундах хэлний хэрэглээний тухай болон уг толийг бүтээсэн аргазүйн талаас нь тайлбарлаж, цаашид юу хийх хэрэгтэй байгааг онцлон тэмдэглэв.

Мөн Буриад судлалын академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, МУИС-ийн докторант Л.Оюунцэцэг “Буриад хэл аялгуугаарх нэвтрүүлгийн хэлний талаар” шүүмж, санал дэвшүүлж, хэлэлцэх асуудлыг чиглүүлж, хуралд оролцогчид санал бодлоо уралдуулав.

Олон эрдэмтэн судлаач санал шүүмж хэлсэн боловч цаашид хэрэгжүүлэхэд анхаарах цөөн зүйлийг нь багцлан тодорхойлов.

Үүнд:

-Буриад хэл аялгууны хэрэглээг нэмэгдүүлэх, олон нутгийн аялгуунуудыг цэгцлэн эмхэтгэн доктор, профессор Г.Гантогтох “Буриад аялгууны толь” бүтээл хэвлэгдсэн онцлон тэмдэглэх ололт юм. Олон жилийн суурь судалгааны үндсэн дээр 20 орчим мянган үгтэй дэлгэр жишээ хавсаргасан толийг эрхлэн хэвлүүлсэн нь буриад олон салбар аман аялгууг харьцуулан судлах, иргэд хэрэглэх, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсан ач холбогдолтой бүтээл болсон байна. Гол нь орон нутагт, буриад сум, аймгийн иргэдэд хүртээмжтэйгээр тараахад дэмжлэг үзүүлэх, орон нутгийн удирдлагууд сургуулийнхаа номын санд худалдан авахад туслах,

-Буриад гэр бүлдээ буриад хэл аялгуугаа мартахгүй хэрэглэх, гэр бүлийн дотор эцэг эх нь үр хойчдоо зааж, сургаж, өв соёлоо эзэмшүүлэх, өвлүүлэхэд анхаарах нь чухал байна. Түүнээс бус буриадын төлөө гэсэн өв соёлоо дээдлэхийн төлөө ажиллаж байгаа байгууллагуудын ажлын хүрээнд бүх зүйл шийдэгдэхгүй тул гэр

бүлийн оролцоог нэмэгдүүлж, буриад хэл аялгаа мартаггүй хөгжүүлэхэд бүгд анхаарах. Ирэх жилийн буриад хэлний олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, эцэг, эхчүүд, ахмадууд үр хүүхэд, ач зээ нартаа хэл, соёлоо заан өвлүүлснээ тайлагнаж байх,

-Буриад хэл аялгуугаар ном зохиол гаргах, сонин сэтгүүл эрхлэх, интернэт цахим ертөнцөд буриад залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх ажлыг эхлүүлэх. “Амин тоонто” ТББ зэрэг буриад залуусын нэгдлийг дэмжин тусалж, хамтран ажиллах,

-Буриад хэл аялгуугаа мартаггүйн тулд соёлын орчинг бий болгож, гэр бүлдээ эцэг эхчүүд буриад аялгаараа ярилцах, өв соёлоо заан сургах гэрийн сургалтыг ашиглаж эхлэх. Буриад хэл аялгууны сайн дурын сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

-Буриад зан заншил, өв соёлоо шингээсэн дунд сургуулийн сурагчид, хүүхдүүд зориулсан сурах бичиг, гарын авлага бичиж хэвлүүлэх. Сурах бичиг, ном хэвлэлээр дамжуулан өв уламжлалыг нь хадгалуулах, ухамсар сэтгэлгээнд нь суулгаснаар соёлоо мартаггүй хөгжүүлэн авч үлдэх боломж нээгдэнэ,

-Буриад хэл соёлын эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлж, ард түмний бүтээж үлдээсэн асар баялаг оюуны соёлыг хамгаалж, олон нийт түгээх, сурталчилахад анхаарч, нарийн мэргэшсэн залуу судлаачдыг бэлтгэх,

-Буриад хэл-аялгуугаарх нэвтрүүлгийн хэлний асуудлыг тодорхойлж, хөтлөгч, сэтгүүлчдийг нь сургах, хэл аялгыг нь засах, заан зөвлөхөд анхаарч, туслан дэмжих хэрэгтэй байна. Шүүмжлэхдээ гол нь биш хийж байгаа зүйлд нь сэтгэл зүрхнээсээ туслан дэмжих талаас бодолцох хэрэгтэй болжээ. Нэвтрүүлгийн мэдээний үг хэллэгийг буриадчилан дуудаж чадахгүй байгаа нь олон нийтийн дунд үл ойлголцох, зарим буриад иргэдийн дургүйцлийг хүргэж байгааг анзаарч, засаж зөвөөр өгүүлж хэвшүүлэхэд бүх талын дэмжлэгийг үзүүлэх,

-Алтаргана наадмыг зохион байгуулахдаа уһан буриад аялгаараа явуулж хэвших. Хувцас өмсгөл зүүсгэл, ахуйн талаасаа буриад боловч хэл яриа, соёл нь дутагдаж байгааг анхаарч, дараагийн наадмыг уһан буриад хэл аялгаар хичээнгүйлэн хөтлөх, бүх үйл ажиллагаанд нь буриад өв соёлыг шингээж хийхэд анхаарах тухай хэлэлцэн тогтов.

Дараа жилийн хурал, хэлэлцүүлэг хүртэл өөр өөрийн зүгээс буриад өв соёлоо хөгжүүлэхэд тодорхой ажил хийсэн байхаар тогтов.

**БУРИАД ХЭЛНИЙ ОЛОН УЛСЫН ӨДӨРТ ЗОРИУЛСАН
“БУРИАД ХЭЛ-АЯЛГУУНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД” СЭДЭВТ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ-ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛ**

УРИЛГА

Эрхэм хүндэттаныг

МҮОНТ-ийн 2-р суваг, Буриад судлалын академи, “Амин тоонто” ТББ-аас хамтран
Олон улсын буриад хэлний өдөрт зориулан зохион байгуулж буй “БУРИАД ХЭЛ-
АЯЛГУУНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД” сэдэвт эрдэм шинжилгээ, онол-практикийн
бага хуралд хүрэлцэн ирэхийг урья.

Хэзээ: 2013 оны 11-р сарын 22-ны өдрийн 14.00-18.00 цагт

Хаана: МҮОНРТ-ийн төв байрны Хурлын их танхимд болно.

**Буриад судлалын Академи
Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн MN2 суваг
Амин тоонто ТББ**

УДИРДАМЖ

Зохион байгуулагч: МҮОНТ-ийн MN2 суваг телевиз, Буриад Судлалын Академи, “Амин тоонто” ТББ

Хамтран зохион байгуулагч: ОХУ-ын Буриад улсын Монгол улсад суугаа байнгын төлөөлөгчийн газар, ОХУ-ын БУИС-ийн Буриад утга зохиолын тэнхэм, Буриад хэлний тэнхэм

Үндэслэл: Буриад хэлний олон улсын өдрийг ОХУ-ын Буриад улсад тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалыг сүүлийн 6 жилд Монгол улсын Буриад судлалын академиас зохион байгуулж ирсэн уламжлалтай бөгөөд буриад хэл-аялгуу, түүх, угсаатан, ёс заншил, уламжлалын чиглэлүүдээр тогтмол хурал, зөвлөгөөн, дугуй ширээний ярилцлага, уулзалтуудыг тогтмол хийж ирсэн. Энэ удаагийн тухайд НҮБ-ын ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр МҮОНТ-ийн MN2 суваг нээгдэж үндэсний цөөнхөд зориулсан казак, тува, буриад хэл-аялгуугаар нэвтрүүлэг бэлтгэж эхэлснийг сайшаан дэмжиж, үйл ажиллагааг нь улам өргөн дэлгэр болгох, үндэсний цөөнхийн хэл, уламжлал, ёс заншлыг олон нийтэд зөвөөр таниулах, сурталчилахад нь дэмжлэг болох үүднээс “Буриад хэл-аялгууны хэрэглээний асуудалд” сэдвийн хүрээнд буриад хэл-аялгууны нэвтрүүлгийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар тусгайлан хэлэлцэхээр болж байна. Ингэснээр цаашид уг

нэвтрүүлгийн чанарыг сайжруулах, олон нийтээс ирж байгаа аливаа шүүмжлэлийг ажил хэрэг болгох, зөв хандлагыг төлөвшүүлэх, мэргэжлийн зөвлөмж, туслалцаа үзүүлэх цаг үеийн шаардлага бий болоод байна.

Оролцох хүмүүс: Монгол Улс, ОХУ-ын БУ, Эрхүү мужийн Усть-Орда, Өвөр Байгалын хязгаарын эрдэмтэн судлаачид, сэтгүүлч сурвалжлагч, нэвтрүүлэгч, редактор, найруулагч нар оролцоно.

Илтгэлийн чиглэл: Буриад хэл-аялгууны хэрэглээ Монголд болон ОХУ-ын буриадад ямархуу байгаа, хэл аялгууны хамрах хүрээ, хэтийн чиг хандлага, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулж байгаа мэдээ, нэвтрүүлгүүдийн хэлний чанар, шаардлагын төвшинд хийсэн задлан шинжилгээг эрдэмтэн судлаачил хийснээ танилцуулж, Монгол дахь буриад хэл-аялгууны нэвтрүүлгийг чанаржуулах боломжийн талаар санал бодлоо солилцоно.

Гарах үр дүн: Буриад хэл-аялгууны хэрэглээний байдалд дүн шинжилгээ хийж, МҮОНТ-ийн MN2 суваг телевизийн буриад хэл-аялгууны нэвтрүүлгийн чанарыг сайжруулж, мэргэжлийн болон хэлний туслалцаа үзүүлж, байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ төвшинд гаргана.

ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

11-р сарын 22.

Улаанбаатар хот

Хурлын дэг: Илтгэгч 10 минут, санал шүүмж 5 минут.

13.30-14.00 цаг	Хуралд оролцогчдын бүртгэл
14.00-14.30 цаг	Хурлын нээлт
	- МҮОНТ-ийн 2-р сувгийн захирал Ц.Лхагвадаш нээж үг хэлнэ
	- БСА-ийн ерөнхийлөгч, доктор М.Одмандах нээлтийн үг
	- Буриад дууны мэндчилгээ Б.Эрдэнэбаатар дэвшүүлнэ.

ҮНДСЭН ХУРАЛДААН: Буриад хэл-аялгуугаарх нэвтрүүлгийг боловсронгуй болгох тухай

Хурлын дарга: Буриад судлалын академийн ерөнхийлөгч, доктор /Ph.D/ М.Одмандах

14.30-14.40 цаг	Г.Гантогтох – МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг судлалын тэнхмийн багш, доктор /Sc.D/, профессор Монгол улс дахь буриад хэл-аялгууны хэрэглээний өнөөгийн байдал
14.40-14.50 цаг	Ж.Эрдэнэцогт – MN2 суваг телевизийн Ерөнхий редактор, С.Алтансүх - Ерөнхий найруулагч Үндэсний цөөнхөд зориулсан нэвтрүүлэг бэлтгэж байгаа байдал, чиг хандлага
14.50-15.10 цаг	Л.Ц.Халхарова – ОХУ-ын БУИС-ийн Уран зохиолын тэнхмийн эрхлэгч, доктор /Ph.D/, доцент Буриад хэлэн дээрэ гарадаг теле-дамжуулгануудай онсо шэнжэ
15.10-15.20 цаг	Ч.Энхзул – MN2 суваг телевизийн хөтлөгч, редактор Буриад хэл-аялгуугаар нэвтрүүлэг бэлтгэхэд гарч буй бэрхшээл, даван туулж буй туршлага
15.20-15.30 цаг	Л.Оюунцэцэг – Буриад судлалын академийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, МУИС-ийн докторант Монгол дахь буриад нэвтрүүлгийг нийгэм соёлын антроплогийн үүднээс шинжлэх нь

Буриад судлал №4 эрдэм шинжилгээний сэтгүүл

15.30-15.40 цаг	Б.Б.Будаин – ОХУ-ын Буриад улсын их сургуулийн Буриад хэлний тэнхмийн багш, доктор /Ph.D./, доцент Олонийтэдэ дамжуулдаг хэрэгсэлнүүдэй ажалишадые буряад орондо бэлдэлгэ
15.40-15.45 цаг	М.Одмандах – БСА-ийн Ерөнхийлөгч, МУБИС-ийн МоСС-ийн Сэтгүүлзүйн тэнхмийн багш, доктор /Ph.D./ Нэвтрүүлгийг боловсронгуй болгоход нэмэрлэх санал
15.45-15.50 цаг	Т.Батзориг – МҮОНРТ-ийн Мэдээлэл судалгааны төвийн дарга MN2 суваг телевизийн үзэгчдийн судалгааны талаар товчхон
15.50-16.00 цаг	Г.Батцэрэн – СУИС-ийн багш, доктор, дэд профессор Зурагт, радиогийн соёл урлагийн нэвтрүүлгийн тухайд
16.00-16.10 цаг	Цайны завсарлага

САЛБАР ХУРАЛДААН: Буриад хэл-аялгууны хэрэглээ, цаашдын хандлага

Хурлын дарга: Буриад судлалын академийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, докторант Л.Оюунцэцэг

16.10-16.20 цаг	Р.С.Романова – ОХУ-ын Буриад улсын Засгийн газрын ажилтан Буриад орондо хэлэнэй талаар ажаябуулга
16.20-16.30 цаг	В.Д.Патаева – ОХУ-ын БУИС-ийн Буриад хэлний тэнхмийн багш, доктор /Ph.D./, доцент Буряадын утга зохиолой хэлэнэй мүнөө үеын байдал
16.30-16.40 цаг	Н.Н.Балжинимаева – ОХУ-ын БУ-ын “Мүнгэн товшо” вэб хуудасны хөтлөгч, сэтгүүлч Буриад хэлийг хойч үедээ өвлүүлэн үлдээхэд интернэтийн үүрэг чухал болох нь
16.40-16.50 цаг	А.Д.Эрдынеева – ОХУ-ын БУИС-ийн багш Буряад теле-радио-дамжуулгануудай хэлэн тухай
16.50-17.00 цаг	Ж.Ц.-Д.Дондокова – ОХУ-ын БУИС-ийн Боханы салбарын багш Усть-Орда тойрогто гарадаг сонинуудай хэлэнэй асуудалнууд
17.00-17.10 цаг	Ц.Б.Базарова – ОХУ-ын БУ-ын Үндэсний номын сангийн ажилтан Буряад хэлэ хари гүрэнэй зонуудта зааха онол арга
17.10-17.20 цаг	Жамьяан Санжаа – ОХУ-ын Буриад улсын судлаач, докторант Буриад аялгууны улс төр, нийгэм, эдийн засгийн үг хэллэгийн сан, түүнийг хөгжүүлэх бодлого

Илтгэлүүдийн хэлэлцүүлэг, зөвлөмж боловсруулах:

17.20-17.50 цаг	Илтгэлүүдийн талаарх санал шүүмж, нэвтрүүлгийг боловсронгуй болгох зөвлөмжийн төслийг хэлэлцэн батлах
17.50-18.00 цаг	Хурлын хаалтын ажиллагаа - Буриад судлалын академийн ерөнхийлөгч, доктор /Ph.D./ М.Одмандах хуралдааныг дүгнэж үг хэлж, хурлыг хаана

Тайлбар: (MN2 суваг телевизийн сэтгүүлч, уран бүтээлчидтэй ажил хэргийн уулзалтыг цайны завсарлагааны дараа тусгайд нь Хэвлэлийн хурлын өрөөнд 16.10-17.00 цагийн хооронд хийнэ. Үүнд телевизийн цаашидын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хэл, нэвтрүүлгийн бодлогыг боловсронгуй болгох асуудлаар мэргэжлийн хүрээний хүмүүсийн хүрээнд уулзалт хийнэ. Тухайн үед зарлаж оролцох хүмүүсийг сонгоно. Буриад хэл-аялгууны хэрэглээний асуудлаарх хурал үргэлжлэн зэрэгцээд хийх болно.)

ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

- оОо -

БУРЯАД ХЭЛЭНЭЙ ЕРЭЭДҮЙ (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал)

ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хотын Ивалгын дацанд “Буриад хэлний ирээдүй” сэдэвт олон улсын бага хурлыг зохион байгуулж, тодорхой шийдвэр гаргасан байна. Бид энэ тухай товч мэдээллийг оруулж байна. Цаашид буриад хэлний талаар явуулах бодлогод нь улсын зүгээс дэмжлэг үзүүлэх ажээ.

Буддын шажантай заншалта Сангхын толгойлогшо XXIV Бандида Хамба лама Дамба Аюшеевэй оролдолго болон үүсхэлээр буриад хэлэнэй ерээдүй тухай асуудал үргэн нийгэмэй урда табигдажа, 2013 оной арбан нэгэн нарын 9-10-да Ивалгын дасанай Ехэ хургуулийн танхим соо Уласхоорондын бага хурал зарлагдаад, зүбиэн хэлсэлгэ үнгэрбэ.

Эндэ Буриад Республикын Арадай Хуралай, Засаг газарай, Монголой, Забайкалийн болон Эрхүүтэй хизаарай, республикын аймагуудай болон Улаан-Үдэ хотын сурбалжалагшад, хургуулийн багшанар, соёлой эмхинүүдэй, дасануудай түлөөлэгшэд, тамиршад болон буриад хэлэнэй мүнөөдэрэй ба ерээдүй байдалда ханаагаа зобоһон 300-аад хүнүүд суглараа, ханал бодолнуудаараа хубаалдажа, зохистой шийдхэбэри абаа.

Энэ хадаа мүнөө үедэ буриад арадай толгойдо тулажа ерээд байһан шухала асуудалнуудай нэгэн, тэрэ мүртөө гол асуудал гэжэ онсолон хэлэхэ шухала. ЮНЕСКО-гой дэбтэртэ оруулагдаад байһан энэ хэлэнэй хойшонхи хуби заяан олон хүнүүдэй ханаа зобооно гэжэ эндэ сугларһан зоние харахада эли. Эндэ Буриад Республикын Арадай Хурал, Монголой, республикын аймагуудай болон Улаан-Үдэ хотын түлөөлэгшэд (хурбалжалагшад, хургуулинуудай, соёлой гуламтануудай, дасануудай, түлөөлэгшэд, тамиршад), тиихэдэ буриад хэлэнэй мүнөөдэрэй байдалда ханаагаа зобоһон хүнүүд суглараа, ханал бодолнуудаа үнэн зүрхэнһөө элидхээ.

«Һалабабди, хандарбабди, үхэбэбди» гэлсэхээр үнинэйбди, гэбэшье мүнөөдэр дээрэ абажа харахада буриад хэлэн тэрэл хэбээрээ, яһала байна, буриадуудай элинсэгһээ нааша сахижа байһан заншал гуримууд тэрэл хэбээрээ сахигдана, гансашье ехэ бага тайзанууд дээрэ бэшэ, үшөө тиихэдэ арад зоний юрын ажабайдалда үргэнөөр хэрэглэгдэнэ, энээндэ хурим түрэ бүтээлгэ хайн жэшээ болоно, хаа яагүй, бишыханууд илгаануудтайшье хаа, энэ заншал зүб мүрөөр сахигдажа байдаг болонхой. Тиихэдэ эдэмнай үндэһэн буриад хэлэн дээрээл үнгэргэгдэжэ байдаг заншалнууд ха юм даа.

Буриад хэлэн баталагдаһан өөрын дүримүүдтэй, хургуулинуудта хайн багшанарта заалгаһан хүнүүд алдуугүй бэшэжэ, зүбөөр хэлэжэ хураад ажабайдалай харгыда гарана, хоёрой хоорондо үнгэрдэг хэшээлнүүдтэй хургуулинуудые

дүүргэгшэд энээхэн шадабарид оройдоошье дүршэлгүй, миил ярянай хэлэ мэдэдэг, тэрэл хэлэн дээрээ бэшэдэг гэжэ һүүлэй үедэ элирэнхэй. Тэдэ зоной дунда зохёолдо бэлигтэй хүнүүд бии, гэбэшье тэдэнэй зохёолнууд бодолтойшье хаа, бэшэлгэнь мэдүүлэл болоогүй байдаг. Хэды олон залуушуул шүлэгүүдые бэшэдэг, тэрээн дээрээ хүгжэм тааруулаад дуулалдадаг, дуунуудай шагнаха согсолборинуудые (дискнүүдые) гаргуулнаб? Тиигэжэ эдэ зон түрэл хэлээ хэлэшгүйгэй ехэ хохидолдо оруулна, мүнгэнэйл байгаа хаа тэрээхэн согсолборинуудыень хэблээд дэлгэрүүлхэ газарнууд захагүй олон. Энэ ябадал хизаарлажа, Буряадай уран зохёолшодой холбоондо зүбшэл заабаринуудые үгэдэг, алдуунуудыень заһадаг, үгышье хаа заажа үгөөд өөһэдтэнь заһуулдаг мэргэжэлтэн хэрэгтэй. Тэрэ хүнэй гү, али холбооной түрүүлэгшын гар табилгагүй хэблэгдэһэн тиимэ дискнүүд, шүлэг болон бусад уран зохёолой түлөө хэблэжэ гаргагшадта хатуу хэмжээ абаагүйдэ үндэһэн хэлээ богоор дүүргэжэ байһан ябадал болоно. Хэлэмнай хүсэд дүүрэн байха мүртөө зүб байха ёһотой бшуу.

Тээд, юунэй түлөө, хэлэтэй байһан аад лэ, ... гэхэн асуудал гаража ерэнэ. Һүүлэй үедэ хургуулинуудта буряад хэлэ заалгын шанар һула, үсөөхэн сагтай, зарим хургуулинуудта оройдоошье заагданагүй, заагдажа байһан газарта болноулагдана, аймагуудта багашаг тосхонуудай хургуулинууд бүхыдөө хаагдана. Иигэжэ үндэһэн асуудалнуудта хайхарамжагүй ябадал хэлэндэ нүлөө үзүүлнэ, тиихэдээ хэлэнэй хүгжэхэ, дэлгэрхэ тээшэ бэшэ юм ааб даа.

Буряад хэлэ мэдэхэ зоной тоо жэлһээ жэлдэ үсөөрнэ, хэлэнэй мүнөөдэрэй байдал тэрэл хэлээ һайнаар мэдэдэг зоной һайгаар гэжэ мэдээжэ. Ябан ошон саг жэлнүүд үнгэрхэ, һаядаа бэшэшье хаа, хэдэн олон (зуугаад юм гү, хэды юм) жэлнүүдэй үнгэрөөд байхада хэлээ мэдэхэ зомнай үсөөрөөд, эхэ хэлээ һэргээхэшье гээ хаа, хүшэ хүрэхээ болихо. Тиихэдэл хэлэгүй арад гээшэ бии болохогүй юм гү гэхэн тон хурса асуудал мүнөөдэр гараба гээшэ ха юм даа. Энэ асуудал шийдхэхэ ехэ хүсэнуудэй эхин дээрэ засаг зургаанууд байха ёһотой гэхэн бодол байна, буряад хэлэнэй баялигай эхин дээрэ байдаг хүдөө тосхонуудые, тэндэхи хургуулинуудые һандаргажа, хаажа байха бэшэ, һэргээжэ, хүгжөөжэ байха, бүхы хургуулинууд болон дээдэ хургуулинуудта буряад хэлэ дүүрэн хэмжээндэ зааха, тэрэ ЕГЭ гээшэдэнь заатагүй буряад хэлэ бэшэг оруулха, ямаршье дээдэ хургуулида оролгондо энэнэ хараада абтаха болобол ехэл һайн байгаал даа.

Бүхы буряад түрэлтэнэй эхэ хэлэн яабашье нютаг хэлэнүүд дээрэ үндэһэлдэг. Нютаг хэлэнүүд мүнөө болотор һаалта болоогүй, аймаг-айлаар тэрэл хэлээрээ хөөрэлдэжэ байдаг, тиимэһээ нютаг хэлэнүүдэй алиниеньшье үлүү үзэһэнэй оройдоошье хэрэггүй, бүхэли ехэ буряад хэлээ дэлгэрүүлхэ хэмжээ ябуулганууд лэ түбхын түрүүндэ байха юм бэшэ гү?

Ивалгын дасанда үнгэрһэн бага хурал энэ ехэ хүдэлөөнэй эхин, түлхисэ боложо, дээгүүр тушаалтадаһаа эхилээд, доошоо гэхэ юм гү, саашадаа хүн бүхэн

үндэһэн асуудалнууд хосороол наа, хэлэнтээс суг нэгэ үдэр хосорхо гэжэ ойлгобол һайн байгаал даа.

«БУРЯАД ХЭЛЭНЭЙ ЕРЭЭДҮЙ» БАГА ХУРАЛАЙ ШИИДХЭБЭРИНҮҮД

- «Буряад хэлэн үгы боложо байһан хэлэнүүдэй нэгэн» гэжэ ЮНЕСКО-гой 2005 оной дэбтэртэ ороһон ушары мэдэрхэ;

- Ехэ хуралнууд болон суглаанууды Буряадай гимнээр эхилхэ, дүүргэхэ;

- Буряад оршон байдалтай (заалга болон хүмүүжүүлгын талаар) хүүгэдэй сэсэрлигүүды элбэгээр нээхэ, байһан сэсэрлигүүдтэ буряад хэлэ заалгатай бүлэгүүды байгуулха. Буряад Республикын үндэһэтэнэй 1-дэхи лицей-интернадтай Улаан-Үдэ хотын «Журавлёнок» сэсэрлигы нэгэдүүлэн, буряад хэлэн дээрэ үхибүүды хүмүүжүүлэн хургадаг тусхай комплекс байгуулха;

- «Буряад үнэн» һониной захил дэлгэрүүлхэ, радио, ТВ дэмжэхэ;

- Эдэе хоолой, эдэй дэлгүүрнүүдэй бараанай нэрэнүүды болон сэн буряадаар дабтаха;

- Залуушуулай хоорондохи яряанай хэлэндэ дайралдадаг, хүдөө гарбалтай үетэндөө өөдэрхэнги хандасатай үгэнүүды хорихо (головар, тормоз г.м.)

- Харгын тэмдэгүүды, уһа голой, нютагуудай, аймагуудай, гудамжануудай, хотын унаагай буудалнуудай нэрэнүүды буряадаар дабтаха;

- Буряад хэлэнэй хэрэглэлгэ тухай хуулида нэмэлтэ оруулха;

- Сэсэрлигүүдтэ, эхин ба дунда хургуулинуудта ород болон буряад хэлэ заалга тэгшэ хэмжээндэ гаргаха;

- Нютаг хэлэнүүдэй үгэнүүдэй тайлбари-толи найруулха;

- Сэлэнгын, Зэдын, Хяагтын аймагуудай буряад хургуулинуудта нютаг хэлэн дээрэ оршон тойрониё шэнжэлхэ арга олгуулха;

- Хүтэлбэрлхы тушаалда гаража байһан эрхэтэдтэ яряанай буряад хэлэ заатагүй мэдэхэ эрилтэ табиха;

- Гүрэнэй албанда тушаалтай буряад хэлэтэй эрхэтэдтэ булюу дэмжэлгэ үзүүлхэ;

- Түхэрээн үдэр ажалладаг FM радио, ТВ байгуулха;

- Буряад хэлэндэ һураха аргууды олошоруулха, дистанционно заалгын арга боломжо ашаглаха;

- Эрхүү можодо ажаһуудаг буряад угсаатантай аймагуудта буряад хэлэнэй тусхай байра болон зааха асуудалнуудта онсо анхарал хандуулха;

- Буряад хэлэ зааха курснууды олошоруулха;

- Буряад хэлэ зааха методико һайжаруулан хүгжөөжэ, найруулан нэбтэрүүлхэ;

- Залуушуулай элдэб янзын (хүгжэмэй, хөөрөөнэй, уран зохёолой, киногой г.м.) хэлэ бэшгэй дүримүүды баримталһан проектнүүды дэмжэхэ;

- Дунда хургуулида түрэл хэлэн дээрэ ГИА, ЕГЭ тушаалгаха;

- ЗАГС-ын эмхи зургаанда буриад нэрэ зүүлгэ гуримшуулха;
- Буриад хэлэ заадаг багшанарай эмхи байгуулха;
- Монгол телевидени хараха арга олошоруулха.
- Энээнһээ гадна Чойдог Бамдажапов ламын түбэд хэлэнэй тайлбари-толи, тиихэдэ Ринчен Бимбаевай халха-монголоой хэлэн дэрэ уран зохёол ба шүлэгүүдые бүтээжэ, Пушкин мэтэ алдартай болоһон ушарые бү мартаарайт!

Баталагдан абтаһан эдэ шиидхэбэринүүдые бэелүүлжэ байха уялгатай «Бага хурал» гэхэн хүдэлмэриин эмхи Бандида Хамба ламын дурадхалаар байгуулха:

Батоцырен Садаевич Дашинамжилов
Николай Дабаевич Бадмаринчинов
Сергей Дондогдоржиевич Бальжанов
Батор Улымжиевич Данзанов (Боохон)
Чинзориг Батжаргалын (Монгол)
Сергей Далаевич Доржиев
Баяр Дабаевич Дугаржапов (Ага)
Цырен Шойжонимаев
Алдар Долгоржапов (Алайрай дасанай шэрээтэ)
Светлана Тогошиевна Банзarakцаева (Бэсүүр)
Гэрэлма Майдарханова (Түнхэн)
Борис Чойнхорович Дамбиев (Дээдэ-Тори, Зэдэ)
Баярма Лубсановна Эрдынеева (Ара-Хэрээтэ, Бэсүүр)
Марина Владимировна Батуева (Ага)
Мүнхэ-Жаргал Николаевич Ошоров (Аха)

-оОо-